

Ц.Гантулга, Л.Алтанзаяа, Б.Нацагдорж,  
Д.Пунцагсүрэн, М.Цогбаяр

# ТҮҮХ VIII

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн  
8 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны  
зөвшөөрлөөр хэвлэв.

Гурав дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.  
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот  
2019 он

DDC  
371.32  
T-826

Түүх VIII: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 8 дугаар ангийн сурах бичиг /Гантулга Ц., ба бусад; Ред. Цолмон С. -УБ., 2015.- 148х

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх, мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN: 978-99962-74-33-6

# ГАРЧИГ

## НЭГ. МОНГОЛ УЛС БА ДЭЛХИЙН ШИНЭ ҮЕИЙН ТҮҮХ (XV-XX зууны эхэн) ХИЧЭЭЛИЙГ ХЭРХЭН СУДЛАХ ВЭ?

1. Сурах бичигтэйгээ танилцацгаая.....5
2. XV-XX зууны эхэн үеийн Монгол ба дэлхий дахин.....8

## ХОЁР. МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ ДАРААХ МОНГОЛ УЛС БА ДЭЛХИЙ ДАХИН (XV-XVIII зууны дунд үе)

### I БҮЛЭГ. МОНГОЛ УЛС НЭГДМЭЛ ХҮЧИРХЭГ БАЙДЛАА АЛДАВ

1. XV-XVIII зууны Монгол улс.....13
2. Нэгдмэл хүчирхэг байдлаа сэргээхийн төлөө тэмцэл.....18
3. Монгол улс (XVII-XVIII зууны дунд үе) .....23
4. XV-XVIII зууны үеийн Монгол улсын гадаад орчин.....28
5. Монгол улс тусгаар тогтнолоо алдав.....31
6. XV-XVIII зууны үеийн монголчуудын амьдрал, соёл.....35

### II БҮЛЭГ. ДЭЛХИЙН ТҮҮХИЙН ШИНЭ ҮЕ ЭХЭЛЛЭЭ

1. Газар зүйн их нээлт, колоничлолын эхлэл.....40
2. Шашны шинэтгэл.....45
3. Сэргэн мандалт ба хүмүүнлэг үзэл.....50
4. Соёнгэгээрлийн хөдөлгөөн.....54
5. Капитализмын үүсэл, шинж онцлог.....58
6. XV-XVIII зууны үеийн өрнө дахин.....61
7. XV-XVIII зууны үеийн дорно дахин.....67
8. XV-XVIII зууны үеийн дэлхийн улс түмний амьдрал, соёл.....71

## ГУРАВ. ХҮИИ-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ БА ДЭЛХИЙ ДАХИН

### I БҮЛЭГ. XVIII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ

1. Монголчууд эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцсэн нь.....77
2. Манж Чин улсын Монголыг захирсан бодлого.....82
3. Монголд бурхны шашин өргөн дэлгэрсэн нь.....88
4. XVIII-XX зууны эхэн үеийн монголчуудын амьдрал.....93
5. XVIII-XX зууны эхэн үеийн Монголын соёл.....96
6. Монголын талаарх Манж Чин гүрний бодлого өөрчлөгдөв.....101

### II БҮЛЭГ. XVIII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН ДЭЛХИЙ ДАХИН

1. Аж үйлдвэрийн хувьсгал.....106
2. Шинжлэх ухааны ололт, нээлтүүд.....111
3. Хувьсгал ба шинэ улс гүрнүүд.....115
4. Наполеон Бонапарт ба Францын эзэнт гүрэн.....123
5. XVIII-XX зууны эхэн үеийн дорно дахиныг колоничлох бодлого.....126
6. Эзэнт гүрнүүдийн дорно дахиныг колоничлох бодлого.....133
7. XVIII-XX зууны эхэн үеийн өрнө дахины улс орнуудын амьдрал, соёл.....139
8. XVIII-XX зууны эхэн үеийн дорно дахины улс орнуудын амьдрал, соёл.....143
- Ном зүйн жагсаалт.....148





## МОНГОЛ УЛС БА ДЭЛХИЙН ШИНЭ ҮЕИЙН ТҮҮХ (XV-XX зууны эхэн)

### ХИЧЭЭЛИЙГ ХЭРХЭН СУДЛАХ ВЭ?



...Дэлхий дээр улс гэр болон тогтнох явдал...түүхтэй холбогдолтой бөгөөд өөрийн улс үндэстний түүхийг ард бүхэн ойлгож мэдвэл хүн бүр улс үндэснийг батлан хамгаалах оюун мэдрэлтэй болох бөгөөд эрт урьдын түүх явдал нь хэдийгээр өнгөрсөн үеийн хэрэг боловч эртнээс нааш улс гэрийн хэрхэн тогтносон, мөхсөн ба ардын аж амьдрал хэрхэн дэвжсэн, буурсан хийгээд засаг, заслалыг хэрхэн олсон, алдсан явдлаар үлгэрлэн жишиж, сайныг нь дууриаж, сайн бишийг нь цээрлэл болгосоор ирсэн тул үүн тухай эртний хүний өгүүлсэн нь "сайн нь миний багш бөгөөд сайн бус нь ч бас миний багш болой" гэжээ. ...Аливаа нэгэн улс төр нь өөрийн улс үндэстний түүх, явдлыг мэдэх танихыг ихэд чухал болгодог тул улсын бүх сургууль, соёлын газрууд, цэрэг, ард хүртэл нийтэд заан сургаж танилцуулдаг ажээ. Монголын ард бүхэн өөрсдийн улс үндэстний түүх явдал ба өөрийн газар шорооны эрхэм чухлыг мэдэж ухах болвоос монгол хүн бүхэн улс төр, үндэс угсаа, газар шороогоо хамгаалах санал бодлоготой болох амуй".

(Монгол улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн А.Амар)

#### 1. Сурах бичигтэйгээ танилцагаая.

Сурах бичиг та бүхний суралцахуйн хөтөч. Сурах бичгийн бүх сэдвийн агуулга нь малгай хэсэг, сэдвийн гол утга санаа, яагаад чухал болох, ямар түлхүүр үг, ухагдахуунд тулгуурлан судлах вэ гэдгийг товч илэрхийлсэн эхлэл хэсэг; асуулт гаргах, асуудал, таамаглал дэвшүүлэх өмнөтгөл; бичвэр, сурвалж баримт, нэмэлт мэдээлэл, унших, шинжлэх, нэгтгэн дүгнэх, үнэлэх, дасгал даалгавар зэргийг багтаасан бүтэцтэй. Тийм учраас та бүхэн сурах бичгийнхээ бүх бүрдэл хэсгүүдтэй сайтар танилцаж, анхааран уншиж, хөтөчөө болгон суралцахыг зөвлөж байна.

Эхлэл хэсэгт анхаарал хандуулан асуулт тавьж, асуудал, таамаглал дэвшүүлснээрээ та бүхэн өөртөө бодол эргэцүүлэл, сонирхол тэмүүлэл бий болгохыг хичээгээрэй. Үндсэн бичвэр хэсэгт тухайн бүлэг сэдвийн үндсэн агуулгыг шинжлэн судлахад хэрэгтэй мэдээлэл, сурвалж баримтууд буй. Тэдгээрийг ашиглан тухайн сэдвийн үндсэн асуудлыг та бүхэн бие даан задлан шинжлэх, үнэлж дүгнэх, танин мэдэх, мэдлэг чадвараа гүнзгийрүүлэх, хамтран ажиллах боломжтой. Энэ бүгд шинжлэн судлах, бие даан суралцах арга барил эзэмшүүлэх, өөрөө түүхийг судлан мэдлэг бүтээх, асуудал шийдвэрлэх, унших, бичих, сэтгэн бодох, амьдралтай холбох, хэрэглэх зэрэг олон талын чадвар хөгжүүлэхэд чиглэгдсэн болно.

Шинэ үеийн түүхийг судлахын утга учир нь та бүхнийг түүх, нийгмийн үйл явдал, үзэгдлийг танин мэдэх арга барилтай, үндэстний бахархал, соёл, уламжлалаа дээдлэн өвлөсөн, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг хүндэтгэдэг монгол иргэн болж төлөвшихөд туслахад оршино. Тиймээс сурах бичгийн агуулга, арга зүй та бүхэнд:

- Шинэ үеийн түүхийн үйл явдал, үзэгдлийг шинжлэн судлах замаар асуудал шийдвэрлэх, түүхийг тайлбарлах, үзэл бодлоо илэрхийлэх чадвар, сурах арга барил эзэмших;
- Энэ үеийн түүхэнд холбогдох үйл явдал, он цаг, түүхэн зүтгэлтэн, нэр томьёо, ойлголтыг тайлбарлах, хэрэглэх чадвартай болох;
- Өөрийн улс үндэсний болон дэлхий дахины өнгөрсөн болон одоог ойлгох, илрүүлэх сонирхолтой, суралцах үйлээ өөрөө удирдан хэрэгжүүлдэг болох;
- Монголоороо бахархдаг, улс, үндэснийхээ эрх ашиг, эх хэл, түүх, соёл, ёс заншлаа эрхэмлэдэг, байгаль орчинтойгоо зохицон амьдрах, түүнийг хайрлан хамгаалах, өвлөн хөгжүүлэх мэдлэг, чадвар, сэтгэлтэй болох;
- Хүн төрөлхтний үнэт зүйлсийг эрхэмлэдэг, ардчиллыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг иргэн болох явдалд туслахад чиглэгдсэн билээ.

Шинжлэн судлах арга барил эзэмших үйл явц нь асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх; үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах; мэдээллийг боловсруулах; үр дүнг хэлэлцэх, шинэ санаа гаргах зэрэг үе шатыг дамжин хэрэгжих учиртай тул та бүхэн тухайн сэдвийг судлахдаа үүнийг сайтар анхаарч хэрэгжүүлээрэй.

*Түүх маш баялаг агуулгатай.* Тиймээс түүний агуулгыг түүхэн он цаг, түүхэн газар нутаг, түүхэн зүтгэлтэн, түүхийн эх сурвалж, түүхэн сургамж гэсэн таван үндсэн ай болгон ангилдаг. Үүнийг суралцахуйн үйл ажиллагаандаа баримжаа болгохыг зөвлөж байна. Мөн та бүхэнд зориулж зарим ухагдахуун, нэр томьёоны утгын тайлбарыг шигтгэн зүүж оруулсан тул түүнийг суралцах явцдаа лавлагаа болгон ашиглаарай.

*Он тоолол түүхийн араг яс нь болдог.* Он цаггүй үйл явдал гэж үгүй. Тэр үеийн Монголын түүхэнд уламжлалт билгийн тооллоос гадна Чингисийн он тоолол (Чингис хаан төрсөн 1162 оноос урагш, хойш тоолно), Манж Чин улсын он тооллыг хэрэглэж байв. Энэ үед дэлхий дахин ч мөн янз бүрийн хуанли хэрэглэж байлаа. Тухайлбал, Юлийн, Григорийн хуанлийг хэрэглэж байжээ. Христийн хуучин тооллоор бол 1493 оноор хуанлийн он дуусч, ертөнцийн төгсгөл болох байв. Гэвч 1493 онд тийм зүйл болсонгүй. Эндээс харин ямар хэрэгцээ шаардлага урган гарсан гэж бодож байна?



2012 оны 12-р сарын 21-нд дэлхий сөнөх тухай цуу яриа хаа сайгүй гарч, хүмүүсийг төөрөлдүүлсэн үйл явдал болсныг та бүхэн санаж байна уу? Үүний учир юунд байв?



XVI зууны сүүлчээр Юлийн тооллын өдөр нь улиралтайгаа зөрөх болжээ. Пап XIII Григорий Италийн математикч Луизи Лилиогийн хуанлийн төслийг хэлэлцээд, 1582 оны 10-р сарын 5-наас хэрэглэх шийдвэр гаргажээ. Түүхэнд Григорийн гэх болсон энэ хуанлийг дэлхий дахин эдүгээ түгээмэл хэрэглэж байна.

*Аливаа түүхэн үйл явдал тодорхой газар нутаг, хил хязгаарт л өрнөдөг.* Ямар нэг газар нутаг дээр болоогүй үйл явдал гэж хаана ч үгүй. Тиймээс аль ч үеийн ямар ч сэдвийг судлахдаа газарзүйн зураг ашиглах, түүхэн газар нутагт тулгуурлан түүхээ судлах нь чухал. Сурах бичигт түүхэн мэдээллийг аль болох газарзүйн зурагт тэмдэглэн оруулж өгөхийг хичээсэн тул газарзүйн зураг дээр сайн ажиллаарай. Шинэ үеийн нэг ололт бол дэлхийн бөмбөрцгийн газарзүйн зураг бий болсон явдал билээ.



Та бүхэн 7-р ангид үзсэн Газарзүйн хичээлээ эргэн санаж, экватор, өргөрөг, уртраг, цагийн голч зэрэг ойлголтууд хэрхэн бий болсныг сэргээн ярилцаарай.

Түүх тодорхой эзэн биетэй. Тухайн түүхэн үйл явдлын цаана гол үүрэг гүйцэтгэсэн, чиглүүлэн залсан, хувь нэмрээ оруулсан түүхэн зүтгэлтэн, хүмүүс заавал байдаг. Тэдний амжилт ололт, алдаа эндлийн аль аль нь түүхийн нэг хэсэг тул бид үүнийг ямагт анхааран судлах учиртай.

Эх сурвалж, баримт бол түүхийн бие махбод юм. Түүнгүйгээр түүх бүтээх боломжгүй. Бид сурвалж бичгүүдэд хадгалагдан үлдсэн мэдээ, мэдээллийг ашиглан өнгөрсөн түүхээ танин мэдэж, судлан сэргээдэг. Тиймээс та бүхэн түүхийн сурвалж баримтыг судлан шинжилж, өөрсдөө түүхийг сэргээн бүтээх мэдлэг, чадвар эзэмшихийг хичээгээрэй.

Түүх судлахын бас нэг утга учир нь өнгөрсөн түүхээсээ суралцах, түүнээс сургамж ухаарал авах явдал билээ. Тиймээс та бүхэн түүхээ судлан шинжлэхдээ үйл явдлын учир шалтгаан, мөн чанар, үр дагаврыг ямагт анхаарч, холбоо хамаарал, бидэнд үлдээсэн сургамжийг аль болох илрүүлж гаргахыг хичээгээрэй. Өнөөдөр тулгамдаж буй асуудлын гарцыг олох, ирээдүйг баримжаалах боломжийг түүх бидэнд олгодог юм шүү.

Энэ үеийн Монголын түүх бидэнд эв эеэ сахихын чухлыг, эрх чөлөө, тусгаар тогтнолын үнэ цэнийг, бусдын эрхшээлд байхын гашуун сургамжийг үлдээсэн билээ.



### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх

XV зуунаас түүхийн шинэ үе эхэлсэн гэж үздэгийн учир юу вэ? Ямар онцгой чухал үйл явдал болсон учраас XV-XX зууны эхэн үеийг бүхэлд нь дэлхийн түүхийн шинэ үе гэж үздэг юм бол? Та бүхэн юу гэж бодож байна? Түүхийн шинэ үе бидэнд юу өвлүүлэн үлдээсэн бэ?

Өчигдөргүй өнөөдөр, өнөөдөргүй маргааш гэж үгүй. Тиймээс өнөөдөр бол өчигдрийн үргэлжлэл, маргаашийн угтал байдаг. Тэгвэл одоо бидний судлах гэж буй үеийн өчигдөр ямар онцлогтой түүхэн үе байсныг сэргээн санаж, өөрийн үзэл бодлыг илэрхийлээрэй. Дунд үеийн түүхэнд монголчууд ямар үүрэг гүйцэтгэсэн бэ? Энэ үеийн дэлхийн түүхийг хэн тодорхойлж байлаа?



7-р ангид үзсэн Түүхийн хичээлээ сэргээн санацгаая. “Монголын зуун”, “Монголын энх амгалан” (Pax Mongolica) гэх ухагдахууны утгыг тайлбарлаарай.



Нэгэн үе дэлхийн бодлого тодорхойлогч байсан монголчууд хаачив? Монгол улс түүхийн тавцангаас бүр мөсөн бууж, алга болсон гэж үү?



XV зуунаас дэлхийн түүхийн шинэ үе эхэлж, XX зууны эхэн хүртэл үргэлжилж, орчин үеийн түүхэнд халаагаа өгсөн байна.

Энэхүү цаг хугацааг та бүхэн өмнөх мэдлэгтээ тулгуурлан хэд дэх мянганд, хэддүгээр жаранд, хэдээс хэдэн онд хамаарахыг тооцож гаргаарай.

Монголын Эзэнт гүрэн задарснаар монголчууд дэлхийг түвшитгэн, эрин үеийнхээ бодлогыг тодорхойлж явсан тэргүүлэх байр сууриа алджээ. Ингэснээр дэлхийн түүхийг, хөгжил дэвшлийг монголчууд, дорныхон тодорхойлохоо больж, өрнөдийнхөн сэргэн мандаж эхлэв.



*Дорно дахин хэсэг хугацаанд хаагдмал, түгжигдмэл байдалд орж, анхаарлын гадна орхигдоход хүрчээ. Энэ юунаас болов? Тунгаан бодож ярилцаарай.*

Гэхдээ Монголын их хаадын бататган тогтоосон дорно-өрнийн хэлхээ холбоо, харилцан хамаарал бүрмөсөн тасалдаагүй юм. Энэ үед дорно болон өрнийнхөн хэрхэн харилцаж байсныг бид судлан мэдэх болно.

Түүхийн шинэ үе хүн төрөлхтөний түүхэнд олон шинэ зүйл, гүнзгий ул мөр үлдээж, өнөө үеийн үндэс суурь чухам энэ үед бүрэлдэж бий болсон юм.

## 2. XV-XX зууны эхэн үеийн Монгол ба Дэлхий дахин

*Эхлээд энэ үеийн Монголын түүхээрээ аялцаагай.*

XV-XX зууны эхэн үе бол Монголчуудын хувьд түүхийн нэгэн шинэ өвөрмөц үе байлаа. Энэ үе бидний хувьд эзэнт гүрэн байхаа больсон ч эх нутагтаа төвлөн оршсон, бас задрал хуваагдал, сулрал доройтлыг туулан, харийн дарангуйлал доор аж төрж ирсэн он жилүүд байв.

Манай ард түмний дунд “Цувж яваа барнаас цуглаж суусан шаазгай дээр”, “Бусдын эрхэнд жаргахаар өөрийн эрхээр зов” гэх хэлц үгс бий. Яагаад ийм хэллэг гарсан юм бол? Эдгээрийн гол утга санаа юу вэ? Та бүхэн тунгаан бодож, задлан шинжилж ярилцаарай.



- 1403 – Ойрадыг Махамуд, Тайван, Батболд нар 3 хэсэг хуваан захирав.
- 1414 – Ойрад, Зүүн Монголын тулалдаанд Мин улс 50 түмэн цэргээр тусалж, Ойрадын эсрэг тулалдаж, Туул гол хүртэл ухраажээ.
- 1449 – Ойрадын Эсэн тайш, Алаг чинсан, Тайсун хаан нар Мин улсыг байлдан, Ин Цзун хааныг олзлов.
- 1450 – Эсэн тайш Ин Цзун хааныг буцааж өгөх талаар хэлэлцээ хийв.
- 1453 – Эсэн Монголын их хаан ширээнд суув.
- 1640 – Тарвагатайн Улаан бураа хэмээх газар Халх, Ойрадын чуулган болж, “Дөчин, дөрвөн хоёрын их цааз” баталжээ.
- 1641 – Хошуудын Төрбайх Төвөдийг эзлэн хаан суув.
- 1648 – Ойрадын Зая бандида Намхайжамц Тод бичиг зохиожээ.
- 1676 – Галдан Зүүнгар улсын хаан ширээнд залрав.
- 1688 – Халх-Ойрадын дайн өрнөв.
- 1696 – Галдан бошогтын цэрэг Манжийн цэрэгтэй Тэрэлжийн Зуу модонд тулалдаж цохигдов.
- 1696 – Францын өдөр тутмын сонинд Монголын тухай, Галдангийн аян дайны тухай мэдээ нийтлэгджээ.
- 1723 – Хөх нуурын монголчууд Манжийн түрэмгийллийн эсрэг зэвсэг барин тэмцжээ.
- 1739 – Зүүнгарын хаант улс, Манж Чин улсын хооронд хилийн хэлэлцээр байгуулжээ.
- 1755 – Манж нар Зүүнгарын хаант улсыг байлдан эзлэхээр довтлов.
- 1755 – Амарсанаа Манжийн түрэмгийллийг эсэргүүцэн бослого гаргажээ
- 1761 – Их хүрээ, Ховдод манж-монгол сайдыг суулгах болжээ.
- 1762 – Ховд хотыг Буянт голын хөвөөнд шилжүүлжээ.

1388-1400 онуудад Монголд таван хаан солигдов.

1410 – Мин улсын хаан өөрийн биеэр 50,000 цэргээр Онон мөрөн хүртэл цөмрөн орж тулалдав.

1455 – Монголын анхны “Бага хаан” Махагургис хаан суув.

1463 – Мандуул хаан суув.

1470 – 7 настай Батмөнхийг Чингис хааны найман цагаан гэрийн өмнө Монголын хаан ширээнд суулгаж, даяарыг эзлэх болтугай гэж Даян цол өргөмжлөв.

1544 – Боди-Алаг хаан суув.

1558 – Түмэн засагт (1539-1593) хаан суув.

1593 – Буян сэцэн (1555 – 1603) хаан болов.

1603 – Лигдэн хаан (1592 – 1634) болов.

1681-1687 - Түшээт хан Байгал нуур, Цөх, Сэлэнгэ голоор Оросууд бэхлэлт барьж суурьших болсныг зогсоохоор удаа дараа цэрэглэн довтлов. Үүгээр Монгол улсын нутаг алдагдаж эхлэв.



Батмөнх даян хаан



Өндөр гэгээн Занабазар

1580 – Одоогийн Архангай аймгийн Цэцэрлэг хотын суурь тавигдав.

1585 – Шарга азарга хэмээх Шанхат уулын ар Тахай нэрт газар Эрдэнэ зуу хийдийг байгуулах ёслол болов.

1608 – Халхын Алтан хан Орос улстай найрамдалт харилцаа тогтоохоор Москвад элч зарав.

1636 – Халхын ноёд Манжийн хааны санд 9 цагааны алба барьж эхлэв.

1639–Халхын ноёд Ширээ цагаан нуур хэмээх газар цугларч, Түшээт хан Гомбодоржийн хөвүүн Занабазарыг Халх Монголын шарын шашны тэргүүн, I Богд Жибзундамба хутагтаар өргөмжлөв.

1662 – Саган Сэцэн “Эрдэнийн товч”-оо туурвив.

1644 – Манж нар Хятадын Мин улсыг эзэлж, нийслэлээ Бээжинд нүүлгэв.

1655 – Манжийн хааны шахалтаар Түшээт хан Чахундорж тэргүүтэй Халхын ноёд хөвгүүд, дүү нараа Манжийн хааны ордонд илгээв.

1686 – Манжийн хааны санаачлагаар Заг, Байдраг голын эх Хүрэн бэлчир гэдэг газар Халхын ноёдын чуулган болов.

1689 - Чин улс, Орос улс хоёр Нэрчүд гэрээ байгуулав.

1691 – Долооннуурын чуулганаар Халх Монгол Манж Чин улсын захиргаанд орсныг албан ёсоор тунхаглажээ.

1727 – Манж, Орос хоёр улс Хиагтад Буурын гэрээг байгуулж, Халх- Оросын хил хязгаарыг тогтоожээ.

1756 – Ар Монголд Хотгойдын Чингүнжаваар толгойлуулсан тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл эхэлжээ.

1789 – Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны хууль зүйлийн бичиг гарчээ.

1861 – Их хүрээнд Оросын консулын газар анх байгуулагдав.

1899 – Их хүрээнд цахилгаан мэдээний газар байгуулагдав.

1900 – Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгийн нутагт алтны уурхай нээн ашиглах “Монголор” гэдэг гадаад улсуудын хувь нийлүүлсэн нийгэмлэг байгуулагджээ.



Лигдэн хаан



МИН

1624 – Хорчин, Дөрвөд, Жалайд, Горлос аймаг Манжид дагаар оржээ.

1626 – Манж нар Лигдэнгийн цэргийг ухруулж Жарууд, Баарин аймгийг довтлон эзлэв.

1627 – Өвөр Халхын 5 отог, Харчин, Найман, Аохан аймгууд Манжид дагаар оров.

1632 – Манжийн хаан Цахарыг довтолж, Лигдэн хаан ялагдаж, Хөх нуурын зүг одов.

1634 – Лигдэн хутагт хаан замдаа Шар тал гэдэг газар өвчнөөр нас барав.

1636 – Өвөр Монголын 16 аймгийн чуулган Мүгдэнд болж Өвөр Монгол Манжид дагаар оров.

1554 – Түмэдийн Алтан хан Хөх хотыг байгуулав.

1559 – Түмэдийн Алтан хан Хөх нуурын монголчуудыг байлдан эзлэв.

1577 – Алтан шарын шашны тэргүүн Содномжамцтай Хөхнуурт уулзав.





- 1492 - Христофер Колумб Карибын тэнгист хүрч, тэндхийн арлуудыг Испаний газар нутаг хэмээн тунхаглав.
- 1494 - Тордесиллийн гэрээгээр Америкийг Испани, Португал хоёр хуваан эзэмших болов.
- 1499 - Америго Веспуччи Өмнөд Америк, Амазоныг нээж, энэ тивийг өөрийн нэрээр нэрлэв.
- 1510 - Анхны Африк боолуудыг Кариб руу авч явав.
- 1519 - Испани Ацтекийн эзэнт гүрэн, Мексикийг эзлэн авав.
- 1636 - Хойд Америк дахь анхны их сургууль Харвард байгуулагдав.
- 1776 - "Тусгаар тогтнолын тунхаг" батлагдаж, АНУ-ыг тунхаглав.
- 1783 - Өмнөд Америкийн чөлөөлөгч Симон Боливар мэндлэв.
- 1787 - АНУ-ын Үндсэн хууль батлагдав. Нэгдсэн улс "Доллар" гэх мөнгөн тэмдэгт гаргав.
- 1861-1865 - Америкийн иргэний дайн. Боолууд эрх чөлөөтэй болов.
- 1867 - Канад тусгаар улс болов.

**Одоо XV-XX зууны эхэн үеийн дэлхийн түүхээр аялцгаая.**



Мартин Лютер (1483-1546)

**XV-XX зууны эхэн үе нь дэлхийн түүхэнд хөгжил дэвшил, өөрчлөлт, шинэчлэлээр дүүрэн, өнөөгийн нийгмийн үндэс суурь бүрэлдсэн үе байсан юм.**



Жорж Вашингтон (1732-1799)



Симон Боливар (1783-1830)




Баско Да Гама (1460-1524)

**XV-XX зууны эхэн үеийн Монголын болон Дэлхийн түүхийн дүр зурагтай танилцаж, агуулгын тойм баримжаа аваарай. Цаашид дэлгэрүүлэн судлахдаа энэ хэсгийг холбон ашиглаарай.**

- 1517** - Германы Мартин Лютер Виттеберг хотын Католик сүмийн үүдэнд ухуулах бичиг нааснаар шашны шинэтгэл эхлэв.
- 1519-1521** - Португалийн Фердинанд Магеллан дэлхийг тойрох анхны аялалыг удирдав.
- 1603** - Англи, Шотланд хоёр нэгдэв.
- 1682** - Агуу Петр Оросын эзэн хаан болов.
- 1710** - Орос улс Балт дахь Шведийн харъяа нутгийг эзлэв.
- 1789** - Францын хувьсгал эхлэв.
- 1848** - Карл Марксын “Коммунист намын тунхаг” хэвлэгдэн гарав.
- 1859** - Чарльз Дарвин Эволюцийн онолоо хэвлүүлэв.
- 1876** - Шотландын багш Александр Белл телефон утас бүтээв.
- 1895** - Италийн Гуггелмо Маркони радио зохион бүтээв.
- 1902** - Мари Кюри, түүний нөхөр Пьер хоёр химийн элемент радийг нээв.

- 1421** - Хятадын Мин улс хүчирхэгжиж, одоогийн Бээжин хотыг нийслэлээ болгов.
- 1453** - Оттоманчууд Константинополийг эзэлснээр Византын эзэнт гүрэн мөхөв.
- 1498** - Португалийн далайчин Васко да Гама Африкаар дамжин Энэтхэгт хүрэв.
- 1556** - Могулын хаан агуу Акбар Энэтхэгийг эрхшээлдээ оруулахаар ирэв.
- 1639** - Япон улс гадныханд хаалттай орон болов.
- 1644** - Мин улс мөхөж, Манж дайчин гүрэн байгуулагдав.
- 1648** - Энэтхэгийн шах Жакхан Таж Махалыг баруулав.
- 1649** - Оросууд Сибирийг эзэлж, Номхон далайд хүрэв.
- 1857** - Энэтхэгт Британий эсрэг бослого дэгдэв.
- 1840-1842** - Хар тамхины 1-р дайн
- 1856-1860** - Хар тамхины 2-р дайн
- 1900** - Чин улс (Манж)-д Боксерын бослого дэгдэв.



Манжийн Энх-Амгалан хаан (1662-1722)

- 1488** - Португалийн далайчин Бартоломей Сайн Итгэлтийн хошууг тойров.
- 1510** - Анхны Африк боолуудыг Кариб руу авч явав.
- 1652** - Нидерландууд Сайн Итгэлтийн хошуунд колонио байгуулав.
- 1795** - Британи Сайн Итгэлтийн хошууг Нидерландуудаас авав.
- 1822** - АНУ Баруун Африк, Либерид эрх чөлөөтэй болсон боолуудаа суулгах болов.

- 1606** - Голландын далайчин Уилльям Женс Австралид анх очив.
- 1642** - Голландын далайчин Абел Тасман Австралиас Шинэ Зеланд хүртэл аялав.
- 1770** - Британий далайчин ахмад Күүк Австралийг Британий өмч гэж тунхаглав. Тэрээр Европд урьд хожид сонсогдож байгаагүй ургамал, амьтдыг олсон юм.
- 1788** - Британий шоронгоос гэмт хэрэгтнүүдийг Австрали руу шилжүүлэв.
- 1826** - Тасманд Британиас шилжин суурьшигчид ба уугуул оршин суугчдын хооронд “Хар дайн” гарав.
- 1840** - Маорикийн гэрээгээр Шинэ Зеланд Британий колони болов.
- 1851** - Австралийн Викториа дахь алтны сургаар Европоос хүмүүс нүүж ирэн, 10 жилийн дотор 500 000 мянгаар нэмэгджээ.
- 1901** - Австрали Британиас тусгаар тогтнов.
- 1907** - Шинэ Зеланд Британиас тусгаар тогтнов.

**Шинэ үеийн түүхийн тулгуур асуудлууд, шинж онцлог**

МОНГОЛЫН ТҮҮХ	ДЭЛХИЙН ТҮҮХ
<p>Энэ үеийн Монголын түүхийн дүр зургийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Дэлхийд ноёлсон Монголын эзэнт гүрний мандал бадрал, их энх амгалангийн үр дүнд Монгол угсаатнууд хөгжин бэхжиж, өнөржин хүчирхэгжсэн</li> <li>• Юань улс унаснаар их төрийн нэгдмэл захиргаа суларч, монголчууд харьцангуй бие даасан шинжтэй хэд хэдэн хэсэгт хуваагдан орших болсон</li> <li>• Монголын их хаад нэгдмэл байдлаа сэргээх оролдлогыг нэг бус удаа хийж байсан</li> <li>• Эв эе алдагдаж, зөрчил тэмцэл даамжирсаар эцэстээ монголчууд эрх чөлөө, тусгаар тогтнолоо алдахад хүрсэн</li> <li>• Монголчууд XVII-XX зууны эхэн хүртэл 156-275 жил харийн эрхшээл дарангуйлал дор аж төрөхөд хүрсэн</li> <li>• Гэсэн хэдий ч энэ үед монголчууд үндэс угсаагаа алдалгүй, төрийн ёс, уламжлалт амьдралын хэв маяг, түүх, хэл, өв соёлоо орхиж гээлгүй хөгжүүлэн баяжуулсаар ирсэн</li> <li>• Монголчууд, монголын газар нутаг хүчирхэг их гүрнүүдийн хараанд өртөж, тал бүрээс тасдан хуваах бодлого хэрэгжиж эхэлсэн зэргийг цохон дурдаж болно. Энэ бүхнийг та бүхэн сурах бичгээ ашиглан судлан шинжилнэ.</li> </ul>	<p>Түүхийн шинэ үеийг тодорхойлох олон чухал өөрчлөлт энэ үеийн дэлхийн түүхэнд гарсан юм. Энэ бол:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Газар зүйн их нээлт</li> <li>• Шашны шинэтгэл</li> <li>• Соён гэгээрэл</li> <li>• Сэргэн мандалт</li> <li>• Аж үйлдвэрийн хувьсгал</li> <li>• Шинжлэх ухааны ололт, нээлтүүд</li> <li>• Аж үйлдвэржсэн нийгэм</li> <li>• Капитализм</li> <li>• Колоничлол зэрэг томоохон үйл явдлууд байлаа. Дэлхийн түүхийг өөрчилсөн эдгээр үйл явдлуудыг бид сонирхон судлах болно.</li> </ul>




XV-XX зууны эхэн үеийн Монголын түүх бидэнд түүхэн ухаарал, сургамж илүүтэй үлдээснээрээ онцлог билээ. Үүний учир юунд орших вэ? Та бүхэн санал бодлоо хуваалцаж ярилцаарай.

Дэлхийн түүхийн шинэ үе хүн төрөлхтний амьдрал, хөгжилд ихээхэн өөрчлөлт авч ирсэн юм.

- Өрнөдөд аж үйлдвэржсэн нийгэм бүрэлдэн тогтсон нь дэлхийн хөгжлийг тодорхойлох болж, өнөөгийн нийгмийн үндэс суурь тавигдав.
- Дэлхий дахины амьдрал, соёлд шинэ дүр төрх, нийтлэг бий болох эхлэл тавигдав.
- Үйлдвэржсэн их гүрнүүд дэлхийг дахин хуваахын төлөө өрсөлдөцгөөв.
- Өрнөдөд гарсан хөгжил дэвшил эргээд дорно дахины улс орнуудад нөлөөлжээ.
- Энэ үеийн дэлхийн түүхийн ололтууд тухайн цаг үедээ төдийгүй өнөөгийн бидний амьдралд үлэмж нөлөө үзүүлсэн хэвээр байна.



Түүний үндэс шалтгаан юу байсан гэж бодож байна? Тунгаан бодоорой. Энэ бүхний учрыг та бүхэн дараа дараагийн бүлэг сэдвүүдийг үзэхдээ шинжлэн судлаарай.



## МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ ДАРААХ МОНГОЛ БА ДЭЛХИЙ ДАХИН

(XV-XVIII зууны дунд үе)

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ МОНГОЛ УЛС НЭГДМЭЛ ХҮЧИРХЭГ БАЙДЛАА АЛДАВ



#### 1. XV-XVII ЗУУНЫ МОНГОЛ УЛС

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
Эзэнт гүрэн задарсан ч Монгол улс эх нутагтаа төвлөн оршиж, төр ёсны түүхээ цааш үргэлжлүүлж ирсэн.	Монголын их эзэнт гүрний дараа Монгол улсын туулсан замнал, бүтэц бүрдэл, онцлог шинж, тэр цаг үеийн төлөв байдал, тулгарсан бэрхшээл, үлдээсэн сургамжийг танин мэдэх.	<ul style="list-style-type: none"> <li>• Улс төрийн зөрчилдөөн</li> <li>• Дөчин түмэн Монгол</li> <li>• Дөрвөн түмэн Ойрад</li> <li>• Зүүн, Баруун Монгол</li> </ul>

**Монгол дахь улс төрийн зөрчилдөөн.** Сурвалжит язгууртнууд эдийн засгийн талаар бэхжиж бие даах чадвартай болохын хэрээр төвлөрсөн удирдлага, хааны захиргаанаас гарахыг эрмэлзэж эхэлсэн байна. Энэ нь төр улсын хүчийг сулруулж, нэгдмэл байдлыг эвдэн, улс орон том, жижиг эзэмшил болон хуваагдахад хүргэдэг ажээ. Улс төрийн ээдрээ зөрчилтэй тийм үе Монголд XIV-XVIII зууны үед тохиожээ.



**Яагаад ийм байдалд хүрэв? Улс төрийн зөрчилдөөний үндэс юу байсан бэ?**

1368 онд Монголын улс төрийн төв эх нутагтаа шилжив. Тэр цагаас монголчууд дорно зүгт Хянган нуруунаас өрнө зүгт Тэнгэр уул хүртэл, умар зүгт Эрчис, Енисейн эхнээс өмнө зүгт Хятадын цагаан хэрэм хүртэлх уугуул нутагтаа төвлөн суух болов. Тиймээс 1368-1634 он хүртэл Монгол улсын төрийг барьсан 22 хааны үеийг “Бага хаадын үе” гэх нь бий. Монголын төр харийн түрэмгийллээс улсынхаа тусгаар тогтнолыг хамгаалах, дотоодын улс төрийн хямралыг зохицуулж аж ахуйгаа сэргээн хөгжүүлэхэд чиглэсэн бодлого явуулсаар иржээ. Ялангуяа төрийн гадаад бодлогод Монгол-Мингийн харилцааны

асуудал анхаарлын төвд байжээ. Монголчууд тэднийг дахин эзэрхэхийн төлөө, Мин улс монголчуудыг хүч суларсан дээр нь эрхшээлдээ оруулахыг эрмэлзэн харилцан тэмцэлдэж байсан нь энэ үеийн онцлог байв.



Тогоонтөмөр хаан цэргийнхээ хүчийг нэгтгэн Хятад орныг дахин эрхшээлдээ оруулахаар хэд хэдэн удаа тулалдсан ч амжилтгүй болжээ. Хятадад Мин улс (1368-1644) байгуулагдаж, Монголын эсрэг тэмцлийг удирдсан Жү Юань Жан, Хун Ү нэрээр хаан өргөмжлөгдөв. Тогоонтөмөр хаан 1370 онд Хятад Монголын хилийн ойр байх Инчан (Өвөр Монголын Хишигтэн аймгийн нутагт байсан) хотод таалал төгсжээ. Их хааныг нас барсны дараа түүний хүү Билэгт (1370-1378), ач хүү Төгстөмөр (1378-1388) нар нийслэл Хархорумд төвлөж, Мин улсын эсрэг удаа дараа довтолсон ч үр дүнд хүрсэнгүй.

*“Монгол улсын Билэгт хаан (Аюуширдар), Тогоонтөмөр ухаант хааны хөвгүүн эцгийн суурийг залгамжлаад, олон монгол аймгийг эзэлж суув. Сууринд есөн жил суугаад нөхчिव. Дүү Усгал (Төгстөмөр) залгамжлав”*

*(Ломи. “Монголын боржигид овгийн түүх”-ээс)*

*“(Хун-Ү-гийн (Мин улсын анхны хааны оны цол)... 13 он (1380 он)-ы хавар цаг жанжин Му Ин их цэрэг толгойлон, Линчжоугаас гараад, Хатан гол гаталж, Хэлань уулыг даван Их говийг туулж явсаар, Хархорумд хүрч байлдав. Тогооч, Айзу (Хархорум хотыг сэргийлэн сахиж байсан монгол цэргийн жанжинууд) нарыг баривчилж, харьяат иргэдийг нь талж, эгэж ирэв”*

*(“Мин улсын түүх”-ээс)*

*Тайлбар: Хархорум хотыг хятадын цэрэг энэ дайнаар үнсэн товрог болгосон юм.*

Монголчуудыг өөрийн харьяанд оруулахын тулд Мин улсын хаан их цэрэг авч хэд хэдэн удаа Монгол руу довтолсон боловч амжилт олсонгүй. Тиймээс түр эвлэрэх бодлого явуулав. Энэ нь шинэхэн байгуулагдсан Мин улсын хүч бэхжээгүйтэй холбоотой байв. Тэд Монгол улстай түр найрамдахаар Тогоонтөмөр хааны олзлогдсон ач хүү Майдарбалыг 1374 онд буцаан өгснөөр хоёр тал хэдэн жилийг тайван өнгөрүүлжээ. Гэвч энэ найрамдал түр зуурынх байлаа.

Тэд хүчээ сэлбэмэгцээ их цэргээр Монголын гүнд нэвтэрч, 1380 онд Хархорум хотыг эвдлэн сүйтгэж шатаажээ. Түүнээс болж Монгол, Мингийн хооронд үргэлжилсэн дайн самуун өрнөв. Ялж, ялагдаж байсан боловч 1388 онд Монгол цэрэг томоохон яладал хүлээж, Төгстөмөр хаан алагджээ. Монголчууд нэгдмэл үедээ Хятадыг давамгайлж, бутарч суларсан үедээ ялагддаг байв.

Монгол жанждын дотор хагарал гарч, Монгол улсын их цэргийн зүүн жигүүрийг удирдаж байсан Нагачу ноён 1389 онд харьяат урианхай нарын хамт Мин улсад дагаж орсон нь байдлыг хүндрүүлэв. Түүний дээр Мин улсын зүгээс монголчуудыг хагалан бутаргах бодлого тууштай явуулсны үр дүнд Монголын эрх баригчдын дунд хагарал гарч, Төгстөмөр хаанаас хойш (1388 оноос) 1400 он хүртэл таван хаан суусан нь бүгд цаг бусаар алагджээ.

Тийнхүү Монгол улсын төрийн эрхийг барьж буй дээд давхаргынхан хямран самуурснаас их хааны эрх захиргаа суларч, улс төрийн гүнзгий хямрал нүүрлэв.



Мин улсын хаан Юн Ло 1409 онд шинэ хаан Буянширийг дайлахаар зуун мянган цэрэг илгээсэн боловч амжилт олсонгүй. Дахин их цэрэг дайчилж, өөрөө удирдан Монголд цөмрөн орж, Онон мөрөнд байсан Буяншир хааныг довтлоход тэрээр Ойрадад зугатан очжээ. Гэвч тэр үед Ойрадыг захирч байсан Махамуд (Батула) түүнийг хөнөөжээ.

Мин улсын хаан Ойрадын ноёдыг ятган Зүүн Монголын Аругтайг цохиход нь тусалжээ. Мин улсын хаан монголчуудын эв нэгдлийг хагалах гэсэн зорилгодоо хүрч чадсан учир Ойрадын ноёдыг өгөөмрөөр шагнав.


Үүний зэрэгцээ Ойрад хүчирхэгжихээс сэргийлж, 1413-1414 онд Махамудын цэрэг Хэрлэнд хүрч ирэхэд Юн Ло хаан өөрийн биеэр цэрэг удирдан ирж, Аругтайд туслан Махамудын цэргийг цохижээ.

Мин улс тийнхүү зүүн, баруун монголчуудын хооронд яс хаяж, хүчийг нь барах, чадвал эзэлж авах, ядвал хүчийг нь өсгөхгүй байх бодлогыг тууштай барьжээ. Тэрхүү бодлогын уршгаар Монгол улсын улс төрийн нэгдэл сулран доройтож, зүүн, баруун монголчууд хоорондоо удтал тэмцэлдэв.



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Монгол-Хятадын харилцаа хурцдах болсон шалтгааныг баримтад тулгуурлан тайлбарлаарай.
2. Улс төрийн зөрчилдөөнд хүргэдэг шалтгааныг жагсаан тодорхойлж, тайлбарлаарай.
3. “Эр бол голыг нь тасал, эм бол үсийг нь самал” хэмээх хэлц үг энэ үед гарсан гэдэг. Үүний утгыг тайлан ярилцаарай.
4. Баримт мэдээлэлд тулгуурлан Зүүн, Баруун Монголын зөрчилдөөнд нөлөөлсөн хүчин зүйлсийг тал бүрээс нь тодорхойлно уу.
5. Энэ үеийн түүхэн үйл явдлууд бидэнд ямар сургамж үлдээснийг хувь хүн, улс орон, бүс нутгийн түвшинд тодорхойлно уу.



**Асуулт, даалгавар гүйцэтгэх**

1. Зураг-1.1-д буй мэдээллүүдийг уншин шинжлээрэй.
2. XVI зууны дунд үеийн Монгол улсын бүтэц бүрдэл, байршлыг зураг болон бүдүүвч ашиглан тодорхойлоорой.
3. Тухайн үеийн Монголын газар нутгийн хилийг өнөөгийн Монгол улсын нутаг дэвсгэртэй харьцуулан үзээрэй.

**Монгол улсын хаад (1370-1634)**



№	Хаадын нэрс	Хаан суусан он	№	Хаадын нэрс	Хаан суусан он
16	Билэгт (Аюушридар)	1370-1378	27	Махагүргис	1454-1465
17	Усгал (Төгстөмөр)	1378-1388	28	Молон хаан	1465-1466
18	Энхзоригт (Есүдар)	1389-1392	29	Мандуул	1472-1467
19	Элбэг нигүүлсэгч	1392-1399	30	Батмөнх	1470-1517
20	Гүнтөмөр	1400-1402	31	Барсболд	1517-1519
21	Үгч хашха	1402	32	Боди Алаг	1519-1547
22	Өлзийтөмөр (Буяншир)	1403-1412	33	Дарайсүн гүдэн	1547-1557
23	Дэлбэг	1415	34	Түмэн засагт	1557-1592
24	Адай	1425-1438	35	Буян сэцэн	1592-1603
25	Тайсун (Тогтобух)	1433-1452	36	Лигдэн хутагт	1604-1634
26	Эсэн	1453-1454			

Тайлбар: Сурвалж бичгүүдэд хаадын төр барьсан он жилийг харилцан адилгүй тэмдэглэсэн байдаг. Тиймээс зарим он цагийг ном бүтээлд өөр өөрөөр тэмдэглэх нь бий.

**Монгол улсын төр, захиргааны бүтэц**



**Тайлбар:** Тайш нь эртнээс хэрэглэж ирсэн төр-цэргийн томоохон албан тушаалтны цол. Батмөнх даян хаан эрх мэдлээ бататгах, ноёдын эрхийг хязгаарлахын тулд тайш цолыг устгаж түүний оронд Жонон гэдэг цолыг бий болгожээ. Энэ цолыг Монгол улс Манжид эзлэгдэх хүртэл хэрэглэсэн.

Монголчуудыг Эзэнт гүрний үед 40 түмэн монгол, 4 түмэн ойрад хэмээдэг байсан бол энэ үед “6 түмэн Монгол, 4 түмэн ойрад” гэж сурвалж бичгүүдэд тэмдэглэх болов.

Монголчууд улс төрийн зөрчилдөөний уршгаар, эхлээд Баруун, Зүүн монгол гэж үндсэн 2 хэсэгт хуваагджээ.

Тухайн үед төрийн эрх барьж байсан хаад Зүүн гурван түмнийг шууд захирч, гол төлөв Халхад, заримдаа Цахарт төвлөн суудаг байв. Баруун гурван түмнийг, хаан ширээ залгамжлах хан хөвгүүн буюу жонон толгойлж, Ордост байрладаг байв. Тэр үед түмэн гэдэг нь 10 000 цэрэг гаргах үүргээ алдаж, засаг захиргааны нэгжийн хувьд том ноёдын эзэмшил гэдэг утгаар хэрэглэгдэх болжээ.

**Дөрвөн Ойрадын хувьд:** XV зууны үед - Цорос, Торгууд, Хошууд; - Хойд, Баатууд, Түмэд; - Барга, Буриад; - Өр Монгол хэмээх дөрвөн хэсгээс бүрдэж байсан ба хожим Цорос, Торгууд, Дөрвөд, Хошууд дөрөв голлох болжээ. Цорос нь Монголын эртний аймгийн хойчис, Торгуудын язгууртнууд нь Хэрэйдийн Ван ханы угсааныхан юм. Хошуудын ноёд нь Хавт Хасарын угсааныхан бөгөөд 1420-иод онд Хянган нурууны баруун талын нутгаас баруунш нүүж иржээ. Хойдын ноёд нь Ойрадын Хутуг бэхийн хойчис юм. Баатууд нь баатар хэмээх үгийн олон тооны хураангуй хэлбэр бөгөөд цэргийн зохион байгуулалтаас үүссэн аймаг болно. Түмэд, Барга, Буриад нэгэн үе Ойрадын бүрэлдэхүүнд мөн багтаж байв. Өр Монгол нь Зүүн Монголоос Ойрадад орж захирагдагсад бололтой.



**Үр дүнг нэгтгэх, танилцуулах**

1. Он тооллын шугамд гол үйл явдлуудыг тооцоолон тэмдэглээрэй.
2. Хаадын үйл хэргийг дүгнэн ярилцсанаа танилцуулаарай.
3. Улс төрийн зөрчилдөөний дотоод, гадаад шалтгаан нь юу байсан бэ?
4. Тухайн үед Монголын хүн ам хэд байсныг баримжаалан тооцоолоорой.
5. Улс төрийн зөрчилдөөний үр дагавар, сургамжийг хэрхэн ойлгосноо тайлбарлаарай.



## 2. НЭГДМЭЛ ХҮЧИРХЭГ БАЙДЛАА СЭРГЭЭХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭЛ

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
Улс орон хүчирхэг оршиход эв нэгдэл, нэгдмэл хүчирхэг төр хамгаас чухал.	Монголын эрх баригчид төр улсынхаа нэгдмэл, хүчирхэг байдлыг сэргээхийг эрмэлзэж, тодорхой оролдлого, алхмууд хийж, үр дүнд хүрч байсан	<ul style="list-style-type: none"> <li>• Эсэн тайш</li> <li>• Даян хаан</li> <li>• Дөчин, дөрвөн хоёр</li> <li>• Түмэн засагт хаан</li> <li>• Баруун, Зүүн Монгол</li> </ul>

**Эсэн тайшийн оролдлого:** XV -XVII зууны үед Монгол улсын нэгдмэл хүчирхэг байдлыг сэргээхийн төлөө тэмцэл нэг бус удаа өрнөж, заримдаа амжилтад хүрч байв. Энэ нь ямар саад бэрхшээлийг туулж, хэрхэн өрнөж байсныг Эсэн тайш, Батмөнх даян хаан, Алтан хан, Түмэн засагт хааны үйл хэрэгт тулгуурлан танилцаарай.



**Монголчуудын нэгдмэл байдлыг сэргээх шаардлага юу байв? Улс төрийн зөрчилдөөнийг зогсоож, хүчирхэгжин нягтарч чадаагүйн шалтгаан юу вэ?**



1440-өөд оны үед төр барьж байсан Тайсун хаан Ойрадын Тогоон тайшийн хүү Эсэнг тайшийн тушаалд томилов. Улс төр, цэргийн хэргийг Эсэн голлон шийдэж, түүний үед монголчуудын хүч богино хугацаанд өсөж, намжмал байдлыг олов. 1451 онд Эсэн тайш Тайсун хааныг довтолсон ба Тайсун Хэрлэнд зугтаж очоод урьдын өшөөт хүнд алагджээ. Энэ үеэс төрийн хэргийг Эсэн тайш мэдэх болов.

*“Тайш манай хязгаар нутагт хоёр удаа халдан, түм буман иргэдийг хорооход, танай харьяат албат нараас амь үрэгдсэн шархадсан нь бас цөөнгүй билээ. Эдүгээ Тайшан хуандийг буцааж, найрамдал хэлэлцсүгэй хэмээн Тайш мэдээлж байна. Чингэвэл Дундад Улс урьд адил мөнгө торго шагнаж, хоёр улс бүгдээр найрамдахаас сайн юм үгүй”*

*Эсэн тайш Мин улсын элч Яншантай 1450 онд хийсэн хэлэлцээнээс (“Мин улсын түүх”-ээс)*

*“...Ойрад баруун гарын Алагтөмөр чинсан, зүүн гарын Хатантөмөр хоёр; Эсэн чи хаан суув. Тайш цолоо манд өг гэв. Чингэхэд тайш өөрийн хөвгүүндээ цолоо өгнө гээд эс өгөв. Тэд өгүүлрүүн: Алагтөмөрийн баатраар Хатантөмөрийн хатуу зоригоор, Автур сэцэний аргаар Ойрад, Монгол хоёрын төрийг авч хаан суув чи. Ганц чиний хүчин билүү? гэж тэд цэрэг хурж, ирж довтолов. Эсэн дутааж гарав. ...Эсэнийг таньж бариад Сорсуны хөвгүүн Бугун барьж алав”*

*(Луесанданзаны “Алтан товч”)-оос*

*Тайлбар: Сорсун бол 1449 онд Эсэн тайш Мин улсын Ин Зүн хааныг олзолсныг Эсэнийн эхэд мэдэгдсэний улмаас цаазлагдсан хүн юм.*

Эсэн тайш хэд хэдэн удаа Мин улсад элч илгээж, эдийн засаг худалдааны харилцаа тогтоохыг оролдсон боловч бүтсэнгүй. Тиймээс 1449 онд Мин улсын эсрэг цэрэглэн довтолжээ. Мин улсын Ин зүн хаан (Тайшан хуанди) өөрийн биеэр цэрэг авч эсэргүүцэн байлдсан боловч ялагдан олзлогдсон байна. Энэ үйл явдлыг түүхэнд тулалдаан болсон газрынх нь нэрээр Түмү-гийн хэрэг гэдэг. Ин зүн-ийг барьцаалан Эсэн тайш Мин улсад улс төрийн шахалт үзүүлсэн боловч тэд Бээжинд шинэ хаан өргөмжлөөд хүлээж авсангүй. Эцэст нь Монгол улс хааныг нь буцааж өгснөөр хэсэг хугацаанд амар тайван болжээ.

Мин улсын зэрэгцээ Дундад Азитай эдийн засгийн харилцаагаа идэвхжүүлэв. Эсэн тайш 1452 онд бүх Монголын хаан ширээнд сууж, нутаг дэвсгэрээ өргөжүүлсэн боловч алтан ургийн хүн биш хэмээн түүнийг хүлээн зөвшөөрсөнгүй. 1455 онд Эсэн хаан алагдаж, түүний дараа арваад жилийн дотор хэд хэдэн хаад солигдож, монголчуудыг нэгтгэх гэсэн эхний оролдлого талаар болжээ.



### Асуулт, даалгавар гүйцэтгэх

1. Эсэн хаан Монголын улс төрийн нэгдмэл байдлыг сэргээж чадсан уу? Тэр ямар бодлого явуулсан бэ?
2. Мин улсын Ин зүн хааныг буцаах тухай хэлэлцээр хэддүгээр жарны хэдэн онд болсныг тооцоолоорой.
3. Эсэн хааны түүхэнд эзлэх байр суурийг баримт мэдээнд тулгуурлан дүгнээрэй.

**Батмөнх даян хааны оролдлого:** XV зууны жараад оны үед төрийн эрхийг барьж байсан Мандуул хаан баруун, зүүн түмнийг нэгтгэхээр тэмцэж байгаад нас баржээ. Түүний дараа хаан ширээний тэмцэл хурцаджээ. Тэрхүү тэмцэлд Мандуулын бага хатан, түүхэнд ухаант сэцэнээрээ алдаршсан Мандухай цэг тавьж Монгол улсын нэгдмэл байдлыг сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

*“Ухаант Мандухай сэцэн хатан унжсан үсээ дээш зөхөж, Улсын эзэн Даян хааныг үхээгэж удирдан мордож дөрвөн Ойрадыг Тас бүрд (одоогийн Завхан аймгийн Алдархаан сумын нутагт буй) дээр довтолж аваад цааз хийж суулгав.*

*(“Шар тууж” сурвалжаас)*



Мандухай сэцэн хатан 1466 онд Батмөнхийг (1466-1504) алтан ургийн бусад ноёдын дэмжлэгтэйгээр хаан ширээнд суулгаж, Даян хаан цол өргөмжлөв. Батмөнх даян хаан нас бага учир хэсэг хугацаанд түүний өмнөөс Мандухай сэцэн хатан төр улсаа чадамгай удирдав.

Мандухай дөрвөн түмэн Ойрадын нэлээд хэсгийг улс төрийн эв зүйгээр талдаа татаж чадсан. Харин Их хаанд захирагдахыг хүсээгүй Ойрадын зарим ноёдыг зэвсгийн хүч хэрэглэн оруулан авчээ. Тэрээр Монгол улсыг бараг бүхэлд нь Батмөнх Даян хааны захиргаан дор нэгтгэв. Тэр үеийг түүхэн сурвалж бичгүүдэд “Гар газар, хөл хөсөр” байсан үе хэмээн тэмдэглэдэг юм.

Батмөнх Даян хаан хөвгүүддээ эзэмшил нутаг хувааж өгснөөр хожим түүний

үр ач нарын үеэс Халх түмэн дотроо Түшээт хан, Сэцэн хан, Засагт хан хэмээн гурван аймаг, долоон хошуу болон хуваагджээ.

*“Даян хаан) Улсболдыг баруун гурванд жонон болгохоор Горлосын Бабахай өрлөгийг дагуулж илгээв. Тэндээс авхай (Улсболд) хүрч, хаан эзний өмнөөс жинон болоод манагаар (маргаааш) эзэнд мөргөө хэмээсэнд Юншээбүүгийн Ибэрэй тайш, Ордосын Мандулай ахлаху хоёр зөвлөлдөн, бид дээрээ ноён авах хэрэг манд юун, өөрийн тэргүүнээ өөрсдөө мэдэж явах буй за. Энэ авхайг эдүгээ тэвчье хэмээлдээд... Ибэрэй, Мандулай хоёр тэргүүлэн хуяглаж ирэхүйе, Хонгирадын баатар Гүрсүн сайн буурал морио (Абхайд) бууж өгөн, улсын зан өөр болов. Харьж өг хэмээн атал, тэсгэлгүй хүрч ирэхэд нь цагаан гэрт хоргодон хатгалдахуйяа Ордосын түмэд Баяалаг хэмээх Ибэрэйн хэнхдэгээр шувт харван, абхай нэгэн хүнийг дэлдэж орхин бүхийд, гэзгийн (арын) хүн нь харваж хороов...”*

*Даян хаан...зүүн гурван түмэн, Авга, Хорчин, Хигээдийг аван мориллов. Төдий баруун гурван түмэн Хааны морилсныг сонсож, Далан тэргүүн дээр угтаж золголдон... Ордосын цэргийн олонх нь үхэв. Төдий баруун гуравны заримууд нь дутааж, заримууд нь орж өгсөнд Даян хаан Хөх нуурыг хүртэл хөөж, гурван түмнийг бүхэл оруулж аваад, Ажины цайдам дээр Ордосын Мандулай ахлаху алснаас хойш Ахлахугийн цайдам хэмээн нэрийдэв. Юншээбүүгийн Ибэрэй тайш ганцаар мунгинан явж цагаан малгайн (хотонгийн) Хамил хотонд орж, хүнд алагджээ. Тэндээс Даян хаан баруун гуравныг бүрэн оруулан зургаан түмэн их улсаа төхөөрөн түвшитгэв”*

*(Саган сэцэн. “Эрдэнийн товч” -оос)*



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Баруун гурван түмэн эсэргүүцэл гаргах болсон шалтгааныг сурвалжийн мэдээнд тулгуурлан шинжлээрэй.
2. Батмөнх, Мандухай нар ямар арга замаар эсэргүүцлийг дарсан вэ?
3. “Мандухай сэцэн хатан” кинонд уг үйл явдлыг хэрхэн үзүүлсэн талаар хэлэлцээрэй.
4. Саган сэцэний “Эрдэнийн товч” сурвалжид буй “харц иргэн эзэнгүй яахин явна” хэмээсэн үгийн утгыг тайлбарлан ярилцаарай. Бусад улсын түүхээс ийм төсөөтэй жишээ олж харьцуулаарай.

*Дарайсун Гүдэн тайж хөх луу жилтэй. Хорин еснийхөө шар бичин (жил) цагаан гэрийн өмнөөс хаан цолыг аван баруун гурван (түмэн) лугаа эе төрөөр барилдан харьж одохуйяа нь Алагийн хоёрдугаар хөвгүүн Алтан угтаж ирээд, ширээний эзэн хаан цолоо аван төрөө төвшитгөө чи. Эдүгээ хааны төрийг хашигч шидао хан хэмээх өчүүхэн хаадын цолыг соёрх. Би их төрийг чинь хашсугай хэмээсэнд хаан зөвшөөрч Алтанд шидао хан цолыг өгөн харьж... (ээ).*

*(Саган сэцэн. “Эрдэнийн товч” -оос)*

**Тайлбар:** Дарайсун бол Боди-Алаг хааны дараа хаан болж, 1548-1557 онд төр барьсан.

XVI зууны эхээр Монгол улс дахин хямарч эхлэв. Түүнийг даван туулахад баруун түмний захирагч жонон, Даян хааны ач хүү **Алтан хан (1507-1582)** чухал үүрэг гүйцэтгэв. Тэрбээр Монголын их төрийн хаан бус Цахар, Түмэд тэргүүтэн өмнөд Монголыг захирсан хан байсан билээ.

Түмэдийн Алтан хан цэрэг улс төрийн талаар хүчирхэгжиж, Ойрад, Хөх нуурыг байлдан эзэлж нөлөөгөө тогтоожээ. Алтан ханы хүч өсөж буйг Мин улс анхааралтай

ажиглаж, түүний худалдаа хийх гэсэн оролдлогыг хүлээж авсангүй. Харин ч 1541 онд Алтан ханы толгойг авчирч өгсөн хүнд их хэмжээний мөнгөн шагнал амлажээ. 1542,1546 онд Алтан ханы Мин улсад илгээсэн элчийг цаазлан хороов. Үүний хариуд Алтан хан хэд хэдэн удаа Мин улсыг довтолж, эцэст нь найрамдлын гэрээ байгуулсан боловч тэр нь удаан үргэлжилсэнгүй.

Алтан хан Түмэдэд тариа тариулан, гар урлал хөгжүүлж, “Байшин” хэмээх хот байгуулсан нь хожим Өвөр Монголын төв Хөх хот болжээ.

“Алтан Хөх хотонд суугаад, Гэгээн хаан хэмээн өргөж, газар газарт байлдан дайлж, Ойрадыг давчилгаад Төвөд улсын янад хязгаар дахь Амдо, Шарай гол аймгийг дагуулав. Бас Мин улсын хязгаар хотыг байлдаж, хот балгасыг давчилахуйд Мин улсын Лун Цин хаан (1567-1573) жил бүр алт, торго хүргэж, Шунь и ван хэмээн цол өргөжээ. Дарайсун хаан сууринд найман жил сууж нөхчив. Хөвгүүн Түмэн засагт залгамжлав”

(Ломи. “Монголын боржигид овгийн түүх”-ээс)

**Тайлбар:** Алтан хан Мин улстай худалдаа хийхийг шаардаж хил хязгаарыг нь түйвээж байсанд Мин улс арга буюу хилийн басар нээж, түүнд 1570 онд «Шунь и ван» гэдэг цол шагнав.



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Түмэдийн Алтан яагаад “шидао хан” цол авахыг Дарайсун хаанаас хүссэн бэ?
2. Алтан хан нутгаа тэлж дайн байлдаан хийж байсны учир юу вэ?
3. Алтан ханы Мин улстай харилцаж байсан бодлогыг сурвалж баримтад тулгуурлан судлан шинжлээрэй.



### Түмэн засагт хааны оролдлого:

Мөн үед Монголын улс төрийн нэгдлийг сэргээх оролдлогыг амжилттай хийсэн хүн бол Дарайсун хааны хүү Түмэн засагт хаан юм. Тэрбээр зүүн, баруун түмнийг эвлэрүүлэх бодлого явуулжээ. Өмнөх зарим хаад, эсэргүүцэл гаргасан баруун түмнийг зохион байгуулалтын хувьд эвдэж, зүүн түмэнд нэгтгэх санал гаргаж байсныг болиулав. Зүүн, баруун түмнийг эвлэрүүлэн нэгдсэн Төв засгийн газрыг байгуулах шийдвэр гаргажээ. Түмэн засагт хаан түмэн тус бүрээс хамгийн нэр хүндтэй нөлөө бүхий хан, ноёдыг оролцуулан “Төв засгийн газар” байгуулав. Түмэн Засагт хааны энэхүү үйл ажиллагааг Халхын Абтай хан, Түмэдийн Алтан хан, Ордосын Хутагтай сэцэн хунтайж нарын зэрэг тухайн үеийн Монголын төрийн томоохон зүтгэлтнүүд сайшаан дэмжжээ. Үүнээс үүдэн тэрээр түүхэнд “Засагт хаан” хэмээн алдаршжээ. Түүний энэ үйл ажиллагаа нь цаг үеэ олсон чухал алхам байсан юм.

“Түмэн тайж сы (шарагчин) гахай жилтэй Ү (шар) морин жил хаан сууж, гучин наймныхаа бин (улаан) хулгана жил илдэн зангидагч Гармаа лам лугаа учралдан шашны хаалганд орж, зургаан түмнийг цуглуулан их цаазыг үүтгээд зүүн түмнээс Цахарын Намуудай хун тайж, Халхын үйзэн Субухай, баруун түмнээс Ордосын Хутагтай цэцэн хун тайж, Асудын Номдар Хулажи ноён,

Түмэдийн Намудай Түрэх хун тайж эднээр засаг байгуулж, Түмэн засагт хаан хэмээн хотол зүгт алдаршиж, арвай их улсын төрийг энх тайван болгоод Зөрчид, Элигүд, Дахигуур гурван хэлтнээс татлага (татвар) аван үлэмж жаргалангаар түмэн амьтныг хангаж, бүрэн гучин таван жил хан суугаад тавин дөрвөйнхөө жэнь (хар) луу жил халивай”

(Саган сэцэн. “Эрдэнийн товч” -оос)



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Түмэн засагт хаан төрийн цааз болон шашны сургаалаар улсыг нэгтгэн хүчирхэгжүүлэх бодлого хэрэгжүүлсний учрыг сурвалж бичгээс тодруулан тайлбарлаарай.



### Үр дүнг нэгтгэх, танилцуулах

1. Монгол улсын нэгдмэл байдлыг сэргээхэд хувь нэмрээ оруулсан түүхэн зүтгэлтнүүдийн бодлого үйл ажиллагааг хүснэгтээр дүгнэн тодорхойлоорой.

Түүхэн зүтгэлтэн	Хэрэгжүүлсэн бодлого	Нийтлэг тал	Ялгаатай тал

2. XVI зуунд болсон түүхэн үйл явдлуудын он цагийг гүйцээн тооцоолоорой.

Аргын он	Монгол жил	Жаран	Монголын түүх, соёлд холбох зарим үйл явдал	Чингисийн он
1507	Улаагчин туулай	1	<b>IX жаран эхлэв.</b> -Түмэдийн Алтан хаан төрөв. /-1583/	346
...	Цагаагчин хонь	5	-Далан тэргүүн хэмээх газар Даян хаан Баруун түмнийг дайлав.	
1512	Хар ...	6	-Барсболдыг баруун түмний жонон болгов.	
...	Шарагчин гахай	...	-Түмэн засагт хаан төрөв. ( -1592)	
..	Цагаан хулгана	...	-Ордосын Хутагтай сэцэн хунтайж төрөв.(-1586)	
1541	Цагаагчин ...	...	-Алтан хаан худалдаа нээхийг хүсэж, Мин улсын хаанд элч илгээв.	
...	Хар бар	...	-Алтан хаан Мин улсад дахин элч илгээв.	
1567	Улаагчин туулай	1	<b>X жаран эхлэв.</b> - Шолой Убаши төрөв. ( -1672)	
...	Цагаан ...	4	-Түмэдийн Алтан хаан Мин улстай гэрээ байгуулав.	
1571	Цагаагчин хонь	...	-Мин улс 4 газраар монголчуудтай худалдаа хийх болов.	
...	Улаан хулгана	...	-Түмэн засагт хаан Төвдөөс улааны шашны Гарма ламыг урьж ирүүлэв.	
...	Шар бар	12	- Алтан хаан III Далай ламыг залж ирүүлэв. -Алтан хаан шашны цааз тогтоов.	
...	Харагчин могой	...	-Түмэн засагт хаан нас барав. (1539- ) -Буян сэцэн хаан болов. (1555-1603)	



### 3. МОНГОЛ УЛС

(XVII-XVIII зууны дунд үе)

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
Нэгдсэн төрийн удирдлага суларч, Монгол улс харилцан хамааралтай хэд хэдэн хэсгээс бүрдэх болсон.	Монгол улс бутарч доройтсон бус харин биеэ даах чадвар нэмэгдэхийн хэрээр дотроо хэд хэдэн харьцангуй бие даасан хэсэгт хуваагдсан. Энэ үеийн Монгол улсын бүтэц, бүрдэл өвөрмөц онцлогтой.	<ul style="list-style-type: none"> <li>• Халх</li> <li>• Цахар</li> <li>• Зүүнгар</li> <li>• Хошууд</li> <li>• Халимаг</li> <li>• Хотгойд</li> </ul>



#### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх

*XV-XVIII зууны үеийн Монголын түүхийг “бутралын үе” гэж нэрлэх нь бий. Энэ үед Монгол улс үнэхээр бутарч сарнисан байсан уу? Ямар учраас ингэж үздэг талаар тунгаан бодож, таамаглал дэвшүүлээрэй.*



Монголын Эзэнт гүрэн задарснаар түүний суурин дээр олон бие даасан улсууд байгуулагдсан байдаг. Тухайлбал, Алтан орд улсаас гэхэд **Казань, Крым, Астрахань, Ногайн орд, Сибирийн** хант улсууд тасран гарчээ. Эдгээр улсууд XV-XVIII зууны үед бүгд Орост нэгдсэн бөгөөд хамгийн сүүлд 1784 онд Крымийн хаант улс **Орост** эзлэгдсэн билээ.

Юань гүрэн унасны дараа Монгол улсын хувьд ч дээрхтэй төстэй нөхцөл байдал бий болж, үйл явдал өрнөснийг бид өмнөх сэдвээр судалсан.

XVII зууны эхэн үед ч Монголчууд хуваагдмал байдалтай аж төрж байв. Үүнд байгаль газар зүйн болон нийгэм түүхийн олон хүчин зүйл нөлөөлжээ. Халх монголчууд Алтай, Хянганы завсарт, харин Ойрад монголчууд Алтайн нуруунаас цааш нутаглаж байсан бол Өвөр монголчууд их элсэн говийн урд бие, Их Хянганы нуруугаар төвлөн сууж байв. Тэдгээр монголчуудыг хооронд нь байгалийн хана хэрэм болох өмнийн их говь, Алтай, Хянганы уул нурууд зааглаж байлаа.



#### Унших, ойлгох, эрж хайх

*Түүхэнд байгаль, газар зүйн хүчин зүйл хэрхэн нөлөөлдөг талаар тунгаан бодож, нотлох, үгүйсгэх жишээ, баримт олохыг хичээгээрэй.*

Энэ үед төрийн нэгдмэл байдал алдагдаж, Халх, Өвөр, Ойрад монголчууд харьцангуй бие даасан шинжтэй орших болжээ. Өөр бие даасан улсууд ч гарч ирсэн байна.



**Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах**

Зураг-1.2-т агуулагдаж буй мэдээллүүдийг шинжлэн судлаарай.



**Өвөр Монголын** 16 аймаг бүхэлдээ их хааны захиргаанд байсан боловч тэдний дунд “төрөөс этгээд явдал” хүчтэй өрнөж байжээ. Энэ үед Монголын сүүлчийн хаан Лигдэн төр барьж байв. Тэрээр эрх хүчээ чангатган, их улсаа нэгтгэн захирахыг эрмэлзэж байсан хэдий ч түүний мэдэл нөлөө суларсаар, сүүлдээ зөвхөн өөрийн мэдлийн 8 отог Цахар түмнийг л захирах хэмжээнд хүрч очжээ. Гэхдээ Лигдэн өөрөө ямар үзэл бодолтой байсныг түүний үгнээс мэдэж болно. Мөн тэрээр идэвхтэй дотоод, гадаад бодлого явуулж байв. Түүний хэрэгжүүлж байсан бодлогыг доор хүснэгтээр үзүүлэв.

Дотоод	Гадаад
<ul style="list-style-type: none"> <li>Цахар түмнийг Монгол уламжлалаар зүүн, төв, баруун гурван түмэн болгоод эв эеэр засан захирах бодлого явуулав.</li> <li>1617 онд Авга хар уул гэдэг газар нийслэл Очир Цагаан хот байгуулав.</li> <li>Хубилай хааны номын цолыг сэргээн хэрэглэв.</li> <li>Төвөдийн Улааны шашны лам Ширваа хутагтыг залж, “Улсын багш” болгов.</li> <li>Бурхан шашны хөлгөн судар 108 боть “Ганжуур”-ыг 33 эрдэмтнээр орчуулуулж, алтан үсгээр бичүүлэн залж, төрийн 3 эрдэнийн нэг болгов.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Мин улстай хэлхээ холбоо тогтоох бодлого баримтлав.</li> <li>1619 онд Мин улсын Гуаннин хотыг довтлон эзлэв.</li> <li>Мин улсаас жил бүр 1000-81000 хүртэл лан мөнгөний татаас авах болов.</li> <li>1619 онд Тиелин даваанд Манжийн цэрэгтэй тулалдаж ялагдав.</li> <li>Лигдэн, Нурхач нар элч солилцон харилцаж байсан боловч 1619 оны эцсээс эвдрэлцэв.</li> <li>Мин улс хилээ нээн худалдаа хийхийг зөвшөөрөв.</li> </ul>

**Халх Монгол** тэр үед дотроо олон отог буюу хошуунд хуваагдсан хоёр гараас бүрдэж байлаа. Халхын ноёд дотроо зөрөлдөөнтэй, мөн Лигдэн хааныг дэмжих, эсэргүүцэх хандлага зэрэгцэн байв. Халх Монгол дотроо Түшээт хан, Сэцэн хан, Засагт хан гэх 3 том хэсгээс бүрдэж, харьцангуй бие даасан шинжтэй оршиж байв.

XVI зууны сүүлээр Ойрад хийгээд Халхын Засагт ханы дундаас бүрэлдэж бий болсон **Хотгойдууд** Гэрсэнз жалайр хун тайжийн жич хүү Шолой Уваш хунтайж (1587-1627)-ийн үеэс бие даасан шинжтэй орших болсон байна. Шолой Уваш 1616 оноос Орост элч илгээн харилцаж эхэлсэн байдаг. Энэ үеэс тэрээр түүхэнд “Алтан хан” гэж алдаршсан юм. Түүний үр удмынхан цаашид Хотгойдуудыг залган захирч, 1694 он хүртэл тусгаар байдалтай оршин тогтножээ.

Ойрад Монголд улс төрийн нөхцөл байдал харьцангуй тогтвортой, тэд “**Дөрвөн Ойрадын холбоо**”-нд нэгдэн тусгаар оршиж, “чуулган” гэх төрийн эрх барих хурлын байгууллагад захирагдаж байлаа. Ойрад монголчуудыг дөрвөн зонхилох аймаг бүрэлдүүлж байсан ба тэдний ихэс ноёдын дунд төвлөрсөн засаглалын төлөө тэмцэл хүчтэй өрнөж байв. Үүний үр дүнд **Зүүнгарын хаант улсын** үндэс суурь тавигдаж, 1676 оноос хүчирхэгжин 1755 оныг хүртэл оршин тогтносон билээ.



Зураг-1.3

XVII зууны сүүл үеийн Монгол.

Ойрадын төрийн эрх зүүнгарын Цорос ноёдын мэдэлд шилжсэнээр Зүүнгарын хаант улсын үндэс суурь тавигджээ. Ойрадын зүүнгар болон Зүүнгарын хаант улсыг:



- Хархул ноёны хүү Эрдэнэбаатар хун тайж - 1635-1653,
- Эрдэнэбаатар хун тайжийн V хүү Сэнгэ - 1653-1670,
- Сэнгийн дүү Галдан бошогт - 1671-1697,
- Сэнгэ хун тайжийн хүү Цэвээнравдан - 1697-1727,
- Цэвээнравдангийн хүү Галданцэрэн - 1727-1745,
- Галданцэрэнгийн дунд хүү Цэвээндоржнамжил - 1745-1749,
- Ахмад хүү Лхамдаржаа - 1749-1752,
- Галдан хааны үр ач Даваач - 1752-1755 онд тус тус хаанчилж байжээ.

1637-1639 онд Зүүнгарын Баатар хун тайж, Хошуудын Төрбайх нар Хөхнуур, Төвөдийг эзлэв. Үүний үр дүнд Гүүш хаан Төрбайхын тэргүүлсэн **Хошууд улс** бий болж, 90 шахам жил оршин тогтносон юм.



*Тэдний үр хойчис өнөөг хүртэл БНХАУ-ын бүрэлдэхүүнд уг нутагтаа аж төрцгөөж байна.*

Тухайн үед Өвөр Монгол, Халх Монгол, Зүүнгар болон бусад монголчууд аль болох хөрш зэргэлдээ улс орнуудтайгаа идэвхтэй харилцах, хэлхээ холбоо тогтоох, өөртөө нэгтгэхэд чиглэгдсэн гадаад бодлого явуулж, улс орныхоо бүрэн эрх, тусгаар тогтнолыг бататган хамгаалахыг эрмэлзэж байв. Гэвч тийм боломж тэр бүр олдохгүй байлаа.

Монголчууд тийнхүү тус тусдаа бие даасан шинжтэйгээр оршин тогтнох болсон хэдий ч хууль цаазаар бодлогоо нэгтгэн, холбоо харилцаагаа зохицуулж, бие биенээ туслан дэмжиж, харилцан хамааралтай зэрэгцэн оршихыг эрмэлзэж байв. Үүний нэг тодорхой илрэл нь Халх, Ойрад, Халимаг, Хошуудын эрх баригч 30 орчим ноёд язгууртнууд 1640 онд Ойрадын нутаг-Тарвагатайн Улаан бураа гэх газар чуулж, хамтран хэлэлцээд, **“Монгол-Ойрадын их цааз”**-ыг батлан гаргасан явдал юм.



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Лигдэн хаан Нурхачид илгээсэн захидалдаа, өөрийгөө “Дөчин түмэн Монголын эзэн” гэж онцолсны учрыг задлан тайлбарлаарай.
2. Сурвалж түүхэнд түүнийг “Цахарын Лигдэн” хэмээдгийн учир юу вэ?
3. Түүхийн эх сурвалжид “Төрөөс этгээд явдал” гэж юуг хэлсэн гэж бодож байна? Тунгаан бодож тайлбарлаарай.
4. Лигдэн хааны явуулж байсан дотоод, гадаад бодлогын зорилго, мөн чанарыг баримт мэдээлэлд тулгуурлан задлан шинжилж тодорхойлоорой.

Дотоод	Гадаад
Зорилго:	Зорилго:
Мөн чанар:	Мөн чанар:



### Үр дүнг нэгтгэх, танилцуулах

1. Монголчуудын хуваагдалд нөлөөлсөн хүчин зүйлсийг хамтран ярилцаж гаргаарай.

Нийгэм, түүхийн хүчин зүйлс	Байгаль, газар зүйн хүчин зүйлс

2. XVII зууны үеийн Өвөр монгол, Халх монгол, Зүүнгар, Хотогойд, Халимаг, Хошууд улсын байршил, газар нутгийг Зураг-1.2, Зураг-1.3-ыг ашиглан тодорхойлоорой.



**Унших, ойлгох, эрж хайх**

**Түүхийг өөрөөр тайлбарлах нь.** Түүхийн зарим асуудлыг түүхчид өөр, өөрийн үзлээр бичиж үлдээх, тайлбарлах явдал гардаг. Энэ нь сурвалж баримт хомс, судалгаа дутмаг, түүх баялаг, олон талтай байдагтай холбоотой юм. Тиймээс та бүхэнд ч түүхийн зарим асуудал, үйл явдлыг өөр өнцгөөс харах, үзэл бодлоо илэрхийлэх боломж бий.

XV-XVIII зууны үеийн Монголын түүхийг, энэ үеийн Монгол улсыг хэрхэн нэрлэх асуудал өнөө хэр түүх судлалд нэг мөр болж тогтоогүй байна. Энэ үеийг судлаачид: “Феодалын бутралын үе”, “Улс төрийн бутралын үе”, “Бага хаадын үе”, “Дөчин, дөрвөн хоёрын үе”, “Монгол улс (XV-XVIII)” гэх зэргээр томъёолж иржээ. Бас “Монголын хаант улсуудын үе”, “Монголын холбоот улсын үе” гэсэн шинэ томъёолол дэвшүүлж ч болох юм. Гэвч энэ бүхний цаана тодорхой үндэслэл, нотолгоо шаардлагатай.

Та бүхэн энэ үеийн түүхээ судлан шинжлэх үндсэн дээр хэрхэн нэрлэх нь тохиромжтой талаар өөрсдийн үзэл бодлыг илэрхийлж, үндэслэл нотолгоо гаргаарай.

**Улс** - Орчин үед доорх шалгуурыг хангаж буй бол улс гэж үздэг зарчим бий. Энэ нь: Нэгд, байнгын хүн ам; хоёрт, тухайлан заагласан нутаг дэвсгэр; гуравт, төр засаг; дөрөвт, бусад улсуудтай харилцаанд орох чадамж болно.

*(Улсуудын эрх үүргийн тухай Монтёвидеоогийн Конвенц. 1-р зүйл, 1933.)*

**Нэгдмэл улс** - Холбооны бус, харин нэгдмэл төрийн байгууламжтай улс.

*Чөлөөт нэвтэрхий толь-Википедиагаас.*

**Хаант засаглал /улс/** - Төрийн засаглалын дээд эрх мэдэл нэг хүний гарт угсаа залгамжлан шилждэг...хугацаагүй бөгөөд насан туршид байна.

*Н.Лүндэндорж. Төрийн онол. УБ., 1997, т.95*

**Холбооны улс** - Хэд хэдэн улсыг нэгтгэсэн төвлөрсөн бус улс төрийн систем. Холбоонд нэгдэж буй улсууд өөрийн улсын мөн чанарыг хадгалсан хэвээр байдаг...

*- Britanica ширээний нэвтэрхий толь. NEPKO. 6-р боть. т.3660.*



**4. XV-XVIII зууны үеийн Монгол улсын гадаад орчин**

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
XV-XVIII зууны үед Монголын гадаад орчинд багагүй өөрчлөлт гарсан	XV-XVIII зууны үед Монголын гадаад орчинд гарсан өөрчлөлт нь Монгол улсын цаашдын хувь заяанд тодорхой нөлөө үзүүлсэн	<ul style="list-style-type: none"> <li>• Мин улс</li> <li>• Орос улс</li> <li>• Төвөд</li> <li>• хожуу Алтан улс</li> <li>• Дундад Ази</li> </ul>

Энэ үед Монгол улсын гадаад орчин амар тайван биш байв. XVII зууны эхэн үед Оросууд баруун Сибирийн ихэнх газар нутгийг эзлэн аваад улмаар Алтай, Байгал, Амур, Зүүн Сибирийн зүг улам бүр түрж байлаа. Монголчууд хойд талаараа Орос улстай шууд хил залган орших болжээ. Зүүн өмнөдөд Манж нар хүчирхэгжиж, өмнөдөд Мин улс доройтож, баруун өмнө Төвөд, баруун талд казах, киргизүүд нутаглаж байв. Орос, Манжийн гадаад бодлого улам идэвхжсэн нь тухайн үеийн Монголын төдийгүй Төв Азийн түүхэнд ээдрээтэй харилцааг бий болгожээ.



**Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх**

*XV зууны үеэс Монгол улсын гадаад орчинд ямар өөрчлөлт гарсан гэж бодож байна? Зураг-1.4-т тулгуурлан тунгаан бодоорой.*





**Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах**

**Манж.** Нурхач (1575-1626) зүрчид, түнгүс угсааны олон аймгийг нэгтгээд 1616 онд **хожуу Алтан улсыг** байгуулж, хаан ширээнд өргөмжлөгджээ. 1618 оноос Мин улсын зүүн хойд хил хязгаарыг уулгалан довтолж эхлэв. Тэд Мин улсад алба төлөхөө больж, хараат байдлаасаа гарсан төдийгүй цэрэг улс төрийн бодлогоо идэвхжүүлэн хөрш зэргэлдээ улс орнууд руугаа уулгалан довтолж болжээ. Тийнхүү хүчирхэг эзэнт гүрэн байгуулагдах эхлэл тавигджээ. 1636 онд Өвөр Монголыг эрхшээлдээ оруулж, Манжийн Абахай хаан өөрийгөө бүх Монголын хаан хэмээн зарлав. 1644 онд Мин улсыг эзэлж, улсаа «Дай Чин улс» гэж нэрлэжээ.



Абахай (1627-1643)



Түүх сударт “Манзшир лам”, “Эцэг Номун хаан” гэж алдаршсан Райчүн Дорждагва анх манж нартай холбогдож, улмаар тэднийг бурхны шашинд оруулах, Мүгдэн хотын архитектурыг хийх ажлыг биечлэн хариуцжээ. Тэрээр, “Манзшир бурхны домогт түүний бодитой орших орон нь Замбутивийн зүүн хойт зүгт бий гэдэг тул зүрчид, түнгүс иргэдийн нэгдлийг анхлан Манзшир бурхны нэрийн эхний үе болох “Манж”, “Манядзу” гэж нэрлэн, улмаар хойч хожмоо хүчирхэгжин мандахын суурийг тавьжээ.

(Мяларайвын саран мэт шавь Райчүн Дорждагвын намтар. *Mongolian Tibetology Series* III. УБ., 2015, т.6-7).

“...Цахар хаан чиний илгээсэн бичигт: дөчин түмэн Монгол улсын эзэн баатар Чингис хаан, мөрний гурван түмэн Манж улсын эзэн гэгээн ханд илгээсэн хэмээн бичжээ. Танай дөчин түмэн Монгол улсын олныг над юунд гайхуулна? Би сонсвол танай их нийслэл хотыг Дай Мин улсын Хун-У хаанд автагдах үед дөчин түмэн монголыг цөм эзэлж, гагцхүү зургаан түмэн буруулан гарсан хэмээн сонссон. Тэрхүү зургаан түмэн монгол цөм чамд үгүй болой. Ордос нэгэн түмэн, арван хоёр Түмэд нэгэн түмэн, Асуд, Юншээбүү, Харчин нэгэн түмэн, тэрхүү Баруун гарын гурван түмэн улс чамд хамаагүй, өвөрчлөн явах улс болой. Эл Зүүн гарын гурван түмэн улс цөм чиний болой. Гурван түмэн улс бүхий атал дөчин түмэн хэмээн эртний үгээр бардамнаж миний улсыг хомс ганцаар гурван түмэн хэмээн доромжлохыг тэнгэр газар үл мэдэх ёс буй, буюу...”

(Нурхачаас 1619 онд Монголын хаан Лигдэнд ирүүлсэн бичгээс)



**Мин улс.** Юань улс унаснаар байгуулагдсан хятадын Мин (1368-1644) улс Төв Азид нөлөөтэй хэвээр байсан боловч хүч чадал нь сулран доройтоод байв. Тэд энэ үед “нүүдэлчдийг нүүдэлчдээр нь цохиулах” Хятадын төрийн уламжлалт бодлогыг явуулсаар байжээ. Мин улс Монголтой худалдаа хийхдээ зөвхөн залуу агт морьд, үржлийн насны гүүгээр хийдэг байв. Мин улсын адууны засгийн бодлого нь монголчуудын цэрэглэх чадварыг бууруулах, адуун сүргийн үржлийн бүтцийг алдагдуулах зорилготой хор уршигтай бодлого байжээ.

“...Харин хил хязгаарыг сахигч олон түшмэлд зарлан мэдэгдэж басар нээлгэн монгол, хятад хүмүүс жил бүр харилцан арилжаалахыг гуйн айлтгана. Жил бүрийн хавар түшмэл бидний элч боомтоор ормогц хугацаа тогтоож төгсмөгц монгол, хятад хүмүүсийг тарааж тус тусыг амар жимэр амьдруулбаас түшмэл миний үр ач нар үеийн үед өршөөл хишигт бишрэн шүтэж аймшиггүй урван тэрслэхгүй болох буйзаа. Хэрэв зөрчигчид гарваас тэнгэрийн гэсгээлтийг амсана”

(“Мин улсын түүх”-ээс)



**Төвөд.** Монголтой хаяа залган оршиж байсан Төвөдүүд XVII зууны эхэн үед дотооддоо шашин улс төрийн бүлэглэлүүдийн хоорондын зөрчилд автагдаад байлаа. Нэн ялангуяа буддын шашны улаан, шарын 2 гол урсгалын хооронд ширүүн тэмцэл өрнөж байв.

*“Улаагчин үхэр жил (1577 онд) Далай лам Содномжамцыг Монголд Түмэдийн Алтан хан залж ирсэн мэдээгээр очиж хилэнц арилгах, буян нэмэх бэлэгт мянган агт тэргүүлэн хатуу зөөлөн эд өргөв. Далай лам... олон авшиг(эрх олох гэсэн утгатай самгарди үг) өршөөгөөд... Абтайг Очирваанийн хувилгаан буй хэмээн Очирай бат Түшээт сайн хан цол соёрхов” (Галдан. “Эрдэнийн эрх”-ээс)*



Монголын баруун урд, баруун талаар Киргиз, Казахын зуутууд, урдуур Моголын их эзэнт гүрэн оршиж байлаа. Дундад Азийн Яркенд, Турфаны захирагч нарын дунд Дорнод Туркестанд ноёрхлоо тогтоохын төлөө тэмцэл өрнөж байв. Ойрад монголчууд тэдний заримыг эрхшээлдээ оруулан захирч байлаа.



**Хаант Орос улс** Сибирийг эзлэн авснаар монголчуудтай нүүр тулав. Түүхэнд “Алтан хан” хэмээн алдаршсан Хотгойдын Шолой Убаш (1567-1627), түүний хүү Омбо-Эрдэнэ хунтайж (1627-1657) нар Оростой найрсаг харилцаатай байв. Оросууд шивээ бэхлэлт барьж суурьших байдлаар Монголын газар нутгийг түрэн эзэлж байлаа. Үүний улмаас газар нутгаа хамгаалан цэрэглэх явдал ч гарч байв. Гэхдээ Монгол улс Орос улстай гол төлөв найрамдалт хөршийн

харилцаатай байхыг эрмэлзэж, тусламж дэмжлэг авах зорилготой харилцаж байв.

Монгол улсын хүч сулран доройтож, төрийн нэгдмэл байдал алдагдсан хэдий ч Мин, Чин, Орос улсын эзлэн дагуулах бодлогыг сөрөн зогсож, төрийн тусгаар тогтнол, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлыг хадгалан хамгаалсаар ирсэн нь энэ үеийн түүхэн гол ололт байв.



### Үр дүнг нэгтгэх, танилцуулах

1. XVII зууны дунд үед Монгол улсын газар нутагт ямар өөрчлөлт орсныг өмнөх үеийн газарзүйн зурагтай харьцуулан гаргана уу.
2. Монгол улсын гадаад орчинд ямар өөрчлөлт гарсныг жишээ баримтад тулгуурлан тайлбарлаарай.
3. Улсуудын хил өөрчлөгдсөн ч нүүдэлчдийн болон суурьшмал иргэншлийн заагт өөрчлөлт орсон уу? Яагаад?
4. Монгол ба бусад улсуудын харилцааны онцлогийг сурвалжуудын мэдээнд тулгуурлан харьцуулан тайлбарлаарай.
5. Монголчууд тусгаар тогтнолоо алдахад ямар гадаад хүчин зүйлс илүү нөлөөлсөн бэ?



## 5. МОНГОЛ УЛС ТУСГААР ТОГТНОЛОО АЛДАВ

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
Монголчууд эв нэгдэлгүй, хүчээ нэгтгэж чадаагүй, дотроо зөрчилдөн тэмцэлдэж байснаас тусгаар тогтнолоо алдсан.	Монголчууд тусгаар тогтнолоо алдан Дай Чин улсад эзлэгдэх болсны учир шалтгаан, Манжийн төрөөс монголчуудыг хэрхэн барьж захирсан, Манжийн эрхшээлийн үеийн түүх монголчууд бидэнд ямар сургамж, ухаарал үлдээсэн зэргийг бид мэддэг байх нь чухал.	<ul style="list-style-type: none"> <li>• Эх орон</li> <li>• Эв нэгдэл</li> <li>• Эрх чөлөө</li> <li>• Тусгаар тогтнол</li> <li>• Харийн эрхшээл</li> </ul>

### 1. Монгол улс тусгаар тогтнолоо алдахын босгонд



#### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх




Лигдэн бол XVII зууны эхэн үеийн Монголын түүхэнд гарсан төр, цэргийн нэрт зүтгэлтэн, Чингисийн алтан ургийн сүүлчийн их хаан байжээ. Монгол улсын тусгаар тогтнолыг хамгаалж үлдэхийн төлөө, Манжийн түрэмгийллийн эсрэг тууштай тэмцсэн зүтгэлтэн юм.



Галдан бошогт (1644-1697) бол Манжийн түрэмгийллийн эсрэг, улс орныхоо тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэгч, шашин, төр, цэргийн нэрт зүтгэлтэн хүн байжээ. Тэрээр Монгол төдийгүй, Төв Азийн түүхэнд өөрийн хувь нэмрийг оруулсан юм.

**Эрдэмтэн судлаачдын үзэл бодол, байр суурьтай танилцаад, асуудал таамаглал дэвшүүлээрэй.**

“...1691 онд Долоон нуур хэмээх газар Манжийн хаан...Халх улсыг Дай Чин улсын жинхэнэ харьяат болгосон тул Монголын Халх улс даруй мөхжээ.... Түүнээс хойш... Зүүнгар улсад хэд хэдэн удаа довтолон байлджээ. Тэдний ард иргэнийг хүйс тэмтрэн хядаж сөнөөсөн зэрэг шалтгаануудаас Монгол улс гэр хэмээх нь ... эвдэрч, цөм Дай Чин улсын албат боол болжээ. Түүний элдэв засаг захиргаа, цааз хууль, ёс суртлыг цөм журамлан дагаж явах болсон амуй...”. (Л.Дэндэв. Манжаас Монголыг эзэрхсэн үеийг илэрхийлсэн хэрэглэгдэхүүн. УБ., 1936, 2007, т. 5-6)

“Түүхэн баримт, үйл явдлуудаас үзэхэд Монгол орон Манжийн колони байсан гэж үзэх үндэслэл онолын түвшинд алга байна.

- Манж нар 1632, 1646, 1697 онд Өвөр Монгол, Халх, Зүүнгарын хаант улсад удаа дараа халдан довтолж байсан боловч энэ нь хүч түрэмгийлсэн интервенцийн гол шинж болох тасралтгүй процессийг өөртөө агуулаагүй...,

- Манж нар Хятадын төрийн системийг уламжлан авсан боловч хятадуудад өөрийн зан заншил, ёс дэглэмээ тулгаж, монголчуудад энэ бүхнийг хүчээр тулгаагүй юм,
- Халх Монгол Манжид дагаар орсны дараа Чин улсын хэмжээнд монгол үндэстнийг манжийн дараа хоёр дахь эрэмбийн үндэстэн хэмээн тооцож, хятад иргэд монголд олноор ирж суурьшихыг цаазлан хорьж байсан юм. Манж нар өөрсдөө ч Монголд бөөнөөрөө ирж суурьшаагүй,
- XVIII зууны дунд үед гарсан бослого дарагдсаны дараа Зүүнгарын хаант улсын хүн амын ихэнх хядагдсаныг эс тооцвол Манжид дагаар орсны дараа Халхад аймаглан устгах, нүүлгэн суулгах, цөлөх, боолын хөдөлмөр эрхлүүлэх зэрэг цэвэр колонийн үйл ажиллагаа явуулаагүй билээ....

Эдгээр шинжийг агуулсан улсыг “Доминион” буюу орчин үед түгээмэл хэрэглэгдэх болсноор нь “dependency” гэж нэрлэдэг. Энэ нь үгчилбэл “хамааралт улс” гэсэн үг болно.... Дээрх бүх шинжүүд Манжийн захиргаан дахь Халх Монгол болон Манжийн эрхшээлээс гарсны дараах үеийн Монгол улсын түүхэн нөхцөл байдалтай тохирч байна... Иймээс Монголын төр Манжаас хамааралтай байсан, Манж Чин улсын доминион байжээ гэсэн дүгнэлтэд хүрч байна...”

(Хэцүү өрөг, уран нүүдэл. Монголын түүхийн сэдвүүд. Ч.Болдбаатар, Д.Мөнх-Очир. УБ.,2011, т. 10-13).



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

Лигдэн хаан өвөг их хаадын номын цолыг хэрэглэж, улсаа урьдын уламжлалаар зохион байгуулж, шинэ нийслэл байгуулан, Төвөдийн Улааны шашны лам Ширваа хутагтыг залж “Улсын багш” болгон, Бурхан шашны хөлгөн судар 108 боть “Ганжуур”-ыг орчуулуулан, алтан үсгээр бичүүлэн залж, төрийн 3 эрдэнийн нэг болгох зэрэг олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байсан билээ.

Лигдэн хаан өөрийгөө “дөчин түмэн Монголын эзэн”; Нурхачийг “мөрөн голын хөвөөнд суух гурван түмнийг захирсан өчүүхэн хан” хэмээн нэрлэж байв. (Лигдэн хааны захидлаас)

“Монголчууд энэ үүлтэй адил, үүл хуралдвал бороо ордог. Монголчууд цуглавал цэрэг болдог. Үүл сарнивал бороо зогсоно. Бид Монголчуудын хүч сарнихыг хүлээж чадвал тэднийг буулган авч чадна”. (Манжийн анхны хаан Нурхачийн хэлсэн үг)

1626 онд Хорчины Ууба тайж тэргүүлэн Манжийн хаанд биеэр бараалхан бэлэг сэлт өргөхөөр ирэхэд Манжийн хаан 10 газрын өмнөөс биеэр угтан авч, Уубад Түшээт хан, Уубагийн ах Түмэнд Дай дархан, дүү Будачид Засагт Дүүрэн цол тус тус шагнаж Уубагийн дүүд төрсөн охиноо гэргий болгон өгч ураг барилджээ.

(Монгол улсын түүх. IV боть. УБ 2003. т.63)

Тайлбар: 1 мод газар= 1,06 км

Энэ үед бусад монголчууд ч тусгаар тогтнолдоо санаа зовниж, тодорхой алхмуудыг хийж байсан юм. Умард зүгээс хаант Орос улс хүч түрэн ирж, Байгал нуур, Цөх, Сэлэнгэ мөрний доод урсгалаар цэргийн бэхлэлт шивээ барин суурших болов. Түшээт хан үүнийг эсэргүүцэж 1681-1687 оны хооронд удаа дараалан цэрэглэн мордож, тэднийг хөөн гаргахыг оролджээ.

1639 онд Халхын ноёд Ширээ Цагаан нуур гэдэг газар чуулж, Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг 5 настайд нь Халх Монголын шарын шашны тэргүүн, анхдугаар Богд Жавзандамба хутагтаар өргөмжилжээ.

Зүүнгарын Эрдэнэбаатар хун тайжийн идэвх санаачилгын үр дүнд 1640 онд Тарвагатайн Улаан бураа хэмээх газар Халх, Ойрад, Хөх нуур, Ижил мөрний

Монголчуудыг төлөөлсөн 28 том ноёд цуглан хамтарсан их чуулган хуралдуулж, цаг үеэ үнэлэн дүгнэж, “Монгол, Ойрадын Их цааз”-ыг баталсан юм. Энэ бол нэгдсэн цааз батлан мөрдөж, эв эеийг эрхэмлэн, хамтын хүчээр аюул заналыг сөрөн зогсох бодлогын шууд илэрхийлэл байлаа.

Ижил болон ялгаатай талыг ажиглаарай.



## 2. Монголчууд тусгаар тогтнолоо алдаа

Өвөр монгол	Халх монгол	Баруун монгол
<p>- 1618 оноос эхлэн Манж нар Монгол, Мин улсын эсрэг жил алгасалгүй довтолн зарим газар орныг эзлэн авчээ.</p> <p>- Манжийн шинэ хаан Абахай /1626-1636/ 1626 оны 2-р сард Хорчин уруу илгээсэн элчийг хорлосон гэдэг шалтгаанаар Цахарыг довтолж түм илүү хүн, мал олзлов. Лигдэн хаан Хорчин руу хариу довтолж ихээхэн хүн, мал олзлон авчээ. Хариуд нь Хорчин, Түмэд, Ордос, Асуд, Юншээбү аймгийнхантай хүч хавсран Лигдэний нийт 43000 их цэргийг бут цохижээ.</p> <p>- 1632 оны 4-р сард Абахай Лигдэнг бүрмөсөн гэнэдүүлэн цохихоор өөрийн биеэр цэрэг удирдан довтолжээ. Манж цэргийн бүрэлдэхүүнд явсан хоёр Монгол цэрэг нууцаар мэдээ хүргэснээр Лигдэн гарз хохирлоос зайлж, Хөх нуурын зүг бууруулан одов. Зам зуураа Ордост байсан Чингисийн онгоны өмнө ёслол үйлдсэнээс гадна онгоныг авч явахыг оролдсон байна.</p> <p>- Лигдэн Хөх нуур явах замдаа 1634 онд Шар тал гэдэг газар цэцэг өвчнөөр нас эцэслэснээр Монгол улс хаангүй, Өвөр Монгол толгойлох эзэнгүй болов.</p> <p>- 1636 онд Өвөр Монголын 16 аймгийн 49 хошууны ноёдын чуулган Мүгдэнд болж, Абахайг Монголын хаан хэмээн хүлээн зөвшөөрснөөр Өвөр Монгол Манжийн эрхшээлд орсон юм.</p>	<p>- 1638 онд Манжийн хаан Халхын 3 ханыг жил бүр 9 цагааны бэлэг барьж байх зарлиг буулгажээ.</p> <p>- Манж Чин улсын зүгээс 1644 онд Мин улсыг эзлэн дагуулсны дараа Халхыг эзлэх аюул нүүрлэн ирэх нь тодорхой болов.</p> <p>- Халхын хаадууд Манжтай найрсаг харилцаа тогтоон хугацаа хожих, энэ сацуу дотоод эв нэгдлээ бэхжүүлэн, харийн түрэмгийллийг эсэргүүцэх бодлого явуулахыг зорив.</p> <p>- Улс төрийн эгзэгтэй хүнд үед Сэцэн хан Шолой 1652 онд, Түшээт хан Гомбодорж 1655 онд насан эцэслэв. Тэдний орыг Норов, Чахундорж нар залгамжилжээ. Шинэ залуу хангууд улс төрийн туршлага нимгэн, алсын хараа дутмаг байснаас зарим үед эсрэг этгээддээ ашиглагдах, барьц боломж олгох явдал гарч байжээ.</p> <p>- 1655 онд Түшээт хан Чахундорж өөрийн дүүгээ Манжийн хааны ордонд барьцаанд илгээжээ.</p> <p>- XVII зууны II хагасаас Халхын дотоод байдал улам хурцдав. Засагт хан аймагт хан ширээний төлөө тэмцэл өрнөж, улмаар харьяат нарын асуудлаас болж Засагт хан, Түшээт хан нар хоорондоо эвдрэлцэхэд хүрчээ.</p> <p>- Халхын дотоод дахь энэ зөрчил даамжирч, Халх, Ойрадыг хамран өргөжжээ.</p> <p>- 1691 оны 5-р сард Долоон нуурт Манжийн Энх-Амгалан хаан Халхын 550-иад ноёд тайж нар, Өвөр Монголын 49 хошууны нөлөө бүхий ноёдын чуулганыг сүрлэгээр зохион байгуулж, уг чуулганаар Халх Монголыг Манж Дай Чин улсын харьяанд орсныг албан ёсоор тунхаглан зарлажээ.</p>	<p>- 1653 онд Эрдэнэбаатар хун тайжийг нас барсны дараа түүний хүү Сэнгэ, улмаар Галдан 1671 онд ширээ залгамжилжээ.</p> <p>- Галдан 1676 он гэхэд Ойрад монголчуудаа бүхэлд нь хураан нэгтгэж, Зүүнгарыг нэгдмэл хүчирхэг улс болгов.</p> <p>- Халх Монголыг эзлэх гэсэн Манжийн бодлого далдуур хэрэгжин, Халх, Ойрадын хүчийг нэгтгэх бодлого, “Их цааз”-ын үзэл санаа зөрчигдөх болов.</p> <p>- 1688 онд Галдан бошогт цэргийн хүчээр Халхад довтолн оржээ.</p> <p>- Дай Чин улс Галданг дарсныхаа дараа Зүүнгарын хаант улсыг эзлэхийн тулд дотор нь хагаралдуулан эвдрэлцүүлж, хүчийг нь сарниулахыг хичээж байлаа.</p> <p>- Зүүнгарын төрийг барьж байсан Цэвээнравдан /1697-1727/, Галданцэрэн /1727-1745/ хаадын хүчтэй хариу бодлого, эсэргүүцэл, тэдний хүч чадал тийм боломж олгохгүй байсан юм.</p> <p>- Галданцэрэн хааныг тэнгэрт хальсаны дараа дотооддоо эвдрэн зөрчилдөж, урьдын хүчирхэг нэгдмэл байдлаа алдахад хүрчээ.</p> <p>- Энэ сацуу Манжийн хаан Өвөр монгол, Халхаас цэрэг, хөсөг, хүнсний үлэмж нөөцийг дайчлан татаж, Зүүнгарын хаант улсын эсрэг довтолжээ.</p> <p>- Зүүнгарын сүүлчийн хаан Даваач 1755 оны 6-р сард 7000 орчим цэрэгтэйгээр Хашин нуурын дэргэд Манжийн их цэргийг хориглон байлдсан боловч давуу хүчинд цохигдон ялагджээ. Төдөлгүй 1755 оны 7-р сард Даваачийг барьж Бээжинд хүргүүлснээр Зүүнгарын газар нутгийг Манжийн цэрэг эзлэн авав. Гэвч үүгээр Зүүнгар мөхөөгүй юм.</p>

**Тайлбар:** Ном бүтээлд “Долоннуур” гэж бичиж хэвшсэн түүхэн газрын нэр нь угтаа “Долооннуур” болно.



Дэлхий дахинд: Манжийн Кан Си (Энх-Амгалан) хаан, Зүүнгарын хаан Галдан нарын дайн тулааны тухай мэдээ 1696 онд Францын Парис хотын сонинд хэвлэгдэж байжээ. Үүнээс ямар дүгнэлт хийж болох вэ?

(Монгол улсын түүх. IV боть. УБ., 2003, т.134)



**Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх**

1. Монголын хаан Лигдэн Манж нарыг хэрхэн үнэлж байсныг сурвалжид үндэслэн тайлбарлаарай.
2. Манжийн хаан Нурхач монголчуудыг хэрхэн үнэлж байсныг сурвалжид үндэслэн тайлбарлаарай.
3. Хорчины Ууба тайж нарыг Манжийн хаан 10 мод газрын өмнөөс угтан авсны учир юу вэ? 10 мод газрын хэмжээг тооцож гаргаарай.
4. Лигдэн өвөг хаадын цолыг авч, Ширвааг улсын багшаар өргөмжилсний учир шалтгаан юу вэ?
5. Халх Монгол шашны тэргүүн өргөмжилсний цаад шалтгаан юу байв?
6. Монгол ноёд олон талаас, хол зам туулан ирж, хамтран чуулаад “Их цааз” батлан гаргасны шалтгаан, мөн чанар юунд орших вэ?



**Үр дүнг нэгтгэх, танилцуулах**

Монголчуудыг бүхэлд нь эзлэн авахын тулд манж нар хэдэн жил зарцуулсан бэ?	Монголчуудын манжийн түрэмгийллийн эсрэг явуулсан бодлогын нийтлэг талыг олж, тайлбарлаарай.	Монголчуудыг эв нэгдэлгүй болгож байсан зүйл юу байв? Түүний шалтгаан, үр дагавар юу вэ? хэлэлцээрэй	Өнөөдөр бид энэ түүхээс ямар сургамж, ухаарал авах ёстой вэ?

Эрх мэдлийн төлөө тэмцэл үү?, Монголчуудын хүч суларснаас уу?, Хувийн эрх ашиг чухал уу?, Улс орны эрх ашиг эрхэм үү? Өөрсдийн үзэл бодлыг илэрхийлээрэй.



**Өөрийгөө үнэлээрэй**

1. Түлхүүр үгийн утгыг тайлбарлаарай
  2. Баримт мэдээнд тулгуурлан, анх өөрийн дэвшүүлсэн таамаглал болон
    - Эх орон
    - Эрх чөлөө
    - Харийн эрхшээл
    - Эв нэгдэл
    - Тусгаар тогтнол
- эрдэмтдийн үзэл саналыг тодорхой үндэслэл нотолгоо гарган батлах буюу няцаана уу.
3. Монголчууд Манжид эзлэгдсэн шалтгааныг тайлбарлаарай.
  4. "Монголчууд бидэнд үлдээсэн сургамж" сэдвээр эргэцүүлэмж бичээрэй.



## 6. XV-ХУИИ ЗУУНЫ ҮЕИЙН МОНГОЛЧУУДЫН АМЬДРАЛ, СОЁЛ

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
Монголчууд нүүдлийн соёл иргэншлийг бий болгож, түүнийгээ үеэс үед өвлүүлэн хөгжүүлж ирсэн. Энэ бол монголчуудыг бусад улс үндэстнээс ялгаруулж өгдөг нэг гол үнэт зүйл мөн.	Монголчууд уламжлалт нүүдлийн сонгодог мал аж ахуй эрхлэн аж төрж, түүндээ зохицсон өөрийн өвөрмөц өв соёлыг бий болгосон. Монголчуудын амьдрал, соёл түүхийн бүхий л цаг үед баяжин хөгжсөөр ирсэн.	<ul style="list-style-type: none"> <li>• Амьдралын хэв маяг</li> <li>• Эрхлэх аж ахуй</li> <li>• Бичиг үсэг</li> <li>• Урлаг, соёл</li> <li>• Өв уламжлал</li> <li>• Шашин шүтлэг</li> </ul>



### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх


*XV-XVIII зууны үеийн монголчууд хэрхэн амьдарч байв? Цогт тайж кинонд тэр үеийн Монголчуудын ахуй амьдрал, дүр төрхийг хэрхэн дүрслэн гаргасныг сэргээн санаарай. Энэ үед монголчуудын амьдрал соёлд ямар нэгэн өөрчлөлт орсон эсэх талаар асуулт таамаглал дэвшүүлээрэй. Гаргасан таамаглалаа батлах, няцаахад та бүхэнд ямар мэдээлэл хэрэгтэй байна?*

**Монголчуудын аж амьдралын** дүр зургийг гаргахын тулд гэр орон, хувцас хунар, эрхлэх аж ахуйд тулгуурлан судалцаая.

#### Түүхийн баримт – 1

Абтай сайн ханы өргөө нь гадна талаасаа Монголчуудын ердийн гэр зөвхөн тоглоом шиг харагдахаар тийм гайхалтай том ажээ. Абтай өргөөнд 300 хүн багтдаг байсан.

Монголчууд бургасыг “монгол мод” хэмээн нэрлэнэ. Яагаад ингэж нэрлэх болсон юм бол?






### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

Тэр үед монголчуудын уламжлалт аж ахуйд онцын өөрчлөлт гарсангүй. Тиймээс монгол айлын амьдрал, аж байдал урьдын хэвээр үргэлжилж иржээ. Үндсэн орон байр нь эсгий гэр хэвээр байсан боловч XVI зууны үед гэрийн төрх, хэлбэр, хэмжээ эрт дундад үеийнхээс нилээд өөрчлөгдөж, бараг одоогийн төрхөө олсон байна. Тухайлбал, гэрийн тооно авсаархан болж, нүүх, тээвэрлэхэд улам тохиромжтой болжээ. Хананын толгой нэмэгдэж, цамхраат тооно бий болж, гэрийн төрх хэлбэрт өөрчлөлт оржээ. Мөн үүний зэрэгцээ ядуу ардууд цээж гэр, хатгуур гэр, овоохой, шовоохой зэрэг орон сууцыг мөн хэрэглэж байв. Гэрийн модыг голдуу бургасаар хийнэ.

XVI зууны үеэс эхлэн хаад ноёдын дунд том хэмжээтэй өргөө гэр дэлгэрчээ. Монгол хаад найм, арван таван ханатай (тэрэмтэй) их өргөөтэй байсан тухай мэдээ байдаг. Ийм өргөө байсныг Абатай сайн ханы баруун өргөө нотлон харуулдаг.

Монголчууд бид жилийн дөрвөн улирал, аж байдалдаа гайхалтай зохицсон үндэсний гоёмсог дээл, хувцастай ард түмэн.



Зураг-1.5



Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум. Бухын хошууны булшнаас олдсон дундад үеийн Монгол язгууртны дээл, түүнийг сэргээн зурсан байдал. (Талын морьтон дайчдын өв соёл. Ред. Ц.Төрбат, У.Эрдэнэбат. УБ., 2014, т.122, 133).

“Тэд сайн морийг бусад малаас тун илүү хайрлана...эрт оройгүй арчлан тэжээж, дэл сүүлийг засан арчилдаг нь тун хэцүү болой. Энгийн хэрэгт унахгүй, гагцхүү сайн бордож байгаад ан гөрөө хийх буюу дайн байлдаанд сая унана. Аливаа агт намрын эцэс болоход цөм таргалах тул энэ үед дэндүү давхиулбаас агт даруй үхнэ. Тэр нь хатуужаагүйн учир болой. Иймд сайн морийг сонгон авч сорьдог арга байжээ. Өдөрт хорь гучин газар давхиулж жаахан хөлс гаргаж түүний өмнө хоёр хөлийг нь тушиж, үсэрч харайлгалгүй бас уяад сайн идүүлж сургахгүй өдөр бүр үдээс хойш болтол, эсвэл оройгоос үүр цайтал уясны хойно бэлчээрт тавина. Дараа өдөр нь мөн ингэж сорих зэргээр тав гурван өдөр буюу есөн өдөр болсны хойно агтны тарга нь зоо нуруундаа хурж гэдэс багасаж чанга болоод, ууц нуруу их бөгөөд чийрэг болно. Манайд нанхиад хүн сорих аргыг мэдэхгүй байн байн тарган морийг хол замд унаж арваас есийг үхүүлдэг байна. Морь тарган бөгөөд чийрэг сайн байна. Морь

*гэж арчлахгүй бол хэрэггүй болой. Тэд бол энгийн хэрэгт, ан гөрөө хийхэд цөм морь унадаг тул үргэлж оролдсоор арчилж тэжээх аргыг олсон байна”*

*(Г.Сүхбаатар, Л.Жамсран “Монголын түүхийн дээж бичиг”)*

XV-XVIII зууны үед монголчууд урьдын адил мал аж ахуй эрхлэн, ус, бэлчээр даган жилийн дөрвөн улиралд нүүдэллэн аж төрцгөөж байв. Бидний өвөг дээдэс байгальтайгаа зохицон амьдарч, эх дэлхийгээ хайрлан хамгаалж, од гариг, тэнгэр хангайгаа ажиглан, цаг уурын өөрчлөлтийг таньж мэддэг арга туршлагаа улам арвижуулж ирсэн байна.

Малаас гарах мах, сүү, арьс, ноосоо боловсруулж, өөрсдийн хэрэгцээгээ хангаж байв. Малын түүхий эдээр ахуйн хэрэгцээний бүхий л зүйлээ хийж чаддаг байлаа.

Орхон, Сэлэнгэ, Туул, Ховд зэрэг гол усны саваар нутаглагчид бага зэрэг тариалан эрхэлдэг байв. Гэвч байгаль цаг уурын эрс тэс байдлаас шалтгаалж, их ургац авч чаддаггүй байлаа.

Ан гөрөө Монголчуудын амьжиргааны чухал хэсэг байсаар ирсэн юм. Өмнөх үеийнх шиг олон хүн оролцсон ав хомрого хийх нь багассан ч хувийн гөрөөлөл буюу хайдаг ав түгээмэл байлаа.

**Монголчуудын оюуны соёлын хөгжил.** Монголчуудын оюуны соёл, бичгийн боловсролын уламжлал аль ч үед тасалдаж байгаагүй билээ. Монгол хүүхдүүдийн сургалт, боловсролын үндэс нь уламжлалт гэрийн сургууль байв.

Түмэн засагт хаан, Алтан хан нарын үеэс эртний Энэтхэг, Төвөдийн шашны ном судрыг монголчлох уламжлал сэргэжээ. Шашны ном судар орчуулах ажил Лигдэн хааны үед үлэмж амжилт олжээ. Монголын 35 хэлмэрч Гунгаа-Одсэрийн удирдлагаар “Ганжуур” хэмээх буддын шашны хөлгөн судрыг орчуулах ажлыг хийж, 113 ботиор, алт мөнгөөр бичиж гаргажээ.

Мин улс Монголын хаадад бичиг захидал илгээхдээ монгол хэл, бичгээр бичиж байсан ба монгол хаад ч хариу илгээхдээ мөн тэдний хэл, бичгийг хэрэглэж байв.

1587 онд Аюуш гүүш Энэтхэг, Төвөд үгийг монгол бичгээр галиглах галиг үсэг буюу “Али гали” үсгийг зохиожээ. Ийнхүү шинэ галиг үсэг зохиосон нь шашин дэлгэрсэнтэй холбоотойгоор харь хэлний үг монгол хэлэнд олноор орж ирж, түүнийг жигдлэх шаардлага үүссэнтэй холбоотой юм.

1648 онд Ойрадын Зая бандид Намхайжамц монгол бичгийг ярианы хэлтэй ойртуулах, төвөд ба санскрит үгийг хялбар бичих зорилгоор “Тод үсэг”-ийг зохиожээ.



*Зая бандид  
Намхайжамц*

Анхдугаар богд Жавзандамба буюу Өндөр гэгээн Занабазар (1635-1723) бол тухайн үеийн Монголын шашин, соёлын нэрт зүтгэлтэн байв.

1686 онд Өндөр гэгээн Занабазар соёмбо үсэг зохиожээ. Түүний бүтээл туурвилыг сэргэн мандлын үеийн урлагийн сор бүтээлүүдтэй эн тэнцэнэ хэмээн



Өндөр гэгээн  
Занабазар

үнэлдэг .

Мөн түүнчлэн энэ үед Монголын эрдэмтэн мэргэд түүх, хэл, улс төр, хууль цаазын холбогдолтой олон зохиол бүтээл туурвижээ. “Алтан товч”, “Шар тууж”, “Эрдэнийн товч”, “Алтан хааны тууж” зэрэг олон түүх шастир гарчээ.

Уран зохиолд дотоодын дайн дажныг эсэргүүцсэн, нэгдэл нягтрал, энх амгалан амьдрал, сайн сайхныг мөрөөдөн уриалсан утга санаа голлосон зохиолууд гарч байв. Жангар, Тогоонтөмөр хааны гэмшил, Мандухай хатны домог, Даян хааны харьяат зургаан түмэн монголчуудын магтаал, Убаши хунтайжийн тууж зэргээс үүнийг харж болно. Тэр үеийн Монголын өндөр боловсролтой түүхэн зүтгэлтний нэг нь Халхын Цогт хун тайж юм.



Цогтын хадны бичиг

Энэ бүхэн монголчуудын соёлын хөгжил, хэл, бичиг үсгийн боловсрол ямар өндөр түвшинд байсныг илтгэн харуулна.



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

“Монголчууд бичиг үсэгтэй хүмүүсээ багш гэж дуудна. Үсэг бичиг сурагчдыг шавь гэдэг. Шавь хүн багшаас сурахдаа юуны өмнө хониор бэлэг барьж мөргөж ёслох бөгөөд өдөр болгон багштайгаа учрахдаа бас мөргөх хэрэгтэй.. Эгэл ард үсэг бичигтэй бол ноёдыг дагаж энгийн ардаас дээгүүр нэг зэрэгт хүрдэг тул монголчуудын дунд багш хүн их хүндтэй юм. Хууль журмын тогтоолоор бол багш хүнийг гутааж доромжлогчид нь багшид нэг морь өгөх ёстой. Урьдын цагт аймаг бүрт хэдхэн багш байсан бол эдүгээ алба үзээд бурхан шашныг шүтэх болсноор багшийн тоо нилээд олширов. Урьд модон самбар буюу арьсан дээр бичиг бичдэг байсан бол ойрд алба үзэх болсноос хойш удаа бүр бийр, цаасны зүйлүүдийг өгдөг. Гэвч цаасыг өргөдөл бичиг бичихэд хэрэглэхээс биш сурах ард мөн модон самбарыг хэрэглэнэ.

(Г.Сүхбаатар, Л.Жамсран. “Монголын түүхийн дээж бичиг”)

“Монголчууд бурхан шашныг эрхэмлэдэг болж, гэр дотроо ердөө бурхны хөргийг тахиж тавиад, идэж уухдаа дээжий нь өргөж, гарч орохдоо наминчлан мөргөдөг. Баячууд нь зориуд сүм хийд байгуулаад бурхан шүтээн тахиж, өдөр бүр лам хувраг залаад ном уншуулж, хүж асаан мөргөдөг билээ. Бас эрэгтэй, эмэгтэй, хөгшин гэж үгүй заримдаа гараасаа эрхи салгахгүй явна. Жич алт буюу мөнгөөр хоёр гурав ямх хэмжээний хайрцаг/гуу/ үйлдэж, түүндээ сахиусаа хийж, сугандаа зүүгээд унтах, хэвтэх, идэх уухдаа биеэсээ салгаж авдаггүй”

(Г.Сүхбаатар, Л.Жамсран. “Монголын түүхийн дээж бичиг”)



**Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх**

1. Монголчууд өнөөг хүртэл гэрээ орхилгүй хэрэглэсээр ирсний учир шалтгааныг тунгаан бодож тайлбарлаарай.
2. Булш оршуулгаас гарсан дээлний олдворыг судлан шинжилж, тал бүрээс нь дүгнэн тодорхойлж бичнэ үү.
3. Монголчууд яагаад адуу илүү өсгөдөг байв?.
4. Сурвалжид өгүүлэн буй Монголчуудын морио арчилж, эдлэх арга ухаан өнөө үед хэрхэн өөрчлөгдсөн бэ? Таамаглал дэвшүүлж ярилцаарай.
5. Хүснэгтийн дагуу ажиллаж соёлын хөгжлийн гол үр дүнг чиглэлийн дагуу тодорхойлоорой.

Соёлын ололт	Хэзээ?	Хэн, юу хийв?	Шалтгаан	Үр дүн юу байв?



Зураг-1.6

6. Эдгээр эд өлгийн сурвалж тухайн үеийн монголчуудын амьдрал, соёлд хэрхэн холбогдохыг дүгнэн тодорхойлоорой. Энэ дурсгал юугаараа үнэ цэнтэй болохыг нотлон тайлбарлаарай.



**Үр дүнг нэгтгэх, танилцуулах**

1. Түлхүүр үг тус бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Амьдралын хэв маяг
- Эрхлэх аж ахуй
- Бичиг үсэг
- Урлаг, соёл
- Өв уламжлал
- Шашин шүтлэг

2. Дээрх баримт мэдээлэл болон бусад эх сурвалж ашиглан нэгтгэн дүгнээрэй.

Тухайн үеийн монголчуудын амьдрал, соёлыг өнөө үетэй харьцуулбал:				
Аж ахуй	Боловсрол	Орон сууц	Хувцас хэрэглэл	Шашин

## ХОЁРДУГААР БҮЛЭГ ДЭЛХИЙН ТҮҮХИЙН ШИНЭ ҮЕ ЭХЭЛЛЭЭ



### 1. ГАЗАРЗҮЙН ИХ НЭЭЛТ, КОЛОНИЧЛОЛЫН ЭХЛЭЛ

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
XV-XVI зуунд дэлхийн түүхийг өөрчилсөн нэг том үйл явдал болсон нь газарзүйн их нээлт байв.	Газарзүйн их нээлт дэлхийн түүхийн шинэ үеийн эхлэлийг тавьж, олон түүхэн өөрчлөлтийг араасаа дагуулсан юм.	<ul style="list-style-type: none"> <li>• Хөлөг онгоц,</li> <li>• Далайн аялал,</li> <li>• Худалдааны шинэ зам,</li> <li>• Колумб, Магеллан,</li> <li>• Гама, Америго Веспуччи</li> </ul>

#### Газарзүйн их нээлтийн урьдач нөхцөл юу байв?



#### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх

XV зуунд Европт хүн ам өсөж, үйлдвэрлэл худалдаа хөгжиж, зах зээлд Итали, Франц, Португали, Испанийн худалдаачид гол үүрэг гүйцэтгэж байв. Европчууд дорно дахины улсуудаас худалдан авах халуун ногоо, гоёл чимэглэл, шаазан, торго, ваар, сав эдлэл зэрэг бараа таваарыг өргөн хэрэглэх болсны зэрэгцээ арилжаа худалдааны явцад газарзүйн мэдлэг ихэд хөгжжээ.

*Европын улс орнуудад далайн шинэ зам эрж олох шаардлага тулгарав. Үүнд Испани, Португали гол үүрэг гүйцэтгэсэн байна. Яагаад?*



Газар дундын тэнгисийн худалдаа хямралд орж европ барааны үнэ хямдарсан тул Европт үнэт металын хомсдол бий болжээ.

Энэтхэг хүрэх Улаан тэнгисийн замыг Арабчууд мэдэлдээ авсан тул нэг бол европчууд их хэмжээний алтны нөөцтэй болж ашигтай худалдаа хийх, эсвэл Энэтхэг хүрэх далайн шинэ зам эрж олох хэрэгтэй болов. Газарзүйн байршлын давуу тал болон Энэтхэг хүрэх далайн замыг нээх гэсэн тэдний бодлого зэрэг нь Испани, Португалийн далайчдыг газарзүйн их нээлтүүдийг хийхэд хөтөлжээ.



- Португаличууд хөнгөн залагддаг, хурд, багтаамж сайтай, салхины эсрэг явах боломжтой олон далбаат “каравелла” хөлөг онгоц шинээр бүтээв.
- XV зууны үед Европын далайчид луужинг газрын зурагтай хэрэглэх болсон нь том амжилт байлаа.




#### Асуулт, даалгавар гүйцэтгэх

1. Европын улсуудаас Газар дундын тэнгис, Улаан тэнгисээр дамжин Энэтхэг хүрэх замыг газарзүйн зурагт зааж үзүүлээрэй.
2. Каравелла хөлөг салхины эсрэг явдаг зарчмыг физикийн хичээлтэйгээ холбон тайлбарлаарай.

**Баримт-1.** Португалийн хан V Альфонсийн шадар сайд Фернандо Мартинецэд 1474 оны 6-р сарын 15-нд дэлхий судлаач Тосканеллийн явуулсан захидлаас:

“Эрхэмсэг хантан, би боловсрол багатай хүн ч энэ замыг ойлгогдохоор зураглан тайлбарлаж бичлээ. Хэдийгээр би дэлхий бөөрөнхий хэлбэртэй гэдгээс үндэслэн, тийм зам байж болно гэдгийг баталж болохыг сайн мэдэж байгаа ч гэсэн, асуудлыг улам тодорхой болгох үүднээс далайн аяллын газрын зураг дээр тэр замыг зурж үзүүлэхээр шийдсэн юм....Хэдийгээр бид Дорно дахины орон гэж нэрлэдэг боловч, халуун ногоо ургадаг тэдгээр улс орныг би Өрнө зүгийн гэж нэрлэсэнд минь битгий гайхаарай. Учир нь хүмүүс үргэлж баруун зүг аялан хөвсөөр дэлхийн бөмбөрцгийн нөгөө талаас нь тэдгээр улсуудад очих болно...” (У.Гонгоржав, Дундад зууны түүхийн дээж бичиг.УБ.,2005.108-109-р тал)

### Газарзүйн их нээлтийг хэзээ, хэн хийсэн бэ?



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

**Испаничуудын нээлт.** Португалийн засгийн газрын дэмжлэгийг авч чадаагүй итали гаралтай Христофер Колумб (1451-1506 он) Испаниас тусламж авч чаджээ. Тэд шинэ нутагт нөлөөгөө тогтоож, олз ашиг олохыг эрмэлзэж байв.

Түүний удирдсан гурван онгоц, 90 хүн бүхий баг 1492 оны 8 сарын 3-нд Атлантын далайн Палос буудлаас хөдлөн явсаар Канарын арлуудыг дайран, 10 сарын 12-нд Төв Америкт Карибын тэнгисийн Багамын Сан-Сальвадор аралд буужээ. Улмаар 1493 оны 3 сарын 15-нд Испанид буцан ирэв. Х.Колумб 1492 оны 10 сарын 12-нд Төв Америкийн арлуудад анх хүрснийг Америк тив нээгдсэн өдөр гэж үздэг.



Х.Колумб шинэ тивийг нээсэн нь нэг талаар газарзүйн мэдлэгийн хүрээг тэлж, нөгөө талаар Испанийн колонийн түрэмгийллийн эхлэлийг тавьсан юм.

(Х.Колумб Сан Сальвадор аралд буусныг Теодор де Брай зэс хөөмлөөр дүрсэлжээ. Зураг-2.2). Тэд шинэ нутагт буухдаа тусгай ёслолоор буудлага хийн, тугаа өргөж, гоёлын хувцас өмсдөг байв. Тэр нь ямар зорилготой үйлдэл байв?

**Баримт 2.** "...Одоо тэр (Колумб) эсэн мэнд эргэн ирж, өөрийн аялал хийгээд нээсэн улс орныхоо тухай ярьж байна. Тэр алт, хөвөн цаас, Кавказынхаас илүү халуун чинжүү авч иржээ. Тэр Гадис (Кадикс)- аас баруун тийш таван мянган миль хөвөөд олон арлууд нээсний дотор Испанийн нутгаас ч том арал байсан агаад хааны нэрийн өмнөөс түүнийг цөмийг нь эзлэн авсан гэж ярьж байна. Түүний ярьж байгаагаар бол тэдгээр арал дээр зэрлэг байдалтай боловч аз жаргалтай аж төрдөг өвөрмөц арьстай хүмүүс амьдардаг ажээ. Тэд үр жимс, төмсний гурилаар хооллодог. Энэ хүмүүс өөр хоорондоо заримдаа дайтах агаад нум сум, үзүүрийг нь шатааж, хурцалсан модон жадаар зэвсэглэнэ..."



Зураг-2.2

(Граф Тендильд, Мартирын бичсэн захидлаас. - У.Гонгоржав. Дундад зууны түүхийн дээж бичиг. УБ., 2005. 109-110-р тал)



Америго Веспучи

**Мэдээлэл-1.** Флоренц хотоос гаралтай Америго Веспучи (1451-1512) өөрийн найз Лоренцо Медичид бичсэн захидалдаа, шинэ газрыг бие даасан тив гэж анх тодорхойлсон юм. Тиймээс Өмнөд Америкийн дорнод хэсгийг Америго Веспучийг хүндэтгэн "Америк" гэж нэрлэсэн нь хожим бүхэл тивийн нэр болжээ.

Португалийн далайчин **Фернан Магеллан** (1480-1521) Испанийн хааны дэмжлэгийг авч, 1518 оны 9 сарын 20-нд аяллаа эхлэх үед түүний багийн бүрэлдэхүүнд 75-120 тонн даацтай 5 хөлөг онгоц 265 хүн байв. Тэд Канар, Ногоон хошууны арлыг дайрч Өмнөд Америкийн Бразилийн эрэг чиглэн явсаар Рио-де-Жанейрогийн булангаар дайрч, Өмнөд Америкийн өмнөд хэсгийн нарийн хоолойд хүрэв. Тэд Номхон далайгаар 110 өдөр явж, 17 мянган км зам туулж, 1521 оны 3 сарын 6-нд хожим Марианы гэж нэрлэгдсэн аралд хүрчээ. Магеллан нас барсан ч Себастьян де Элькано багаа удирдан, "Виктория" онгоцоор 1522 оны 9 сарын 6-нд Испанидаа эргэн ирэх үед 18 хүн л үлдсэн байв.



**Ф.Магелланы аяллын гол үр дүнг өмнө судалсан Газарзүйн хичээлтэйгээ холбон сэргээн санаарай.**

**Мэдээлэл-2. Португаличуудын нээлт.** Португаличууд 1445 онд Ногоон хошууг нээж, 1471 онд Гвинейг Алтан эрэг гэж нэрлэн, тэнд цэргийн түүшиц газар байгуулав.

1497 онд адмирал Васко да Гама (1469-1524) гурван усан онгоцтой аялж Энэтхэгийн Калькутта хотод хүрсэн боловч хотын захиргаа Васко да Гамаг хүлээж авсангүй. Тиймээс бага зэрэг худалдаа хийж, халуун ногоо ачин, 1499

оны 8 сард нутгийн зүг хөдөлж, 9 сард 2 онгоцтой Португалид буцаж иржээ. Васко да Гама 1502-1503 онд 13 цэргийн онгоцтойгоор Энэтхэг рүү дахин аялж, ихээхэн олз ашиг олж, өмнөд Ази дахь Португалийн колоничлолын эхлэлийг тавьжээ.



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Баримт-1-ийн мэдээнд тулгуурлан дэлхийн хэлбэрийн талаарх XV зууны Европын судлаачдын мэдлэг газарзүйн их нээлттэй хэрхэн холбогдохыг тодорхойлоорой.
2. Далайн аялал хийхэд мэдлэгтэй чадварлаг далайчин, сайн усан онгоц болон бусад хэрэгсэл, санхүүжилтийн зэрэгцээ өөр юу хэрэгтэй вэ?
3. Баримт, мэдээллийг задлан шинжлээрэй.

Баримт	Баримтын шинж чанар	Гол үзэл санаа	Ач холбогдол
Баримт-1			
Баримт-2			
Мэдээлэл-1			
Мэдээлэл-2			
Нэгтгэн дүгнэх нь:			



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

## Газарзүйн их нээлтийн үр дагавар юу байсан бэ?

Европчууд далайн чанад дахь дэлхийн зарим хэсэгт хүрэх замыг нээв. Шинэ газарт цөөн далайчин, цэргүүд, шилжин суурьшигчид чухал газруудыг эзлэн, бэхлэлт суурингуудаа байгуулж, улс төрийн ноёрхлоо тогтоов. Европчууд бусад ард түмнээс техник, зохион байгуулалт, цэргийн зэвсгээр давуу байжээ.

Газарзүйн их нээлт Европын эдийн засаг богино хугацаанд асар их өөрчлөгдөх үндэс болж, олон улсын худалдааны гол зам нь Газар дундын тэнгисээс Атлантын болон Номхон далайд шилжсэнээр худалдааны төвийн үүргийг Итали бус Португали, Нидерланд, Англи гүйцэтгэх болжээ. Европт капиталын анхны хуримтлалын шинэ хүчин зүйл бүрдэв.

Америк тивийн Ацтек, Майя, Инк нарын дотоод дахь хагарал сул дорой байдал нь Европчуудыг дэлхийд колоничлох, санхүүгийн хийгээд иргэншлийн ноёрхлоо тогтоох суурь нөхцөлийг бүрдүүлсэн.

Испани, Португали, Голланд, Англи, Франц нь Америк, Ази, Африкт колонийн эзэмшилтэй болж, байгалийн баялаг, ажиллах хүчний асар их нөөцтэй болжээ. Америкийг нээсний дараа Испани Португали 1494 онд Тордесильяс хотод хэлэлцээ хийв. Уг хэлэлцээрээр Ногоон хошууны арлаас баруун тийших газар нь Испанийн, зүүн тийших нутаг нь Португалийн эзэмшил болохыг батлав.

Газарзүйн их нээлтийг судлаачид мөшгин дагаж шинэ нутгийн тухай шинжлэх ухааны гүнзгий мэдлэгтэй болохыг чармайжээ. Тэд Ази, Америкийн амьтны болон ургамлын аймаг, тэндхийн хүмүүсийн амьдрал, соёл, хэлний онцлогийг шинжлэн, тайлан бичиж байв. Тэр нь шинэ хуучин тивийг харьцуулан судлах үндсэн хэрэглэгдэхүүн болж байлаа.

**Тайлбар:** Колони- Харийн эзэн улсын шууд захиргаанд оршдог, улс төр, эдийн засгийн ямар ч эрх мэдэлгүй нутаг орон.

**Колоничлол-** Хүчирхэг улс гүрнүүдийн хөгжил буурай, эзэнгүй, хүн ам цөөтэй нутаг дэвсгэрт ноёрхлоо тогтоон уугуул нутгийнхныг засаглан захирах, соёлоо дэлгэрүүлэх, шилжин суурьших үйл явц

“...Эрхэм хантан, бүх индианчуудыг Кастильд аваачих уу, эсвэл энэ арал дээр нь олзонд байлгах уу гэдгийг соёрхож айлд. Тэднийг үг дуугүй захирч, дуртай зүйлээ хийлгэхэд тавин хүн бүрэн хүрэлцээтэй. (Колумбын I аяллын өдрийн тэмдэглэлээс.)”



### Колоничлол хэрхэн эхлэв?

**Испанийн колоничлол.** XVI зуунаас эхлэн Африкаас хар арьст боолуудыг ачиж умард Америкийн өмнөд хэсэгт аваачин худалдах болсон. XVI зууны эхний хориод жил нь нээлтийн үе байсан бол 1520 -1550-иад он нь эзлэн түрэмгийллийн (конкистадорын) үе байв. Тухайлбал, төв Мексикт оршиж байсан Ацтекийн гүрнийг Кубын амбан захирагч байсан Фернан Кортес (1485-1547) эзлэн авсан бол Перу төвтэй Эквадороос Чили хүртэлх өргөн удам нутагтай Инкийн их гүрнийг Франциско Писсаро (1478-1541) мөхөөж, 1533 онд нийслэл хот Куског нь эзлэн авчээ. Нутгийн индианчуудыг боолчлон уул уурхайд хүчээр ажиллуулахын зэрэгцээ Африкаас хар арьст боолчуудыг олноор нь авчирч ажиллуулах болов.

**Португалийн колоничлол.** Энэ үйл явц 1415 онд эхэлж тэд Африкийн баруун эргийг эзэмшив. XV зууны 40-өөд онд Гвинейн булан хүрснээс хойш өмнө зүгт давших болж, Португалид алт, зааны яс, боолчууд цутган орж ирэх болжээ. Энэтхэгт суулгасан амбан захирагч Альбукеркийн удирдлага дор 1509-1515 оны хооронд Африкийн дорнод эргээс Малакийн хойг хүртэл түшиц газрын бүхэл бүтэн сүлжээ байгуулжээ. Португали-Испанийн ноёлсон колонийн түрэмгийллийн эхэн үе нь худалдааны шинжтэй байсан юм. Харин XVI зууны сүүлч, XVII зууны эхэн үеэс Европын колонийн түрэмгийлэлд Нидерланд, Англи тэргүүлэх үүрэг гүйцэтгэх болжээ.

**Английн колоничлол.** XVII зууны үе гэхэд Англи цэргийн болон худалдааны усан онгоцны тоогоо нэмэгдүүлж, хүчин чадлыг нь сайжруулснаар далайн худалдааны эрх мэдлийг аажмаар өөртөө төвлөрүүлж эхэлжээ. 1770 онд Жеймс Кук Австралийг нээж, Английн хааны өмч гэж зарлажээ. Тухайн үед Австралийн 300 мянга уугуул хүн ам ан гөрөө, түүвэрлэх аж ахуй эрхлэн амьдарч байв. Европчууд очиж хонины аж ахуй, улаан буудай, чихэр, тамхи, жимсний аж ахуй эрхэлжээ.

**Колонийн байдал.** XV-XVI зуунд Испанийн колоничлогчид Өмнөд Америкийн уугуул оршин суугчдыг устгаж, испани хэл яриа, зан заншлыг нэвтрүүлэв. Тэнд эртний латин хэлний нэг испани хэл дэлгэрсэн тул хожим Латин Америк гэж нэрлэжээ. Колоничлолын уршгаар Америк дахь Мексик, Перугийн уугуул хүн ам бараг устав. Цэргийнхэн, худалдаачдыг дагалдан “гартаа загалмайтай, зүрхэндээ алтанд шунасан бодолтой” явсан католик гэлэнгүүд колониос олсон орлогын үлэмж хэсгийг нь хүртжээ. Америк тивийн уугуул оршин суугчид болох индианчуудтай шилжин суурьшсан Европ, Африк, Азийн хүмүүс үлэмж холилдож хэл соёл, шашин шүтлэг, зан заншлын асар их өөрчлөлт гарсан юм. Газарзүйн их нээлтийн дүнд дэлхий дахины шинж чанартай болсон арилжаа худалдааны хөгжилт нь Европын улсуудын хоорондын харилцааг өөрчилсөн төдийгүй хүн амын өсөлт хийгээд хотжилт, үйлдвэрлэлд ихээхэн нөлөө үзүүлсэн юм.



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Х.Колумбын аялал колоничлолтой хэрхэн холбогдох вэ?
2. Уугуул оршин суугчид хялбархан олзлогдоход цэрэг зэвсгээс гадна юу нөлөөлсөн болохыг эргэцүүлэн бодоорой.
3. Колони улсуудын хүн ам, хэл соёл, шашин шүтлэг яагаад өөрчлөгдөх болсныг баримтаар нотолно уу.



### Үр дүнг нэгтгэх, танилцуулах

1. Баримт, мэдээлэл болон зураг-2.1-д тулгуурлан газарзүйн их нээлтийг хэзээ, хэн, хэрхэн хийснийг нэгтгэн дүгнээрэй.
2. Газарзүйн их нээлт дэлхийн түүхийн шинэ үеийн эхлэл болох үндэслэл, нотолгоог гаргаарай.
3. Колоничлолын эерэг, сөрөг үр дагаврыг хамтран тодорхойлж танилцуулаарай.



## 2. ШАШНЫ ШИНЭТГЭЛ

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
XV-XVI зууны баруун болон төв Европын нийгмийн амьдралд гүнзгий өөрчлөлт авчирсан шашны шинэтгэл нь дундад зууны бурангуй үзлээс ангижирч, шинэ үеийн үзэл санаа дэлгэрэхэд чухал хувь нэмэр оруулсан.	“Мартин Лютерийн шашны зоригтой шинэчлэлээр Европт ивд агуу том соён гэгээрлийн салхи сэвэлзэж, сэргэн мандлын үйл эхэлж, үйлдвэржилтийн хувьсгал болж, шинжлэх ухаанд нээлтүүд хийж, Европчууд бүхий л салбарт тэргүүлж бусад улс орнуудыг хөтлөн дагуулж гэрэлтүүлсэн юм”. <i>Макс Вебер</i>	<ul style="list-style-type: none"> <li>• Католик шашин</li> <li>• Шашны шинэтгэл</li> <li>• Протестант</li> <li>• Индульгенц</li> </ul>



### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх

Урьд нь хэмжээлшгүй эрхт хаант засаг, сүм хийдийн дарангуйлал ноёрхсон, шашны номлол, мухар сүсэг, ядуурал, өлсгөлөн, санхүүгийн хямрал, окууны хоосрол, сэтгэлгээний боолчлолд нэрвэгдсэн, хүн ам нь бичиг үсэггүй, мөлжлөг дарангуйлал, зовлон гачаалаас ангижрахын тулд өөрт байгаа сүүлчийн зоосоо өргөн бурхнаас аврал гуйдаг ийм л амьдралыг туулж ирсэн Европчууд яаж энэ хүнд байдлаас гарсан бэ? Тэднийг хэн, юу аврав?

### Дараах хоёр эшлэлийн утгыг тайлбарлаж ярилцаарай

“Төлсөн зоос нь өргөлийн хайрцагт жингэнэн ороход сүнс нь ариутгалын орноос диваажин руу нисэн одно”

*Иохан Тецель*



“...бурхны үнэн зөвийг та итгэхдээ мэдэх болно. Тиймээс итгэлээр амьдрах хэрэгтэй”

*Гэгээн Павел*

*Эх сурвалж. mn.khanacademy.org*



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

**Баримт-1.** 1517 оны 10 сарын 31-нд Саксони мужийн Виттенбергийн их сургуулийн профессор, санваартан **Мартин Лютер** орон нутгийн сүмийн хаалган дээр өөрийн үзэл санааг илэрхийлсэн 95 зүйл бүхий бичгийг наажээ. Эл бичиг нь дэлхийн түүхнээ **реформац** хэмээн нэрлэгдсэн шашны шинэтгэх хөдөлгөөний эхлэлийг тавьсан түүхтэй. Түүний бичигт Ромын Папын эсрэг чиглэсэн зүйл заалтууд байсан юм. Тэрээр хүмүүс нүглээ цайруулахын тулд сүмд өргөл өгөх (нүглээ цайруулах



Мартин Лютер  
/1483-1546/

бичиг авахын тулд мөнгө төлөх) явдлыг эсэргүүцэж байлаа.

Мартин Лютер хүн өөрийн итгэл үнэмшлээр бурханд хандах учиртай. Сүм хийдийн санваартан түүнд оролцох эрхгүй. Харин бурханд хүрэх замыг олоход нь туслах хэрэгтэй. Иймд сүм хийд бүх хүмүүст хэрэггүй. Харин хүсэж буй хүмүүст Библийн болон бурхны сургаалийн утга учрыг ойлгоход санваартнууд дэмжлэг үзүүлэх ёстой гэж үзэж байв. Тэрээр сүм, хийд анх байсан шигээ энгийн байж, хөрөнгө хуримтлуулахгүй, буян үйлдэж байх ёстой гэж уриалж байлаа.

1522 оны 3-р сард Библийн судрыг герман хэлнээ орчуулан хэвлүүлж, Ромын католик санваартнуудын латин хэлээр номлож буй библийн сургаалыг хүмүүс ойлгохгүй байдлыг ашиглан дураараа дүрэм ёс гаргадаг булхайг илчилсэн юм. Үүгээрээ Мартин Лютер соён гэгээрэлд ч чухал хувь нэмэр оруулжээ.



Тэр үед **Индальгенц** буюу нүгэл хилэнцтэй хүмүүсийн нүглийг мөнгөөр худалдан авч, тухайн хүнээс зайлуулах утга бүхий үйлдэл гараад байв. Өөрөөр хэлбэл, сүсэгтэн олон нүглээ наминчлахын тулд мөнгө төлөх ёстой гэж католик шашны санваартнууд номлож, олон түмнээс их хэмжээний мөнгө авах үйл ажиллагаа дэлгэрээд байсныг индальгенц гэдэг.



Ромын пап X Лео  
/1475-1521/  
байв.

Ромын католик шашин (католик-бүх дэлхий гэсэн утгатай)-ыг бүх дэлхийн шашин гэж тухайн үеийн Европчууд үздэг байв. Ромын хэмээдэг нь энэ шашны тэргүүн Ромын пап лам байсантай холбоотой юм.

Тухайн үеийн хүмүүс шашны сургаалд итгэн шүтэж, дагаж мөрдөх нь хойд насандаа диваажинд очиж сүнсээ аврах цорын ганц зам гэж итгэдэг байв.

**Баримт-2. Жан Кальвин** Францын хуульч, санваартан. Шашны шинэтгэх хөдөлгөөний удирдагчдын нэг. 1536 онд Швейцарийн Базель хотод “Христийн шүтлэг дэх сургаал” бүтээлээ туурвиж, шашныг үзэх өөрийн үзэл бодлоо илэрхийлжээ. Тэрээр Христос сүм хийд нь ёс суртахууны хатуу чанга хэм хэмжээ, зан суртахууныг номлогч байх ёстой хэмээн тунхаглаж, түүнийгээ бүх амьдрал, үйл ажиллагаандаа мөрдлөг болгожээ. Энэ үзлээ тайлбарлахдаа, хэрэв хүний ажил үйлс бүтэмжтэй байгаа бол бурхан түүнийг энэрэн хайрлаж байгаа нь тэр бөгөөд түүний өмнө диваажингийн үүд хаалга нээлттэй байх болно, харин ажил үйлс нь бүтэлгүйтэж, золгүй явдал тохиолдох түүнийг бурхан үл таалснаас болж байгаа бөгөөд тэр тамд унах ёстой гэжээ.



Жан Кальвин  
/1509-1567/

Ж.Кальвин 1559 онд протестант шашны номлогчдыг бэлтгэх Женевийн академийг үүсгэн байгуулжээ. Чухам энэ сургуулийг төгсөгчид Кальвины номлолыг Европ даяар дэлгэрүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байна. Амьдралынх нь сүүлийн жилүүдэд өвчин ээрч, биеийн байдал нь доройтож

байсан ч гэсэн зохиол бүтээлээ туурвиж, боловсрол, худалдаа арилжаа, нийт хүн амын эрүүл ахуйн холбогдолтой ажилд ч өөрийн биеэр оролцож байжээ.



### Асуулт, даалгавар гүйцэтгэх

#### 1. Баримт мэдээллийг судлан шинжлээрэй.

Баримт	Гол зорилго	Гол үзэл санаа	Шийдсэн асуудлууд
Баримт 1			
Баримт 2			
Нэгтгэн дүгнэх нь:			

- Тэр үед сүм хийдүүд “Бурхан зөвхөн латин хэлээр ойлгодог. Тиймээс Библийн судрыг орчуулах нь бурхны эсрэг маш том нүгэл” хэмээн тунхаглаж байлаа. Тийнхүү эсэргүүцэж байсны учир юу вэ?
- Шашны ном судар орчуулсны ач холбогдол юунд орших вэ?



М.Лютер, Ж.Кальвин нар католик шашинд шинэтгэл хийх тал дээр санал нэгдэж байсан ч ямар арга замаар уг шинэтгэлийг хэрэгжүүлэх тухайд өөр, өөр үзэл бодолтой байжээ. Үүний улмаас шашны шинэтгэх хөдөлгөөнд хагарал гарч, нэг хэсэг нь М.Лютерийг, нөгөө хэсэг нь Ж.Кальвиныг дэмжих болжээ.  
(Дэлхий дахины түүх, УБ., 2002.)

**Кальвинизм:** Франц, Нидерланд, Шотланд, Англид дэлгэрсэн. Тэд бурхан ба хүний хооронд ямар ч зуучлагч байх учиргүй. Шүтлэг бишрэл нь зөвхөн хүний оюун ухаан, шашны мэдрэмжид тулгуурлах ёстой гэж үзэж байв. Үндэслэгч нь Францын хуульч Ж.Кальвин юм.

**Лютерийн урсгал:** Герман, АНУ Скандинавын орнуудад өргөн дэлгэрсэн. XVI зууны үед Германд бий болж, 1555 онд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн. М.Лютерийг залгамжлагчид Ромын папын засаглалаас татгалзаж, католик шашны олон дэг журмыг өөрчлөв. Тухайлбал, сүм хийдийн барилгыг энгийн хийц загвартай болгож, хурал номыг үндэсний хэлээр хурах болсон байна.

XVI зууны 20-30-аад оны үед Германд анхлан гарсан шашны шинэтгэх хөдөлгөөн удалгүй Франц, Нидерланд зэрэг оронд өрнөж, улмаар Төв болон Баруун Европд дэлгэрчээ.

XVI зууны туршид католик шашныг шинэтгэх гэсэн оролдлогууд гарч байсан боловч төдийлөн амжилт олсонгүй. Учир нь католик сүм хийдийн нөлөө нийгэмд хүчтэй ноёрхсон хэвээр байв.

Католик шашныг шүүмжлэгчид болон өөр үзэл бодол баримтлагчдыг тэрс үзэлтнүүд хэмээн нэрлэж, тэдгээрийг залхаан цээрлүүлэх шүүх хүртэл байгуулсан байна. Шүүх тэрс үзэлтнүүдийг торгох, шоронд хорих, галд шатаах зэргээр шийтгэдэг байв. Ийнхүү католик сүм хийдийн санваартнууд өөрийн шашны мөн чанарыг хадгалахын төлөө хүчтэй эсэргүүцэл үзүүлж байсан бөгөөд тэдгээр нь түүхэнд **сөрөг шинэтгэл** хэмээн тэмдэглэгдэн үлджээ.

Шашны шинэтгэлийн төлөө тэмцэл ийнхүү католик шашинтнуудын эсэргүүцэлтэй тулгарсан төдийгүй эцэстээ Европ дахиныг хамарсан 30 жилийн дайнд хүргэжээ.




**Гучин жилийн дайн.** Европын олон улс орнуудыг хамарч 1618–1648 онд өрнөсөн дайн. Герман улсаас эхлэлтэй бөгөөд гол шалтгаан нь удам угсааны зөрчил болон тухайн үед улс төрийн бодлогод чухал үүрэг гүйцэтгэж байсан шашны асуудал, түүний дотор христийн католик ба протестант урсгалын зөрчилдөөн байв. Ариун Ромын эзэнт улс анх шашны тэмцлийг эхлүүлсэн. Аажмаар энэ тэмцэлд Европын нөлөө бүх улсууд бараг татагдан орж, өргөн хүрээг хамарсан байна. Гучин жилийн дайны уршгаар цэрэг арми, хоол хүнсний хэрэгцээнд бүхнийг зориулж байснаас өлсгөлөн ядуурал, өвчин зовлон нүүрлэжээ. Гучин жилийн дайн Вестфалийн энхийн гэрээ байгуулснаар дууссан юм.



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Европ дахь шашны шинэтгэлийн үр дагаврыг баримт мэдээлэлд тулгуурлан тодорхойлоорой.
2. Он тооллын шугам ашиглан мэдээлэлд дүн шинжилгээ хийгээрэй.



3. Монголчууд XIV зуунаас эхлэн бурхны шашны ном судрыг орчуулж эхэлсэн байдаг. Ялангуяа XVI-XVIII зууны үед ихээхэн амжилт олсон. Гэвч монголчууд Манжийн эрхшээлд орсноор энэ уламжлал алдагдаж, сүүлдээ шашны бүх ном уншлага Төвөд хэлээр явагдах болжээ. Одоо ч энэ байдал үргэлжилсээр байна. Манай сүм хийдүүд өнөөдрийг хүртэл шашны номлолыг харь хэлээр уншиж байгааг судалсан сэдэвтэйгээ холбон хэлэлцүүлэг өрнүүлээрэй.




Христийн шашин анх ганц сургаал, ганц урсгалтай байсан боловч түүхийн явцад олон урсгалд хуваагдсан. Тэдгээрийн хамгийн том 3 нь католик, ортодокс, протестант урсгал юм. Протестант урсгал нь Католик урсгал дотроосоо салбарлан гарч иржээ. Энэ урсгал шашны шинэтгэх хөдөлгөөний үр дүнд бий болж, XVII-XVIII зууны үеэс баруун Европын орнуудад түгэн дэлгэрсэн. Католик сүмийн эрх мэдэлтнүүд шашны хүрээнээсээ хальж, улс төрийн үйл хэрэгт оролцох болсон хүмүүсийн дургүйцлийг хүргэж, түүнийг эсэргүүцэгчид протестантууд болжээ. Учир нь “протестант” гэдэг нь латин хэлээр “Тэрс үзэлтнүүд” гэсэн үг юм. Протестант урсгал хожим дотроо мөн олон салбартай болсон.



**Үр дүнг нэгтгэх, танилцуулах**

1. Шашны шинэтгэх хөдөлгөөнд холбогдох түлхүүр үгийн утгыг тайлбарлаарай. (Ромын католик сүм, Индульгенц, Реформац, Сөрөг шинэтгэл...)
2. Газарзүйн зургийг ажиглан, сэдэвтэйгээ холбон харьцуулж дүн шинжилгээ хийгээрэй



Зураг-2.3

3. М.Лютер өөрийн үзэл санааг илэрхийлсэн 95 зүйл бүхий бичиг гаргах болсны шалтгаан юу байв? Энэ үеийн Европын нийгмийн дүр зургийг баримтад тулгуурлан дүрсэлж, тайлбарлаарай.
4. Судалсан мэдээллүүдээ эрэмблэн ангилж, дараалалд оруулаарай: Багуудад хуваагдан тус бүр 3-5 үйл явдлыг сонгож, он тооллын шугаман дээр тэмдэглэх ба тэдгээр үйл явдлууд нийгэм болон хүмүүст хэрхэн нөлөөлснийг тайлбарлан ярилцаарай.



### 3. СЭРГЭН МАНДАЛТ БА ХҮМҮҮНЛЭГ ҮЗЭЛ

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
Сэргэн мандалт нь нийгмийн амьдралыг өөрчилж, орчин үеийн шинжлэх ухааны олон салбарын эх үндсийг тавьснаас гадна хүмүүнлэг үзлийг дэлгэрүүлэн урлагийг шинэ шатанд гаргасан.	Сэргэн мандалт нь хүн төрөлхтний түүх, соёлын хөгжлийн нэг томоохон үе шат байсан. Энэ үеийн ололт, бүтээлүүд өнөөдөр ч дэлхий дахинд гайхагдсаар байна.	<ul style="list-style-type: none"> <li>• Сэргэн мандалт</li> <li>• Флоренц хот</li> <li>• Хүмүүнлэг үзэл</li> <li>• Соёл, урлаг</li> <li>• Шинжлэх ухаан</li> <li>• Бүтээлүүд</li> </ul>



**Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх**

Мэдээлэлд тулгуурлан түүхийн асуулт зохиож ажиллаарай.



Итали, Флоренц хот 1550 он



“Санта Мариа”-гийн сүм бөмбөгөр оройтой

Нэхмэл даавуун бүтээгдэхүүнээр алдартай

Сүмд Медичийн ивээн тэтгэсэн уран зургуудыг байрлуулж чимэглэсэн

Италийн яруу найрагч Данте: Флоренцийн яруу найрагчид алдартай, атаархал бахархал хосолсон хүмүүсээр дүүрсэн байдаг.

Зураг-2.4



**Асуулт, даалгавар гүйцэтгэх**

Өмнөх зурагт мэдээллийг ашиглан хүснэгтийн дагуу ажиллаарай.

Мэдээллийн гол агуулгыг тодорхойлно уу	Шинэ ойлголт (нэр томъёо) юу байсан бэ?

XV-XVII зуунд Европчуудын оюун санаа, нийгэм, эдийн засгийн амьдралын бүх хүрээг хамарсан гүн гүнзгий өөрчлөлтийн үйл явцыг түүхэнд **Сэргэн мандалт** хэмээн нэрлэдэг. Сэргэн мандалт нь эртний Грек, Ромын соёлын хөгжлийн уламжлалыг сэргээн, түүнийг Европ дахинаа дэлгэрүүлэх гүүр болсон юм.



*Сэргэн мандалт нь XIII зууны II хагасаас эхэлж, XV-XVI зууны зааг үед жинхэнэ утгаараа хөгжсөн юм. Түүний хөгжлийг дараах үндсэн үе шатанд хувааж үздэг. Үүнд:*

- 1. Сэргэн мандалтын эхэн үе: XIII зууны II хагасаас XIV зууныг хамардаг. Энэ үед дундад зуунд утга зохиолын үндсэн хэл байсан Латин хэлийг аажмаар тухайн ард түмний хэлээр сольж байв.*
- 2. Түрүү сэргэн мандалтын үе: XIV-XV зууныг хамрах ба энэ үед утга зохиол, уран баримал хүчтэй хөгжсөн байна.*
- 3. Сэргэн мандалтын оргил үе: XV зууны сүүлчээс XVI эхэн үеийг хүртэл үргэлжилнэ. Энэ бол сэргэн мандалт өрнөн гүнзгийрч хөгжсөн үе болно.*

Сэргэн мандалт нь орчин үеийн шинжлэх ухааны олон салбарын үндэс суурийг тавьжээ. Шинжлэх ухааны хөгжил нь Европ тивийн төдийгүй хүн төрөлхтний иргэншилд хүчтэй нөлөө үзүүлсэн юм. Энэ үеийн соёлын гол төвүүд нь Флоренц, Милан, Венец зэрэг Италийн цэцэглэн хөгжиж буй хотууд байжээ. Эдгээр хотод худалдаа, банк, үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байв. Тухайн үеийн сурвалжит гэр бүлүүд болох Флоренц хотын Медичи, Милан хотын Сфорзагийн гэр бүлийнхний өөрсдийн нэр төрийг өргөх гэж соёлын тансаг зүйлсэд мөнгийг чөлөөтэй зарцуулж байлаа. Түүнчлэн Унгарын Маттиас Корвин, Францын I Франсис зэрэг баян хаад сүр хүчээ сурталчлах үүднээс уран бүтээлч, оюунлаг хүмүүсийг ихээр дэмжиж байв. Үүний үр дүнд шинжлэх ухаан, урлаг соёлын олон шинэ нээлт бүтээл гарчээ.



Нисдэг машин

1628 онд Английн хаан I Чарльзийн хувийн эмч Уильям Гарвей хүний судас нь цусыг зүрхнээс зайлуулж урсгадаг артерийн, зүрх рүү урсгадаг венийн гэсэн хоёр төрөлтэй болохыг нээжээ. Леонардо да Винчи нисдэг машин, математикийн салбарт Италийн эрдэмтэн Ж.Кардано гурав дахь эрэмбийн тэгшитгэлийг бодох аргыг тус тус нээв.

1543 онд одон орон судлаач Польшийн эрдэмтэн Николас Коперник манай гарагийн хөдөлгөөний хуулийг нээж, “Нар орчлонгийн төв”-д байдаг. Харин манай гараг бол ертөнцийн хөдөлгөөнгүй төв биш, бусад 6 гарагийн 3 дахь нь болж нарыг тойрон эргэлддэг гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

Италийн физикч, одон орон судлаач Галилео Галилей “Одон орны дуран”-г бүтээж энгийн нүдэнд үл үзэгдэх олон тооны од эрхэс, сарны гадаргуу, нарны толбо зэргийг тодорхойлсон байна.



Зураг-2.6

Анхны хэвлэгч машин

Европт хамгийн их нөлөө үзүүлсэн бүтээгдэхүүн бол хэвлэлийн машин байлаа. Хөдөлгөөнт металл хэв, тосон суурьтай бэх ашиглан ном хэвлэх хэвлэлийн суурь машиныг Германы гар урлаач, худалдаачин Иоханнес Гутенберг анх XV зуунд зохион бүтээсэн байна. 1455 онд Библийг анх удаа Европт энэхүү машинаар хэвлэсэн түүхтэй.

Сэргэн мандалтын үеийг авчирсан эрдэмтэд, зохиолчид, яруу найрагчид, уран барималчдыг “хүмүүнлэг” үзэлтэн гэж нэрлэж байсан бөгөөд тэд бурхныг бус, харин хүнийг ертөнцийг үзэх үзлийнхээ цөм болгож байсан тул ингэж нэрлэгджээ. Хүмүүнлэг (гуманист) үзэл бол шашныг үгүйсгэж, хувь хүний үзлийг илүү дээдэлсэн үзэл юм. Энэ үзэл нь эртний Грек, Ромын сонгодог уран зохиолд тулгуурлаж байлаа.

Түүхийн энэ үед шинжлэх ухаан төдийгүй урлаг, уран сайхны соёл цэцэглэн хөгжиж, шинэ шинэ бүтээлүүд төрөн гарчээ. Тухайлбал, утга зохиолын салбарт Данте, Боккаччо, Сервантес нарын зохиолчид бүтээлээ туурвиж байлаа. Сервантес дэлхийн урлагийн шилдэг сор бүтээлүүдийн нэг болсон “Дон Кихот” романаа шоронд байхдаа туурвисан байна. Театрын урлагт Английн алдарт зохиолч, яруу найрагч У.Шекспир, К.Марло нар хүний гадаад байдал төдийгүй дотоод оюун санааны зөрчлийн эх сурвалж, мөн чанарыг жүжгийн хэлээр илэрхийлэн олон түмэнд хүргэж байсан юм. У.Шекспир амьдралын баяр баясгалан, өөдрөг хүмүүнлэг үзлийг илтгэсэн “Ромео Жульетта” жүжигтээ хүний сайн сайхан байдлыг магтан дуулж, хүн бол “бүх амьд амьтны хүрээний хамгийн гоо сайхан нь юм” хэмээн тунхагласан билээ



Зураг-2.7

Сэргэн мандалтын үед эртний уламжлал дууриалаар хөгжиж хамгийн үр дүнд хүрсэн салбар бол уран барилга юм. Түүний анхны том ололт нь Филиппо Брунеллесчийн Флоренц хотноо бүтээсэн сүм байлаа. Уг бөмбөгөр оройтой сүм нь инженер, урлаг, уран сайхны талаасаа гайхамшигт бүтээл болжээ. Сэргэн мандалтын үеийн уран барималчид эртний Ромын хөшөөг дууриан гантиг чулууг ихээр ашиглаж байв.

Уран зураг, баримал, уран барилгад Леонардо да Винчи, Микеланджело, Рафаэль нарын бүтээл ихээхэн алдартай. Тэднийг сэргэн мандалтын үеийн гурван оргил гэж түүхэнд тэмдэглэдэг.



Сэргэн мандалтын үеийн нэг онцлог нь соёл урлагт нийгмийн шинж буюу “ертөнцийн төвийг хүн гэж үзэх” үзэл санаа нэвт шингэсэн явдал юм. Өөрөөр хэлбэл, энэ үед хүн, хүний үйл ажиллагааг эн тэргүүнд тавьж, онцлон судлах болжээ. Энэ үеэс хүн бол нийгмийн хамгийн дээд баялаг гэж үздэг, хувь хүний мөн чанар, эрх чөлөө, түүний идэвхтэй үйл ажиллагааг эрхэмлэдэг хүмүүнлэг үзэл (гуманизм) бий болжээ. Томоохон хотуудад сүмийн хяналтаас ангид, шашны бус үйл ажиллагаа эрхэлдэг, ертөнцийг үзэх эрс өөр үзэлтэй, хүмүүнлэг үзлийг дээдэлсэн шинжлэх ухаан, урлагийн төвүүд бий болсон байна. XV зууны дунд үед ном хэвлэн гаргах болсон нь хүмүүнлэг үзэл Европ даяар тархан дэлгэрэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Хүмүүнлэг үзэл нь соён гэгээрлийн хөдөлгөөнийг нөхцөлдүүлж, түүнтэй салшгүй холбоотой хөгжсөн юм.



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

Дараах түлхүүр үг, зургуудаас тус бүр хоёрыг сонгон авч ямар утга агуулга илэрхийлж буйг өгсөн мэдээлэл, бусад эх сурвалж ашиглан судлан шинжлээрэй.

Түлхүүр үг: Шинжлэх ухааны хувьсгал, Соёл, Флоренц, Леонардо да Винчи, Ромео Жульетта, Хүмүүнлэг үзэл



Зураг-2.8

### Судлан шинжлэхдээ энэхүү хүснэгтийг ашиглаарай.

Үйл явдал	Ямар агуулга, утга санааг илэрхийлж байна вэ?	Яагаад?
Түлхүүр үг-1		
Түлхүүр үг-2		
Зураг-2.5		
Зураг-2.6		
Зураг-2.7		



### Үр дүнг нэгтгэх, танилцуулах

- Италийн Флоренц, Милан хотууд яагаад сэргэн мандалтын өлгий нутаг болж байсан бэ?
- Сэргэн мандалтын үеийн эрдэмтэд, зохиолч, яруу найрагчдын бүтээлд хүмүүнлэг үзэл хэрхэн тусгалаа олж байсныг тодорхой жишээ баримтад тулгуурлан бичиж, тайлбарлаарай.
- Сэргэн мандалтын үеийн онцлогийг илэрхийлсэн гурван бүтээлийг сонгож, танилцуулга бэлтгэн хэлэлцүүлээрэй.
- Монголын эзэнт гүрний үеийн уран барилгын хөгжлийг энэ үетэй холбон үзэл бодлоо илэрхийлээрэй.



#### 4. СОЁН ГЭГЭЭРЛИЙН ХӨДӨЛГӨӨН

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
Соён гэгээрэл хүн төрөлхтний үзэл сэтгэлгээ, нийгмийн амьдралыг өөрчлөхөд маш чухал үүрэг гүйцэтгэсэн.	Соён гэгээрэл хүн төрөлхтөнийг дундад зууны хоцрогдол, дарангуйллаас аварч, түүхийг өөрчилсөн. Түүний үр дүн, үзэл санаа нь өнөөдөр ч үргэлжилж, аливаа улс, үндэстний хөгжил дэвшилд хүрэх гол түлхүүр хэвээр байна.	<ul style="list-style-type: none"> <li>• Гүн ухаантнууд</li> <li>• Гол төлөөлөгчид</li> <li>• Хууль тогтоох</li> <li>• Шүүх</li> <li>• Эрх мэдэл</li> </ul>



#### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх

*XVIII зууны эхэн үеэс Их Британи, Франц, Герман тэргүүтэй Европын орнууд хөгжлийн шинэ шатанд гарч, дэлхийн түүхийн шинэ үеийн өнгө төрхийг тодорхойлох болж, эдгээр улсууд өнөөдрийг хүртэл хүчирхэг мандсаар буйн нууц юунд орших вэ?*

*Хэмжээгүй эрхт хаант засаг, сүм хийдийн дарангуйлал, мухар сүсэг, оюуны хоосрол, сэтгэлгээний хоцрогдол, боловсролын доройтол, хямрал, ядуурлаас тэд хэрхэн ангижирч, чөлөөлөгдөж чадав? Таамаглал дэвшүүлээрэй.*

Соён гэгээрлийн хөдөлгөөн бол мухар сүсэг, хэдхэн хүний хязгааргүй эрх мэдэл, шинжлэх ухаанч бус сэтгэлгээ зэрэг зүй бус явдлыг шүүмжилж, нийгмийн харилцааны зүй тогтол, эрүүл зөв үзэл, шинжлэх ухаанч сэтгэлгээг хөгжүүлэх, энэ хүрээнд бурхны тухай, хүний тухай, төр, нийгмийн тухай гэх мэт уламжлалт сэдвүүдээс эхлээд гүн ухаан, урлаг, утга зохиол, логик, ёс зүй, шинжлэх ухаан зэрэг ухагдахууны агуулгад шинэ үзэл, тайлбар өгсөн хөдөлгөөн байв.

Хуучин үзэл санаа	Шинэ үзэл санаа
“Төр бол би”. (XIV Людвик)	1-рт, төрд хууль үйлчлэх ёстой. (Фридрих)
Эзэн хааны зарлиг бол тэнгэрийн санаа юм.	Засаглалын эрх мэдэл хуулийн хүрээнд хэрэгжих ёстой .



**Соён гэгээрлийн эхлэл.** Соён гэгээрэл нь шашны шинэтгэл, сэргэн мандалт болон Английн улс төр, оюуны соёлын хөгжлөөс эхтэй. XVIII зуунд Европчуудын оюуны амьдралд гарсан нэг шинэ зүйл бол соён гэгээрүүлэх хөдөлгөөн байлаа. Соён гэгээрүүлэх үзэл санаа бүхий олон шинэ ном зохиол хэвлэгдэн гарч, нийтийн анхаарал гүн ухаанчдын зүгт хандах болов. Гүн ухаанчид

хэмээн нэрлэгдсэн сэтгэгчид мухар сүсэг, харгис бурангуй, шударга бус нийгмийн байдлыг шүүмжилж байв. Тэд ухаарал гэгээрэл, хүлээцтэй байдал, шударга ёс, эрх зүйт тогтолцоог бий болгохын тулд шинжлэх ухааны ололт амжилтад тулгуурлан, төр, нийгмийн тухай хүмүүсийн үзэл бодлыг өөрчлөхийг хүсэж байв. Энэ хөдөлгөөний голомт нь Англи, Франц улсууд байв.

Улс нийгмээ хөгжлийн шинэ шатанд гаргахын тулд иргэддээ мэдлэг боловсрол олгох, оюун сэтгэлгээг нь өөрчлөх хэрэгтэй болов. Үүнийг нийгэмд ойлгуулах, уриалан дуудах, араасаа дагуулах шаардлага тулгарав. Үүнд Ф.Бэкон, Т.Гоббс, Ж.Локк, А.Вольтер (Франц), Ж.Ж.Руссо (Франц), Д.Дидро (Франц), Р.Декарт, К.А.Гельвеций (Франц), П.Гольбах (Франц), Ш.Л.Монтескье (Франц), К.Ф.Лессинг (Герман), И.Кант (Герман), Н.И.Новиков (Орос), А.Н.Радищев (Орос), В.Г.Белинский (Орос), Н.Г.Чернышевский (Орос), Т.Жэффэрсон (Америк) гэх мэт агуу сэтгэгчид их үүрэг гүйцэтгэсэн юм. Чухам тэд л өөрсдийн бүтээлүүдээрээ олон түмнийг гүн нойрноос нь сэрээж, соён гэгээрлийн хөдөлгөөнийг түүчээлсэн билээ. Тухайлбал, Монтескьегийн “Перс захидлууд”, “Хуулийн амин сүнс”, Волтерийн “Философийн толь бичиг”, Руссогийн “Нийгмийн гэрээ”, Дидро, Аламберийн хамтран бүтээсэн 28 боть нэвтэрхий толь, Адам Смитийн “Үндэсний баялаг”, И.Кантын “Цэвэр оюуны шүүмж”, Бэнтамын “Ёс суртахуун ба хууль ёсны зарчмуудын удиртгал” гэх зэрэг бүтээлүүд тухайн үеийн хүн төрөлхтний оюун сэтгэлгээг нээж өгчээ. Чухам үүний ачаар Европ тэр чигээрээ сэтгэлгээний хувьд шинэчлэгдэн, хүчирхэгжсэн байна.



**Соён гэгээрүүлэх үзэл санаа.** Соён гэгээрлийн гол төлөөлөгчийн нэг болох Английн Жон Локк (1632-1704) засаглалын эрх мэдлийг хуваарилах онолыг боловсруулж, хууль тогтоох эрх мэдэл нь гүйцэтгэх эрх мэдлээс ангид байх учиртай гэсэн санааг дэвшүүлж байв.

Харин францын Шарль Монтескье (1689-1755) “Хуулийн амин сүнс” бүтээлдээ, хаант засаглалыг гүйцэтгэх (хаан), хууль тогтоох (парламент), шүүх гэсэн гурван хэсгээс бүрдэх загварыг санал болгожээ. Тэрээр, Засгийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэж хуваан, бие биедээ хяналт тавьж байх ёстой. Энэ нь хэн нэг хүний дур зоргоороо авирлах явдлыг хазаарлан барих нэг нөхцөл гэжээ. Хувьсгалын жилүүдэд түүний бүтээл онцгой сонирхол татаж байв.

Жан Жак Руссо (1712-1778) Ардчилсан бүгд найрамдах улсад нийгмийн бүрэн эрхт иргэд нийгмийг удирдан жолоодох, хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох ёстой. Ийм байдлаар иргэний тэгш байдлыг тогтоож чадна гэж үзжээ.

Ж.Локк олонхын удирдлагын зарчимд баттай итгэдэг байсан ч засгийн газар хязгааргүй эрх мэдэл эдлэх ёсгүй, олонхийн зүгээс хүмүүсийн зүй ёсны эрхийг хүчирхийлж болохгүй, хүмүүсийн өмч эзэмших эрхэнд халдаж, хасаж болохгүй, засгийн газар хууль ёсны үндэслэл гаргаж байж тухайн иргэний зөвшөөрснөөр л ямар нэг өмчийг нь хураан авч болно гэж үзэж байлаа. (Энэ үзэл санаа АНУ-д “Батлагдаагүй ямар ч татвар авч болохгүй...” гэсэн зарчмаар илэрдэг) Америкийн хувьсгалын гол үзэл санааг зуун жилийн өмнө Ж.Локк боловсруулсан гэж үздэг.

Ном унших нь язгууртнуудын дунд байдаг зүйл биш болж, дунд ангийг ч хамрах болов. Энэ бол соён гэгээрлийн нэг үр дүн байлаа. Ном уншдаг хүмүүс нэмэгдэхийн хэрээр ном, тогтмол хэвлэл улам бүр олширч байв. Их Британиар жишээлэн үзэхэд, тогтмол хэвлэлийн тоо 1700 онд 25, 1760 онд 103, 1780 онд 158 болж өсчээ.



### Соён гэгээрүүлэх хөдөлгөөн бусад салбарт.

Эдийн засгийн сонгодог онолыг үндэслэгч Адам Смит (1723-1790) хүндтэй байр эзэлнэ. Тэрээр аж ахуй эрхлэх нь хүний төрөлх сонирхол гэж үзэж байлаа. Хүмүүсийн ахуй амьдралаа сайжруулах хүсэл эрмэлзэл нь үүнд хүчтэй түлхэц болж өгдөг. Эдийн засагт төрөөс оролцох хэрэг байхгүй гэж үзэж байжээ. Тэрээр хүмүүсийн зан суртахуун, үйл хэргийг “төмөр” гараар хазаарлан барьж байдаг эрх бүхий албан байгууллагын хэрэг байхгүй гэж байв.

Имманиул Кант нарны системийн гарал үүслийн талаарх таамаглалаа дэвшүүлсэн. Энэ нь хожим кантлапласын онол хэмээн алдаршжээ. Тэрээр орчлон ертөнцөд сансрын системүүдийн (галактикуудын) мөнхийн үүсэл, мөхөл явагдаж байсан гэж үзсэн юм.

**Урлаг, утга зохиол.** Соён гэгээрүүлэх хөдөлгөөний үзэл санаа XVIII зууны Европын уран зохиолд тусгалаа олсон байдаг. Жишээ нь Робинзон Крузогийн тухай романыг Даниэль Дефо 1719 онд хэвлүүлжээ. Мөн 1726 онд “Гулливерийн” нэртэй соён гэгээрүүлэх хөдөлгөөний үеийн баатар Гулливерийн тухай өгүүлсэн ном хэвлэгдэн гарчээ.

Дүрслэх урлагийн хөгжлийн соён гэгээрүүлэх хөдөлгөөн ихээхэн нөлөө үзүүлсэн билээ. Энэ үед Франсуа Буше (1703-1770), Антуана Ватто (1684-1721) нарын олон уран бүтээлчид бүтээлээ туурвижээ.

Эл үеийн хөгжмийн урлагийн суут төлөөгч болох Германы хөгжмийн зохиолч Иоганн Себастьян Бах (1685-1750), Австрийн хөгжмийн зохиолч Вольфганг Амадей Моцарт (1756-1791) нарын олон алдартнууд зохиол бүтээлээ туурвижээ.



### Асуулт, даалгавар гүйцэтгэх

1. Соён гэгээрлийн хөдөлгөөн ямар салбараас эхтэй вэ?
2. Соён гэгээрэл нь улс орны хөгжилд ямар хувь нэмэр оруулахыг тодорхойлоорой.
3. Мэдээллийг шинжлэн судлаад төрийн эрх мэдлийн хуваарилалтын талаарх үзэл баримтлалыг хүснэгтийн дагуу гүйцээж тодорхойлоорой.

Гол төлөөлөгч	Парламент	Засгийн газар	Шүүх
Жон Локк	Хууль тогтоох	Гүйцэтгэх	
Шарль Монтескье			
Жан Жак Руссо			

4. Зураг-2.9 дээр ажиллаж Соён гэгээрлийн үед Европын улс орнуудад гарсан ололт өөрчлөлтийг шинжлэн дүгнээрэй.



**Шигтгээ:** “Хүн бүр эрхтэй бөгөөд хүн эрхээ мэдэж байж л сайн хамгаалдаг”.

(А.Вольтер).

**Сургамж:** Хүмүүс боловсролгүй, мэдлэггүй байхад боломжийг нээж өгсөн ч түүнийг ашиглаж чаддаггүй болохыг энэ үеийн түүх харуулсан юм. Энэ бол түүх бидэнд үлдээсэн, санаж явах ёстой сургамж.



### Үр дүнг нэгтгэх, танилцуулах

1. Соён гэгээрлийн үед эрдэмтдийн гаргасан ном бүтээлүүд хүмүүсийн сэтгэлгээнд хэрхэн нөлөөлснийг шинжлэн судалж тайлбарлаарай.
2. Олон түмэн оюуны хувьд дорой, боловсролгүй байвал аливаа шинэ үзэл санааг хүлээж авч, сэтгэлгээний боолчлолоос ангижирч чадах уу? Эндээс бид ямар дүгнэлт хийж болох вэ? Тунгаан ярилцаж, санал бодлоо илэрхийлээрэй.



### Өөрийгөө үнэлээрэй

1. Соён гэгээрлийн хөдөлгөөний үеийн бусад салбарын гол төлөөлөгчид, тэдний оруулсан хувь нэмрийн талаар мэдээлэл бэлтгээрэй.
2. Дараах түлхүүр үгийн утгыг тайлбарлана уу.
  - Гүн ухаантнууд
  - Хууль тогтоох
  - Эрх мэдэл
  - Гол төлөөлөгч
  - Шүүх



## 5. КАПИТАЛИЗМЫН ҮҮСЭЛ, ШИНЖ ОНЦЛОГ

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
Капитализм бол хувийн өмчид голлон тулгуурладаг, үйлдвэрлэл, ашиг, орлого, зарлага, хуваарилалт бүхэлдээ зах зээлийн эрэлт, хэрэгцээгээр тодорхойлогддог тогтолцоо. Хөрөнгө мөнгө үйлдвэрийн эзэн, худалдаачдад төвлөрч, тэд ажилчдыг хөлслөн ажиллуулж, ашиг орлого олдог байв.	Капитализм бол шинэ үеийн түүхийн нэг гол бүтээл юм. Аж үйлдвэрийн хувьсгалын үр дүнд капитализм цэцэглэн хөгжсөн. Хүн өөрийн чадлаар хөдөлмөрлөж, түүнийхээ үр шимээр амьдрах ёстой гэдэг зарчмыг хэрэгжүүлдэг.	<ul style="list-style-type: none"> <li>• Хөлсний хөдөлмөр</li> <li>• Үйлдвэрийн эзэн</li> <li>• Ажилчин</li> <li>• Хувьцаат компани</li> <li>• Хөрөнгө</li> <li>• Мануфактур</li> </ul>

### Капитализм үүсч хөгжсөн нь



#### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх

- Доорх зургуудад капиталист нийгмийн дүр төрхийг хэрхэн илэрхийлж байна вэ?
- Капитализм нь нийгмийн хөгжилд ямар өөрчлөлт авчирсан бэ?



Манчестер, 1852 он.  
<https://en.wikipedia.org>



Зураг-2.10

Үйлдвэрийн эзэн

Үйлдвэрийн ажилтан

The Nystrom. Atlas of World History. Second edition. Herff Jones Nystrom. Printed in the USA. 2012, 2004, pp.101



#### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

XV зуунд алс аялах чадвартай усан онгоц бүтээж, Америкийг нээсэн нь капиталист эриний эхлэлийг тавив. Эзэнт гүрнүүд бий болж, тэднийг санхүүжүүлэх

худалдааны төвүүд далайн чанадад байгуулагдсан нь дэлхийн худалдаанд түлхэц өгчээ. Капитализм XII зуунаас Европын эдийн засаг, улс төр, соёл, бүр дайны үйл хэрэгт ч нөлөөлөх болов.

Дорноос Европд оруулж байсан барааны үнэ өртөг аяллын зардлаа хэд нугалахаар өндөр байв. Тиймээс худалдаанд хэдийгээр эрсдэл ихтэй ч хөрөнгө оруулалт хийх нь ашигтай байлаа. Шаардлагатай хөрөнгө босгохын тулд худалдаачид хамтарсан компани байгуулах болов. Уг компани нь тодорхой хугацааны дараа хөрөнгө хуримтлуулж эрэлт ихтэй зах зээл эзэмшиж урт хугацаагаар оршин тогтнох болсон юм. Тэд хилийн чанадад худалдааны давуу эрх эдэлж байв.

Тэрчлэн уламжлалт цехийн зохион байгуулалт нэхмэлийн үйлдвэрийн цаашдын чиг хандлагатай зөрчилдөж бэрхшээл үүсэх болов. Иймээс цэмбэний худалдаагаар баяжсан худалдаачид өөрсдийн эзэмшдэг цехүүдийг нэгтгэсэн том фабрик санаачлан байгуулж үйлдвэрийн эзэд болж эхлэв.

XVI зууны үеэс Англид аж үйлдвэрийн анхдагч хэлбэр болох мануфактурууд бий болсон юм. Үйлдвэрийн эзэд ажилчдын хөлс хүчээр асар их ашиг олох болов. Жишээ нь: Зүүний цех өдөрт 20 зүү гаргадаг байсан бол мануфактурын зохион байгуулалтад орсноор өдөрт 1800 зүү үйлдвэрлэх болжээ. Хөдөө аж ахуйн зарим салбарт аж ахуйгаа эрхлэн хөтлөх шинэ арга нэвтэрч эхлэв. Энэ нь эдийн засаг, нийгмийн бүхий л хүрээнд нөлөөлөв. Урьд нь тариалж байсан газар бэлчээр дээр үйлдвэрийн газрууд байгуулагдаж, хотын хүн ам хурдацтай өсөх болжээ.

**Эсэргүүцэл тэмцэл.** Нийгэмд баян, ядуугийн ялгаа улам нэмэгдэж, үйлдвэрийн эзэд, чинээлэг худалдаачдын амьдрал хөдөөгийн иргэд, хотын ажилчдынхаас эрс ялгарах болов. Хүн амын дийлэнх болох жирийн иргэд, эмэгтэйчүүд улс төрийн ямар ч эрх мэдэлгүй байлаа. Үйлдвэрийн газрууд томрон хөгжихийн хэрээр нийгэмд шинэ давхарга бий болсон нь ажилчин анги байв. Тэд өөрсдийн эрх ашгийг хамгаалахын төлөө тэмцэх болж эвлэлдэн нэгдэж эхэлжээ. Сонгуулийн эрхийн төлөө болон нийгмийн баялагийн хувиарлалтанд оролцох, түүнээс хувь хүртэхийн төлөө тэмцэх болов.



### Асуулт, даалгавар гүйцэтгэх

1. Далайн худалдаа хөгжсөн улс оронд ямар давуу тал бий болсон бэ?
2. Хамтарсан хувьцаат компани байгуулсны ач холбогдол юунд орших вэ?
3. Үйлдвэрийн эзэд яагаад том үйлдвэр байгуулах болсон бэ?
4. Бүтээгдэхүүн үйлдвэрлэгч гол хөдөлгөгч хүч нь хэн болохыг тайлбарлаарай.



Хожим XIX зууны дунд үеэс эрх ашгаа хамгаалах гэсэн ажилчдын тэмцэл, хөдөлгөөн улам идэвхжиж, эрдэмтэн судлаачдын дунд капиталист нийгмийн мөн чанарыг судлах, шүүмжлэх явдал эрчимжив. К.Маркс, Ф.Энгельс нар социализм, коммунизмын тухай үзэл онол бий болгов. Тэд капитализмын мөн чанарыг судлан шүүмжлээд, түүнийг түлхэн унагааж, коммунист нийгэм байгуулах үзэл санааг дэвшүүлсэн юм. К.Маркс, Ф.Энгельс нар социализм бол эрх тэгш, сайн сайхан нийгэм байх болно гэж төсөөлж байв. Тэд тухайн үеийн түүхэн нөхцөл байдалд үндэслэн нийгмийн баялгийг бүтээгч гол хүч болсон ажилчин ангийн эрх ашиг, хүсэл сонирхлыг хамгаалж чадахуйц нийгмийн тогтолцоог бий болгох онол боловсруулахыг зорьсон байна.



Марксист онолын үзэл санааг амьдрал дээр бодитой хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг дараа үеийн түүх бидэнд харуулсан юм. XX зуунд Зөвлөл Холбоот Улс тэргүүтэй олон улс социализм, коммунизм байгуулах оролдлого, туршилт хийсэн боловч эцэстээ нуран унасан билээ. Өнөөдөр тэдгээр улс орнууд бараг бүгдээрээ коммунист тогтолцооны алдаа доголдлыг хүлээн зөвшөөрч, капитализмын замыг сонгон замнаж байна. Үүнд ардчлал, зах зээлийн замыг сонгосон Монгол улс ч багтана.

Капиталист тогтолцоо	Социализмын үзэл онол
<ul style="list-style-type: none"> <li>• Хувь хүн, аж ахуй эрхлэгч хэн ч өмчийнхөө эзэн байдаг.</li> <li>• Хувь хүн өөрийн хүсэл сонирхлын дагуу ажиллах, бүтээх боломж нээлттэй байдаг.</li> <li>• Зах зээлд чөлөөтэй өрсөлдөж, илүү хямд, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хүргэх боломж бүрдүүлдэг.</li> <li>• Хэрэглэгчдийн эрх ашиг, хүсэл сонирхлын өрсөлдөөн нь зах зээлийг хэлбэржүүлж, тэнцвэржүүлж өгдөг.</li> <li>• Бизнес тэр хөндлөнгөөс оролцох ёсгүй гэж үздэг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төр улс үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх ёстой.</li> <li>• Хүмүүс хоршоолд нэгдэж, (хамтрал, коммун, нэгдэл) хамтаараа эрх тэгш нийгмийг байгуулна гэж үздэг.</li> <li>• Хөрөнгөтнүүд ажилчдын хүч хөдөлмөрийг шулан мөлждөг бол социалист нийгэмд төр ажилчин ангийн эрх ашгийг ямагт хамгаална.</li> <li>• Капиталист нийгэмд өмчийн тэгш бус байдал үйлчилдэг бол социалист нийгэмд хүн бүрт нийгмийн баялгийг тэгшитгэн хуваарилна.</li> <li>• Улс орныг бүхэлд нь нам төр залж чиглүүлж, удирдах ёстой гэж тунхаглаж байв.</li> </ul>



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг эдийн засгийн гол зарчим болгох нь аль тогтолцооны мөн чанар вэ?
2. Баримт мэдээлэлд тулгуурлан тэр үеийн капиталист тогтолцооны давуу болон сул талыг өөрийн ойлгосноор харьцуулан тодорхойлж танилцуулаарай.
3. Социализмын тухай онолын эерэг тал болон амьдралаас хол ямар үзэл санаа агуулагдаж байсныг судлан шинжилж, санал бодлоо хуваалцаарай.



### Үр дүнг нэгтгэх, танилцуулах

1. “Амстердамд худалдаа эрхэлдэггүй хүн надаас өөр байхгүй”. Рене Декарт (1600-гаад он)-ын хэлсэн энэ үгийн утгыг тухайн нөхцөл байдалтай холбож тайлбарлана уу.
2. Дараах түлхүүр үгийн утгыг тайлбарлана уу.

<ul style="list-style-type: none"> <li>• Хөдөлмөр</li> <li>• Эзэн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ажилчин</li> <li>• Хувьцаат компани</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгө</li> <li>• Мануфактур</li> </ul>
--	---	---



3. Монгол улс 1990-ээд оноос хойш чөлөөт зах зээлийн замаар хөгжиж буй. Өнөөгийн Монголын нийгэм капитализмтай хэрхэн холбогдохыг тодорхойлоорой.



## 6. XV-XVIII ЗУУНЫ ҮЕИЙН ӨРНӨ ДАХИН


ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
XV-XVIII зууны үеийн өрнө дахины түүхэнд Франц, Англи, Орос гүрэн гол байр эзлэх болж, хүчирхэгжин мандав.	XV-XVIII зууны үеийн өрнө дахины улс орнуудын төрийн засаглал, эзэмшил нутаг, хил хязгаар, эдийн засагт томоохон өөрчлөлтүүд гарч, энэ нь дэлхийн түүхэнд багагүй хувь нэмэр оруулсан.	<ul style="list-style-type: none"> <li>• Хэмжээгүй эрхт хаант засаг</li> <li>• Хувьсгал</li> <li>• Тусгаар тогтнолын дайн</li> <li>• Үндсэн хууль</li> <li>• Их гүрнүүд</li> </ul>

Энэ үеийн нэг онцлог нь Европд шинэ улсууд өндийн босож, эрх мэдэл, газар нутгийн төлөө өрсөлдөцгөөх болсон юм. Үүний зэрэгцээ язгууртан вангуудтай засаглалаа хуваалцахыг хүсээгүй хаад хэмжээгүй эрхт хаант засаг тогтоож, засгийн эрхийг ганцаараа барих болсон явдал юм.



### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх

*XV зууны сүүлээс XVIII зуунд Европын олон улс, Африк, Ази, Америкийг холбосон худалдааны том гүрнүүд буй болж хөгжив. Эзэнт гүрнүүд төвлөрсөн хаант засаглал болон үйлдвэржилт, гадаад худалдааны үр дүнд хүчирхэгжиж байв. Өмнө үзсэн сэдвүүдтэйгээ холбон энэ үед ямар улсууд хүчирхэгжин гарч ирсэн талаар Зураг-2.11-ийг ашиглан таамаглал дэвшүүлээрэй.*



## 1. Франц гол тоглогчийн нэг болов.



## Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

**Зуун жилийн дайн** (1337-1453)-д эцэстээ Франц ялж, XI Людвикийн үеэс Франц хүчирхэгжин, дараагийн зуунуудад Европын улс төрийн гол нөлөө бүхий хүчин болсон юм. Франц хэл Европын гол хэл болж хувирав. Язгууртнууд Францын соёлыг эрхэмлэх болжээ.

XV зууны II хагасаас буюу XI Людвикийн үеэс Францад хааны төвлөрсөн засаглал тогтож засгийн эрх нэг хүний мэдэлд шилжжээ. 1598 онд IV Генрих Католик шашны ноёлох байр суурийг албан ёсоор баталгаажуулжээ. XII Людвикийн өөрчлөлтийг XIII Людовик (1610-1643) үргэлжлүүлж 1614 онд Ерөнхий штат (Францын парламент)-ыг тараав. Тийнхүү хэмжээгүй эрхт хаант засаг тогтож, хаант төрийн гол үүрэг нь язгууртан хөрөнгөтнүүд хийгээд худалдаа аж үйлдвэрийг хөхүүлэн дэмжих болжээ.

**Баримт-1** "... Франц улсад 140 гаруй хот, эзэмшил нутаг, шилтгээн цайз, тосгон суурин асар их... хүн ам нь асар олон юм. Ганцхан Парис хотод 4-5 мянган хүн сууна. Оршин суугчид нь чадал чинээ, зэрэг дэвээрээ 3 давхаргад хамаардаг байна. Нэгдүгээр зэрэгт лам нар, хоёрдугаар зэрэгт тайж нар, гуравдугаар нь тодорхой нэргүй, учир нь янз бүрийн чадал чинээтэй өөр өөр ажил хийдэг хүмүүс багтдаг агаад ардын давхраа гэж ерөнхийд нь нэрлэж болно..." (Венецийн Бүгд Найрамдах улсын элч Микель Суриано 1561 онд Франц улсад очоод бичсэн "Францын хаант улсын тухай тайлбар"-аас)

**Тайлбар:** Хэмжээгүй эрхт хаант засаг - Хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх засаглалын бүх эрх мэдлийг зөвхөн эзэн хааны гарт төвлөрүүлсэн төрийн засаглалын хэлбэр.

XIV Людовик (1643-1715) засгийн эрхэнд гарч, 50 гаруй жил Франц орныг захирсан үеийг XIV Людвикийн зуун хэмээдэг. Тэрбээр хэмжээгүй эрхт хаант засаглалыг тахин шүтэж, түүний сонгодог хэлбэрийг тогтоон, хааныг бурхантай адилтгаж үзсэн юм. Аж үйлдвэр, худалдаанд анхаарч, импортын барааны хураамжийг өсгөснөөр дотоодын үйлдвэрлэл, худалдаа, аж үйлдвэр, зам харилцааг эрчимтэй хөгжүүлж чаджээ. Ерөнхий хянагч (сайд) Ж.Кольбере олон арван жил Францыг эдийн засгийн хувьд Европын тэргүүлэгч гүрний нэг байлгав. Европын улсууд Францыг дуурайн гар үйлдвэрлэл эрхлэгчдээ дэмжиж байлаа. Тэд Франц шиг бэлэн бүтээгдэхүүн гаднаас оруулж ирэхэд гаалийн өндөр татвар оногдуулж, гадагшаа гаргах түүхий эдийн татварыг нэмэгдүүлж байв.

**Баримт-2** "...Шүүх цааз бол хэмжээгүй эрхт хаан, хаант улсаа захирах буянт үйлсийн хамгийн гол зайлшгүй хэсэг юм... Парламент болон манай шүүхийн зөвлөгчид дарга, бусад албан тушаалтан түшмэдүүд шүүхийн гаргасан шийдвэрийг өөрчлөх буюу түүнээс татгалзах эрх байхгүй". (XII Людовик (1498-1515)-ийн зарлигаас)

«Нэг бодол, нэг асуудал, нэг хаан л байх ёстой. Миний хүсэл зориг ийм байна». "Нийгмийн дэглэм, хэм хэмжээ бүхэлдээ надаас хамаарна. Үндэстний сонирхол, эрх ашиг, эрх энэ бүхэн миний гарт байна. Төр бол би" (XIV Людовик (1661-1715)-ийн хэлсэн үг)

Олон удаагийн дайнаар газар нутгаа өргөтгөж, баруун Европт Франц улс зонхилох

байр суурьтай болсон байна.

XVII зууны үеэс Францын тариачид дотроо хөрөнгө чинээгээрээ ялгаран хуваагдаж, газаргүй ба бага газартай тариачид нь их газартай тариачдад хөлсөөр ажиллах болжээ. Хөдөөд гар үйлдвэр, гоёл чимэглэл, нэхмэлийн салбар хүчтэй хөгжиж, хөлсний ажилчдыг төрүүлэв. Хотод байгаа үйлдвэрүүд нь мануфактурын шинжтэй болж, Францын хотууд нь аажмаар үйлдвэр, худалдаа, соёлын төв болон хувирчээ.

Францын эзэн хаадын үе залгамжлал (1328-1870)							
Валуачууд (1328—1589):							
1328	1350	1364	1380	1422	1461	1483	1498
Филипп VI	Иоанн II	Карл V	Карл VI	Карл VII	Людвик XI	Карл VIII	
1498	1515	1547	1559	1560	1574	1589	
Людвик XII	Франциск I	Генрих II	Франциск II	Карл IX	Генрих III		
Бурбончууд (1589—1792):							
1589	1610	1643	1715	1774			1792
Генрих IV	Людвик XIII	Людвик XIV	Людвик XV	Людвик XVI			
1792	1804	1814	1824	1830	1848	1852	1870
—	Наполеон I (Бонапарт)	Людвик XVIII	Карл X	Луи-Филипп I (Орлеаны)	—	Наполеон III (Бонапарт)	



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Францын төр яагаад язгууртнууд, хөрөнгөтнүүдийг дэмжиж байсан бэ?
2. Баримт-1-д тулгуурлан хэмжээгүй эрхт хаант засгийн гол шинжийг тодорхойлоорой.
3. Баримт-2-ыг уншаад Парисын хүн ам ямар давхаргад хэрхэн хуваагдаж байсныг харилцан ярилцаарай.
4. XVII зууны Францад яагаад импортын барааны хураамжийг өсгөх бодлого хэрэгжүүлсэн бэ?
5. XVII зууны Францын нийгмийн амьдралыг сэргээн төсөөлж, тодорхойлоорой.

## 2. Англи аажмаар дэлхийд тэргүүлэгч гүрэн болов.



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах



I Элизабет

Зуун жилийн дайнд Англи ялагдал хүлээсэн явдалд хааныг буруутгаж, эсэргүүцэл тэмцэл гарах болов. Энэ нь улаан цагаан сарнайн дайн гэх иргэний дайнд (1455-1487) хүргэв. Олон жилийн дайны төгсгөлөөр Английн хаан ширээнд VII Генрих (1485-1603) сууж, Тюдорын угсааныхны засаглал эхлэв.

Английн гол өрсөлдөгч нь Испани байсан ч 1553 онд Тюдорийн Мария Испанийн хунтайж II Филипптэй гэрлэж асуудлыг шийджээ. Харин хатан хаан I Элизабет

(1533-1603) худалдаа, үйлдвэрийг дэмжиж, Испанитай тэмцэж байв. 1588 онд Филипп Английн эсрэг “Ялагдашгүй Армада” хэмээх 130 орчим онгоц бүхий усан флотоо илгээжээ. Гэвч тэднийг ялснаар Англи дэлхийд тэргүүлэгч далайн гүрэн болсон юм.

XVI зууны Англид хэмжээгүй эрхт хаант засаг бэхжиж, 1629 онд I Карл хаан парламентыг тараав. 1640 онд Англид хөрөнгөтний хувьсгал дэгдэв. Хаант засгийг дэмжсэн өмнөд нутгийн тайж, газрын эзэд болон парламентыг дэмжсэн төвийн бүсийнхний хооронд 1642-1649 онд иргэний дайн явагдав.

1649 оны 1-р сарын 30-нд хааныг цаазлан, 5-р сарын 19-нд Бүгд найрамдах улсыг тунхаглажээ. 1651 онд парламентын талыг баримтлагч Оливер Кромвель засгийн эрхийг авав. Гэвч 1660 онд II Карл хаан ширээнд өргөмжлөгджээ. 1688 оноос Англид үндсэн хуульт хаант засаг тогтжээ.

**Тайлбар:** Үндсэн хууль-нийгэм ба төрийн байгууламж, харилцааг тодорхойлох гол хууль

**Улс төрийн байдал:** 1689 онд парламентын шийдвэрээр II Яковыг хаан ширээнээс буулгаж, Нидерландын В.Оранскийд шилжүүлж, эрхийг нь хязгаарлажээ.

XVII зууны сүүлээс Английн парламент худалдаа, үйлдвэрийн хөрөнгөтнүүдийн бие төлөөлөгчдийн нөлөөгөөр эрх ашгийг нь хамгаалсан улс төр, эдийн засгийн арга хэмжээ авч байв.

Колонийн бодлогын хувьд Нидерланд, Испани, Португали, Францыг шахаж чадсан бөгөөд Энэтхэгт амжилт олов. Харин Америк дахь бодлого нь уналтад оржээ.

**Эдийн засгийн байдал:** XV-XVI зууны үед Англид тариачдын газрыг хүчээр булаан авч бэлчээр болгосныг “Хашаалалт” хэмээдэг. Ноосон бүтээгдэхүүний эрэлт өссөн тул хонины аж ахуй эрчимтэй хөгжив. Газаргүй болсон тариачид мануфактур (хөлсний ажилчдын хүчээр бүтээгдэхүүнийг дамжлагаар үйлдвэрлэх газар)-ын ажилчид болжээ. XVII зууны эцсээс үйлдвэрүүд өргөжиж, цаашид машинт үйлдвэрлэлд шилжих нөхцөл бүрэлдэв.



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Английн иргэний дайны шалтгаан, үр дагаврын холбоог тайлбарлаарай.
2. Үндсэн хуульт хаант засаглал болон хэмжээгүй эрхт хаант засаглалын давуу, сул талыг тодорхойлоорой.

### 3. Орос улс сэргэн босов.



#### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

Алтан ордны улсын суурин дээр XVI зууны эхээр Орост төвлөрсөн улс байгуулагдаж, сэргэн мандаж эхлэв. 1606-1607 онд И.Болотниковын удирдсан бослого гарсан ч дарагджээ.

Хөдөө аж ахуй зонхилсон Оросын хүн ам энэ үед 7 сая орчим байсан бөгөөд анхны мануфактур байгуулагдав. XVII зуунд өмнөд Урал, Сибирь зэрэг олон газрыг нэгтгэн улсаа 250 уездэд (нутгийн засаг захиргааны анхдагч нэгж) хуваан захирав.

1648-1649 онд Нутгийн захиргааны чуулган хаан Алексей Михайловичийн “Бүгд хууль”-ийг баталсан нь 1832 он хүртэл мөрдөгджээ.

XVII зуунд Орост томоохон хотуудын тоо аажмаар нэмэгдэж, худалдаа өсч, хүн амын татвар болон төрийн алба тогтворжин, улс орон мэдэгдэхүйц хөгжиж байлаа. Гэвч XVII зууны сүүл үед Орос нь Европын хөгжингүй орнуудаас үйлдвэрлэлийн өсөлт зэргээр хоцронгуй байв.


Балтийн болон Хар далайд гарцгүй ч Каспи, Цагаан тэнгист далайн боомт, худалдааны хөлөг онгоц барих ажил эхлүүлэв. Тэр үед тухайн улсын хүчин чадлыг тодорхойлоход цэргийн болон худалдааны онгоцны тоо, их буу, зэр зэвсэг, сум, дарь үйлдвэрлэх төмрийн нөөц, цэрэг дайны ур чадвар зэрэг нь чухал үзүүлэлт болдог байв.

Тухайн үеийн тайж нар өөрсдийн гадаад байдлаараа эцэг өвгөдөөсөө эрс ялгарах болов. Европ маягийн гадуур богино цамцаар Москвагийн урт хүрмийг сольж, толгойдoo хиймэл үс ба гурвалжин малгай, хөлдөө ботфорт (урт түрийтэй савхин гутал) өмсдөг болов.



I Петр хаан

1682 онд I Петр Оросын хаан ширээнд суув. Тэрээр баруун Европын үлгэр жишээгээр улс орноо хөгжүүлэх бодлого баримталж байв. Дотоод гадаад бодлогоо шинэчлэн, Орос улс түүхийн тавцанд сэргэн босож ирэв.



## Оросын хаан ширээ залгамжлал (1547-1721)



№	Хаан	Хаанчилсан он
<b>Рюриковичийнхан:</b>		
1	Иван IV Васильевич Грозный (1530-1584)	1547-1584
-	Симеон II Бекбулатович. (? — 1616)	1575-1576
2	Федор I Иванович (1557—1598)	1584-1598
<b>Годуновынхан:</b>		
-	Ирина I Фёдоровна (1557—1603)	1598-1598
3	Борис I Фёдорович (1552—1605)	1598-1605
4	Федор II Борисович (1589—1605)	1605-1605
<b>Үймээний үе:</b>		
5	Лжедмитрий I (Дмитрий Иванович). (? — 1606)	1605-1606
6	Василий IV Иванович Шуйский (1552—1612)	1606-1610
-	Владислав I Жигимонтович (1595—1648)	1610-1613
<b>Романовынхан:</b>		
7	Михаил I Федорович (1596—1645)	1613-1645
-	Патриарх Филарет (1554—1633)	1619-1633
8	Алексей I Михайлович (1629—1676)	1645-1676
-	Алексей Алексеевич (1654—1670)э	1654-1670
9	Федор III Алексеевич (1661—1682)	1676-1682
-	Софья Алексеевна (1657-1704)	1682-1689
10-	Иван V Алексеевич (1666—1696)	1682-1696
11	Их Петр I Алексеевич (1672—1725)	1682-1721

- Ёс төдий хаан байсан



## Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

- XVII зуунд улс орны хүч чадлыг юугаар хэмждэг байв? Үүний учир юу вэ?
- Орос улс хүчирхэгжихэд нөлөөлсөн хүчин зүйлүүдийг сурвалж баримт ашиглан тодорхойлоорой.
- Зураг-2.12-ийг ашиглан XV-XVII зууны Орос улсын тэлэлтийг ялган тодорхойлоорой.



## Үр дүнг нэгтгэх, танилцуулах

- Өрнө дахины улсууд дэлхийд хэрхэн нөлөөгөө тогтоосон бэ?
- Бидний төлөөлөл болгон судалсан Европын томоохон улсуудын нийтлэг болон ялгаатай тал юу байсан бэ?

Өрнө дахины улсуудын хөгжлийн шалтгаан юунд байсан бэ?	Өрнө дахины улсууд хоорондоо хэрхэн харилцаж байсан бэ?	Өрнө дахины улсуудад шинэчлэл хэрхэн хэрэгжсэн бэ?	Шинэчлэлийн үр дүн юу вэ?



## 7. XV-XVIII ЗУУНЫ ҮЕИЙН ДОРНО ДАХИН

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
Дорно дахины улсууд энэ үед тусгаарлагдмал байдалтай, бослого тэмцэл, дайн тулаан ихтэй байсан.	Тухайн үеийн дорно дахины улсуудын үндэс суурин дээр өнөөгийн улсууд бий болсон юм.	<ul style="list-style-type: none"> <li>• Улс төр</li> <li>• Эдийн засаг</li> <li>• Бослого, тэмцэл</li> <li>• Засаглан хаах</li> </ul>



### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх

*Дорх нэргүй газарзүйн зураг ашиглаж, XV-XVIII зуунд дорно дахинд ямар хүчирхэг улс гүрнүүд оршин тогтнож байсан талаар таамаглал дэвшүүлээрэй.*



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

**Мэдээлэл-1. Мин улс.** XIV зууны дунд үеэс Хятад оронд Монголын захиргаанаас гарах үзэл, оролдлого идэвхжсэн юм. Тухайлбал, 1348 онд тариачдын хэд хэдэн бослого дэгдэж, төдөлгүй бүх Хятадыг хамарч, газар сайгүй эсэргүүцэл тэмцэл өрнөв.

Ядуу тариачин Жу Юань Жан босогчдыг толгойлж, тариачдын их цэргийг байгуулав. Тэд ард түмний дэмжлэгийг хүлээж, олон хотыг эзлэн авчээ. 1368 онд

Наньжин хотыг эзлэн авч, өөрийгөө “Хуанди”, улсаа “Мин” хэмээн нэрлэжээ. Улмаар Жу Юань Жан умар зүг довтлон Бээжинг эзлэн авснаар хятад дахь Монголын ноёрхол эцэс болжээ. (Нанжин-түүхэнд “Өмнөд нийслэл” гэгддэг, 1368–1420 онд Мин улсын, 1928–1937 болон 1945–1949 онд Дундад Иргэн улсын нийслэл байсан).

Шинэ хаан тариачин өрхийн газрын хэмжээг нэмж, газар хуваарилах ажилд хатуу хяналт тавьж, дотоод, гадаад худалдааг дэмжиж, бараа таваарын үнийг хямдруулах, улсын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг хуваарилах, зарим бараанд худалдааны онц эрх эдлэх явдлыг хэвээр үлдээжээ. Худалдаанд хэрэглэх зэс зоос гүйлгээнд гаргаж, алт, мөнгөн зоос хэрэглэхийг хориглосон боловч энэ нь хэрэгжсэнгүй.

XVI зууны үеэс Европчууд Мин улстай худалдааны харилцаа тогтоохыг эрмэлзэх болсон байна. Анхлан Португаличууд Мин улсад худалдааны газар байгуулахыг зорьж, 1557 онд Макао (Аомень)-г эзлэн авч суурьшжээ. Дараа нь Испани, XVII зууны сүүлийн хагасаас Нидерланд, Англичууд ирж худалдаа наймаа эрхлэх болов.

XV зууны үеэс нийгэм, эдийн засаг, шашин хоорондын зөрчлөөс үүдэн Мин улс хямралын байдалд орж эхэлжээ. Эцэст нь Ли Зы Чэний удирдсан тариачдын бослого гарсан нь Мин улсыг мөхөхөд багагүй нөлөө үзүүлжээ. 1644 онд босогчид Бээжинг эзлэн авахад Мин улсын эрх баригчид, жанжид Чингийн цэрэгт Цагаан хэрмийн хаалгыг нээн өгч бослогыг хүч хавсран даржээ. Энэ үйл явдлаар Мин улс мөхөж, Манж Чин улсын эрхшээлд орсон байна.



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

**Мэдээлэл-2. Япон.** XVI зууны 60-аад оноос XVII зууны 60-аад он хүртэлх 100 жилийг Японы түүхэнд “дайтагч улсуудын үе” хэмээн нэрлэдэг. Энэ үеийн Японы эзэмшилд Хонсю, Кюсю, Сикоку гэсэн 3 том арал болон бусад жижиг арлууд харьяалагдаж байв. Японы түүхэнд “аугаа их гурвал” хэмээн нэрлэгдсэн Ода Нобунага, Тоётоми Хидэси, Токугаваи Иэясу нар Япон орныг нэгтгэж, нэгдсэн улс байгуулахад ихээхэн гавьяа байгуулжээ.

Ода Нобунага 1568-1582 онд Хонсю арлын төв хэсэг, Киотогийн болон Эдо (Токио)-гийн ойролцоох газар нутгуудыг нэгтгэсэн юм. Тэрээр төр барьж байх үедээ Японы ихэнх нутгийг эзэлж, эзэлсэн газар нутагтаа их хэмжээний татвар оногдуулж, эсэргүүцэл гарах аваас хэрцгийгээр дарж байлаа. Тариачдыг газартай хадаж, “газрын гэрээ” гэгчийг байгуулав. Томоохон худалдаачдыг засгийн газартай холбож, худалдааны дангаар ноёлсон нэгдлүүдийг устгаж, худалдааг өргөжүүлэн хөгжүүлсэн юм.

Хидэсигийн үед тариачдын бослого ихээр гарах болсон. Цэргийн хүчээ бэхжүүлэхийн тулд цэргийн албыг тариачны ба иргэний гэсэн хоёр хэлбэрээр гүйцэтгүүлэх болсноор тариачид мэргэшсэн цэрэг болов. Гэвч тариачдын бослого ихээхэн газар авсан тул тариачдын зэвсгийг хурааж, “жад авлах” нэрийн доор тариачдын эсрэг тэмцжээ.

Хидэеси улс орноо “засаглан хааж” хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, Европын шашин номлогчдын үйл ажиллагааг хязгаарлаж, шашин номлогчдын эсрэг тэмцэх болов. Шашны номлогчдыг мэдээлсэн хүнийг 100 ембүүгээр шагнаж зарлиг гарсан нь 200-300 ембүү болтлоо өсчээ. Европ хүмүүсийг хянаж, Японд амьдрах хугацааг 9 сар, 20 хоногоор тогтоов. Европын бараа худалдаж авсан самурай нарт хүртэл шийтгэл оногдуулах болжээ.

**Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах**

**Мэдээлэл-3. Чусон улс.** Энэ үед солонгост Чусон улс оршин тогтнож байв. XVI зууны 80-аад оноос Япон улс Чусоны өмнөт боомтууд руу довтлох болжээ. 1592 оны 5-р сард Япон 200 000 цэрэгтэйгээр Пусаныг довтлон эзэлжээ. Улмаар Сөүлийн зүг хөдөлж, замдаа засгийн газрын цэргийг Чхунжугийн талд бут цохисон байна. Хаан ойр төрлийнхнөө авч хойт зүг зугтжээ. Япончууд Сөүл, цаашлаад Пхеньяныг эзэлжээ. Тийнхүү Япончууд солонгосын газар нутгийн ихэнхийг эзлэн авч, нутгийн ард олныг эрхшээн захирсан байна. Гэвч солонгосын ард түмэн үүнийг эсэргүүцэн “үнэн хэргийн төлөө” дайчдын бүлгүүд, сайн дурын цэргийн хүчнийг бий болгон тэмцжээ. Энэ тэмцэлд Ли Сун Сины удирдсан усан флот чухал үүрэг гүйцэтгэжээ. Тэрээр байлдааны хөлөг онгоцоо боловсронгуй болгож, үхэр буу, галт сумаар зэвсэглэсэн байна. Ли Сун Син Японы цэргийн ар тал болж байсан усан цэргийн флотыг бут цохисноор ялалтын эхлэлийг тавьжээ. Мөн энэ үед Хятадын 50 000 хүнтэй арми Чусонд тусалсан нь тэдний тэмцэлд чухал нөлөө үзүүлжээ.

XVII зууны эхээр Японы санаачилгаар хоёр улс найрамдаж, олзны хүмүүсээ буцаан, Пусан боомтоор худалдаа хийж, харилцан элч зарж, бэлэг сэлт солилцжээ.

Гэвч тун удалгүй Чусонд бас нэгэн дайсан бий болсон нь Чин улс байлаа. Тэд 1637 онд Чусоныг эзлэн, түшмэг улсаа болгож, Хятадтай хийх байлдаанд хөлөг онгоц, зэвсэг хэрэглэл, хүн хүчний туслалцаа үзүүлэх үүрэг хүлээлгэжээ. Мөн жил бүр алт мөнгө, цагаан будаа, торго хөвөн даавуу, цаасны алба барихаар болсон байна. Энэ мэтээр Чусон улс энэ үед гадны довтолгоо, тэмцэл тулааны хөлд сүйдэж, хөдөө аж ахуй, гар үйлдвэр нь уналтанд орсон ажээ.

**Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах**

**Мэдээлэл-4. Моголын эзэнт улс.** 1525 онд Бабур хаан Хойд Энэтхэгийг эзэлж, “шах”-аар өргөмжлөгдөв. Ийнхүү тэр олон үндэстэн, угсаатныг нэгтгэсэн Их Моголын эзэнт улсын үндсийг тавьсан юм. Моголын эзэнт улсын газар нутаг нь баруун хойд хэсэгтээ Афган, Кашмир, Пенжаб, Синкх аймгууд, баруун талдаа Кашмир, зүүн талдаа Бенгал, өмнө талаараа Памир, Декканы тал хүрч байв. Моголын эзэнт гүрэн нь Бабур, Акбар, Ауранзэв хаадын үед газар нутгаа их хэмжээгээр тэлжээ.

Акбар хаан улс орноо төвлөрүүлэх бодлогыг хэрэгжүүлж, бие даасан хаант улсуудыг нэгтгэж, орон нутгийн ноёдын газар нутгийг хураан авснаар хааны эрх мэдэл үлэмж нэмэгдэв. Акбарын хийсэн бас нэг шинэчлэл бол албан татварын өөрчлөлт юм. Үүгээр газрын үржил шим, тарьж байгаа ургамлын төрөл зүйлийг харгалзан тариачин тус бүрт алба ноогдуулах болжээ. Тариачин бүрийн эзэмшилд байгаа газрыг тоолж, хэмжээг нь гаргаж, газрын чанарыг тодорхойлов. Татварыг мөнгөөр авах болсон байна. Мөн энэ үеийн газар эзэмшлийн зонхилох хэлбэр нь “жагир” байв. Энэ нь Шах-д алба хааж буй түшмэдэд өгдөг томоохон эзэмшил газар юм. Жагирын эзэмших дундаж хугацаа арваас илүүгүй жил байв. Алба хаахаа боливол газрыг хураан авна.



**Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах**

**Мэдээлэл-5. Осман (Оттоман)-ы эзэнт улс.**

Бага Азийн хамгийн баруун этгээдэд оршиж байсан нэгэн аймгийн удирдагч Осман 1299 онд хаант улс байгуулсан нь түүхэнд түүний нэрээр алдаршжээ. Тэд газар нутгаа өргөтгөх зорилгоор аян дайн хийж байв. II Махмудын үед тэд Константинополийг эзлэн авахаар довтолжээ. Константинополь нь хуурай ба усан замын уулзварт, хоёр тивийн зааг дээр байрлах, худалдаа, соёлын харилцааны томоохон төв байсан юм. Тэд Константинополийг 100 мянган цэргээр бүслэн довтолсон бол хотыг түүнээс 10 дахин бага цэрэг хамгаалж байжээ.

II Махмуд Константинополийг эзлэн аваад, нийслэлээ болгож, Истанбул хэмээн нэрлэсэн нь одоо ч энэ нэрээрээ буй. Ийнхүү Балканы хойг, Бага Азийг эзэлсэн хүчирхэг гүрэн бий болжээ. Туркт тариачид ноогдол газрынхаа ургацын 10 хувийг татварт өгнө. Мөн тээрмийн алба, малын татвар, гэр бүл болсны, газар ашигласны торгууль төлөхөөс гадна, цэрэгт явах, зам гүүр, хэрэм бэхлэлт барих зэрэгт дайчлагддаг байв. Тариачид газраа үе улируулан эзэмших ба боловсруулаагүй тохиолдолд газраа хураалгадаг байжээ.



**Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх**

1. Мин улс цаашид оршин тогтнож чадаагүйн шалтгаан юу вэ?
2. Япончууд өөрийн улсаас Европчуудыг хөөх болсны учир шалтгаан юу байв?
3. Европчуудыг шахан гаргасан бодлого Япон улсын хөгжилд ямар нөлөө үзүүлснийг хамтран хэлэлцэж гаргаарай.
4. Энэ үеийн Чусоны түүхийн гол онцлог юу вэ?
5. Моголын Эзэнт гүрний нэр хийгээд хаадын удам гарлын талаар судалж танилцуулаарай.
6. Османы Эзэнт гүрний суурин дээр өдгөө ямар улс оршин тогтнож байна вэ?



**Үр дүнг нэгтгэх, танилцуулах**

1. Мэдээлэл 1-5-д тулгуурлан дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

Баримт	Гол төлөөлөгч	Зорилго, шалтгаан	Шийдсэн асуудлууд
Мэдээлэл-1			
Мэдээлэл-2			
Мэдээлэл-3			
Мэдээлэл-4			
Мэдээлэл-5			

2. Гол үйл явдлыг ашиглан он тооллын шулуун үйлдэж, тухайн он тооллууд улс орон, хүмүүсийн амьдрал, соёлд хэрхэн нөлөөлснийг задлан шинжилж, нэгтгэн дүгнээрэй.
3. Эрэл хайгуул хийж, дараах түлхүүр үгийн утгыг тайлбарлаарай. (засаглан хаах бодлого, бослого тэмцэл, газрын гэрээ, газар эзэмшил)



## 8. XV-XVIII ЗУУНЫ ҮЕИЙН ДЭЛХИЙН УЛС ТҮМНИЙ АМЬДРАЛ, СОЁЛ

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
XV-XVIII зууны эхэн үеийн өрнө ба дорно дахины ард түмэн өөрсдийн онцлог дүр төрх, хэв маягтай аж төрж байв. Энэ үед дэлхийн улс түмний соёлын хөгжил ч шинэ шатанд гарчээ.	Өрнө, дорнын улс түмний аж амьдрал хэрхэн өөрчлөгдсөн, түүнд ямар хүчин зүйл нөлөөлсөн, ахуй соёлын хувьд тэд юугаараа ялгаатай, тэдний соёлын үнэт зүйл юу болохыг танин мэдэх	<ul style="list-style-type: none"> <li>• Амьдралын хэв маяг</li> <li>• Соёл</li> <li>• Өвөрмөц ёс заншил</li> <li>• Эрхлэх аж ахуй</li> </ul>



### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх

*Түүх олон талтай, олон бүрдэл хэсэг, олон өнгө төрх, баялаг агуулгатай, тэр бүхнийг өөртөө багтаасан хоорондоо харилцан хамааралтай нэг бүхэл цогц зүйл. Түүний нэг нь тухайн цаг үеийн хүмүүсийн амьдрал, соёл билээ.*

*Та бүхэн өмнө үзсэн сэдвүүдээ эргэцүүлж бодоорой. XV-XVIII зууны үед дэлхийн түүхэнд ямар өөрчлөлт гарсан бэ? Өрнө дахинд ямар онцлог, шинэ содон үйл явдал энэ үед өрнөсөн билээ? Тэр бүхэн энэ үеийн хүмүүсийн амьдралын дүр төрх, соёлын хөгжилд зүй ёсоор тусгалаа олсон юм.*

*Сурвалжийн мэдээнд тулгуурлан тэр үеийн хүмүүсийн амьдрал, соёлд гарсан өөрчлөлтийн талаар асуулт гаргаж, таамаглал дэвшүүлээрэй.*

### Өрнийхөний амьдрал, соёл.



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

Сэргэн мандалтын үеийн хүмүүнлэг үзэлт зохиолчдын нэг Томас Мор хашаалалт ба хонины аж ахуйг хөгжүүлснээр XVI зууны Английн нийгмийн амьдралд бий болсон зовлон бэрхшээл, ирээдүйд ямар нийгмийг хүмүүс хүсэж байгааг харуулсан “Утопи” гэх алдартай зохиол бичсэн юм. Түүний зохиолд тулгуурлан тэр үеийн Европын ард түмний аж амьдралын дүр зураг, хүсэл мөрөөдлийг судалж үзэцгээе.

**Баримт-1.** “Биеэр бага танай хонинууд эдүгээ догшин ширүүн, идэмхий хомхой болж, бүр хүн барьж идэж, тариан талбай, гэр байшин хот сууринг цөлмөн хоосолж байна гэж ярилцах болов. Үнэт нарийн ноост хоньтой тэдгээр сурвалжит язгууртанууд, бүр зарим гэлэн лам нар хүртэл өвөг дээдсийнхээ үлдээсэн эзэмшлээсээ жилд олдог орлогодоо үл ханаж, баян тансаг амьдрал нь нийгэмд ямар ч ашиг өгөхгүй байгаагаар үл барам харин ч хор хүргэж байгаад сэтгэл нь их гонсгор сууна. Ийнхүү тэд өөрийн эзэмшилд тариа тарих нэг ч газар үлдээлгүй, байшин савыг нурааж, хот тосгоныг эвдэж, зөвхөн сүмийг гахайн байр болгохоор үлдээн бусдыг малын бэлчээр болгов...”

(Томас Мор. Утопия. М., 1953 с. 62-64)

**Баримт-2.** Бүх эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд ч ялгаагүй зөвхөн газар тариалан эрхлэх бөгөөд түүнээс хэн ч эс чөлөөлөгдөнө. Хүн бүрийг бүр багаас нь сургуулиар онолыг нь зааж хотын ойролцоох тариалангийн талбайд тоглуулах гэж байгаа юм шиг аваачиж үзүүлэхийн хамт бас биеийн тамирын дасгал болгож ажиллуулдаг юм. Газар тариалангаас (бүх хүн үүнийг эрхэлдэг гэж би хэлсэн билээ) гадна хүн бүр ямар нэгэн тусгай гар урлалыг эрхэлж сурна. Энэ нь ердийн ноос нэхэх, маалинга нэхэх буюу чулуучин, эсвэл дархан мужааны ажил байдаг...

(Т. Мор Утопия с.116-118)

**Баримт-3.** *Нэхмэлчдийн тухай баримт (1555).* “Энэ ханлигийн нэхмэлчид, цэмбэ үйлдвэрлэдэг баячууд янз бүрийн аргаар биднийг хавчин хоосруулж байна гэж парламентад гомдол мэдүүлэх болов. Тэдний нэг хэсэг нь гэртээ олон тооны суурь машин тавьж, нэхэж чаддаггүй олон хүнийг түүн дээрээ ажиллуулж, гараар нэхэх урлалд мэргэшсэн олон тооны гар урчуудыг хоосруулж байна. Нөгөө хэсэг нь олон суурь машин цуглуулаад, түүнийгээр гэр бүл, эхнэр хүүхэддээ, тэр бүү хэл, өөрийгөө тэжээх аргагүй өндөр төлбөр төлөх болзолтойгоор ядуу гар урчуудад өгч байна. Урьдын адил даавуу, цэмбэ нэхэхэд хуучнаас бага хөлс төлж байгаа болохоор гар урчууд сурсан мэргэжлийн ажлаа хаяхаас өөр аргагүй болж байна”

(Хрестоматия по социально-экономической истории Европы. с. 200)

XVI зууны үед Английн хүн ам 2.5-3 сая байсан нь Испаниас 3 дахин, Францаас 5 дахин цөөн байв. Англид хонины аж ахуй хөгжиж, нэхмэлийн үйлдвэрүүдийг байгуулан, цэмбэ даавуу дотооддоо үйлдвэрлэх болжээ. Хонь өсгөх шаардлагаас үүдэн газар эзэмшигчдээс газрыг нь авч бэлчээр болгосноор тариачид газаргүй болж хоосорчээ. Хоосорсон тариачид хотод нэхмэлийн үйлдвэрт хөлсөөр ажиллах болсон байна. Тийнхүү ажилчин хэмээх шинэ давхарга бий болжээ.



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Ажилчин хүн гэж хэнийг хэлэх вэ? Тэр үед ажилчин хүн хэрхэн ажиллаж, амьдарч байв? Тунгаан бодоорой.
2. Үйлдвэржилт Европын хүн амын уламжлалт амьдралын хэв маягийг хэрхэн өөрчилсөн бэ?
3. Баримтуудыг задлан шинжлээрэй.

	Баримтын утга	Гол санаа	Хийх дүгнэлт
Баримт-1			
Баримт-2			
Баримт-3			

XV зууны үед Европт Италийн Болони, Парис, Праг, Английн Оксфордын их сургуулиуд байгуулагдаад байв. Хотууд хөгжихийн хирээр үйлдвэр худалдааны орлогыг тооцох, хөтлөн явуулдаг боловсрол мэдлэгтэй хүний хэрэгцээ шаардлага улам нэмэгдсэн. Үүнтэй уялдаж хотуудад иргэний сургуулиуд байгуулагдах болов. Ийм сургуульд бичиг үсэг, тоо бодлого үзэхийн хамт байгалийн шинжлэх ухааны зарим мэдлэг олгодог байжээ.

Улмаар нягтлан бодогч, хуульч, инженер техникч, багш, эмч зэрэг тусгай мэргэжил боловсролтой хүмүүсийн хэрэгцээ шаардлага өсөж, оюуны хөдөлмөр эрхэлдэг бүлэг хүмүүс буюу сэхээтнүүд бий болжээ.



Оросын түүхэнд нэрээ мөнхөлсөн Монгол хүн. Эмгэний Бороноо (1678-1754) бол Монголд, Сэлэнгэ мөрний хөвөөнд төрж, 13 настайдаа Орост олзлогдон, Михаил Иванович Сердюков гэх овог нэртэй болж, хожмоо Орос даяар алдаршсан худалдаачин, усан байгууламжийн нэрт мэргэжилтэн, зохион бүтээгч болсон юм. 1700 онд I Петр хаантай уулзаж, авьяас, чадвар, үнэнч шударга байдлаараа үнэлэгдэн, хааны итгэн даалгасан алба үүргийг гүйцэтгэх болжээ.

Орос, Англи, Итали, Франц, Нидерланд зэрэг олон орны мэргэжилтнүүд үзэж судлан боломжийн шийдэл олж чадахгүй байхад М.И.Сердюков Вышневолокийн усан системийг барьж байгуулах өөрийн өвөрмөц төслийг I Петр хаанд өргөн барьж, 1719-1723 онд түүнийгээ амжилттай хэрэгжүүлж алдаршсан юм. Тэрээр цогц шинжтэй олон далан, суваг байгууламжуудыг барьж, шинэчлэн, цэрэг-улс төр, худалдааны маш чухал усан замын сүлжээг бий болгосноороо Орос гүрний түүхэн хөгжилд чухал хувь нэмэр оруулжээ. (В.С.Виргинский, М.Я.Либерман. Михаил Иванович Сердюков (1678-1754). Орос хэлнээс орчуулсан Э.Дондов. "Мир" хэвлэлийн газар. М., 1989)

### **Дорныхоны амьдрал, соёл.**

XV-XVIII зууны үеийн дорно дахины улс түмний амьдрал, соёл өөрчлөгдөн хөгжиж байсан юм. Энэ бүхнийг Монголын төдийгүй Энэтхэг, Мин, Япон, Солонгос зэрэг олон орны түүхээс харж болно.

Тухайн үед дорно дахины ихэнх улс орнуудад хамжлагын харилцаа ноёрхож, нийгэм нь олон давхаргаас бүрддэг байлаа. Жишээ нь: Мин улсад хүн амыг язгуур угсаагаар нь ангилж:

1. Дээд язгууртны давхарга
2. Том ноёд, худалдаачид
3. Дунд, жижиг газар эзэмшигчид, түшмэд
4. Тариачид, гар урчууд
5. Боолууд гэж хувааж байв. Боолууд болон олзлогсдыг бүх насаар нь үе дамжуулан боол болгох ба өрөнд орж, хоосорсон тариачид, ядуучууд боол болох явдал түгээмэл байжээ.


Мин улс дорно дахины суурин соёлын үндсэн голомт хэвээр байж, энд уламжлалт хэв шинжээ хадгалсан өвөрмөц аж амьдрал, соёл өрнөн хөгжиж байв.

Хөх мөрний адгаар байсан томоохон хотуудад нэртэй том эрдэмтэд, зохиолч, урлаачид аж төрдөг, тэнд улсын нийт ном хэвлэлийн тал орчим хувийг хэвлэн гаргадаг байв. Үүний учир юунд байсныг эргэцүүлж бодоод санал солилцоорой.

Мин улс өөрийгөө гадаад ертөнцөөс тусгаарлаж, христийн шашны төлөөлөгчид ч тус орныг орхин одоход хүрчээ. Гэвч XV зууны сүүл үеэс Италийн санваартнуудад Мин улсад суух зөвшөөрөл олгож, шашнаа номлож, сүм байгуулах эрх олгосон байна. Тэд хятадуудын дунд христийн сургаалыг номлохын хамт тэдний уламжлалт шүтлэгийг хүндэтгэн хүлээн зөвшөөрч байлаа.

Мин улсын хоёр нийслэл Бээжин, Нанжинд дээд сургууль нээгдэж, бүх төрлийн сургууль төрийн хяналтанд оршиж байв. Түүх, газар зүй, анагаах ухаан, техник, урлагийг багтаасан их нэвтэрхий толь гаргав.

XV-XVIII зуунд уран барилга сэргэн хөгжиж, уран тансаг сүм хийдүүдийг барьж байгуулжээ. Цагаан хэрмийн ихээхэн хэсгийг шинэчлэн засварласан байна. XV- XVII зуунд Бээжин хотод эзэн хааны их ордон баригдав. 17 кв.км гаруй талбай эзлэх энэ хотыг түүхэнд “Хориотой хот” гэж нэрлэдэг.



Зураг-2.14

XVII зууны хятадын уран зураг илүү чөлөөтэй, өрнүүн, байгалийн яруу хурц өнгө давамгайлсан шинжтэй болжээ.

XV-XVIII зууны үеийн хятад хүмүүсийн амьдрал, энэ үед гарсан соёлын ололтын талаар мэдээлэл цуглуулж, танилцуулга бэлтгээрэй.



**Японы цайны ёслол.** Харин Японд тариачдыг цэрэгт татахыг хориглосноор тэд газартаа бүрэн хадагдаж, ургацынхаа 50%-ийг түрээсийн татварт өгөх болов. Тариачид өглөө эрт босох бөгөөд цай болон архи уухгүй, тамхи татахгүй, тариагаар хийсэн энгийн хоол хүнс хэрэглэхээр хуулинд заасан байжээ.

Энэ үед Японд 17 үет хайку шүлэг, зэн цэцэрлэг, цэцэг засах урлаг, цайны ёслол, театрын урлаг зэрэг соёлын төрлүүд

бий болсон юм. Японы цайны ёслол нь өөрийн гэсэн дэг жаягтай, өвөрмөц зан үйл бөгөөд 500 гаруй жил тасралгүй уламжлагдсаар иржээ.

Японд уламжлалт Шинто шүтлэгээс гадна Буддын шашин дэлгэрч, өвөрмөц онцлог бүхий урлаг, утга зохиол, уран барилга, дүрслэх урлаг амжилттай хөгжиж байв.

**Тайлбар:** Но театр. Ногаку буюу Японы уламжлалт нэгэн театрын төрөл. Эмэгтэй хүний дүрийг эрэгтэй хүн бүтээдэг онцлогтой.

### Их Моголын өв соёл.

XV-XVIII зууны үед Энэтхэгийн нийгмийн амьдрал, соёлын хөгжилд Моголын эзэнт гүрэн том хувь нэмэр оруулсан юм. Үүнийг тэд хүн төрөлхтөний 7 гайхамшгийн нэг болох алдарт Таж Махалыг чухам энэ үед бүтээсэн явдлаас харж болно. Таж Махалыг Их Могол улсын шах Жаханы зарлигаар 1630-1653 онд бүтээн байгуулсан түүхтэй.



**Таж Махал** нь өнөөгийн Энэтхэг улсын Агра хотод орших гоёмсог уран барилгын дурсгал бөгөөд Их Моголын эзэнт гүрний хаан Шах Жахан өөрийн хайрт хатан Мумтаз Махалд зориулан бариулсан гэдэг. Таж Махалыг Моголын архитектурын хамгийн яруу тод жишээ гэж үздэг. Түүний хийц, хэлбэрт Перс, Оттоман, Энэтхэг болон Исламын архитектурын хэв маяг шингэсэн ажээ. 1983 онд Таж Махалыг ЮНЕСКО-гийн Дэлхийн соёлын өвд бүртгэхдээ, түүнийг “Муслим урлагийн шигтгээ Таж Махал нь дэлхийн соёлын өвийн шагшин гайхагдах сод бүтээлийн нэг мөн” хэмээн үнэлсэн байдаг.

Цасан цагаан гантигаар бүтээгдсэн бөмбөгөр орой нь Таж Махалын цогцолбор байгууламжийн хамгийн алдартай содон шинж нь юм. Мянга мянган уран дархан, гар урчуудын хүч хөдөлмөр шингэсэн уг барилгын ерөнхий архитектураар Персийн уран барилгач Устад Ахмад Лахаури ажилласан гэдэг. Таж Махалыг хэрхэн барьсан тухай хэд хэдэн домог бий.



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Тухайн үеийн Европын хүмүүсийн амьдралын талаар өгүүлсэн сурвалжуудыг харьцуулан ярилцаарай.
2. XVI зууны эхэн үеийн Английн ард түмний амьдрал ямар байв?
3. Баримт, мэдээлэлд тулгуурлан тухайн үеийн Мин, Могол, Османы эзэнт улсуудын амьдрал, соёлын нийтлэг ба ялгааг тодорхойлоорой.



### Үр дүнг нэгтгэх, танилцуулах

1. Баримт мэдээлэлд тулгуурлан гарсан өөрчлөлтийн үр дүнг тодорхойлоорой.

Тухайн үеийн хүмүүсийн аж амьдралыг өнөө үетэй харьцуулна уу.			
	Амьдралын хэв маяг	Хүмүүсийн ажил төрөл	Соёл иргэншлийн хэлбэр
Өрнө			
Дорно			


2. Сэдэвтэй холбоотой цайны ёслол, хайку шүлэг, цэцэг засах урлаг, Таж Махал зэргийн талаар мэдээлэл цуглуулж, бусадтайгаа хуваалцаарай.

МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ ДАРААХ МОНГОЛ БА ДЭЛХИЙ ДАХИН

(XV-XVIII зууны дунд үе)

Түүхэн он цаг, үйл явдлын товчоон

- 1449 – Ойрадын Эсэн тайш Мин улсыг байлдан Ин Цзун хааныг олзлов.
- 1453 – Эсэн Монголын хаан болов.
- 1470 – 7 настай Батмөнхийг Монголын хаан ширээнд өргөмжлөв.
- 1558 – Түмэн засагт хаан (1539-1593) хаан суув.
- 1577 – Алтан шарын шашны тэргүүн Содномжамцийг залж, “Далай лам”-аар өргөмжлөв.
- 1585 – Эрдэнэ зуу хийдийн шав тавих ёслол болов.
- 1636 – Өвөр Монгол Манжийн эрхшээлд оров.
- 1639 – Занабазар (1635-1723)-ыг Халх Монголын шарын шашны тэргүүнээр өргөмжлөв.
- 1640 – Тарвагатайн Улаан бураад “Дөчин, дөрвөн хоёрын их цааз” баталжээ.
- 1641 – Хошуудын Төрбайх Төвөдийг эзлэн хаан сууж, Хошууд улс байгуулагдав.
- 1648 – Огторгуйн далай хэмээх Зая бандида Намхайжамц тод үсэг зохиожээ.
- 1676 – Галдан бошогт Зүүнгарын хаант улсын хаан болов.
- 1681 – 1687- Чахундорж Оросуудын түрэмгийллийг эсэргүүцэж, удаа дараа цэрэглэв.
- 1686 – Занабазар 90 үсэг бүхий Соёмбо үсэг зохиожээ.
- 1691 – Халх Монгол Манж Чин улсын захиргаанд оров.
- 1696 – Галдан Тэрэлжийн Зуу модонд Манжийн цэрэгт цохигдов.
- 1723 – Жавзандамба хутагтын шавь нарын хэргийг Эрдэнэ шанзудба эрхлэх болжээ.
- 1725 – Халхад Сайн ноён аймаг шинээр байгуулагджээ.
- 1727 – Манж, Орос хоёр улс Буурын гэрээг байгуулж, умард хилээ тогтоожээ.
- 1739 – Зүүнгарын хаант улс, Чин улс хоёрын хооронд хилийн хэлэлцээр байгуулжээ.



- 1421 – Бээжин хот Мин улсын нийслэл болов.
- 1443 – Солонгосын авиазүйн цагаан толгойг зохиов.
- 1453 – Оттоманчууд Константинополийг эзэлснээр Византын эзэнт гүрэн мөхөв.
- 1492 – Х.Колумб Европчуудаас анх удаа Карибын тэнгист хөл тавив.
- 1498 – Португалийн далайчин Васко да Гама Африкаар дамжин Энэтхэгт хүрэв.
- 1499 – Америго Веспуччи Өмнөд Америк, Амазоныг нээсэн нь түүний нэрээр нэрлэгдэв.
- 1510 – Анхны Африк боолуудыг Кариб руу авч явав.
- 1517 – Германы Мартин Лютер шашны шинэтгэх хөдөлгөөнийг эхлүүлэв.
- 1519 – Эрнандо Кортес Мексикт ирж, 1521 онд Ацтексийн эзэнт гүрнийг эзлэв.
- 1519 – 1521 – Португалийн Ф.Магеллан дэлхийг тойрох анхны аяллыг удирдав.
- 1520 – I Сулейман Османы эзэнт улсын султан болов.
- 1531 – Польшийн одон оронч Коперник дэлхий нарыг тойрч эргэдэг гэх санааг гаргав.
- 1533 – Испаний Франчиско Пизарро Инкийн эзэнт гүрнийг эзлэв.
- 1556 – Моголын хаан агуу Акбар Энэтхэгийг эрхшээлдээ оруулахаар ирэв.
- 1558 – I Элизабет Английн хатан хаан болов.
- 1587 – Виржинид Англичууд колончи байгуулав.
- 1600 – Энэтхэгт “English East India” худалдааны компани байгуулагдав.
- 1603 – Англи, Шотланд хоёр нэгдэв.
- 1603 – Японд Токугава шогуны үе эхлэв.
- 1606 – Голландын далайчин Уиллием Яансз Австралид очив.
- 1612 – Токугава Шогун Японыг гадныханд хаалттай орон болов.
- 1618 – 30 жилийн дайн эхлэв.
- 1628 – Английн эмч Уиллиам Харвей цусны эргэлтийн тухай нээлт хийв.
- 1636 – Хойд Америк дахь анхны их сургууль Харвард байгуулагдав.
- 1642 – Голландын далайчин Абел Тасман Австралиас Шинэ Зеланд хүртэл аялав.
- 1649 – Оросууд Сибирийг эзэлж, Номхон далайд хүрэв.
- 1652 – Голландууд Сайн Итгэлтийн хошуунд колончи байгуулав.
- 1661 – XIV Людовик Францад хэмжээлшгүй эрхт засаглал тогтоов.
- 1664 – Англичууд “Шинэ Нидерланд”-ын колонийг булаан авч, Нью-Йорк гэж нэрлэв.
- 1655 – Английн эрдэмтэн Исаак Ньютон татах хүчний тухай хуулиа нээв.
- 1682 – Агуу Пётр Оросын эзэн хаан болов.
- 1707 – Энэтхэг дэх Моголын эзэнт гүрэн бутарч эхлэв.
- 1710 – Орос улс Балт дахь Шведийн харьяа нутгийг эзлэв.
- 1736 – Иран дахь Сафавидын засаглал нуран унав.



## XVIII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ БА ДЭЛХИЙ ДАХИН

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ XVIII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ



#### 1. МОНГОЛЧУУД ЭРХ ЧӨЛӨӨ, ТУСГААР ТОГТНОЛЫНХОО ТӨЛӨӨ ТЭМЦСЭН НЬ

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
Эх орон, эрх чөлөө, тусгаар тогтнол бол монгол хүн бүрийн эрхэм үнэт зүйл мөн.	Монгол хүнд эх орон, газар нутаг, эрх чөлөө, тусгаар тогтнол хамгаас эрхэм чухал. Шаардлага тулгарвал бид энэ бүхний төлөө босож тэмцэх ёстой.	<ul style="list-style-type: none"> <li>• Эх орон</li> <li>• Эрх чөлөө</li> <li>• Тусгаар тогтнол</li> <li>• Бослого тэмцэл</li> <li>• Зарга</li> </ul>



#### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх

*Монголчууд анхнаасаа Да Чин улсад үг дуугүй захирагдсаар ирсэн үү? Монголчуудад Манжийн эрхшээлээс ангижрах боломж үнэхээр байгаагүй гэж үү? Эх орон, эрх чөлөө, тусгаар тогтнолын үнэ цэн юугаар тодорхойлогдох вэ? Энэ бүхний талаар эргэцүүлэн бодож, өөрийн таамаглал, үндэслэлийг дэвшүүлээрэй.*

Монголчууд Манж чин улсын эрхшээлд орсноор эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэх шаардлага тулгарав. XVIII зууны дунд үеэр Ойрад, Халх (Хотгойд), Өвөр Монголын зарим ноёд Манжийн эсрэг нэгэн зэрэг бослого гаргаж, Их Монгол Улсаа сэргээн байгуулахаар нууцаар хэлэлцэн тохирчээ. Үүний илрэл нь 1755-1758 оны зэвсэгт бослого байв.

Манж Чин улс бослого гаргах сэжиг олж мэдээд, тэднийг хүчээ нэгтгэхээс сэргийлэх арга хэмжээ авчээ. Чингүнжавыг Хан-Хатан голын Тэлэнгэд нарыг дагуулах үүрэг өгч явуулахын хамт Сэвдэнбалжирыг хэрэг зөвлөнө гэж Бээжинд дуудан аваачаад хэргэм зэргийг нь эвдэн, гэрийн хорионд оруулжээ. Улмаар Амарсанааг ч мөн “хэрэг зөвлөнө” гэж Бээжинд яаралтай дуудав.



**Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах**

**Монголчуудын 1755-1758 оны Манжийг эсэргүүцсэн зэвсэгт бослого**



“Эх орноо хамгаалах хэрэгт эр бие, энэ нас хайран үгүй”.  
Хойдын жанжин Амарсанаа (175...- 1757).

“Чингис хааны үрийг язгуураас яллах ёсон үгүй”  
“Төр, үр хоёр минь мөнх оршиг”.  
Хотгойдын шадар ван Чингүнжав (1710-1758)



Зүүнгарын хаант улс	Халх Монгол
<p>Амарсанаа “эзэн хаанд бараалхана” гэж гараад Алтайн цаана Өрөнгө голд хүрч ирмэгцээ шадар 300 цэргээ удирдан 1755 оны 9 сарын 24-нд бослого гаргаснаар 1755-1758 оны Монголчуудын тусгаар тогтнолын зэвсэгт бослого эхэлжээ.</p> <p>Амарсанаа нарын уриалгаар Ойрадууд нийтээрээ зэвсэглэн босож, Манж цэргийн анги, хэсгүүдийг энд тэндгүй довтлон цохиж, хүрээгээ тэлсээр байлаа.</p> <p>Баруун Монголд тусгаар тогтнолын зэвсэгт бослого өрнөсөн явдал Манжийн төрийн эрх баригчдыг ихэд сандаргав. Манжийн хаан дахин хоёр замын цэрэг татаж, Жалафунгагаар удирдуулан илгээжээ. Манж нар их цэргийн удирдлагаа хэдэнтээ өөрчлөн дайтсан боловч тэд бослогыг дарж чадахгүй байлаа. Гэвч босогчид дотоод эв нэгдлээ сахиж, хүчээ нэгтгэж чадахгүй байснаас дорвитой амжилт олохгүй байсаар ялагдал хүлээхэд хүрсэн байна.</p> <p>1757 оны 6 сарын 30-нд Шарбэл гэдэг газар Амарсанаа болон Манжийн их цэргийн жанжин Халхын Цэнгүнжав нарын хооронд сүүлчийн шийдвэрлэх тулалдаан болж Амарсанаа хэд дахин давуу хүчинд цохигдон цөөн хүний хамт Орос руу зугтан оджээ. Ойрадууд 1757-1758 оны туршид энд тэнд тэмцлээ үргэлжлүүлэн байсан хэдий ч Манжийн цэрэг тэднийг цувуулан цохисоор Баруун монголын ард түмний тусгаар тогтнолын зэвсэгт тэмцлийг дарсан байна.</p>	<p>1756 оны 4-р сард II Богд Жавзандамба хутагтын ах Ренчиндоржийг Амарсанаагийн хэрэгт холбогдуулан цаазалсанд Халхын ноёд язгууртнууд улам дургүйцэж бослогод бэлтгэж эхлэв.</p> <p>Хотгойдын шадар ван Чингүнжав 1756 оны 6-р сард 800 цэргээ удирдан дайны талбарыг хаяж нутагтаа ирснээр Халх дахь Манжийн эсрэг тэмцэл эхэлжээ. Мөн тэр үед Түшээт хан Ямпилдорж, Засагт хан Балдир, Сэцэн хан Манибадар, Сайн ноён хан Дэмчигжав, Дамиран гүн нарын зэрэг ноёд Манжийн албыг хаяж тус тусын нутагт нэгэн зэрэг буцсан байна.</p> <p>Чингүнжав нар Халхын томоохон ноёдод хүн зарж, нууц бичиг илгээн, Манжийн эсрэг албаа хаян босохыг уриалж байв. Халхчууд газар сайгүй Манжийн өртөө, харуул, төмөр сүрэг болон цэргийн албыг хаян босч хэдэн арваас хэдэн зуун хүнтэй бослогын цэргийн багууд буй болжээ. Тэд Манжийн дарангуй цэрэг, Хятадын шунахай худалдаачдын суусан хот суурингууд болон зарим урвагч ноёд түшмэдийг ч довтлон цохиж байв. Гэвч босогчид нэгдмэл зохион байгуулалт, удирдлагагүй саланги тусдаа тэмцэж байсан тул дорвитой амжилтанд хүрч чадаагүй юм.</p> <p>Манжийн төр Халхад өрнөсөн тусгаар тогтнолын тэмцлийг дарах даалгаврыг Улиастайн жанжин Чин ван Цэнгүнжавт өгчээ. Тэр 1756 оны 11-р сард хэдэн мянган цэрэг авч Чингүнжавын эсрэг довтолжээ. Энэ үед Манжийн их цэрэг айсуу сургаар зарим ноёд цэргээ аван салан одсон, дотроо санал зөрөлдсөн зэргийн улмаас Чингүнжавын цэргийн хүч ихээхэн сулраад байв.</p> <p>Чингүнжав Манжийн цэрэгт цохигдон Шишгэд гол руу ухарч, улмаар Оросын зүг зугтсан боловч 1757 оны эхээр Манжийн цэрэгт баригджээ. Түүнийг гэр бүлийнх нь хамт Бээжинд хүргэн, 1757 оны 3-р сарын 11-нд хэрцгийгээр цаазалжээ. Бослогод оролцсон, талархан дэмжсэн хүмүүсийг ч хорлох, цаазлах зэргээр харгислан шийтгэсэн байна. Цаазалсан хүмүүсийн толгойг олны хөлийн газар шонд өлгүүлжээ.</p>

Ховд хязгаарын Ойрадуудын дунд Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцэгч бөгөөд 1756 онд Орост зугтаж гараад Тобольск хотод нас барсан Амарсанаа нэгэн цагт эргэж ирнэ. Тэгээд ойрад түмнээ манж, хятадын боолчлолоос чөлөөлж, харийн дайснаас өшөөгөө авна гэж тангараг өргөсөн юм гэнэ билээ гэлцэнэ... Хавар болгон намайг Оросоос буцаж ирэхэд, -Амарсанаа хэзээ ирэх гэж байна? Хэзээ биднийг хятадаас чөлөөлөх юм бол? Сураг байна уу? гэсэн асуултыг тавьдаг байлаа”.

(А.В.Бурдуков. Хуучин ба шинэ монголд. УБ., 2013, т.49)

Шадар ван мянгадуудад тугаа өгөхдөө захиас болгон хэлсэн нь: Би Манж-хятадын дарлалаас гарах гэж тэмцэж яваад бүтээж чадсангүй энэ боллоо. Та нар хар хаяавчтай, хөх үүдтэй яваарай. Хар хаяавчийн учир нь дайсан дунд байх цагт хар санаагаа, хаяагаа манаж, сэрэмжтэй яв гэсэн үг. Миний захиасыг мартахагүйн тэмдэг болгож, гэрийнхээ хаяавчийг хараар хийгээрэй. Би хар санаагүй явсан учир ингэж гэнэдлээ. (Чингүнжавын тухай Мянгадуудын дунд тархсан домгоос).



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Монголчууд яагаад бослого тэмцэл өрнүүлэх болсон бэ?
2. Монголчууд бослого тэмцэл гаргах гэж байгааг манж нар хэрхэн мэдсэн бэ?
3. Ойрад, Халхад бослого яагаад зэрэг эхэлж чадаагүй вэ?
4. Бослого тэмцлийг олон түмэн яагаад дэмжиж байв?
5. Дээрх домгуудад ямар ижил зүйл ажиглагдаж байна вэ?
6. Амарсанаа, Чингүнжав нарын тэмцэл монголын ард түмний зүрх сэтгэлд юуг үлдээсэн бэ?
7. Та бүхэн эрх чөлөө, тусгаар тогтнолын түүхэнд холбогдох биет дурсгал, газар нутаг, домог, хууч яриа юу байдаг талаар эрэл хайгуул хийж, тэмдэглэл хөтлөөрэй.



### Үйлийг төлөөлөх, мэдээлэл цуглуулах

**Тэмцэл үргэлжилсэн нь:** Амарсанаа, Чингүнжав нарын 1755-1758 оны бослого дарагдсан боловч монголчуудын тэмцэл хөдөлгөөн үүгээр дуусаагүй билээ. Бослогын домог түүх олон түмний дунд хоногшин үлдэж, монголын ард түмэн эрх чөлөө, тусгаар тогтнолоо эргүүлж олж авах хүртлээ олон арга хэлбэрээр харийн дарангуйллын эсрэг тэмцсээр ирсэн юм.

Монголчууд харийн хааны тамга, хуулийн дор оршиж байсан ч XX зууны эхэн үеийг хүртэл бослого тэмцэл үе үе дэгдсээр байв. Хэдийгээр 1755-1758 оных шиг өргөн далайцтай бослого тэмцэл гараагүй боловч орон нутгийн шинжтэй эсэргүүцэл тэмцэл тасраагүй юм. Тэмцлийн арга хэлбэр нь зэвсэглэн босох, заргын бичиг үйлдэж заалдах, дугуйлангийн хөдөлгөөн, алба хаях, нутаг хошуунаасаа оргон зайлах, ганцаарчлан тэмцэх зэрэг олон янз байв. Үүний нэг илрэл нь шилийн сайн эрсийн тэмцэл байлаа. Энэ бүхэн эцсийн эцэст тэсч үлдэхийн төлөөх тэмцэл байжээ.



### Зарим томоохон тэмцэл хөдөлгөөнүүд:

- 1800 онд Сэцэн хан аймгийн чуулган дарга Санжайдоржтой ардууд заалдан тэмцсэн хэрэг
- 1815 оны Түшээт хан аймгийн ван Цэдэндоржийн хошууны заргын хэрэг
- 1880 оны Онолтоор удирдуулсан Улиастайн цэргийн бослого
- 1881 оны Их Хүрээний лам нарын бослого
- 1900 онд Энхтайваны удирдлагаар гарсан Улиастайн 2000 цэргийн бослого
- 1903-1918 онд завсартайгаар үргэлжилсэн Засагт хан аймгийн ард Аюушийн тэмцэл
- 1910 оны Их Хүрээний үймээн тэмцэл.



Монголчууд үндэс угсаагаа марталгүй, уламжлалт аж амьдрал, ёс заншил, соёл, өв уламжлалаа орхиж гээлгүй, үндэсний үзэл, ухамсараа хадгалан, сэтгэлгээний эрх чөлөөг эрхэмлэн, оюуны дархлаагаа алдалгүй, бататган бэхжүүлсээр ирсэн нь нэг талаар оршихуйн төлөө тэмцэл байлаа. Монголчууд эцэг өвгөдийнхөө сургаал, эх орон, газар нутгаа ямагт эрхэмлэн дээдэлж ирсэн нь бидний хэзээ ч мартаж болохгүй үндэсний үнэт зүйл мөн.

1822-1868 онд Сэцэн хан аймгийн Илдэн засгийн хошууны засаг ноён, 1859-



Халхын «Хэцүү»  
Тогтохтөр ван

1868 онд Сэцэн хан аймгийн Чуулган дарга байсан жүн ван Тогтохтөр эх нутгийнхаа бүрэн бүтэн байдлыг хамгаалахын төлөө идэвхтэй тэмцэгчдийн нэг юм. Монголын зүүн хязгаарын олон газарт хилийн маргаан дэгдэж байсан бөгөөд тийм газрын нэг бол одоогийн Дорнод аймгийн Халх гол сумын нутагт буй Хулд уул болно. То ван нутгийнхаа энэ уулыг Манжид алдалгүй авч үлдсэн домогтой.

Хулд уул хэний нутаг болох тухай маргааныг шийдвэрлэхээр Манжийн их түшмэл томилогдон иржээ. Түүнд То ван ийн хэлүүлжээ:

- Энэ уул яг л нэг үхрийн ширний хэмжээтэй юм шүү. Хэрэв үхрийн ширний хэмжээнээс илүү гарвал тэр илүү хэсгийг эрхэм та хүртэж болох биз. Танай манай хоёр, айл буухад хүрвэл манай нохой идүүртэй хоолноосоо танай нохойд долоолгохгүй байх шүү гэжээ. Энэ үгийг сонссон манж түшмэл учрыг олж ядан гайхаж, "Хичнээн том үхрийн шир байлаа гэхэд энэ уулнаас юу хороох вэ? Ийм тэнэг хүн яаж жүн вангийн зэрэгт хүрдэг байна аа" гэж бодоод,

- За тэгвэл энэ уулнаас үхрийн ширний хэмжээтэй нь танай газар, илүү нь миний газар болог гэжээ. Ингээд То ван манж түшмэлийг хоёр хоногийн дараа ир гэжээ. То ван нэг том үхрийн ширийг хурц хутгаар тойруулан утас мэт нарийн зүсүүлж урт аргамж бэлдэжээ. Нөгөө аргамжаа усанд дэвтээж байгаад түшмэлийг

ирэхэд “За та сайтар харж бай” хэмээн дагуулан аргамжаа хөвж явсаар уулыг тойрон битүү бүсэлсэнд цаана нь алд хэр аргамж илүү гарчээ.

Тэгээд То ван: манай уулнаас нэг хэсгийг хулгайч авсан байна. Зуугаад жилийн өмнө миний эцэг эзэн хаанд бэлэглэхээр хадгалсан алтаа энэ ууланд булсан гэдэг юм. Одоо тэр алт булсан хэсэг нь алга болсон бололтой. Түүнийг та мэдээд хулгайлан авч, дахин алт гарч юу магад гэж манай энэ уулыг авах гэсэн биз гэж хэлжээ. Манж түшмэл ихэд айн сандарч:


- Ай, би яаж хулгайлж чадна. Та лав өөр хүнд алдсан байлгүй хэмээн хулгайд сэрдэгдэхээс эмзэн, То ванд өндөр хараат ембүү хоёрыг бариад ихэд яаран сандран буцсан гэдэг. Мөн өөрийн нутгийн хилийн зааг дээр хар хорхой байдаг гэж хэлээд түүнийг нотолгоо болгон ашигласан домогтой.

Хулд уулын тухай домогос



### Үр дүнг нэгтгэх, танилцуулах

1. Амарсанаа, Чингүнжав нарын бослого үр дүнд хүрээгүй ч монголчуудад ямар ухаарал сургамж, үлгэр дууриал үлдээсэн бэ?
2. Амарсанаа, Чингүнжав нар Дай Чин улсын талд зүтгэж, өндөр хэргэм зэрэг, цалин пүнлүү хүртэн, алба тушаал хашиж суухыг хүсэлгүй, амь насаа үл хайрлан бослого тэмцэл гаргасны учир юу вэ? Тунгаан бодож тайлбарлаарай.
3. Чингүнжавын тэмцлийг дарахад, баригдаж, гэр бүлээрээ хөнөөлгөхөд урвагчдын оролцоо их байсан гэдэг. Үүнээс ямар дүгнэлт хийж, сургамж авч болох вэ?




4. Энэ зурагт тэмцлийн ямар хэлбэрийг харуулж байна вэ? Утга санаа, өгүүлэмжийг задлан шинжилж тайлбарлаарай.
5. Заргын бичигт нэрсээ нарны цацраг мэт дугуйлан зурдаг нь ямар учир шалтгаантай вэ?
6. Газар нутаг ямар үнэ цэнтэй, монголчууд эх нутгийнхаа төлөө хэрхэн тэмцэж ирснийг өмнөх болон дараа үеийн түүхтэйгээ холбон жишээ гаргаж тайлбарлаарай.
7. “Эх нутгийн шороо алт”- сэдвээр эсээ бичээрэй.



### Өөрийгөө үнэлээрэй

1	Бослого хөдөлгөөн гарах шалтгаан юу байв?	
2	Бослого тэмцлийн зорилгыг тодорхойлоорой?	
3	Босогчид яагаад амжилтад хүрч чадаагүй вэ?	
4	Бослогын удирдагчдыг түүхэнд эзлэх байр суурийг тодорхойлно уу?	
5	Бослого тэмцлийн бидэнд үлдээсэн гол сургамж юу вэ?	



## 2. МАНЖ ЧИН УЛСЫН МОНГОЛЫГ ЗАХИРСАН БОДЛОГО

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
Манжийн төр монголчуудыг захирахдаа уламжлалт нийгмийн онцлог, хэв шинжийг харгалзсан боловч эдийн засгийн нь хувьд Чин улсын бөглүү хязгаар болгон хувиргажээ.	Манж Чин улс монголчуудыг хэрхэн барьж захирч байсан, тэр үеийн засаг захиргааны зохион байгуулалт, улс төр-эдийн засгийн дарангуйлал, тэдгээрийн мөн чанарыг мэднэ, үлдээсэн ул мөр нь дараа үеийн түүхэнд холбогдоно.	<ul style="list-style-type: none"> <li>• Манжийн төр</li> <li>• Аймаг, хошуу, сум</li> <li>• Алба, гувчуур</li> <li>• Сум, хамжлага, шавь</li> <li>• Гадаад худалдаа</li> </ul>



**Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх**

XVII



XVIII




XIX-XX




*Монголчуудыг ямар арга замаар Манжийн төр захиран барьж байв?  
Монголчууд Манжийн эрхшээлд олон жил захирагдсаны үр дагавар юу вэ?*

Зураг-3.1



**Монгол дахь Манжийн засаг захиргааны зохион байгуулалт**

Бүдүүвч-3.1

**Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах**

Манж Чин улс монголчуудыг эрхшээлдээ оруулаад тэднийг барьж, захирч байхад чиглэгдсэн засаг захиргааны зохион байгуулалтыг тогтоов. Тэд монголчуудыг эрхшээлдээ хянан захирч байх төрийн бодлогоо хэрэгжүүлэх зорилгоор “Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яам” (ГМТЗЯЯ)-ыг байгуулжээ. Тус яамнаас “Монгол цаазын бичиг”, “ГМТЗЯЯ-ны хууль зүйлийн бичиг” зэргийг батлан гаргаж, монголчуудыг чандлан захирах бодлогоо хуульчилжээ.

Монголчууд Манжийн эрхшээлд орсноор бие даасан төрийн бодлого явуулан хэрэгжүүлэх боломжгүй болов. Монголын газар нутаг, хүн амын дээд эзэн нь Манжийн хаан болжээ. Ар Монголд Манжийн төр захиргааны удирдлагыг гардан хэрэгжүүлдэг, монголчуудыг баримтлан захирдаг газар нь Улиастайн Манж жанжны газар, Хүрээ болон Ховдод суух Манж амбаны газрууд байлаа.

Манжийн үеийн Монголын засаг захиргааны хамгийн том нэгж нь аймаг байв. Манжийн төрөөс тухайн газар оронд томилогдсон жанжин, амбан сайдын шууд удирдлагын доор аймгуудын чуулган ажиллаж байв. Өвөр Монголд 6, Ар Монголд 6 чуулган байжээ. 1725 онд Сайн ноён аймгийг нэмж байгуулснаар Халх 4 аймагтай болжээ. Чуулган бүр чуулган дарга, дэд даргатай байжээ. Чуулган 3 жилд нэг удаа чуулж хэрэг хэлэлцэнэ. Аймагт мөн туслагч жанжин гэж байсан ба тэд тухайн аймгийнхаа цэргийн хэргийг хариуцдаг байв.

Монголын бүх хошуудыг дотоод, гадаад засаг хошуу гэж хувааж байлаа. Өвөр Монголын хошуудыг “Дотоод монгол”, Халх, Ховд, Илийн, Хөх нуур, Эзнээ, Алшаагийн хошуудыг “Гадаад монгол” гэж нэрлэж байв.

Хошууг засаг ноён толгойлж тухайн хошууны аливаа хэргийг эрхлэн хариуцна.


Хошууны тамгын газарт туслах тайж, захирагч, мэйрэн, залан, бичээч, тахар зэрэг алба тушаалтнууд ажилладаг байв. Хошуу нь дотроо сум, багт хуваагдана. Хууль ёсоор бол 150 цэрэг эр гаргах хэмжээгээр нэг сум байгуулсан байна. Гэхдээ зарим тохиолдолд 150 эр хүрэхгүй өрхтэй байсан ч хондог сум гэж байгуулдаг байв. Сумыг сумын занги захирна. Сумын энгийн ард олон суман ард (цэрэг албат), хамжлага, шавь ард гэж хуваагддаг байв. Хошууны ноёд, тайж нар зэргээсээ хамаарч, хамжлага захирна. Хамжлага нь цэргийн зэрэг албанаас чөлөөлөгддөг байв. Хутагтуудын харьяат албатыг шавь нар хэмээдэг.

XVII зууны үеэс Монгол болон Манжийн эрх баригчид өөр өөрсдийн тодорхой зорилготойгоор бурхны шашныг тэтгэн дэлгэрүүлэх бодлого явуулсан билээ. Манж

Чин улсын хувьд шарын шашин нь монголчуудыг эрхшээлдээ баримтлан захирч байхад чухал учир холбогдолтой байв. 1723 онд Жавзандамба хутагтын шавь нарын хэргийг хамаарах Эрдэнэ Шанзудбад тамга олгожээ. Богд Жавзандамба болон хутагтуудын шавь нарын засаг захиргааны үндсэн нэгж нь отог байв. Отог нь дотроо баг, арванд хуваагдана.

**Алба, гувчуур.** Монголчууд Манжийн хаанд болон улсад есөн цагаан, Бээжинд жасаалах, сүрэг адуулах, албан тарианы, ангийн үсний, зоог шүүсний, цэрэг, харуулын, өртөөний, хурал номын, засаг захиргааны зардал хэрэглэлийн гэх мэт төрөл бүрийн алба залгуулдаг байжээ. Эдгээрийн дотроос хамгийн хүнд нь өртөөний алба байв.

Манжийн элч төлөөлөгчид, цэрэг, албан бичиг зэргийг яаралтай нэвтрүүлэн хүргэх зориулалттай цэрэгжүүлсэн морин өртөөг буухиа өртөө гэдэг байв.



Зураг-3.2

Бээжингээс Өвөр монгол, Ар монгол, Баруун Монголын нутгийг дамжуулан холбосон буухиа өртөөд нь дайран өнгөрч буй газар нутгийг хамаарах Манж сайдын газарт захирагдана. Нэг суурьт 5-30 өрх алба хаадаг байжээ. Манжийн үед Сайр ус, Их Хүрээ, Хиагт, Ховд, Улиастай зэрэг газрыг дайруулсан 120 суурь өртөө байгуулж түүний хэрэгцээнд жил бүр 47 мянган тэмээ, 250 мянган адуу, 53 мянган хонь зэргийг зарцуулдаг байжээ. XX зууны эхээр 120 суурь буухиа өртөөнд нийт 1250 гаруй өрх, тэднийг захирах түшмэл, занги 60 гаруй, үйлчилэх хөтөч 20 хүн сууж алба залгуулж байв.


Монголчууд Авга, Сөнөд, Дарьганга, Илд байсан Манжийн хааны сүрэг болон бусад нутагт байсан албаны мал сүргийг хариулах албыг мөн дагнан гүйцэтгэдэг байв. Тэрчлэн хамжлага ардууд харьяа ноёндоо гувчуур төлдөг байлаа.

**Асуулт, даалгавар гүйцэтгэх**

1. Бүдүүвч 3.1 болон зураг 3.3-т тулгуурлан тухайн үеийн Ар Монголын засаг захиргааны зохион байгуулалтыг тодорхойлоорой.
2. Нэг өртөөнд хэдий хэр хэмжээний зардал ногдож байсан бэ ?
3. Өртөөний зардлыг хэнээс гаргуулдаг байсан бэ?

Зураг-3.3

МАНЖИЙН ЭРХШЭЭЛИЙН ҮЕИЙН АР МОНГОЛ



ТАНИХ ТЭМДЭГ:  
 \* ИХ ХҮРЭЭ  
 ● Хот суурин  
 — Ар Монголын хил  
 — Аймгийн хил  
 — Хөшууны хил  
 Эх сурвалж:  
 БНМАУ-ын түүхийн номын хавсралт.

Та бүхний оршин суугаа газар нутаг тухайн үед хаана харьяалагдаж байсан болохыг зураг ашиглан тодорхойлоорой.

**Тайлбар:** ЗАСАГТ ХАН АЙМАГ: 1. Эрдэнэ бишрэлт засагт ханы хошуу, 2. Эрдэнэ дүүрэгт вангийн хошуу, 3. Ахай бэйсийн хошуу, 4. Далай гүний хошуу, 5. Мэргэн гүний хошуу, 6. Цогтой бэйсийн хошуу, 7. Ачит вангийн хошуу, 8. Цэцэн вангийн хошуу, 9. Баатар вангийн хошуу, 10. Эрдэнэ бэйсийн хошуу, 11. Түшээ гүний хошуу, 12. Хойдын хошуу, 13. Дархан бэйсийн хошуу, 14. Дайчин вангийн хошуу, 14. Дайчин вангийн хошуу, 16. Итгэмжит бэйсийн хошуу, 17. Илдэн гүний хошуу, 18. Ест бэйсийн хошуу, 19. Жонон вангийн хошуу, 20. Зоригт вангийн хошуу, 21. Жалханз хутагтын шавь нар, 22. Ялгуусан хутагтын шавь нар, 23. Бэгэр номун хан хутагтын шавь нар.

САЙН НОЁН АЙМАГ: 1. Өөлдийн өвөр хошуу, 2. Зоригт гүний хошуу, 3. Ачит гүний хошуу, 4. Илдэн бэйсийн хошуу, 5. Ахай бэйсийн хошуу, 6. Баатар бэйсийн хошуу, 7. Өөлдийн умард хошуу, 8. Түшээ гүний хошуу, 9. Саруул гүний хошуу, 10. Эрх гүний хошуу, 11. Ест бэйсийн хошуу, 12. Сайн ноёны хошуу, 13. Дайчин вангийн хошуу, 14. Үйзэн вангийн хошуу, 16. Дархан гүний хошуу, 17. Далай чойнхор вангийн хошуу, 18. Хошууч бэйсийн хошуу, 19. Жонон бэйсийн хошуу, 20. Цогтой гүний хошуу, 21. Эрдэнэ вангийн хошуу, 22. Итгэмжит бэйсийн хошуу, 23. Мэргэн гүний хошуу, 24. Шива ширээт хутагтын шавь нар, 25. Наран хутагтын шавь нар, 26. Эрдэнэ бандид хутагтын шавь нар, 27. Мэргэн ноён хутагтын шавь нар, 28. Хамба хутагтын шавь нар, 29. Нарванчин хутагтын шавь нар, 30. Зая бандид хутагтын шавь нар, 31. Чин сүжигт номун хан хутагтын шавь нар, 32. Улиастайн газар, 33. Харуулын газар.

ТҮШЭЭТ ХАН АЙМАГ: 1. Омйрбат түшээт ханы хошуу, 2. Дайчин вангийн хошуу, 3. Дархан чин вангийн хошуу, 4. Түшээт вангийн хошуу, 5. Эрдэнэ вангийн хошуу, 6. Мэргэн вангийн хошуу, 7. Зоригт вангийн хошуу, 8. Баатар вангийн хошуу, 9. Үйзэн гүний хошуу, 10. Цэцэн гүний хошуу, 11. Дайчин бэйсийн хошуу, 12. Бишрэлт гүний хошуу, 13. Жапон гүний хошуу, 14. Ахай гүний хошуу, 15. Сүжигт гүний хошуу, 16. Илдэн гүний хошуу, 17. Далай гүний хошуу, 18. Ачит гүний хошуу, 19. Ест гүний хошуу, 20. Цогтой гүний хошуу.

СЭЦЭН ХАН АЙМАГ: 1. Махасамди далай сацэн ханы хошуу, 2. Дархан чин вангийн хошуу, 3. Жонон вангийн хошуу, 4. Бишрэлт вангийн хошуу, 5. Сацэн вангийн хошуу, 6. Илдэн вангийн хошуу, 7. Далай вангийн хошуу, 8. Хурд вангийн хошуу, 9. Баатар бэйсийн хошуу, 10. Дайчин бэйсийн хошуу, 11. Ачит бэйсийн хошуу, 12. Үйзэн бэйсийн хошуу, 13. Эрхэмсэг бэйсийн хошуу, 14. Сүжигт бэйсийн хошуу, 15. Ест бэйсийн хошуу, 16. Зоригт бэйсийн хошуу, 17. Ахай бэйсийн хошуу, 18. Дархан бэйсийн хошуу, 19. Саруул гүний хошуу, 20. Сэргэлэн гүний хошуу, 21. Эрдэнэ гүний хошуу, 22. Мэргэн гүний хошуу, 23. Эрх гүний хошуу, 4. Даргангын сүрэгчин, ХӨВСГӨЛИЙН ХЯЗГААР: 1. Жавзандамба хутагтын Дархад шавийн отгуд, 2. Ар ширхтэн Урианхай, 3. Өвөр ширхтэн Урианхай, 4. Хөвсгөл нуурын Урианхайн бүгдийн дарлэн хошуу, ХӨВДЫН ХЯЗГААР: 1. Төгс хүлэг далай ханы аймаг, 2. Үнэн зоригт ханы аймаг, 3. Алтайн Урианхайн 7 хошуу, 4. Өөлд хошуу, 5. Мангад хошуу, 6. Захчин хошууд, 7. Торгууд хошууд.



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

**Худалдаа, мөнгө хүүлэл.** XVII зууны сүүлчээс XIX зууны эхэн хүртэл Манжийн төрөөс хятад худалдаачид иргэдийг Монголд бөөнөөр нь оруулахгүй, хянан зохицуулж байв. Энэ нь монголчуудыг холбоотон, түшиг болгон цэрэг харуулын хэрэгт ашиглах, эдийн засаг нь доройтох, эсэргүүцэл тэмцэл гарахаас болгоомжилсон зэрэг шалтгаантай байв. Гэхдээ Хятадын худалдааг эрс хориглох бодлого баримтлаагүй бөгөөд тиймээс жил ирэх бүр өргөжин тэлсээр байв. Энэ нь бараа таваарын хомсдолоос болж Оросын нөлөө дэлгэрэхээс сэргийлсэн хэрэг байлаа.

Хятадын худалдаачид эд бараа, мөнгийг монголчуудад жилд 36%-ийн хүүтэйгээр зээлдүүлээд, 3 жилийн дотор өрийг төлж дуусгах шаардлага тавьдаг байв. Гэвч Монголчууд өрөө хугацаанд нь төлж чаддаггүй тул үүнийг далимдуулан, өнгөрсөн хугацаанд үржсэн хүүг нэмж их болгоод, төлөх хугацааг дахин 3 жилээр сунгаж, хүү үржүүлдэг байжээ. XVIII зууны үед хятадуудын худалдаанд жижиглэн худалдаалах арга ноёрхож байсан бол XIX зууны зуунд бөөнөөр худалдаалах аргад шилжжээ. Ингэснээр зардал хямдарч, эргэлт хурдсаж, орлого нь нэмэгджээ.



Зураг-3.4

*Хятад худалдаачдын хэрэглэж байсан мөнгөн ембүү, зоосон мөнгө, эрхийн тэмдэг, өрийн бичиг*

XIX зууны эцсээр ат 30 лан, ингэ 20 лан, морь 15-20 лан, гүү 9-11 лан, шар 20 лан, үнээ 15-20 лан, эр хонь 1.5-2 лан, эм хонь 1.5 лан орчим үнэтэй байв. XX зууны эхэн гэхэд Ар Монголоос худалдаачид 100 мянган үхэр, 70000 адуу, 3000 тэмээ, 800000 бог малыг хөлөөр нь гаргаж байжээ.



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Монголд гадаадын худалдаа нэвтрэн хөгжсөний эерэг, сөрөг үр дагаврыг шинжлэн судалж ярилцаарай.
2. Хятад худалдаачдаар дамжин хэдий хэр хэмжээний баялаг урсан гарч байсныг тооцоолон бодоод үнэлэлт дүгнэлт хийгээрэй.

**Манжийн есөн эрүү.** Манжийн төр монголчуудыг гэсгээн цээрлүүлэх, ял шийтгэл оноохдоо хэрэгтнийг шаахайдах, мүглэнд хийх, талхидах, савслага,

хонгор азарга, хулс шаах, төөнөх банздах, туйпуу сугалах гэсэн 9 эрүүг хэрэглэдэг байжээ.



Зураг-3.5



**Үр дүнг нэгтгэх, танилцуулах**

"1874 онд Түшээт хан аймгийн гүн Эрэндоржийн хошуу албаны учир түнш Хишигтийн пүүснээс нэг бүрийг нь 3.7 лангаар үнэлэн 40 хонийг 148 лангаар бодож зээлэн авчээ. Гэтэл тэр үед нэг хонь 2 лангаас хэтрэхгүй ханштай байсан тул хонио зах зээлийн үнээс 85%-ийн өндөр үнэтэй зээлээд, бас дээр нь хүү үржүүлсэн байна."  
(Монгол Улсын Түүх. IY боть, т.233)

Хишигтийн пүүс хэдэн хувийн ашигтай ажиллаж байсан бэ?

Манж нар Монголчуудыг эрхшээлдээ оруулаад олон аймаг, хошуунд хувааж захирахдаа ноёд язгууртнуудыг олон зэрэг дэвд хуваан, цалин пүнлүү, тодорхой эрх мэдэл өгч зүтгүүлдэг байв.


Монголчууд Манжийн албанаас гадна орон нутгийн ноёдод мөн биеэр буюу бүтээгдэхүүнээр гэсэн хоёр хэлбэрээр төрөл бүрийн алба гувчуур төлдөг байжээ.

"...Тэд чинь цөмөөрөө хүүхэд шиг улс. Дэлгүүр пүүсний газар ирэхээрээ юу харсан бүгдээ л авах гэдэг. Мөнгө нь хүрэхгүй бол бид тусалдаг. Бид тэдэнд эд бараагаа зээлээр өгөхөд тэд сүүлд нь илүү үнэ төлөх ёстой. Түүнээс 30-40%-ийн ашиг олно. Бага багаар хүү өссөөр хүүгийн хүү болж үржинэ. Бид тэрийг авна. Зөвхөн Монголчуудтай ингэж болно. Жил бүр бид Монгол нутгаар хэрэн явж ер нэхэмжлэн хүүг хураахад үхэр, хонь, адуу, тэмээ тэргүүтнийг өрөндөө өгдөг. Энэ нь юутай ч зүйрлэшгүй их ашиг юм. Бид ийнхүү маш хямд авсан адуу малаа зээлийн газар туйлын үнэтэй зарна. ... Ёстой л алтан хайрцаг даа."  
(1844 онд Монголоор аялсан Францын жуулчин Е.Р.Гюкд нэгэн хятад худалдаачны ярьсан зүйл.)



Мэдээллийг шинжлэн судалж, тэр үеийн монгол орны нийгэм-эдийн засгийн байдлыг бүдүүвчийн дагуу гаргаарай.

“Манжийн захиргаан дахь монголчууд” сэдвээр эсээ бичээрэй.



### 3. МОНГОЛД БУРХНЫ ШАШИН ӨРГӨН ДЭЛГЭРСЭН НЬ

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
Шашин нийгэмд эерэг, сөрөг нөлөө үзүүлдэг. Тиймээс шашны мөн чанарыг танин мэдэх нь маш чухал.	Монголын түүхийн энэ үед бурхны шашин өргөн дэлгэрсэн. Энэ нь тодорхой шалтгаантай байсан. Монголчуудын зонхилох шүтлэг болох бурхны шашны тухай бодит мэддэг байх шаардлагатай.	<ul style="list-style-type: none"> <li>Шарын шашин</li> <li>Шашин шүтлэг</li> <li>Хүрээ, дацан</li> <li>Монголын бурхны шашны зүтгэлтнүүд</li> </ul>



#### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх

*Зурган болон тоон мэдээллийн агуулгыг бие даан судлан шинжлээрэй. Мэдээллийн агуулгад тулгуурлан түүхийн асуулт зохиогоорой.*



Зураг-3.6



Бүдүүвч-3.2

Бурхны шашныг Хүннүгийн үеэс монголд нэвтэрсэн хэмээн үздэг бөгөөд хэдэнтээ дэлгэрсэн болохыг бид өмнөх ангидаа үзсэн. Энэ тухай сэргээн санаарай.

Өмнө нь Монголд Бурхны шашин хоёр ч удаа төрийн шашин болж байсан хэдий ч хаад, язгууртны орд өргөөнөөс хальж чадаагүй билээ. Харин XVI зууны хоёрдугаар хагасаас Монголд нэгэн шинэ үе эхэлж, Бурхны шашны шарын урсгал хүчтэй дэлгэрсэн түүхтэй. Энэ урсгалыг үндэслэгч нь Төвөд лам Зонхов юм. Шинэтгэл шаардлагатай болсон учраас Богд Зонхов XIV зууны сүүл, XV зууны эхээр бурхны шашинд шинэтгэл хийсэн. Яагаад шинэтгэл хийсэн, юуг нь шинэчилсэн талаар та бүхэн эрэл хайгуул хийж, сурвалжлан мэдэхийг хичээгээрэй.



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

Монголд бурхны шашин дахин дэлгэрч эхэлсэн XVI зууны сүүл үеэс хойш бөө мөргөлийг шахах бодлого хүчтэй явагджээ. 1587 онд Түмэдийн Алтан ханы зарлиг гарч, бөө мөргөлийн элдэв цуст тайлга, тэр дундаа хойлоглон оршуулах ёсыг цаазлан хориглосон байна.

Монгол улс тусгаар тогтнолоо алдах, аюулд өртөөд байсан XVII зууны сүүлийн хагасаас шарын шашин монголчуудын зонхилох шашин болжээ.

Шарын шашин өргөн дэлгэрснээр монголчуудын амьдралын хэв маягт өөрчлөлт орж, шашнаар дамжин дорно дахины урлаг, соёл нэвтрэн хөгжих боломж нээгдсэн юм.

Монголын нийгэмд лам нарын давхраа шинээр бий болж, бурхны шашны нөлөө амьдралын бүхий л хүрээнд нэвтэрчээ.

Эрчүүд сүм хийдэд олноороо шавилан суух явдал улам бүр нэмэгдэх болов.

Монголд бурхны шашин өргөн дэлгэрэхэд Ширээт гүүш цорж, Майдар хутагт, Жалханз хутагт, Зая бандида Намхайжамц, Өндөр гэгээн Занабазар, Зая бандида Лувсанпэрэнлэй зэрэг шашны зүтгэлтнүүд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байна. Мөн хошууны ноёд, язгууртнууд ч багагүй нөлөө үзүүлжээ. Тэд өөрсдийн хошуунд сүм, хийд олноор байгуулахыг зорьж байв. Ноёд, язгууртны хэргэм зэрэг хэдий чинээ өндөр байна, хүрээ хийд төдий чинээ олон, бас том сүрлэг байдаг байв.

Шашны хүрээ хийдүүд мөн тэр үеийн Монголын нийгэмд суурин газрын үүргийг гүйцэтгэж байв. Монголд хүрээ, хийд олноор байгуулагдах болсон нь олон зуун жилээр уламжлагдан ирсэн нүүдлийн соёл иргэншлийн дүр төрхийг ч ямар нэгэн хэмжээгээр өөрчлөхөд хүргэжээ. Хүрээ хийдүүд бас тухайн үеийн соёл, боловсрол, урлаг, шинжлэх ухааны төв болж байв. Шашны хурал, ёслолын үед эгшиглэн дуугарах хөгжим, аялгуу, бүжиг, цам харайх зэрэг нь яван явсаар монголын хөгжмийн болон бүжгийн урлагийн нэгэн төрөл болон хувирчээ. Мөн хүрээ хийдийн дэргэд суух урчууд бурхан цутгах, сийлбэрлэх, наах, зурах, оёх, хатгах зэргээр шашны холбогдолтой бүх зүйлийг урладаг байв.



### Бурхны шашин гэж ямар шашин бэ? Бурхны шашинтай хүн гэж ямар

**хүнийг хэлэх вэ?** Хамгийн оюунлаг, хамгийн шинжлэх ухааны үндэслэлтэй шашин бол бурхны шашин гэж үздэг. Альберт Эйнштейн “Орчин үеийн шинжлэх ухааны хэрэгцээг хангаж чадах хамгийн шинжлэх ухаанч шашин бол Буддын шашин” гэжээ. Энэ мэтээр А.Эйнштейн, И.Кантаас эхлээд дэлхийд танигдсан олон эрдэмтэд өөрсдөө бурхны шашинтан биш ч түүнийг шинжлэх ухааны үндэстэй шашин гэж дүгнэсэн байдаг ба өнөөдөр үүнийг дэлхий нийт хүлээн зөвшөөрч байна. Хорвоо ертөнц тоосонцороос үүсэлтэй гэдгийг 2500 жилийн өмнө, Дэлхий өндгөн хэлбэртэй гэдгийг 2300 жилийн өмнө бурхны шашны ном сударт тэмдэглэсэн байдаг ажээ.



**Монголд бурхны шашин өргөн дэлгэрэхэд олон хүчин зүйл нөлөөлжээ**



Бүдүүвч-3.3

**Мэдээлэл-1.** Шарын шашны лам нар өөрийн шашныг Монголд дэлгэрүүлэхдээ монголчуудын гол шүтлэг бөө мөргөл болон бөө, удган нартай ширүүн тэмцэл хийж байв. Тэд монголчуудын шүтдэг онгод шүтээнийг айл бүрээс хураан авч шатаах, удган зайран залж бөөлүүлсэн хүнд малын торгууль ногдуулах, бөө нарын ид шид, хүч чадлыг үгүй болгохоор нохойн баасаар утах зэрэг үйлийг гүйцэтгэдэг байжээ.

**Мэдээлэл-2.** Монгол оронд бурхны шашин дэлгэрснээр ард олон соён гэгээрч эхэлсэн. Оюун сэтгэлгээний өндөр түвшинд хүрснийг нотлох олон монгол эрдэмтдийн зохиол бүтээл гарсан байна. Санскрит, төвөд хэлийг гарамгай эзэмшсэн эрдэмтэд бурхны номыг монгол хэлнээ хөрвүүлж, монгол бичгийн галиг үсэг болох Али-гали үсгийг 1587 онд Аюуш гүүш, Тод үсгийг 1648 онд Зая бандид Намхайжамц, Соёмбо үсгийг 1686 онд Өндөр гэгээн Занабазар тус тус зохиож, бичиг соёлын түүхэнд үнэтэй хувь нэмэр оруулжээ. Мөн дүрслэх урлаг, уран барилгын хөгжил шинэ шатанд гарчээ. Жишээ нь: Өндөр гэгээн Занабазар Очирдарь бурхан, 21 дарь эх, Майдар зэрэг олон гайхамшигт бүтээлээ урласан байна.

Энэ үед монголчууд амьдардаг бүх нутагт бурхны шашны олон зуун сүм хийд байгуулагдсан бөгөөд тэдний төлөөлөл болгож, Монгол улсын нутагт буй зарим томоохон хийдийн талаар судалцгаая.



Халхын Очирбат Түшээт хан Абтай 1577 онд Буддын шашны тэргүүн Далай лам Содномжамцтай уулзаж, Халх монголд бурхны шашыг дэлгэрүүлэхээр тохиролцож, улмаар 1586 оны зуны дунд сарын 15-нд “Эрдэнэ зуу” хийдийг байгуулжээ. Тийнхүү Халхад бурхны шашин өргөн дэлгэрэх үүд хаалга нээгдсэн байна. Эрдэнэ зуу хийд нь халхын бурхны шашны анхны хийд юм. Тус хийд нь одоогийн Өвөрхангай аймгийн Хархорин сумын төвийн ойролцоо, Эзэн Чингисийн байгуулсан Монгол улсын нийслэл Хархорум хотын суурин дээр байрладаг. Энэ хийд нь ЮНЕСКО-д бүртгэгдэж дэлхийн өвд орсон Орхоны хөндийн соёлын дурсгалд багтдаг. 1930-аад оны их хэлмэгдүүлэлтээр монголын олон зуун хийд устгахад Эрдэнэ зуу хийд ч мөн өртжээ. Өнөөдөр Эрдэнэ зуу хийдийн шашин мөргөлийн үйл ажиллагаа сэргээсний дээр сүм музейн хэлбэрээр ажиллаж, гадаад, дотоодын жуулчдад үйлчилж байна.



Анхдугаар Богд Жавзандамбын дурсгалд зориулан Түшээт хан аймгийн Эрдэнэ вангийн хошуу, одоогийн Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутаг, Бүрэнхан уулын өвөрт, Ивэн голын дэнжид 1727 онд Манж Чин улсын хааны зарлигаар “Амарбаясгалант” хийдийг байгуулжээ. Тухайн үед хийдийг Хүрэннээс Далай ламын багш Агваанжамба тэргүүтэй ихэс лам нар ирж аравнайжжээ. Уг хийдэд XIX зууны сүүлээр 2600-3000 лам ном хурж байсан гэдэг. Анхдугаар Богдын

шарилыг 1736 онд уг хийдэд залжээ.

Хуучин Түшээт хан аймгийн Дархан чин вангийн хошуу, одоогийн Төв аймгийн төвийн ойролцоо, Богд хан уулын өвөрт буй “Манзушир”-ын хийдийг ачит номун хан Донхор хутагт Агваанжамбалданзан 1733-1748 онд байгуулж, Жавзандамба хутагтад өргөн барьжээ. Энэ хийд 500 гаруй лам хуврагтай байсан гэдэг.

1937 оны их хэлмэгдүүлэлтэд Манзуширын хийд өртөж, лам нарыг нь баривчилж, хөрөнгө зоорийг хураахад 53 лам баривчлагдаж, ихэнх нь цаазаар авахуулсан байна.

(Монголчууд XX зууны эхэнд. Зурагт түүх. УБ., 2011, т.207-213)



#### **Бурхны шашинд:**

1. Зовлон үнэн
  2. Зовлонгийн шалтгаан үнэн
  3. Зовлонг гэтлэх үнэн
  4. Зовлонг гэтлэх арга зам үнэн гэж сургадаг.
- Үүнийг “Хутагтын дөрвөн үнэн” хэмээнэ.

#### **Бурхны шашны сургаалийн гол үзэл санааг товчоор:**

1. Нүгэл үйлдэхгүй байх
2. Буян их үйлдэх
3. Сэтгэлээ амгалан байлгах явдал гэж тодорхойлж болно.



**Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх**

1. Баримтуудыг бүлэглэж судлан шинжлээрэй.

Баримт, мэдээлэл	Гол агуулга	Гол агуулга гэж үзэх болсон шалтгаан	Ойлголт (нэр томьёо, түлхүүр үг)	Цаашид ямар асуудлыг шийдвэрлэхийг хүсч байна
Баримт 1				
Баримт 2				
Нэгтгэн дүгнэх нь:				


2. Монголд шарын шашин өргөн дэлгэрсний эерэг болон сөрөг талыг шинжлэн дүгнэж хүснэгтийн дагуу жагсаан бичнэ үү.

Эерэг тал	Сөрөг тал



**Үр дүнг нэгтгэх, танилцуулах**

1. Монголд бурхны шашин дэлгэрэхэд нөлөөлсөн гадаад ба дотоод хүчин зүйлсийг ангилж, тодорхойлно уу
2. Монголын бурхны шашны түүхэнд холбогдох томоохон дурсгалт газруудыг мэдээлэлд үндэслэн газрын зурагт тэмдэглээрэй
3. Өөрийн орон нутагт ямар хүрээ хийд байсан талаар сурвалжлан судалж мэдээлэл цуглуулаарай.
4. Бурхны шашин монголын нийгэм болон хүмүүсийн амьдралд ямар үүрэг гүйцэтгэж байсан, одоо ямар үүргийг гүйцэтгэж байна, ирээдүйд ямар үүрэг гүйцэтгэж болох талаар ярилцаарай
5. Өнөөдөр манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа бурхны шашны хийд, дацан, лам нарын тоог холбогдох эх сурвалж, баримтуудаас цуглуулж нийт хүн амын хэдэн хувийг эзэлж буйг тооцоолон дүн шинжилгээ хийж, бусдад танилцуулаарай
6. Монголын бурхны шашинд шинэтгэл хэрэгтэй юу? сэдвээр чөлөөт мэтгэлцээн зохиож, үзсэн хичээлтэйгээ холбон, өөрийн үндэслэл нотолгоог гарган тайлбарлаарай.



4. XVIII-XX зууны эхэн үеийн монголчуудын амьдрал

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
XVIII-XX зууны эхэн үеийн монголчуудын амьдралын хэв маяг, дүр төрх зарим талаар өөрчлөгдсөн.	Харь гүрний эрхшээл дор амьдрах хугацаанд монголчуудын амьдрал зарим өөрчлөлт гарсан. Үүнд ямар хүчин зүйлс нөлөөлснийг танин мэдэх	<ul style="list-style-type: none"> <li>Амьдралын хэв маяг</li> <li>Монгол хүн</li> <li>Зан араншин</li> <li>Эрхлэх аж ахуй</li> </ul>



**Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх**

Дараах зургуудыг ажиглан сэдэвтэй холбогдох түүхийн асуулт зохиож, бусдадаа танилцуулаарай.



Зураг-3.7



**Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах**



**Баримт-1.** Оросын дипломатч И.Я.Коростовец "...монгол хүн гүндүүгүй, бодь сэтгэл өвөрлөж, хээр талаар морин дэл дээр өссөн шигээ бүхий л амьдралаа өнгөрүүлдэг, хүүхэд шиг зантай" гэж тодорхойлжээ.

Монгол хүн сэтгэл санааны хувьд хамгийн тайван хүмүүсийн тоонд орно. Тэд аливаад яарахыг огт боддоггүй. Хэзээ нэг цагт болж л таарна гэж үзнэ. Оюун ухааны хувьд монголчууд маш авхаалжтай, эелдэг сайхан сэтгэлтэй, нөхөрсөг, зочломтгой ард түмэн бөгөөд манж, хятадын нөлөөгөөр монголчууд үсээ хусах болж, зөвхөн ар дагзандаа бага зэрэг гээг үлдээх болсон байна. Ар дагзандаа гээгтэй болсон нь манжийн үед буй болсон уламжлал бөгөөд энэ нь манжид захирагдаж буйг гадаад төрхөөрөө илэрхийлж байсан хэрэг болно.

(Монголчууд XX зууны эхэнд. Зурагт түүх. УБ., 2011, т.38)



**Баримт-2.** Манжийн эрхшээлийн үед монголын нүүдэлчид урьдын адил хот айлын зохион байгуулалттай амьдарч байв. Нэг хот айлд садан төрлийн хэлхээ бүхий 5-6 айл нэг дор айлсан бууж, мал аж ахуйгаа хамтран эрхлэн явуулахыг хэлнэ. Хот айлын зохион байгуулалт нь XVIII-XX зуунд хэлбэршин тогтсон монголчуудын аж ахуйгаа хөтлөн явуулах гол хэлбэр байв. Энэхүү хэлбэр нь монголчуудын өдөр тутмын амьдралын үйл ажиллагаанд ч нөлөөлөх болжээ. Тухайлбал, ан авд мордох, тариа тарих, овоо тахих гэх мэтийг нэрлэж болох юм.

(Монголчууд XVII-XX зууны эх үе. Зурагт түүх. УБ., 2014, т.210)



**Баримт-3.** Монголчууд нүүдэллэхэд ямагт бэлэн байдаг. Тэдний морин тэрэг нь нүүдлийн гол хэрэгсэл юм. Монгол хүн нүүдэл хийхийг хүнд бэрхээс илүүтэй дураар оршин амьдрах өөрийн жам ёсны зүйл хэмээн ойлгож, түүндээ тохирсон ахуй соёлыг нэгэнтээ буй болгожээ. Нүүдлийн амьдрал нь монголчуудыг өвөрмөц онцлогтой ахуй, соёлоо тээж хөгжүүлэх, өвлүүлэх, уламжлалаа хадгалах зэрэгт нөлөө үзүүлсээр ирсэн бөгөөд XVIII зуунаас эхлэн монголчуудын нүүдэллэх байдал нэлээд өөрчлөгдсөн юм. Тэр үеийн монголчууд хавар болон намарт уртын нүүдэл хийж, харин зун, өвлийн цагт ойрын нүүдлээр амьдарч эхэлсэн байна.

(Монголчууд XVII-XX зууны эх үе. Зурагт түүх. УБ., 2014, т.210)



### Асуулт, даалгавар гүйцэтгэх

1. Зурган болон бичвэр мэдээллийн агуулгыг бие даан шинжлэн судалж, дүгнэлт хийгээрэй.
2. Дээрх баримтын мэдээллүүдийг ашиглан XVIII-XX зууны эхэн үеийн монголчуудын амьдралыг төсөөлөн сэргээж хэлэлцүүлэг өрнүүлээрэй.



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

XVIII зуунаас өмнөх үед монголчуудын амьдрал нэг л хэвийн байв. Тэр үеийн эрчүүдийн хийдэг гол ажил нь дайн байлдаан, хэрэв дайн тулаан байхгүй бол ан гөрөө хийх нь тэдний хамгийн гол ажил байв. Манжийн эрхшээлд орсноор монгол эрчүүдийн амьдралын онцлогт өөрчлөлт гарч эхэлжээ. Тухайлбал, Манжийн төрийн бодлогоор эрчүүдийг ихээр цэрэгт татахыг больж, цөөн тооны байнгын цэрэгтэй болгосон нь монголчуудын амьдралын хэв маягт өөрчлөлтийг авчирсан юм. XVIII зуунаас өмнө дайчин эрэмгий эрчүүдийн үнэлэмж өндөр байсан бол энэ үеэс эхлэн бие хаа тэгш, иж бүрэн хэрэглэл бэл сайтай, сайхан морь унасан эрчүүд нийгэмд дээгүүр байр суурийг эзлэх болжээ. Тэр үеийн монгол эмэгтэйчүүд нар мандмагц саалиндаа гарах бөгөөд дараа нь малаа ихэвчлэн хөвгүүд, охид нь хариулахаар бэлчээрт гаргадаг. Монгол эмэгтэйчүүд хоол унд хийж, үнээ малаа

саан, цагаан идээ хийж, шинээр төллөсөн малыг арчилж, хувцас хунар оёх, үр хүүхдээ асрах гэх мэт ажлыг гүйцэтгэдэг байв.

Монгол гэр бүл эрэгтэй хүүхдээ лам болгохыг урьтал болгох болжээ. Учир нь, лам нарын суудаг хүрээ хийд бол монголчуудын боловсрол эзэмших гол суурин газар болоод байв.

XIX-XX зууны зааг үед Монгол оронд 18-20 мянган малтай баячууд 30 гаруй байжээ. Халх даяар алдартай эдгээр баячуудын нэлээд нь язгуур угсаагүй баян малчид байлаа. Үүний зэрэгцээ мянгаас дээш малтай чинээлэг малчид олон байсан байна. Манжийн эрхшээлийн энэ үед Монголчуудын аж төрөл урьдынхаасаа төдий л өөрчлөгдөөгүй боловч зарим эрхлэх аж ахуйд өөрчлөлтүүд гарав. Тухайлбал, мал маллагаанд саравчтай хашаа, задгай хороо барьж ашиглах, өвс хадлан бэлтгэх, малын үүлдэр угсаа сайжруулах арга ажиллагаа нэвтэрч хөгжжээ. Түүхийн энэ үед худалдаа эрхлэх явдал монголчуудын аж амьдралд тодорхой байр эзлэх болов. Монголчууд мал, мал аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эд болон байгалийн баялаг, ангийн бүтээгдэхүүн зэргийг худалдаалдаг байжээ.



*XVIII зууны сүүл, XIX зууны эхээр Их Хүрээний лам Цамба Европ, Америк, Ази тивийг хэрэн, дэлхийг тойрон аялжээ. Энэ тухай Миндол Номун хан Жамбалдорж 1820 онд Долоон нуурын Хөх сүмд “Өмнөх замбатовийн байр байцыг дэлгэрэнгүй номносон тодорхой толь” гэх тэмдэглэлийг төвөд хэлээр бичжээ.*

Монголчуудын уламжлалт зан үйлд бурхны шашны нөлөө тусгал ихээхэн нэвтэрч, шашны үзэл сэтгэлгээ бүхий болжээ. Монгол наадам хэлбэржин тогтворжсоноос гадна олон зүйлийн тоглоом наадгай түгэн дэлгэрчээ.


Монгол орныг Манж Чин улсын төлөөний сайд захирч, монголчуудаар өртөө, харуул, цэргийн зэрэг хүнд хүчир алба хаалгах, манжийн хааны олон арван мянган малыг үнэ хөлсгүй хариулгах, Ховдод байсан манжийн дарангуй цэргийн хүнсний тариа тариулах, цаг зуурын элдэв албанд дайчлан мордуулах, татвар гаргуулах зэрэг олон зүйлийн алба гүйцэтгүүлж байв.

Манжийн эрх баригчид шашныг бүх талаар дэмжин дэлгэрүүлэх, шашны үзэл номлолыг ашиглан ард олныг номхон хүлцэнгүй болгон захирах бодлого баримталж байв. Хүрээ хийд, лам нарын тоо хэт олширсноор олон мянган идэр залуу эрчүүдийг бүтээлч хөдөлмөрөөс хөндийрүүлж, хүн амын хэвийн өсөлт саарахад хүргэжээ. Сүм хийд, лам нарын хоол унд, хувцас хунар, хурал номын бүхий л зардлыг бэлтгэн нийлүүлэх үүргийг ард олон давхар хүлээдэг байлаа.



### Үр дүнг нэгтгэх, танилцуулах

1. Дараах ойлголтуудыг тайлбарлаарай.
  - Монгол хүн, монгол хүний дүр төрх
  - Монголчуудын аж амьдрал
  - Монгол зан араншин
  - Монголчуудын ажил үйл
2. Дээрх баримт, мэдээлэлд тулгуурлан XVIII-XX зууны эхэн үеийн монгол айлын амьдралыг төсөөлөн оюуны зураглал хийгээрэй
3. XVIII-XX зууны эхэн үеийн монголчуудын дүр төрх, амьдралын хэв маяг, эрхэлж байсан аж ахуйтай холбогдох баримтат кино, мэдээ, мэдээлэл, эх сурвалжийг цуглуулж зургийн цомог бэлтгээрэй.



5. XVIII-XX зууны эхэн үеийн монголын соёл

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
XVIII-XX зууны эхэн үед ч монголчууд нүүдлийн соёл иргэншлээ хадгалан оршиж байв. Энэ үед Монголын уламжлалт эдийн болон оюуны соёл олон талаар баяжин хөгжсөн юм.	Монголчууд харийн эрхшээл доор аж төрж байсан ч үндэсний соёлоо орхиж гээлгүй хөгжүүлж ирсэн. Оюуны дархлаагаа баталгаажуулж, үндэс угсаагаа хадгалан үлдэж чадсан. Үндэсний соёл нь тусгаар тогтнол, эв нэгдэл, эх оронч үзэлтэй салшгүй холбоотой.	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсрол</li> <li>• Мэдлэг ухаан</li> <li>• Уран зохиол</li> <li>• Урлаг</li> <li>• Уран барилга</li> <li>• Хууль ёс</li> </ul>



**Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх**

*Сэдвийн малгай болгож өгсөн зургуудыг ашиглаж, тэр үеийн Монголын соёлын онцлог, ямар өөрчлөлт гарсан талаар асуулт, таамаглал дэвшүүлээрэй.*

*“...хошуудын бичгийн сургуулийн хөвгүүдийн дотроос нас бага хүнийг манж бичигт сургах хэмээн тогтсон тул...урьд манай газраас монгол бичиг төсөөлж сурав хэмээн мэдүүлсэн хөвгүүдийн дотроос манж бичиг, үг сурах нэгэн хөвгүүнд гурван сарын гэр, хөтөл, хүнс, уух ба түлээний үнэ, цай ачлага, уналга өгч мордуулан, энэ зуны тэргүүн сарын шинийн нэгэнд манай дэргэдэх жасааны газраа эрхгүй хүрч ирээд суулгатугай”.*  
 (1872 оны 4-р сарын 2-нд Түшээт ханаас нэгэн засаг ноёнд илгээсэн бичгээс Л.Жамсран. Монголын түүхийн дээж бичиг УБ.1992. т.114)

*Тэнгэрийн тэтгэсний 32-р он (1767)-д Өөлд, Мянгадаас хорин хүүхэд гаргаж, манж, монгол бичиг сургахаар айлтган тогтоожээ. Ховд хотод байгуулагдсан энэ сургуульд Алтайн Урианхай, Дөрвөд, Торгууд, Захчинаас мөн хөвгүүд татан сургаж байв.*  
 (Л.Жамсран.Монголын түүхийн дээж бичиг.3. УБ.,1992)



**Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах**

Энэ үед Монголд уламжлалт гэрийн сургууль гол үүрэг гүйцэтгэж байсны зэрэгцээ төв суурин газруудад албаны сургуулиуд байгуулагдах болсон байна. XVIII зууны II хагасаас Чин улс нилээд хэдэн сургуулийг Монголд байгуулж, Манжийн засаг захиргааны албан хаагч түшмэдийг бэлтгэх болсон байна. Тухайн үед Монгол хэд хэдэн төрлийн сургуультай байв.

XVIII-XX зууны эхэн үед Монголын сургууль соёлын салбарт шашны сургууль давамгайлж байлаа. Хөвгүүдийг 5-7 настайгаас нь эхлэн сүм, хийд, багш ламд шавь оруулж суралцуулдаг байв. Томоохон хүрээ хийдүүд дэргэдээ шашны сургалт явуулдаг төрөлжсөн дацангуудтай байлаа. Лам нар Монголдоо суралцахын зэрэгцээ Энэтхэг, Төвөдөд суралцдаг байв.

Монголчуудын дунд ардын уламжлалт эмнэлгийн зэрэгцээгээр Энэтхэг, Төвөд анагаах ухаан багагүй дэлгэрч, өвчнийг оношлох, анагаах явдлыг оточ, маарамба нар голлон гүйцэтгэх болжээ.



**Асуулт, даалгавар гүйцэтгэх**

1. Тухайн үеийн сургуульд юу заадаг байв?
2. Дээрх сурвалж тус бүрийн ил болон далд утга агуулгыг илрүүлж тайлбарлаарай.
3. Сурвалжид үндэслэн монголчуудын гэрийн сургуулийн талаар тодруулж мэдээллээ хуваалцаарай.



Монгол эмч нар өөрсдөө зохиол бичихийн зэрэгцээ Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны зохиолыг орчуулан өөрийн орны өвөрмөц онцлог нөхцөлд тохируулан эмчлэх, Монгол орны эмийн ургамлыг шинжлэн эмчилгээнд хэрэглэх талаар судалгаа хийж байжээ. Жишээлбэл:

Найманы Жамбалдоржийн “Гайхамшигт нүдний чимэг” хэмээх бүтээлийг авч үзэж болно.  
(Монгол улсын түүх. IV боть. УБ.2004., т. 285-287)



**Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах**



“Мянган оны учир шалтгааныг бийр бэхсээс асууж, Мяралзан эрээлжлэх үйл явдлыг судар бичиг лүгээ хэлэлцмүй”

“Үндсээ үл мэдэх нь адгуус буюу... өвөг юугаан үл мэдэх нь мал буюу. Нүд буй бөгөөд түүх юүгээн үл үзэх нь сохор номин буюу. Мэдэлтэй (оюун сэтгэхүйтэй) бөгөөд язгуур юугаа үл мэдэх нь мунхаг гахай буюу”.

(Монголын нэрт соён гэгээрүүлэгч Ванчинбалын Инжинаш)

XVIII-XX зууны эхэн үед Монголд олон цааз хууль үйлчилж байв. Тэдгээрийн нэг нь “Халх журам” юм. Уг хуулиар тухайн үеийн Монголчуудын нийгмийн амьдралыг зохицуулж байжээ. Монголчуудын дунд “Тэнгэрийн доор төрж, хуулийн доор амьдарна” гэх хэллэг бий. Энэ үгийн мөн чанарыг та бүхэн тунгаан бодоорой.

Монголчууд цаазалсан бэлчээр газрыг зоргоор хагалж тариулах болбоос ван, бэйл, бэйс, гүн, жич туслагч тайж нарыг журганаас чангалан ял хэлэлцмүй. Тайж болбоос шууд түшмэл эвд. Түшмэл, цэрэг, сул монгол болбоос хоёр сарын дөнгө дөнгөлж, зуун ташуур занч. Хагалсан тариаг бүрэн ширэлдүүлж, бэлчээр болго...

Нэгэн зүйл. Хаалгын дотор (Цагаан хэрэм) суусан хошууны хүн, иргэд (хятад хүмүүс) хаалга гарч, монгол газарт тариа (газар) хагалж болохгүй... Аливаа засаг ба засаг бус хан, ван, бэйл, бэйс, гүнгүүд зоргоор иргэнийг элсээн хурааж, тариа хагалбаас нэгэн иргэнээс аравт хүрснийг нь нэгэн жилийн пүнлүү хас.

(Л.Жамсран. Монголын түүхийн дээж бичиг. УБ., 1992)



### Асуулт, даалгавар гүйцэтгэх

1. Дур зоргоороо тариа тарихыг хориглож байсны учрыг тал бүрээс нь тайлбарлаарай.
2. Сурвалжид өгүүлсэн ял шийтгэл хүлээлгэх тухай заалтаас ямар дүгнэлт хийж болох вэ?



Монголчуудын дунд уламжлагдан ирсэн соёлын нэг төрөл нь аман зохиол юм. Манжийн эрхшээлийн үед Монголчуудын аман зохиол улам баяжин, баатарлаг өнгө аяс, эрх чөлөө, тусгаар тогтнолын үзэл санаа тусгалаа олох болсон байна. Монголчуудын эртний өв соёл болох туульд ч энэ үзэл санаа шингэж байв. Энэ үед Дөрвөдийн Сарисан, баядын Парчин, Урианхайн Жилхэр нарыг зэрэг олон алдартай туульчид төрөн гарчээ.

Түүний зэрэгцээгээр энэ үед монголын уран зохиол бичгийн хэлбэрээр ихэд хөгжсөн юм. Монголчууд түүхт үйл явдлыг уран зохиолын аргаар дүрслэн бичихийг эрхэмлэх нь нэлээд түгээмэл байв. Жишээлбэл, Шар тууж, Лувсанданзаны “Алтан товч”, Саган сэцэний “Эрдэнийн эрхи” зэрэг сурвалжууд нэг талаар түүхийн, нөгөө талаар уран зохиолын шинжтэй юм.

Өгүүлэн буй үед Инжинаш, Хишигбат, хуульч Сандаг, Гэлэгбалсан зэрэг олон алдартай авьяастнууд аж төрж, зохиол бүтээлээ туурвиж байлаа. Эдгээрээс та бүхэн хэний, ямар бүтээлийг мэдэх вэ? Уран зохиолын хичээлтэйгээ холбон санаарай.



Өнөөгийн монголчуудын дунд өргөн тархсан “Үлэмжийн чанар”, “Урьхан хонгор” дууг та бүхэн мэдэх үү? Энэ хэдийд бий болсон, хэний бүтээл вэ?

“Монголчууд дуулах их дуртай. Тэд найраглан, хоолой нийлүүлэн гоцлон дуулах нь туульсын шинжтэй байдаг ба тэд дуундаа зоригт эр, хүлэг сайн морь, гоо охин, нутаг усаа магтан дуулна. Монголчууд өөрсдөө дуугаа гурван төрөл болгон хуваана”. Оросын жуулчин Козловын 1892 онд бичсэн тэмдэглэлээс.

(Монгол улсын түүх. IV боть. УБ., 2004, т.309)



### Асуулт, даалгавар гүйцэтгэх

1. Инжинашийн хэлж сургасан үгийн утгыг задлан шинжлээд хийсэн дүгнэлт, өөртөө тусган ойлгож авсан зүйлээ танилцуулаарай.
2. Монгол ардын дууг ямар үндсэн төрөл болгон хувааж болох вэ? Сурвалжлан судалж, саналаа солилцон ангилал зохиогоорой.



1. ЮНЕСКО 2003 онд Уртын дууг, 2008 онд Морин хуурыг, 2009 онд бий биелгээ, тууль, цуурыг, 2010 онд хөөмэй, Монгол наадмыг, 2011 онд Лимбэний битүү амьсгалаар тоглох уламжлалыг, 2013 онд “Есөн эрдэнийн ганжуурыг” дэлхийн соёлын өвд бүртгэжээ. Үүний утга учир, ач холбогдол юу вэ?



Шашны дүрслэх урлагт Өндөр гэгээн Занабазар үнэтэй хувь нэмэр оруулав. Тэрээр цутгуурын гайхамшигт урлалыг бий болгожээ. Түүний бүтээсэн 21 Дарь эх зэрэг бүтээлүүд ур хийцийн хувьд үнэхээр гайхалтай юм.

Монголд сүм хийд олноор баригдах болсноор уран барилгын арга ухаан улам хөгжиж, өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүхий бие даасан хэлбэрийг олсон байна. Энэ үеийн монголчууд Энэтхэг, Төвөдөөс нэвтэрч ирсэн сүм хийдийн барилгын хэв загварт өөрсдийн уламжлалаа тусган оруулж, шинэ дүр төрхийг бий болгосон юм. Үүнийг Амарбаясгалант хийдийн цогчин дуган, Чойжин ламын сүм, Гандангийн цогчин дуган зэрэг барилга байгууламжаас харж болно.

Цахим сүлжээ ашиглан эдгээр уран барилгуудтай танилцаж, бусад сүм хийдтэй харьцуулан чухам юугаараа онцлог ялгаатай болохыг олж мэдээрэй.

XVIII-XX зууны эхэн үед Монголын дүрслэх урлаг ахуйн, шашны гэх хоёр үндсэн чиглэлээр хөгжих болжээ. Энэ явцад нутаг нутгийн урчуудын ур хийц, урлалын онцлогийг илтгэсэн нэртэй хийц бий болсон байна. Жишээ нь: Дарьганга, Батноров хийц г.м.



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Монголын уламжлалт өв соёлын дурсгалуудыг судлан шинжилж, тэдгээрийг зориулалтаар нь ангилж, үнэ цэн ач холбогдлыг нь тодорхойлоорой.



Зураг-3.8



2. Дээрх зурган эх сурвалжууд монголчуудын уламжлалт соёлд хэрхэн холбогдох вэ? Тэдгээрийн утга агуулга, зориулалтыг хэлэлцэн гаргаарай.



**Үр дүнг нэгтгэх, танилцуулах**

Соёлын салбарууд	Ямар мэдээлэл авав?	Мэдээллийн юу нь чухал байв?	Цаашид юуг дэлгэрүүлж судлахыг хүсч байна вэ?
Сургууль			
Анагаах ухаан			
Уран зохиол			
Урлаг			
Уран барилга			
Ахуйн соёл			



**Өөрийгөө үнэлээрэй**

1. Түлхүүр үг тус бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Сургууль
- Урлаг
- Уран зохиол
- Уран барилга
- Ардын аман зохиол

2. Мэдээлэл болон бусад эх сурвалж ашиглаж судлан гүйцэтгээрэй.

Тухайн үеийн монголчуудын амьдралыг өнөө үетэй харьцуулбал:				
Сургууль боловсрол	Урлаг	Уран зохиол	Уран барилга	Хувцас, гоёл чимэглэл



### 6. МОНГОЛЫН ТАЛААРХ МАНЖ ЧИН ГҮРНИЙ БОДЛОГО ӨӨРЧЛӨГДӨВ

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
<p>Монголд Шинэ засгийн бодлого хэрэгжүүлсэн түүхэн цаг, хугацаа</p> <p>Шинэ засгийн бодлого хэрэгжүүлсэн шалтгаан, хүчин зүйлс, үр дагавар</p>	<p>Монголын талаарх Манж Чингийн бодлого өөрчлөгдсөн нь Монголчууд тусгаар тогтносон төр улсаа сэргээх тэмцлийн урьдач нөхцөлийг бүрэлдүүлсэн юм.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Манж Чин гүрэн</li> <li>• Шинэ засгийн бодлого</li> <li>• Монгол</li> <li>• Хүчин зүйлс</li> <li>• Үр дагавар</li> </ul>



**Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх**



Зураг-3.9

Зураач Б.Шарав.  
1923 он

Энэ зурагт тухайн үеийн түүхийн бодит байдлыг дүрслэн үзүүлсэн үү?

Эсвэл уран сайхны хэтрүүлэг үү?

Хэрэв бодит байдал гэж үзвэл Монголчуудыг ямар хувь заяа хүлээж байна вэ?

Энэхүү зурагт хуудасны өгүүлэмж, утга агуулгын талаар үзэл бодлоо илэрхийлээрэй.

XIX зууны сүүлчээс Чин улс бодлогоо өөрчилж, “Шинэ засгийн бодлого” явуулав. Энэ нь ямар учиртай бодлого байсан талаар асуудал дэвшүүлээрэй.

Манж Чин улсын төрийн бодлого өөрчлөгдсөн нь монголчуудын нутаг орны байгаль, аж ахуй амьдрал, шашин соёлд сөрөг нөлөө үзүүлэхэд хүрсэн.



Зураг-3.10

Ар Монгол дахь Манжийн сайд, түшмэд

Манж Чин улс дотоод, гадаад шалтгаанаар хямралд оров.

Хямралаас гарахын тулд шинэтгэлийн бодлого хэрэгжүүлэв.

Монголыг Хятадаас тусдаа байлган захирах бодлого үндсээрээ өөрчлөгдөв.

**Тайлбар:** Шинэ засгийн бодлого (Синьчжэн-хятадаар) гэдэг нь Монголыг бүрмөсөн колоничлон дуусгаж, хятадын адил болгох гэсэн Чин улсын төр-эдийн засаг, соёлын ихээхэн хор уршиг бүхий бодлого юм.



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

**Мэдээлэл 1.** XIX зууны 90-ээд онд дэлхийн их гүрнүүд Манж Чин улсыг нөлөөнийхөө хүрээнд хэсэглэн хуваав. 1895 онд Япон Хятадаас Тайвань арлыг, 1898 онд Герман Цзяочжоувань булан болон Шаньдуны хойгийн хэсгийг, Хаант Орос Ляодуны хойг, Дальянь ба Порт-Артур боомтуудыг, Англи Цзюлун хойг болон Шаньдун мужийн Вэйхайвэй боомтыг, Франц Гуанчжоувань эргийг тус тус эзлэн авчээ. Гадаадын нөлөөгөөр XX зууны эхээр Манж Чин улсад капитализмын хөгжил түргэсэв. 1898-1900 онуудад гадаадынхныг эсэргүүцсэн бослого дэгдсэн ч 1901 онд дарагджээ. Япон, Орос, Герман, АНУ, Франц, Англи, Австри-Унгар, Итали зэрэг 8 улстай хийсэн дайнд ялагдаж, их хэмжээий дайны төлбөр төлөхөөр болов. Шинэ хөрөнгөтнүүд феодалын дэглэм, харийн хүчирхийлэлд автсан Манж Чингийн засаглалыг өөрчлөхийг зорив.

(Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Монгол улс. (1911-1919). УБ., 2006)

**Мэдээлэл 2.** Манж Чингийн хаан 1901 онд зарлиг гаргаж нийгмийн хямралаас гэтлэх зорилгоор “Шинэ бодлого” хэмээх шинэтгэлийг хэрэгжүүлэхээр болсон юм. Энэ хүрээнд Монгол, Төвөд зэрэг хязгаар оронд шинэтгэл хийхээр төлөвлөснийг нь монголчууд “Шинэ засгийн бодлого” гэж нэрлэж байлаа. Түүний зэрэгцээ “Иргэнийг шилжүүлэн суулгаж хязгаарыг бэхжүүлэх” хэмээх бодлогоор олон мянган хятадуудыг нүүлгэн суурьшуулж эхэлжээ.

Тэдгээр бодлогыг хэрэгжүүлэхэд Монголын олон хошуудын эрх баригчид аргагүйн эрхэнд хамрагдах болов. Тухайлбал, монголчуудын бэлчээр нутгийг тариалангийн газар болгох зорилгоор олон зүйлийн судалгаа байцаалт хийх болов.



### Унших, ойлгох, эрж хайх

**Баримт 1. 1907 онд Манжийн төрөөс монгол хошуудын талаар тусгай судалгаа хийв. Үүнд:**

1. Хятад иргэд ба монголчуудын тарианы газрын хэмжээ, тарьдаг тариа, атаршсан газрыг сэргээж хятад иргэдээр хагалбарлуулбал болох эсэх, сул газрыг тодорхойлох.
2. Нэрт их ууланд ямар төрлийн мод ургадаг, хөндлөн гулд тийшээ хэдэн газар, түүнийг яаж өсгөн тарих, тэр модоор юу үйлдэж болох, хаашаа тээвэрлэн худалдаж ашиглаж байгаа эсэх, албан худалдаа гаргаваас ямар?
3. Тайж, харц ардын адуулан тэжээсэн дөрвөн зүйлийн мал хэд хичнээн, бэлчээр нь бүгд хэдий газар болох, ямар мал хэд хичнээн өвс, ус дагаж нүүж нутаглах, мал адуулах, бордож тэжээх аргыг тодорхойлох.
4. Ой мод, уул нуруунд олон зүйлийн гөрөөс бий эсэх, ямар ямар хүмүүс тэдгээрийг агнадаг, тэргүүлсэн хүн байдаг уу, ангаас орох орлого хир зэрэг, агнах аргыг тодорхойлох.
5. Малын арьс шир, унгас ноос, яс зэрийг ашиглаж боловсруулах үйлдвэр нээвэл ямар?
6. Ямар зүйлийн ашигт малтмал хаана байдаг, түүнийг ашиглаж байгаа эсэх, цаашид яаж ашиглах?
7. Аль нуурт ямар төрлийн загас байдаг, хятад, монголчууд агнадаг эсэх, түүнийг хэрхэн өөр аргаар агнуулах.
8. Давст нуур бий эсэх, ямар төрлийн давсыг хаашаа тээвэрлэн худалдах, давст нуурын талбай хичнээн газар, хятад, монгол хүмүүс ашигладаг бол ямар үнэ гаальтай байдаг?
9. Олон хошууны цэрэг, зэр зэвсгийн уг тогтоосон тоо хэд, одоо ямар зүйлийн зэр зэвсэгтэй яаж сурган боловсруулдаг, цэрэг цалин авдаг эсэх, цаашид хэрхэн тэгшитгэн шийтгэх.
10. Сургууль бий эсэх, шинээр сургууль байгуулсан газар хэд, юуг баримталж байгуулсан, сургагч багш, сурагчид хэд, цаашид яаж төлөвлөж байгаа?
11. Аймаг хошуудад хэдэн өртөө өртөө байдаг, тэдгээрт ажилладаг хүмүүсийн тоо, зардал сүйтгэл хичнээн?
12. Аймаг, хошуудын нутгийн зах зааг, хаашаа ямар газраар нийлдэг, гадаад улстай хил залгадаг эсэх?
13. Худалдааны иргэд хэд, хашаа хүрээ буй эсэх? ямар газар гадаадын хүмүүс голлон худалдаалдаг буюу худалдвал ашигтай, цаашид худалдаачдыг хэрхэн ирүүлэх?
14. Хятадын аль мужаас худалдаачин, цэрэг иргэн ирэхэд тохиромжтой их зам буй, яаравчлан төмөр зам байгуулбал хаанаас залгаж тавих зэргийг байцаажээ.

Энэ байцаалтанд засаг захиргаа, шашин шүтлэгийн талаар төлөвлөж байсан арга хэмжээ тусгаагаагүй боловч Чин улсын төрөөс тунхагласан шинэ засгийн бодлогын үндсэн агуулга багтсан юм.

(Л.Жамсран. Монголын түүхийн дээж бичиг.3. УБ., 1992)



Манжийн төрөөс Монголын талаарх бодлого өөрчлөгдөх болсон шалтгаан нь дараах мэт болно. Үүнд, Манж Чин улсын зах хязгаар орныг гадаадынханд алдахгүйн тулд газаргүй тариачин хятад иргэдээр дүүргэж асуудлыг шийдвэрлэх, нутгийн баялгийг ашиглахын тулд нээлттэй болгох, дайны төлбөрийг төлөхөд нөөц бололцоог бүрэн дайчлах, манж нарыг уусгасан хятад түшмэдийн бодлогоор хятад биш үндэстнийг хүчээр уусган устгах зэрэг болно. Жишээ нь, Манж Чин улсаас Хаант Орос улсын нөлөө ихсэж байсан нөхцөлд Монголыг



Зураг-3.11

хятадын дотоод муж болгохын тулд урьдын уламжлалт бодлогоо өөрчилсөн юм.

Үй олон хятад тариачдыг Монгол газар ирүүлж, газар хагалуулж, тариа тариулах нэрийдлээр нүүлгэн шилжүүлэх болов. Энэ бодлогоо хэрэгжүүлэхийн тул 1906 онд Бээжин хотноо “Нүүдлийн иргэдийн хэргийг эрхлэх хороо” байгуулан, монгол, оросын хилийн дагуу нутагт хятад тариачдыг ирүүлэн суурьшуулж эхэлсэн юм.

Манж Чин улс Монголд шинээр цэрэг бэлтгэх газар, цагдан сэргийлэх хороо, ой модны түрээсний ерөнхий ба салбар хороо, эрүүлийг хамгаалах хороо, хэмжээт засгийн явдлыг сүвэгчлэн

бэлтгэх газар, гадаадтай харилцах хороо, худалдааны явдлыг хянан байцаах хороо гэх зэрэг хорь орчим албан газрыг байгуулсан юм.

Монголчуудын аж ахуйн орлого, түлээ мод болон бусад тээврийн зүйлээс гааль хурааж эхэлжээ. Энэ бүхэн монголчуудын дургүйцлийг зүй ёсоор төрүүлж байв. Иймд тэрхүү харгис бодлогыг монголчууд “үндсийг таслах, шашныг устгах” бодлого хэмээн үзэв. Улмаар “язгуурын ёсоо журамлах” уриан дор Манжийн төрийг эсэргүүцэн босож, тусгаар тогтнохын төлөө тэмцэж эхэлжээ.

**Баримт-2:** “... Хятад түшмэд манай ... эрхийг эзэлж эрт эдүгээд олон монголыг хилс бэрхээр дарлан зовоож хашруулан бүхий учрыг эдүгээд бидний товчлон гаргаж мэдүүлэх нь:

... Нэгэн зүйл. Эзэн хаан жил бүр манай монгол олон засгуудад хууль ёсоор шагнавал зохих торго будааны зэрэг тоо бүхий юмыг олон онд өгсөнгүй. Манж хятад түшмэл завсраас шүүрэн авч ашиглаад сүрээр айлгаж, ер нэхэх гомдох газаргүй болсон билээ.

Нэгэн зүйл. Монгол газарт Шинэ засаг дэлгэрүүлэх нэрээр шалтгаалж олон иргэнийг нэн үлэмж хуруулан халхын хойд хязгаарын хэд хэдэн хошууны нутгийг зөвд нь хагалан тариа тариулж нутаглан суулгахаар нэгэнт тогтоон бүхий нь Монголын амьдралыг нэгмөсөн тасалж, харьяат хязгаар захыг батлая гэсэн санаа лавтайяа мөний тул нэн цухалдаж хорсох билээ.

Нэгэн зүйл. Манай Монгол Манж улсад дагаж орсноос хойш олон зальхай иргэд наймаа худалдааны учир өөрсдийн юмыг онц их үнээр худалдан өгөх бөгөөд манай монголын мал юмыг боогдуулан хялбар үнэнд авах ба мөнгө зоос зээлдүүлбэл хүүгээс хүү үржүүлж авсаар нэгэнт яс чөмгөнд хүртэл ядруулсан бөгөөтөл одоо “Шинэ засаг” хэмээн нэрийдэж олон зүйлийн юмнаас цөм гааль татвар хурааж улмаар мөлжин элдэв зүйлээр үрэгдүүлэн бүхий нь манай Монголын хүчин яахин тэсэх билээ.

Нэгэн зүйл. Угаас тогтоосон хуулинд монгол, иргэн харилцан ураг барилдаж болох ёсон үгүй бөгөөтөл одоо Шинэ засгаар шалтгаалж хуучин хуулийг халж монгол, иргэн харилцан ураг барилцахаар ноднин жил зарласан нь үнэхээрийн хортой санаа мөн бөгөөд энэ мэт харанхуй засгийг манай Монгол яахин дааж чадах билээ...”

(Л.Дэндэв. “Монголын товч түүх”-ээс)



**Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх**

1. XIX зууны сүүлч XX зууны эхэн үеийн Манж Чин улсын талаарх мэдээ, баримтад дүн шинжилгээ хийнэ үү.  
а). Мэдээллийг өгсөн чиглэлийн дагуу бүлэглэж даалгаврыг гүйцэтгээрэй.

Агуулга / Эх сурвалж	Цаг, хугацаа	Гол мэдээлэл	Мөн чанар
Мэдээлэл-1			
Мэдээлэл-2			

а). Эх сурвалжийн агуулгийг нэг бүрчлэн задлан шинжилж, бүлэглэн ангилж өөрийн үнэлэлт дүгнэлт өгөөрэй.

Агуулга / Эх сурвалж	Гол утга санаа	Зорилго, мөн чанар	Хувийн дүгнэлт
Баримт-1	1. 2. — —		
Баримт-2	1. 2. — —		

2. “Шинэ засгийн бодлого”-ын түүхэн нөхцөл шалтгааныг тодорхойлно уу.
3. Монгол хошуудыг яагаад байцаан судлах болсон бэ?



**Үр дүнг нэгтгэх, танилцуулах**

1. “Шинэ засгийн бодлого” нь монголчуудын аж ахуй, нийгэм, шашин, соёлын амьдралд ямар өөрчлөлт оруулахаар болсныг холбогдох баримт, мэдээлэлд тулгуурлан жишээ гаргаж тайлбарлах, нотлох
2. Монголчуудад хятадчлагдах аюул тулгараад байсныг ямар баримтаас мэдэж болох вэ, түүний үр дагавар, хор уршгийг тунгаан бодож тайлбарлаарай.
3. “Үндсийг таслах, шашныг устгах бодлого” хэмээсний утгыг тайлбарлан эргэцүүлэмж бичээрэй.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ XVIII-XX зууны эхэн үеийн дэлхий дахин




### 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН ХУВЬСГАЛ

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
<p>Үйлдвэржилт нийгмийн хөгжил, хүмүүсийн амьдралыг бүхэлд нь өөрчилсөн юм.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Аж үйлдвэржилт нийгмийн хөгжилд өөрчлөлт авчирдаг.</li> <li>• Үйлдвэржилт хүмүүсийн амьдралд чухал хувь нэмэр оруулдаг.</li> <li>• Үйлдвэржилт мөн сөрөг үр дагавартай.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Аж үйлдвэржилт</li> <li>• Машин техник</li> <li>• Эзэн, ажилчин</li> <li>• Аж үйлдвэржсэн нийгэм</li> </ul>



#### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх

Мэдээлэлд тулгуурлан асуудал таамаглал дэвшүүлээрэй.



#### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

**Аж үйлдвэрийн хувьсгалын эхлэл.** Аж үйлдвэрийн хувьсгал 300 гаруй жилийн өмнө Англид эхэлж, Европын бусад улс орнууд, АНУ-д дэлгэрсэн.


**Нэхмэлийн салбар.** Англичууд гол төлөв ноос болон маалингаар мануфактурт хийсэн хувцас өмсдөг байв. Баячуудад зориулсан торгыг Энэтхэг, Хятадаас авдаг байжээ. Хэрэглээ нэмэгдэж, эрээн даавууны эрэлт ихэссэн тул Манчестрийн даавууны үйлдвэрлэлийг дэмжихийн тулд Британийн засгийн газар Энэтхэгээс бөс даавуу авчрахыг хориглосон байна. Нэхмэлийн фабрикууд эхлээд Энэтхэг даавууг дууриалган хийсэн боловсруулалт тааруу даавуу үйлдвэрлэж байсан боловч чанар нь аажмаар сайжирч байлаа. Ноосон даавууг бодвол хөнгөн, эдлэхэд тохиромжтой даавуугаар хийсэн цамц, бэлэн хувцас өмсөхийг хүсэгчид улам бүр олширчээ. Энэ нь шинэ шаардлагыг бий болгов. 1733 онд Жон Кей нэхмэлийн суурь машин зохион бүтээв. Мөн нэг зэрэг найман утас ээрдэг “Женна” нэртэй машиныг Жеймс Харгрийвс 1765 онд зохион бүтээжээ. Эдмунд Картрайтын

зохион бүтээсэн нэхмэлийн суурь машин хөдөлмөрийн бүтээмжийг 40 дахин нэмэгдүүлэв.



*Зургийг ажиглан шинжилж, үйлдвэржилтийн үр дагаврыг үнэлж тодорхойлоорой.*

Зураг-3.12



Эх сурвалж: *The Random House Children's Encyclopedia.*  
Random House. New York, Toronto. 1991, pp.281

**Тайлбар:** Аж үйлдвэрийн хувьсгал гэж XVIII-XIX зуунд явагдсан аж үйлдвэрийн хөгжлийг цоо шинэ шатанд гаргасан техник, технологийн дэвшил, түүний үр дүнд нийгэм түүхэнд гарсан өөрчлөлтийг хэлдэг.

**Уурын хөдөлгүүр бий болсон нь.** Уурын хөдөлгүүр аж үйлдвэрийн хувьсгалын түүчээ нь болсон юм. Усан хөдөлгүүр бүхий машин техникийг ажиллуулахын тулд үйлдвэрүүдийг гол мөрний ойролцоо байгуулдаг байлаа. Харин уурын хөдөлгүүр зохиосноор заавал гол мөрний эрэгт үйлдвэр байгуулах шаардлагагүй болов. Уурын хөдөлгүүр бий болсон нь мөн нүүрсний хэрэгцээг нэмэгдүүлэв. Нүүрсний уурхайгаас үйлдвэр хүртэл хямд төсөр аргаар нүүрс тээвэрлэх шаардлага урган гарлаа. XVIII зууны II хагаст Брижуотер нүүрснийхээ уурхайг Манчестертэй холбосон 60 км суваг байгуулжээ. Нэг тонн нүүрсийг хуурай газраар тээвэрлэхэд 2 фунт зарцуулж байсан бол сувгаар тээвэрлэхэд 50 пенс зарцуулдаг болов.

Аж үйлдвэрийн хувьсгалын явцад Германы эрдэмтэн Р.Дизелийн (1853-1913) бүтээсэн дотоод шаталтын хөдөлгүүр чухал үүрэг гүйцэтгэжээ. XIX зууны 70-90 онд дэлхийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл бараг 3 дахин өсөв. Үйлдвэрлэлд үр ашигтай шинэ нээлтүүд олноор гарч, тэдгээрийг үйлдвэрлэлд

нэвтрүүлэх явдал 1870-1900 онд 56 дахин өсчээ.

XVII зуунд Англид үхрийн амьдын жин 170 орчим кг байсан бол XIX зуунд 350 кг болж, нэмэгдсэн. Нэг үнээнээс саалийн хугацаанд 800-1000 л сүү саадаг бол 1880 –аад оны үед Францад 1200 л, АНУ-д 1300-1800 л, Британид 1800-1900 л сүү саадаг болов.



Зураг-3.13

**Байгаль орчинд.**

Ногоон зүлэг байсан олон газарт үйлдвэр байгуулагдаж, утаа орчин тойрныг бохирдуулах болов. Эргэн тойрон нүүрс, үйлдвэрийн хаягдалд дарагдсан нь газрын хөрсийг ихээр бохирдуулж байлаа...



**Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх**

1. Яагаад шинэ ээрэгч машиныг зохион бүтээх болов?
2. Үйлдвэрлэлийн бүтээмж хэрхэн өсөж байна вэ?
3. Малын ашиг шим хэдэн хувиар нэмэгдсэнийг тооцон гаргаж, юу нөлөөлснийг судлан шинжилж тогтоогоорой.
4. Нүүрс ихээр ашиглах нь байгаль орчинд ямар ямар сөрөг нөлөө үзүүлэхийг тодорхойлж, өнөөгийн амьдралтай холбон жишээ гаргаж, үзэл бодлоо илэрхийлээрэй.

Зураг-3.14



**Баримт.** Тухайн үед үйлдвэрийн ажилчид 14-18 цаг ажиллаж байжээ. Хүүхдийн хөдөлмөрийг насанд хүрэгчдээс багаар үнэлж, хямдхан ажиллуулдаг байв. Зарим үйлдвэр тоног төхөөрөмжөө засуулахад тохиромжтой учир хүүхдийг насанд хүрэгчдээс илүү авч ажиллуулах сонирхолтой байв. Хөвөн утас ээрч буй хүүхдүүд хөл нүцгэн ажилладаг байв. Тухайн үед хүүхдүүд сургуульд сурах боломжгүй, гэр бүлдээ туслах зорилгоор долоо хоногийн зургаан өдөр үйлдвэрт ажиллана. Тэдний ажиллах нөхцөл хүнд, ядарч туйлдан ажлаасаа тарахад харанхуй, заваан,

аймшигтай орчин угтдаг байлаа. Жишээ нь: Вильям Купер, 10 настай эгчийн хамт нэхмэлийн үйлдвэрт ажилладаг. Ажил нь өглөө 5 цагт эхэлдэг. 12 цагаас 40 минутын цайны завсарлагатай бөгөөд үүнийг маш их хүлээдэг байв. Тэд унтаж ер болохгүй, ташууртай хянагч хяналт тавьдаг байв ... 18 цагаас оройн хоолоо иддэг. 21 цагт ажил нь дуусдаг боловч Купер эгчийн хамт өөр нэг газар ажиллаж, 11 цагт гэртээ харьдаг байжээ.



**Асуулт, даалгавар гүйцэтгэх**


1. Яагаад үйлдвэрийн ажилчдын эрх ашгийг хамгаалах байгууллага байгуулагдсан бэ?
2. Дээрх баримтад хүүхдийн ямар ямар эрх зөрчигдөж байна вэ?




Үр дүнг нэгтгэх, танилцуулах

1700


1800



Томас Ньюкомэн 1712 онд уурын хөдөлгүүрийг зохион бүтээж уурхайн гүний усыг шахан гаргахад хэрэглэв.




Жеймс Ватт 1765 онд уурын хөдөлгүүрийг сайжруулж уурхай, нэхмэлийн болон бусад үйлдвэрийн янз бүрийн машин ажиллуулах боломжтой болов.



Ричард Трэвитик 1799 онд өндөр даралтат уурын хөдөлгүүрийг бүтээж анхны сүйх тэрэг, галт тэрэгний зүтгүүрийг бий болгов.

Он тооллын шулуун ашиглан уурын хөдөлгүүрийн бүтээмжид ямар өөрчлөлтүүд гарсныг тайлбарлаарай.



(Европын түүхийн статистик, 1750-1975. - McDougal Littell. World History Patterns of interaction. Roger B.Beck, Linda Black., Printed in the USA, 2007. pp.727)

1. Зурган мэдээлэл дээр ажиллаад үйлдвэржилт хүмүүсийн хэрэгцээг хэрхэн хангаж байгааг тодорхойлоорой.

Төмөр зам	Төмрийн үйлдвэр	Нэхмэлийн үйлдвэр	Нүүрсний уурхай


2. Ноосон даавууны хэрэглээ хэрхэн өсөж байна вэ?
3. Хотын хүн ам өсөхөд юу нөлөөлсөн бэ?

Хэрэгцээний төрөл	Юуг зохион бүтээсэн бэ ?	Юуг өөрчилсөн бэ?	Ямар үр дүнд хүрсэн бол...




**Өөрийгөө үнэлээрэй**

1. Доорх түлхүүр үгийн утгыг тайлбарлана уу.
  - Уурын хөдөлгүүр
  - Машин техник
  - Эзэн
  - Ажилчин,
  - Аж үйлдвэржсэн нийгэм
2. Он тооллын шулуун дээр аж үйлдвэрийн хувьсгалд холбогдох гол үйл явдлуудыг тэмдэглэ.



3. Үйлдвэржилт хүмүүсийн хэрэгцээг хангахад ямар үүрэг гүйцэтгэснийг тайлбарлаарай.
4. Аж үйлдвэрийн хувьсгалын ач холбогдол, үр дагаврыг ангилан тодорхойлоорой.

Үйлдвэржүүлэлтийн үр дүн, ач холбогдол	Үйлдвэржүүлэлтийн сөрөг үр дагавар



## 2. ШИНЖЛЭХ УХААНЫ ОЛОЛТ, НЭЭЛТҮҮД

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
Шинжлэх ухааны ололт, нээлтүүд нь хүн төрөлхтний түүхэнд томоохон өөрчлөлт авч ирсэн.	Шинжлэх ухааны хөгжил, түүний үр дүн, ололт нээлтүүд нийгмийн хөгжлийг урагшлуулагч чухал хүчин зүйл болдог. Шинэ үед гарсан шинжлэх ухааны нээлтүүд өнөөдөр ч бидэнд ач тусаа өгсөн хэвээр байна. Бид шинжлэх ухааныг танин мэдэж, түүний төлөө зүтгэх ёстой.	<ul style="list-style-type: none"> <li>• Шинжлэх ухаан</li> <li>• Нээлт бүтээл</li> <li>• Анагаах ухаан</li> <li>• Байгалийн ухаан</li> <li>• Техникийн ухаан</li> <li>• Холбоо, мэдээлэл</li> </ul>



### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх

*Шинжлэх ухааны ололт, нээлт нийгмийн хөгжилд юугаараа ач тустай вэ? Яагаад өрнөдийн улс орнуудад шинжлэх ухааны хөгжил шинэ шатанд гарч чадав?. Шинжлэх ухаан хөгжсөнөөр энэ үед хүн төрөлхтний түүхэнд чухам ямар өөрчлөлт гарав? Энэ бүхний талаар тунгаан бодож, таамаглал дэвшүүлээрэй.*



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

**Байгалийн шинжлэх ухаанд:** Химич эрдэмтэд эмийн төрөл аспиринаас эхлээд шинэ сүрчиг, саван, маргарин гэх зэрэг ахуйн болон хүнсний хэдэн зуун бүтээгдэхүүнийг бий болгов. Шинэ бордоо бий болгосон нь газар тариалан, хүнсний үйлдвэрлэлд онцгой үүрэг гүйцэтгэжээ. Британий байгаль судлаач Чарлз Дарвин олон жилийн ажиглалт, судалгааныхаа үр дүнд туурвисан “Зүйлийн үүсэл” алдарт бүтээлээ 1859 онд гаргав. Тэрээр өдгөө дэлхий дахинд Дарвины хувьслын онол хэмээн алдаршсан онолоо дэвшүүлэв. Энэ үзэл онол нь хүн, амьтныг бурхан бүтээсэн гэх номлолыг үгүйсгэсэн юм.

**Анагаах ухааны салбарт:** Английн физикч Майкл Фарадей эфирийн химийн нэгдэл өвдөлтийг зогсоодог нээлтийг хийв. Америкийн мэс засалч хагалгааны үед анх удаа эфирийг ашиглаж, мэдээ алдуулах аргыг хэрэглэв. Мөн Жосеф Листер бактерийн эсрэг карболын хүчлийг мэс засалд ашиглажээ. Мэс заслын үед бээлий өмсөх, мэс заслын багажуудыг халдвар тогтохооргүй гөлгөр материалаар хийж, ариутгаж байх саналыг гаргаж байлаа. 1846 онд Америкийн эмч Вэндэлл Холмс өвдөлт намдаах үйлчилгээтэй химийн бодисуудыг өвчин намдаагч, бүх мэдрэхүйг үгүй болгодог бодисыг мэдээ алдуулагч гэж нэрлэсэн байна.


**Техник, технологийн шинжлэх ухаанд:** 1831 онд Америкт Сирьюс Хол МакКормикын бүтээсэн механик ургац хураагч нь гурван хүний ажил гүйцэтгэдэг байв. Мөн 1850-иад онд Фаулерийн уурын анжисыг газар тариаланд хэрэглэв. Швед эрдэмтэн Альфред Нобель динамитыг зохион бүтээж, барилга, цэргийн салбарт ашиглажээ. АНУ-д дугуй үйлдвэрлэгч ах, дүү Орвил, Вилбур Райт нар 1903 онд анхны нисэх онгоцыг зохион бүтээжээ.

**Холбоо, мэдээлэл харилцааны салбарт:** 1836 онд Америкийн зохион бүтээгч Семюэл Морзе холбооны шинэ телеграф бүтээж, цахилгаан соронзон аппаратын тусламжтайгаар мэдээллийг цэг, зураасаар тэмдэглэн дамжуулах болжээ. 1879 онд харилцах утасны сүлжээ бий болов. XIX зууны эцэст Италийн эрдэмтэн Гульельмо Маркони мэдээллийг радио долгионоор дамжуулах утсан шугамгүй телеграфийн тухай санал гаргаж, 1896 оноос туршин мэдээгээ 15 км зайтай газар дамжуулсан нь шинэ ололт байв.



Томас Эдисон (1847-1931) бол дэлхийн хамгийн агуу зохион бүтээгч, шинийг санаачлагч юм. **«Суут хүн гэдэг нэг хувийн авьяас, ерэн есөн хувийн хичээл, зүтгэл»** хэмээн тэр хэлжээ. Хөдөлгөөнт зураг, дуу хураагуур зэргийг хамааруулж үзвэл 1000 гаруй бүтээлийг зохион бүтээсэн (1093 патент авсан) байдаг. Тухайлбал, анхны цахилгаан дэнлүү бүтээж, хотууд үзэмжтэй болж, шөнө дөлөөр ажиллах боломжтой болжээ.






Александр Грэхэм Белл (1847-1922) анхны телефон утсыг 1876 онд АНУ-д зохион бүтээсэн байна. Энэ нь өнөөдөртэй зүйрлэшгүй, маш ойрхон зайд холбоо барьдаг байжээ. Шотландын зохион бүтээгч Александр Грэхэм Белл ба хамтрагч Томас Ватсон нар утсыг туршиж хоорондоо холбоо барьжээ. Тэдний анхны яриа нь “Ватсон хүрээд ир, чи хэрэгтэй байна” гэсэн үг байв. Телефон утасны анхны загвар нь бүрээ хэлбэртэй яригч чагнууртай байлаа.

 **Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх**

**1. Мэдээллүүдийг судлан шинжилж, нэгтгэн дүгнэж, доорх хүснэгтийн асуултад хариулаарай.**

Д/д	Юуг нээсэн бэ?	Хаана нээсэн бэ?	Хэзээ нээсэн бэ?	Хэн нээсэн бэ?	Ач холбогдол нь юу вэ?
1					
2					
3					
4					
5					
6					
7					



2. Хөдөлгүүрийн хурдад гарсан өөрчлөлт нь хүн төрөлхтөнд ямар ашиг тустай байгааг жишээ баримт гарган тайлбарлаарай.
3. Баримт мэдээлэлд тулгуурлан шинжлэх ухааны ямар ололт нээлт аль улсад гарсныг газарзүйн зурагт тэмдэглээрэй.



4. Баримтад үндэслэн аль улс нь шинжлэх ухааны ололт, нээлтээрээ тэргүүлж байгааг харуулсан баганаан диаграмм байгуулаарай.
  - Аль улс
  - Хэдэн бүтээл
  - ...



**Үр дүнг нэгтгэх, танилцуулах**

1. Шинжлэх ухааны нээлтээр ямар шинэ шийдлийг олсон бэ?

Шинжлэх ухааны ололт нээлтүүд	Өнөөдөр хүмүүс хэрхэн ашиглаж байна вэ?:	Ач холбогдол нь юу вэ?	Шинжлэх ухааны хөгжил үйлдвэржилтэй хэрхэн холбогдохыг тайлбарлаарай
Байгалийн шинжлэх ухаанд			.....
Анагаах ухааны салбарт			
Техник, технологийн шинжлэх ухаанд			



**Өөрийгөө үнэлээрэй**

- Нээлт, ололт гэх үгийн утгыг тайлбарлаарай
- Шинэ нээлт, ололтын үр дүнд хүн төрөлхтний амьдралд гарсан өөрчлөлтийн нотолгоог гаргаарай.
  - Нийгмийн хөгжилд .....
  - Хүмүүсийн харилцаанд.....
  - Хүмүүсийн амьдрах орчинд.....
- Шинжлэх ухааны бусад ололт, нээлтүүдийн талаар мэдээлэл цуглуулж танилцуулаарай.




### 3. ХУВЬСГАЛ БА ШИНЭ УЛС ГҮРНҮҮД

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
<p>XVIII-XIX зуунд гарсан хувьсгалууд тухайн эрин үедээ төдийгүй дараагийн зуунд чухал үүрэг гүйцэтгэсэн. Хувьсгалын үр дүнд ардчилсан засаглал, хүний суурь эрх баталгаажсан.</p>	<p>Шинэ үеийн түүхийн нэг онцлог бол олон хувьсгалт эргэлтүүд болсон явдал юм. Хувьсгал нь түүхийн шинэ үеийн дүр төрхийг өөрчилсөн төдийгүй, өнөө үеийн түүхэнд ул мөрөө үлдээсэн.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боолчлол</li> <li>• Эрх чөлөө</li> <li>• Хувьсгал</li> <li>• Үндсэн хууль</li> <li>• Тусгаар тогтнол</li> </ul>



#### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх



Газарзүйн зургийг ажиглан, түүнд буй мэдээлэлд тулгуурлан асуудал таамаглал дэвшүүлээрэй.

**Тайлбар:** Хувьсгал - Аливаа тогтсон суурь харилцааг үндсээр нь богино хугацаанд эрс өөрчлөх нийгмийн үйл явц. Тогтсон засаглалын хэлбэр, тогтолцоог өөрчлөх шаардлага нь нийгэмд бүрэлдсэн нөхцөл байдлаас хамаардаг.

## Английн хүчирхэгжил, Америкийн тусгаар тогтнолын дайн




### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

**Мэдээлэл-1.** 1492 оны 10 сарын 12-нд Х.Колумб Америк тивийг нээснээс хойш Европын олон орон энэ тив рүү тэмүүлэн колоничлолын бодлогыг эхлүүлжээ. Англи улс 1585 онд хамгийн анхны колонио хатан хаан Елизабетад зориулан “Виржини” гэж нэрлэснээс хойш XVIII зууны сүүл хүртэл Атлантын далайн баруун эрэгт 13 колонитой болоод байв. Их Британи колонийн өрсөлдөөнөөс Нидерланд, Испани, Португали, Францыг шахаж, Энэтхэгт амжилт олов. Ажиллах хүчин, зах зээл, түүхий эдийн хэрэгцээ байнга өсөж, үүнд колониуд ихээр нэрвэгдэх болжээ.



XVIII зуунд Их Британи улс машинт үйлдвэрлэлд шилжиж, Лондонгийн зэрэгцээ Бирмингем, Ливерпуль зэрэг худалдаа, үйлдвэрийн шинэ хотууд үүсэж, хүн ам нь 7 саяд хүрчээ. Британий парламент бүрэлдэхүүнд нь орсон хөрөнгөтний бие төлөөлөгчдийн нөлөөгөөр тэдний эрх ашгийг хамгаалсан шийдвэр гаргаж байв. Виги намын удирдагч Роберт Уолпол 1721-1742 онд Ерөнхий сайд байхдаа хааныг тэргүүлэх байр суурьгүй болгожээ.

XVIII зуунд Британий Америк дахь колониудын оршин суугчид өөрсдөд нь халгаатай дүрэм журам, татварын тогтолцоог тэсвэрлэх аргагүй болж иржээ. Колонийн иргэд татвараа төлж чадахгүй байв. Британий эрх баригчид Америкийн газар нутгийг эзэмших, нутгийн уугуул иргэд индианчуудыг хяналтандаа байлгах үүднээс өөрсдийн эрх ашгийг хангасан хуулиудыг гаргах болжээ. Аппалачийн уулс, Аллеганы нуруунаас баруун тийш шилжин суурьшихыг хориглосон хууль гаргаж, улмаар 1764 онд “Чихрийн хууль”, 1765 онд “Тамганы хууль”-ийг тус тус батлан гаргав. Тамганы хууль нь баримт бичиг, сонин, зарлал, үнэмлэх, аж ахуйн эрх зүй гэх мэт зүйлд татварын албанаас заавал тамга тэмдэг даруулах, төлбөр төлж үйлчлүүлэх тухай заалтууд орсон нь америкчуудын дургуйцлийг төрүүлж, тамгатай цаасыг шатаах, татвар хураагчдыг давирхайгаар будах, тэдний орон гэрийг шатаах зэргээр эсэргүүцлээ илэрхийлэх болов. Улмаар Англичуудыг эсэргүүцсэн нууц бүлгүүд хүртэл байгуулагдах болжээ.



Зураг-3.18

### АНУ байгуулагдав.

1773 оны 12 сард колонийн иргэд Бостоны боомтыг хааж, Ост-Индийн компанийн цайг оруулахыг хориглож далайд хаяжээ. Үүний хариуд Английн засгийн газар цэрэг илгээж, босогчдыг дарж, учруулсан хохирлыг төлүүлэх, оролдлого хийсэн нь босогчдын цар хүрээг улам өргөсгөв. Америкчуудын “Харгис хууль” гэж нэрлэх болсон залхаан цээрлүүлэх хуулийг Англи улс 1774 онд баталсан нь колониудыг тэмцэлд нэгдэхэд хүргэв.

1775 оноос умард Америкт тусгаар тогтнолын дайн эхлэв.

1775 оны 5-р сарын 10-нд Филадельфид 13 колонийн төлөөлөгчид хуралдаж, тивийн армийг командлах, тусгаар тогтнолын дайныг удирдах үүргийг Виржинийн төлөөлөгч Ж.Вашингтонд хүлээлгэв. Түүний хувьд сайн дурын үндсэн дээр бүрэлдсэн, байлдааны туршлагагүй, зэр зэвсэг муутай армийг удирдана гэдэг хүнд байлаа.

1776 оны 7-р сарын 4-нд хуралдсан II хурлаар “Тусгаар тогтнолын тунхаг”-ийн төслийг 13 колонийн төлөөлөгч гарын үсэг зурж баталж, Британий эсрэг шийдвэрлэх тулалдаан эхлэв. Тунхаглалд: “Хүн бүхэн өөрт заяагдсан эрх чөлөөтэй амьдрах, жаргалыг хүсэх, эрхээ эдлэх ёстой” хэмээн зааж, АНУ тусгаар тогтнолоо тунхаглав. Улмаар 1787 онд анхны Үндсэн хуулиа баталж, Бүгд найрамдах засгийг тунхаглажээ. Үндсэн хуулиндаа, хүн бүр заяагдмал тэгш эрхтэй, төр засагт ижил тэгш төлөөлөлтэй байхаар зааж, хүний эрх, эрх чөлөө, иргэний болон улс төрийн эрхийг баталгаажуулж өгсөн юм.



Ерөнхийлөгч Жорж Вашингтон

Жорж Вашингтон 1789 онд анхны Ерөнхийлөгчөөр сонгогдов. Конгресс нь Сенат ба Төлөөлөгчийн Танхимаас бүрдэх болж, Үндсэн хуулийн манаанд зогсох Дээд Шүүхийг байгуулав. АНУ 1776 онд тусгаар тогтонолоо тунхаглан зарлаж, 1783 оноос хүлээн зөвшөөрөгдсөн юм.

“Хүн бүрт тэгш эрх заяагдсан юм. Хүн бүхэн өөрт заяагдсан эрх чөлөөтэй амьдрах, жаргалыг хүсэх эрхээ эдлэх ёстой.

”Тусгаар тогтнолын тунхаг”-аас.

Хүн бүр тэгш эрхээ эдлэх боломжийг Засгийн газар бүрдүүлж өгөх ёстой. Хэрвээ Засгийн газар үүнийг хэрэгжүүлж эс чадвал ард түмэн түүнийг огцруулж, шинэ Засгийн газрыг сонгох эрхтэй.

”Тусгаар тогтнолын тунхаг”-аас.

### АНУ-ын Ерөнхийлөгчид (1789-1909)



№	Ерөнхийлөгчийн нэр	Он цаг	№	Ерөнхийлөгчийн нэр	Он цаг
1.	Жорж Вашингтон	1789-1797	14	Франклин Пирс	1853-1857
2.	Жон Адамс	1797-1801	15	Жэймс Бюкенэн	1857-1861
3.	Томасс Жэфферсон	1801-1809	16	Абрахам Линкольн	1861-1865
4.	Жэймс Мэдисон	1809-1817	17	Эндрью Жонсон	1865-1869
5.	Жэймс Монро	1817-1825	18	Симпсон Грант	1869-1877
6.	Жон Адамс	1825-1829	19	Ратерфорд Берчард Хейс	1877-1881
7.	Эндрью Жэксон	1829-1837	20	Жэймс Абрам Гарфилд	1881
8.	Мартин Ван Бюрен	1837-1841	21	Честер Алан Артур	1881-1885
9.	Уильям Харриссон	1841	22	Гровер Кливленд	1885-1889
10	Жон Тэйлор	1841-1845	23	Бенжамин Харрисон	1889-1893
11	Жэймс Нокс Полк	1845-1849	24	Гровер Кливленд	1893-1897
12	Закари Тэйлор	1849-1850	25	Уильям Мак-Кинли	1897-1901
13	Миллард Филлмор	1850-1853	26	Теодор Рузвельт	1901-1909



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

1. Эх сурвалж, мэдээллээс юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.
2. Өгүүлэн буй үеийн Америкийн оршин суугчдын амьдрал ямар байв? Яагаад тийм байдалд орсон бэ?
3. Америкийн оршин суугчид юуг хүсэж байв?
4. АНУ байгуулагдсаны ач холбогдлыг хамтран ажиллаж тодорхойлоорой.

## Францын хувьсгал



## Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

Хувьсгалын эхлэлтэй холбоотой гол үйл явдлууд аль нь вэ?

Францын хувьсгал хэрхэн эхэлсэн бэ? Хувьсгал яагаад гарах болсон бэ?

**Мэдээлэл-2.** Испани Францын хооронд явагдсан дайны үр дүнд Испани улс их хэмжээний газар нутгаа алдаж, баруун Европт Франц улс зонхилох байр суурьтай болов. 1700 онд II Карлыг нас барсны дараагаар, XIV Людовик хаан ширээ залгамжлав. 1713, 1714 оны дайнуд Франц орныг сүйрүүлэн, нэр нөлөөгөө алдаж, харин Британий нэр хүнд улам өсчээ.

XVII-XVIII зууны үед Францын нийгэм, улс төрийн байдал тогтворгүй болж, санхүүгийн хямрал нүүрлэв. Энэ үеийн Францын хүн ам 3 үндсэн давхаргад хуваагдаж байв. Хөдөөд гар үйлдвэр, гоёл чимэглэл, нэхмэлийн салбар хүчтэй хөгжиж, хөлсний ажилчид бий болов.

Хотод байгаа үйлдвэрүүд нь мануфактурын шинжтэй болж, Францын хотууд нь аажмаар үйлдвэр, худалдаа, соёлын төв болон хувирчээ.

Улс оронд эмх замбараагүй байдал газар авах болов. Хотуудад ажилчид ажил хаях, үйлдвэрийн машиныг эвдэх, эрх баригчиддаа өргөх бичиг барих зэрэг хэлбэрээр тэмцэх болжээ. Тариачид ч мөн энэ хөдөлгөөнтэй нэгдэв.

Энэ бүхний эцэст “Эрх чөлөө, шударга ёс, ахан дүүс” хэмээх уриан дор 1789-1799 онуудад хаант засгийн хуучин дэглэмийг халж, бүгд найрамдах засаг тогтоохын төлөө гуравдугаар давхаргынхан голлосон Францын хувьсгал өрнөсөн байна.

1789 оны 7 сарын 14-нд Парис хотын босогчид Бастилыг эзлэв. Энэхүү өдрийг өнөөг хүртэл Францчууд үндэсний баярын өдөр болгон тэмдэглэдэг. Уг хувьсгалаар нэгдмэл цэгцтэй болгох олон өөрчлөлт хийсний нэг нь “**СИ тогтолцоо**” буюу олон улсын хэмжүүрийн нэгжийн тогтолцоо юм. Жишээ нь, уртын хэмжүүрийн үндсэн нэгж болох метрийг 100 хуваасны нэгтэй тэнцэх нэгжийг сантиметр гэж нэрлэн “см” гэсэн үсгээр товчлон илэрхийлдэг болжээ.

1789 оны 8 сарын 4-нд феодалын бүх эрх мэдлийг хүчингүй болгов. Барааны үнэ хязгааргүй өсч, ажилчид, тариачид, гар урчууд, хотын ядуус дөнгөж амь зуух төдий амьдарч, Францын хувьсгалд аюул тулгарав.

Н.Бонапарт төрийн эргэлт хийж, нэгдүгээр консулын гагцаар захирах дэглэмийг тогтоож, улмаар 1804 онд Францын эзэн хаанд өргөмжлөгдсөн байна.

1793-1806 онд Францад Бүгд найрамдах улсын хуанли үйлчилж байв.

XVI Людовик 1789 оны 5-р сарын 5-нд Ерөнхий штатыг зарлан хуралдуулав. Энэхүү Ерөнхий штатад гуравдугаар давхрааны төлөөлөгчид олон ороод байжээ. Ерөнхий штатад оролцсон төлөөлөгчид үндсэн хуультай болох тал дээр санал нэгдсэн боловч хаант ёс, язгууртнуудын эрх мэдлийн тал дээр санал зөрөлдөж байлаа.

Тариачид хэмжээгүй эрхт хаант засгийг өөрчлөх санал гаргаж, 1789 оны 7 сарын 14-нд Францад үндсэн хуульт хаант засаг тогтов. Францын хувьсгалын гол ололт нь “Хүн ба иргэний эрхийн тунхаглал”-ыг батлан гаргасан явдал юм.

Хүн бүр эрх чөлөөтэй, тэгш эрхтэй төрдөг. Нийгмийн ялгаа нь зөвхөн нийтэд ашигтай байх зарчим дээр үндэслэсэн байх ёстой.

Ямар ч улс төрийн холбооны зорилго нь хүний төрөлх хийгээд халдашгүй эрхийг хамгаалах явдал юм. Ийм эрхийн мөн чанар нь хүн эрх чөлөөтэй байх, өмчтэй байх, аюулгүй байх, дарлал мөлжлөгийг эсэргүүцэх болно.

– Францын “Хүний ба иргэний эрхийн тунхаглал” /1789/-аас



**Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх**

1. График дүрслэлд тулгуурлан XVIII зууны сүүл үеийн Францын нийгмийн зураглалыг гаргаарай.



2. Гол нэр томъёо, ухагдахууныг түүж, товч тайлбарлан бичнэ үү.

ТЭМДЭГЛЭЛ ХИЙХ	ГОЛ САНАА	ҮЗЭЛ САНАА, БИЧЛЭГТ ШҮҮМЖЛЭЛТЭЙ ХАНДАХ
1. Яагаад Францын хувьсгал болсон талаар тайлбарлан бичнэ үү.	1. 3-р давхаргын гишүүд яагаад сэтгэл хангалуун бус байсан бэ?	<b>1. Санааг дэмжих.</b> Францын хувьсгал гарцаагүй үйл явдал байсан гэж бодож байна уу? <b>2. Үзэл санаанд дүн шинжилгээ хийх.</b> 1 ба 2-р давхаргын зарим гишүүд Үндэсний Зөвлөлд нэгдэж, засгийн газрын шинэчлэлд ажиллаж байсан явдлыг хэрхэн үзэж байна вэ? <b>3. Бичлэгийг идэвхжүүлэх.</b> Нэг үгээр тайлбарлавал 3-р давхаргын гишүүдийн үүрэг юу вэ? Францын улс төрийн тогтолцоо яагаад өөрчлөгдөх шаардлагатай вэ?

**Латин Америк дахь тусгаар тогтнолын тэмцэл**

“Францчууд Францыг, англичууд Британийг удирддаг юм бол мексикчүүд Мексикийг удирдаж болохгүй гэж үү”. - Мексикийн хувьсгалч Мигель Идальгогийн хэлсэн үгэнээс

**Мэдээлэл-3.** Америк, Францад гарсан хувьсгалууд Латин Америкийн орнуудад нөлөөлж, 500 мянган боолтой Гайти арал дээр бослого гарав. 1801 онд тус арлынхан боолчлолыг халж, бүх иргэд хуулийн өмнө тэгш эрхтэй байх заалт бүхий үндсэн хуулийг батлав.

1818 онд Мексикт өрнөсөн үндэсний эрх чөлөөний тэмцлийг Мигель Идальго удирдсан юм. Мигель Идальгогийн удирдсан бослого дарагдсан ч эрх чөлөөний төлөө тэмцлийг Хосе Морелос удирдан амжилтанд хүргэжээ. Мексик 1824 онд тусгаар тогтнолоо тунхаглав.



Симон Боливар

Энэ үед колони орнуудад эзэн орноо эсэргүүцсэн тусгаар тогтнолын тэмцлүүд ээлж дараалан гарах болжээ. 1811 онд Венесуэл тусгаар тогтнолоо зарлав. Венесуэлийг чөлөөлөх тэмцлийг цэргийн жанжин Симон Боливар удирдан ихэд алдаршжээ. 1817 онд Испанийн хуучин офицер Сан Мартин Аргентинаас 5000 цэрэгтэйгээр Андын нурууг давж, Чилийн нутагт байсан хааны цэргүүд рүү гэнэт довтлов. Босогчид 1821 онд шинэ Гренадаг чөлөөлөв. Өмнөд ба умардын арми Андын нуруунд хааны цэргүүдийг хоёр талаас нь бүслэн бут цохив. Ийнхүү Латин Америкийн орнууд тусгаар тогтнолоо ээлж дараалан олж авсан юм.



**Үр дүнг нэгтгэх, танилцуулах**

1. Эдгээр хувьсгалуудын онцлох үйл явдлуудыг гаргаж, юуны учир онцолсноо тайлбарлаарай.

Эх сурвалж /үйл ажиллагаа/	Цаг, хугацаа	Хувьсгал гарах болсон шалтгаан	Хүрсэн үр дүн
Мэдээлэл 1			
Мэдээлэл 2			
Мэдээлэл 3			

2. Газрын зурагтай ажиллаж, мэдээллийг боловсруулан:

а). Аль орныг ямар улсууд колончилж байсныг тодорхойлоорой.

б). Өмнөд Америкийн газрын зурагт ямар өөрчлөлт орсныг өмнөх зурагтай харьцуулан гаргаарай.

3. АНУ байгуулагдсанаар хойд Америкийн газрын зурагт ямар өөрчлөлт орсон бэ?



Зураг-3.19



**Өөрийгөө үнэлээрэй**

1. Түлхүүр үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлаарай.

- Боолчлол
- Эрх чөлөө
- Хувьсгал
- Тусгаар тогтнол

2. Хувьсгалууд улс төр, оюун санааны амьдралд хэрхэн нөлөөлснийг тайлбарлаарай.

3. Хувьсгалын удирдагчид, түүхэн зүтгэлтнүүдийн талаар мэдээлэл цуглуулж бусдадаа танилцуулаарай.

4. Дээрх хувьсгалуудын үр дүнд баталгаажсан хүний эрхийн асуудал одоогийн манай улсын үндсэн хуулинд туссан байна уу, харьцуулан судлаарай.

### Оросын эзэнт гүрэн хүчирхэгжив



Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

Өрнө дахинд өрнөсөн хувьсгалууд, шинэтгэл, үйлдвэржилт, өөрчлөлтийн нөлөөгөөр орос гүрэн ч хүчирхэгжин тэлэв. I Петр хаан нийгмийн бүхий л хүрээг хамарсан шинэчлэл хийжээ. 1708 онд улс орноо губерн, муж, уездийн зохион байгуулалтад оруулав. 1711 онд Сенат байгуулж хэмжээгүй эрхт хаант засаглалыг бэхжүүлэх арга хэмжээ авчээ.

1721 онд I Петр өөрийгөө эзэн хаанаар өргөмжлөв. Түүний цагаан толгойн болон хуанлийн шинэтгэл түүхэнд алдартай. Тэрээр колончлолын бодлогоо Азов, Хар далай, Балтын тэнгис, Сибир рүү чиглүүлснээр үйлдвэрлэлээ өсгөх, эзэнт гүрнээ тэлэх боломж нээгджээ. 1722 онд баталсан хуулиар цэргийн болон иргэний бүх албан тушаалтныг 14 зэрэг дэвд хувааж, эрх үүргийг нь тодорхойлсон байна.

Орост үйлдвэр сул хөгжсөн тул Баруун Европоос хараат байдалтай байв. I Петр аж үйлдвэрийн хөгжилд анхааран тусалж, хөнгөлөлт олгодог болов. Ялангуяа гадаадаас оруулах зүйлүүдийг дотооддоо боловсруулахад их анхаарав.

Балтийн тэнгист боомттой болж, зам харилцааг сайжруулан худалдааны яармагууд ажиллуулав. Түүний үед мануфактурын тоо 100 илүүд хүрч, төмөрлөгийн үйлдвэрлэл хөгжиж, Урал, Петербург зэрэг үйлдвэрийн томоохон төвүүд бий болов. XVIII зуунд гарсан тэдгээр өөрчлөлтүүдийн үр дүнд Орос улс хүчирхэг гүрэн болж чаджээ. Орос, Австритай хамтран 1735-1739 онд Турктэй дайтав. 1759 онд Оросын арми Пруссийн армийг бут цохиж, Польшид нөлөөгөө тогтоов. Хатан хаан II Екатерина 1780 онд зэвсэгт төвийг сахих холбоо байгуулсан нь Америк дахь колонийн дайнд Англи ялагдахад нөлөө үзүүлжээ.





**Оросын эзэнт гүрний их хаад**

№	Эзэн хаад	Хаанчилсан он	№	Эзэн хаад	Хаанчилсан он
1	Петр I Алексеевич	1682-1725. 1721 оноос Эзэн хаан	8	Екатерина II Алексеевна	1762-1796
2	Екатерина I Алексеевна	1725-1727	9	Павел I Петрович	1796-1801
3	Петр II Алексеевич	1727-1730	10	Александр I Павлович	1801-1825
4	Анна I Иоанновна	1730-1740	11	Николай I Павлович	1825-1855
5	Иван VI Антонович	1740-1741	12	Александр II Николаевич	1855-1881
6	Елизавета Петровна	1741-1762	13	Александр III Александрович	1881-1894
7	Петр III Фёдорович	1761 -1762	14	Николай II Александрович	1894-1917



**Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх**

1. Гол нэр томъёо, ухагдахууныг түүж, 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичнэ үү.

ЭРЭХ, ТЭМДЭГЛЭХ, ХАРЬЦУУЛАХ	ТОДРУУЛАХ	ҮЗЭЛ САНАА, БИЧЛЭГТ ШҮҮМЖЛЭЛТЭЙ ХАНДАХ
1. I Петр хаан Оросыг хаанчилж байхдаа Оросын газар нутгийг тэлсэн. Тэрээр ямар ямар голын сав нутгийг өөрийн эзэмшилд оруулсан бэ?	3. Оросын ирээдүй шинэ усан боомтуудаас хамаарна гэдэгт I Петр яагаад тийм итгэлтэй байв?	5. Дүгнэлт гаргах. Оросын нийгмийн аль хэсэг нь I Петрийн шинэчлэлээс үр ашиг хүртэж чадаагүй вэ? Яагаад?
2. III Иван Оросын газар нутгийг их хэмжээгээр тэлсэн. Тэрээр 1462-1505 онуудад Оросыг захирч байсан билээ. I Петр, III Иван аль нь агуу вэ?	4. I Петр Оросыг баруунжуулах ямар ямар бодлогууд явуулж байсан бэ?	6. Таамаглал. I Петрийн өрнөджүүлэх бодлого Баруун Европын христийн шашинтай ард иргэдийнх нь үзэл санаанд хэрхэн нөлөөлж байсан бол?
		7. Бичих, үзэл бодлоо илэрхийлэх. I Петрийн агуу үйл хэргийг тайлбарлах, түүнийг Оросын агуу дарангуйлагч гэдэгтэй санал нийлж байна уу?

2. I Петр хааны шинэчлэлт нь Орос улсыг эрс өөрчилсний шалтгаан юунд байв? Түүнийг яагаад “Европт гарах цонхыг нээсэн” гэж үздэг вэ? Өөрийгөө соригорой.



**Үр дүнг нэгтгэх, танилцуулах**

1. Их гүрнүүд хүчирхэгжин мандсан түүхийг нэгтгэн дүгнээрэй.

Ай	АНУ	Франц	Англи	Орос
Он тоолол				
Газар зүйн байршил				
Түүхэн зүтгэлтэн				
Гол үйл явдал				
Түүхэн сургамж				



#### 4. НАПОЛЕОН БОНАПАРТ БА ФРАНЦЫН ЭЗЭНТ ГҮРЭН

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
<ul style="list-style-type: none"> <li>• Наполеон Бонапарт түүхэнд нэрээ үлдээсэн алдартай зүтгэлтэн байв.</li> <li>• Түүний явуулсан бодлого, Европт өрнөсөн дайны үр дагавар их юм.</li> </ul>	<p>Дэлхийн түүхийн шинэ үед өрнө дахинд өрнөсөн онцлог түүхэн үйл явдлыг эх сурвалж ашиглан судлах, тайлбарлах, үнэлэлт дүгнэлт өгөх, түүхэн зүтгэлтнүүдийг судлах, танин мэдэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Наполеон Бонапарт</li> <li>• Зөрчил тэмцэл</li> <li>• Эвслийн дайн</li> <li>• Наполеоны хууль</li> </ul>



#### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх



**Наполеон Бонапарт (1769-1821)**

1769 оны 8 сарын 15-нд Францын эзэмшилд байсан Корсик арал дахь Аяччо хотод сурвалжит гэр бүлд мэндэлжээ. 1779 онд вангийн тэтгэлгээр Бриенний цэргийн сургуульд элсэн оржээ. Тэнд 5-н жил суралцаад дараа нь Парисын Цэргийн сургуульд шилжин суралцаж, 1785 онд төгсжээ. Наполеон цэргийн албаа артиллерийн дэслэгч цолтойгоор эхэлсэн байна. Тэрээр Италийн ойролцоо байдаг “Элба” болон “Гэгээн Елена”-ийн арал руу цөлөгдөж байв. 1821 онд нас баржээ. Түүний үхлийн шалтгааныг янз бүрээр тайлбарладаг. Дэлхий дахинд Наполеоны тухай өгүүлэх олон кино, зохиол бүтээл байдаг нь түүний хэр алдартай болохыг илтгэнэ.

*Мэдээлэл болон газрын зургийг шинжлэн судалж, түүхийн асуулт зохиогоорой. Газрын зураг юу илэрхийлж буй талаар асуудал, таамаглал дэвшүүлж, түүнийгээ батлах, няцаах эрэл хайгуул хийж ажиллаарай.*

XVII зууны төгсгөлд Францын хөрөнгөтнүүд их баяжиж, усан флотын офицерууд, дамын наймаачид хөлжиж, язгууртан баячуудын дунд эмх замбараагүй байдал ихэд дэлгэрчээ. Бараа, бүтээгдэхүүний үнэ хягзааргүй өсч, ажилчид, тариачид, гар урчууд, хотын ядуус гол зогоох төдий байв. Тэр барьж байсан Директорын нэр хүнд унаж, түүний эсрэг уур амьсгал Францад бий болов.



**Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах**

**Дараах мэдээллийг ашиглан дэвшүүлсэн асуулт, таамаглалаа нотолцгооё**

**Мэдээлэл-1.** Наполеон Бонапарт Францын хувьсгалын үеэр Якобинчуудын клубын гишүүн байв. 1793 онд Тулон хотыг Британи, Испаний цэргийн хүчнээс чөлөөлөхөд Наполеоны байгуулсан гавьяаг Конвент өндөр үнэлсэн байна.

Ард түмний уур хилэн дээд цэгтээ хүрч Конвентын эсрэг босоцгооход Наполеон дахин тодрон гарч, зэвсэг барьсан 40000 босогчдыг их бууны галаар нухчин дарав. Ийнхүү хоёр дахь удаа Конвент түүнийг өндөр үнэлж бригадын генерал цолоор шагнав.

(XVI-XIX зууны Европын түүх. УБ., 2000, т. 216)

**Мэдээлэл-2.** Наполеон Бонапарт 1799 оны 11 сард төрийн эргэлт хийж, нэгдүгээр консулыг ганцаар захирах дэглэмийг тогтоов. Францын I эзэнт гүрнийг захирч, 1804 онд эзэн хаанаар өргөмжлөгдөв. Ийнхүү Францын Бүгд Найрамдах Улс Францын эзэнт гүрэн болон хувирч, эзэн хаан Наполеон Бонапартын ордон өөрийн баян тансаг байдлаараа Европын бүх хаадын ордноос даван гарчээ.

Наполеон хувьсгалаар байлдан олсон ардчиллын бүх ололтыг устгав. Тэрбээр тайж, язгууртны зэрэг дэвийг дахин сэргээв. Наполеон өөрийн генерал, маршалуудыг эрхэм цолоор шагнаж ван, герцог, гүн, барон цолыг хүртээжээ. Наполеон өөрийн засгийг хууль зүйн хувьд бэхжүүлэхийн тулд шинэ “Үндсэн хууль”-ийг батлав. Францын эзэнт гүрэн шинэ үндсэн хуультай улс болсон боловч үнэн хэрэгтээ засгийн бүх эрх түүний гарт төвлөрч байв. 1804, 1808, 1811 онуудад Иргэний ба гэр бүлийн, Худалдааны, Эрүүгийн хуулиуд гарсныг түүхэнд “Наполеоны хуулиуд” (кодекс) гэж нэрлэдэг.


**Мэдээлэл-3.** Франц улс Наполеоны эзлэн авсан газар нутгууд дээр хэд хэдэн улсуудыг эмхлэн байгуулав. Тухайлбал, Нидерланд Батавын Улс, Умард Италид Цзальп болон Лагурийн улсуудыг тус тус үүсгэн байгуулжээ. Ийнхүү Францын эзлэн түрэмгийлэл Өрнө дахины хаант улсуудад аюул учруулсан тул бусад өрнийн улсууд холбоо байгуулан, эвслийн нэгдсэн аян дайныг удаа дараалан хийжээ.

**Мэдээлэл-4.** 20 гаруй жил үргэлжилсэн эцэс төгсгөлгүй дайнууд 1811 онд Францын эдийн засгийг хямралд оруулав. Язгууртнууд өөрийн эд баялагаа чөлөөтэй ашиглах боломжгүйдээ дургүйцэж, тариачид Наполеоноос нүүр буруулах болжээ. 1813 оны 10 сард Лейпцигийн дэргэдэх тулалдаанаар Наполеоны Европ дахь ноёрхол нуран унав. Орос, Австри, Прусс, Швед дараалан ялалт байгуулжээ. Эцэст нь 1815 оны онд болсон Ватерлоогийн дэргэдэх тулалдаанаар нэг мөсөн ялагджээ.



**Асуулт, даалгавар гүйцэтгэх**

Он тооллын шулуунд тэмдэглэсэн түүхэн үйл явдлууд хэддүгээр зууны, хэддүгээр хагаст болсныг тооцоолж гаргаарай.




**Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх**

МЭДЭЭЛЭЛ	ГОЛ АГУУЛГА	ҮНЭ ЦЭН, АЧ ХОЛБОГДОЛ
Зураг-3.21		
Мэдээлэл 1		
Мэдээлэл 2		
Мэдээлэл 3		
Мэдээлэл 4		
Нэгтгэн дүгнэх нь:		



**Үр дүнг нэгтгэх, танилцуулах**

1. Наполеон Бонапартын Францын эзэнт гүрний хөгжилд оруулсан хувь нэмрийг тодорхойлон ярилцаарай.
2. [www.opb.mn](http://www.opb.mn) цахим хуудасны Дэлхийн түүхийн хэсгээс “Наполеон Бонапарт”-ын тухай богино хэмжээний киног үзэж бусдадаа танилцууларай.



**6. XVIII-XX зууны ЭХЭН ҮЕИЙН ДОРНО ДАХИН**

ГОЛ САНАА ЮУ ЮУ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
XVIII-XX зууны эхэн үед дорно дахины улс орнууд түүхэн хөгжлийн өвөрмөц үеийг туулсан	XVIII-XX зууны эхэн үеийн дорно дахин бол тухайн үеийн өрнийн их гүрнүүдтэй зэрэгцэн оршиж уламжлал шинэчлэлийг хослуулан өөрийн өвөрмөц онцлогтойгоор хөгжиж байсан түүхтэй.	<ul style="list-style-type: none"> <li>• Дайчин улс</li> <li>• Тайпины бослого</li> <li>• Токугавагийн Япон</li> <li>• Их Моголын уналт</li> <li>• Османы уналт</li> </ul>



**Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах**



XVII-XX зууны эхэн үед дорно дахинд хүчирхэг **Дай Чин гүрэн** (1644 -1911) оршин тогтнож байлаа. Газар нутаг уудам, ашигт малтмал их, хүн ам олонтой том гүрэн байв. Гэвч хамжлагын харилцаа ноёрхсон, тархай бутархай аж ахуйтай, эдийн засагт нь худалдаа, мөнгө хүүлэл хүчтэй ноёрхсон, дотоод зөрчил гүнзгийрсэн, Европоос хоцрогдсон орон байлаа. Чин улс нь монгол, хятад, төвөд, хотон, манж зэрэг таван угсаатныг нэгтгэсэн, 14.7 сая км<sup>2</sup> газар нутагтай их гүрэн байлаа. Хамгийн сүүлд Тайванийг өөртөө нэгтгэсэн боловч XIX зууны төгсгөлд Японтой хийсэн дайнд ялагдаж, тэдний мэдэлд шилжүүлсэн байна. Үүнээс гадна Чусонь, Вьетнам зэрэг орон Чин улсад алба барьж хараат оршиж байв.

XX зууны эхэн гэхэд Манжуур, Шинжааныг задалж, дотор газрын 18 мужаа 22 болгоожээ. Чин улсын бүрэлдэхүүнд Тэнгэр уулын ар, өвөр, Хами зэрэг алс баруун хязгаар нутаг, Ар Монгол (Халх, Ховд, Хөвсгөл, Урианхайн хязгаар), Өвөр Монголын 6 чуулган (Жирэм, Зост, Зуу үд, Шилийн гол, Улаанцав, Их зуу), бусад монгол газар (Алшаа, Эзнээ, Или, Хөхнуур, Дарьганга, Түмэд, Цахар, Хөлөнбуйр), Төвөд, Манжуур багтаж байв.

Дотоодын зах зээл нь тэлснээс гадна XVII зууны сүүл үеэс эхлэн гадаад худалдаа хурдтай сэргэж, XVIII зууны сүүлийн хагас гэхэд жилд 4%-иар өсөж байв. цай, торго Хятадын экспортын гол бүтээгдэхүүн байлаа.

Үр тарианы үнийн хяналтын систем нэвтрүүлж, тариа будааны хомсдолыг арилгах арга хэмжээ авч байсан боловч цагаан будааны үнэ XVIII зууны турш зугуухан өссөөр байсан нь хүн ардын аж амьдралыг хүндрүүлж байлаа.

Хэд хэдэн хүчин зүйлийн улмаас хүн ам нь ихээхэн өссөн байна. Мин улсын үед хүн амын тоо нь 150 саяас 430 саяд хүрч өсжээ.

**Тайлбар:** Дай Чин улс - 1636 онд Өмнөд Монголыг, 1644 онд Мин улсыг нэгтгэсний дараа Абахайг их хаанд өргөмжилж, улсын нэрээ хожуу Алтан улс байсныг Дай Чин (их ариун) улс болгожээ.



### Үйлийг төлөөлөх, мэдээлэл цуглуулах

1843 онд тосгоны багш Хун Сю Цюань Христос болон эртний Хятадын Күнзийн сургаалийг хослуулан улс төр, шашны үзэл боловсруулж, уг үзлээ баримталсан “Тэнгэрийн эцэг нийгэмлэг”-ийг байгуулжээ. Хун Сю Цюань 1851 оны 1 сарын 1-нд тариачны улс болох “Тайпинь Тянь Го” байгуулагдсаныг зарлав. Өөрөө улсын ван болж, тариачдын зэвсэгт бослогыг анх зохион байгуулж, хожим нь арми болгон өөрчилсөн Янь Сю Цинийг засгийн газрын тэргүүн болгов. 1852 онд Тайпинчуудын арми Гуаньси мужийг бүхэлд нь, 1853 онд Нанжиныг эзлэн Тайпинь Тянь Го улсын нийслэл болгож, тариачдын олон зуун жилийн мөрөөдөл болсон газрын тухай хуулийг баталжээ. Гэвч 1864 онд Чин улсын засгийн газар Тайпинчуудын бослогыг дарсан юм.

1898-1901 онд Чин улсад Ихэтуаний бослого гарсан нь ихэвчлэн гадаадынхны эсрэг чиглэж байв.

“... хүндрэл, маргаан үүсвэл сыма хэмээх хүйн ахлагчид хандаж, хэн нь зөв бурууг сонсож ... ургац хураалт явагдаж байгаа үед сыма хүйн ахлагч нарыг удирдан улсын санд улаан буудай, мөөг, түүхий олс, хөвөн зэргийг тушааж дараа жилийн ургац хүртэл 25 өрх бүлүүдийн хүнсний хэрэгцээг хангана.....Нэг орон нутагт ургац алдвал тусламж үзүүлнэ. Хэрэв газар байвал хамтран боловсруулж, хоолыг хамтран боловсруулж, хоолыг хамтран хэрэглэж, татварыг хамтран төлж, мөнгийг хамтран зарцуулна. Газар сайгүй эрх тэгш байна”. (“Газрын тухай хууль” буюу Тайпины улсын үндсэн хуулиас)

Манай алдар сууг өргөцгөөе. Та хэнтэй нэгэн дээвэр доор амьдарч чадахгүй гэдгээ тунхаглацгаая. Өөрийн төр улсдаа хүндэтгэлтэй хандацгаа. Тэд (манж нар) манай ард түмнийг яаж өлсөж, үхэж, оргож зугтаж, гэр орноо орхиж яс арьс болж байгааг тайван ажиглаж байна. Манж нар хятад хүмүүсийн өөрийн авьяас чадварыг шавхан дуусгахыг эрмэлзэж байгаа юм. Түшмэдүүд бэлэг сэлт барьж, ял шийтгэлээс мөнгөөр чөлөөлөгдөж, баячууд улам баяжиж, алдартай хүмүүс бүхий л найдвараа алдаж байна. Шударга ёсыг нэр төрөө болгосон хүмүүс хятад орноо хүчирхэг болгох, шинэ шинэ самууныг өдөөж, хүмүүсийг гэр бүлээр нь, төрөл садангаар нь хөнөөж буй манж нарын эсрэг тэмцэхийг уриалж байна. (Тайпинчуудын ятгах хуудаснаас)



### Асуулт, даалгавар гүйцэтгэх

1. Зураг-3.22-т тулгуурлан Чин гүрний газар нутгийн хилийг тодорхойлоорой.
2. Тайпинчуудын ятгах хуудасны үндсэн агуулга юу байв?
3. Тайпины бослого Манж Чин улсын нутаг дэвсгэрийн аль хэсэгт өрнөсөн бэ? Зураг-3.22-ыг ашиглаарай.
4. Манж Чин улс сулран доройтсон нь ямар шалтгаантай болохыг харилцан ярилцаж тодорхойлоорой.



### Унших, ойлгох, эрж хайх

**Япон улс. Улс төрийн байдал:** Японы Токугавагийн засаглалын үед Минамото, Ашикага, Токугава зэрэг овог аймгууд цэрэг язгууртнуудын засаг захиргаа-бакүфүгийн хэлбэрээр төр барьж байв. Улс төр, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдал нь газар зүйн тусгаарлагдмал байдал, 1853 он хүртэл цэрэг-улс төрийн эрчимтэй дарамт шахалт амсаагүйтэй холбоотой.

XVIII зууны сүүлчээр Японы эдийн засаг тогтонги байдалд оржээ. Тиймээс XIX зууны 60-аад оны эхэн хүртэл Токугавагийн угсааныхантай хэн ч байр суурь булаацалдахгүй байв.

**Эдийн засгийн байдал:** XVIII зууны үед Японы хүн амын нягтшил нэмэгдэж, хөдөө аж ахуйд өсөлт гарч, үндэсний нэгдсэн зах зээл бүрэлдэж, бүс нутгууд бүтээгдэхүүнийг дагнан үйлдвэрлэх болов.

XVIII зууны сүүлчийн хагасаас аж үйлдвэрлэл, худалдаа хөдөө тосгонд төвлөрч эхэлжээ. Таваар-мөнгөний харилцаа, уламжлалт үйлдвэрлэл өргөжин хөгжиж, соёл-аж ахуйн хэвшил бүрэлдсэнээр XIX зууны үед Япон аж үйлдвэржихэд бэлэн болжээ.

**Шинэчлэлийн хэрэгжилт:** XIX зууны II хагаст барууны гүрнүүдийн шахалтын улмаас Японд улс төрийн зөрчил ихээхэн хурцадсан байна. 1841 онд Нидерландын хаан Японд улс орноо нээхийг зөвлөн сэрэмжлүүлж, 1846 онд Их

Британи, Францын усан онгоц Рюүкюү (одоогийн Окинава арлууд)-гийн эрэгт ирэв. 1853 онд Америк цэргийн сүр хүч үзүүлж, командлагч Перри улс орноо нээхийг шаардав.

1868 оны 1-р сард Эзэн хааны шууд эрх мэдлийг тогтоосон, шинэ засгийн газар байгуулах зарлиг баталсан. Энэ үйл явдлыг “Мэйжийн шинэчлэл” хэмээн нэрлэдэг. Япон орон улс төр, эдийн засгийн асар том өөрчлөлтийн замд оржээ.

Бакуфуг устгасны дараа Японы шинэ удирдлагын өмнө яаралтай шийдвэрлэх олон хурцадмал асуудал тулгарав. Тухайлбал, гадаад харилцааг зохицуулах, төрийн шинэ аппарат бүрдүүлэх, улс орныг нэгтгэх асуудал тавигджээ. Эзэн хаан, 1889 онд үндсэн хууль баталж, 1890 онд парламентыг зарлан хуралдуулах амлалт өгсөн байна.

1881 оноос засгийн газар үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд таатай нөхцөл бүрдүүлэх үүрэг хүлээж, орчин үеийн банкны систем бий болгожээ. 1882 онд Японы Төв банк байгуулагдав.

Үйлдвэрлэл эрхлэх санаачилга хувь хүмүүсийн гарт төвлөрөх болжээ. 1880-аад оны үеэс үйлдвэрлэлийн төвлөрлийн үйл явц эхэлсэн.



1871 онд феодал самурайн харилцаанд тулгуурласан Японы засаг захиргааны овог хошууны тогтолцоог халж, орчин үеийн муж сумын бүтцээр сольсон өөрчлөлтийн үйл явцыг хошуудыг халж, мужийг тохинуулах хэмээн нэрлэдэг. Японд ноёлж байсан хоёр зуун далан даймёо ноёд нэг шөнийн дотор байхгүй болсон үйл явдал. Язгууртан анги, самурай нар л даа-энэ давхаргынхны хүн ам нэг сая есөн зуун мянган хүн, тэр үеийн Японы хүн амыг гучин сая гээд бодохоор 6.3 хувь нь болж байна. Энэ хүмүүс нэгэн зэрэг ажилгүй болцгоожээ. Мэйжигийн шинэчлэл нь язгууртнуудын өдүүлсэн хувьсгал байлаа. Олон самурай амь эрсэджээ.

(Шива Рёотари. Мэйжи хэмээх төр улс. УБ., 2000)

1. Японы эзэнт улс нь үеэс үед эзэн хааны тасралтгүй угсаа залгамжлалд захирагдана. 2. Эзэн хаан бол халдашгүй дархан бие хүн мөн 3. Эзэн хаан бол төрийн тэргүүн, дээд захирагч, тэрээр энэхүү үндсэн хуулийг тогтоосны дагуу дээд засаглалыг хэрэгжүүнэ. 4. Эзэн хаан эзэнт улсын парламенттай зөвшилцсөнөөр хууль тогтоох засаглалыг хэрэгжүүлнэ. 5. Эзэн хаан хуулиудыг батлаж, тэдгээрийг тунхаглах, гүйцэтгэх тушаал гаргана. 6. Эзэн хаан эзэнт улсын парламентыг хуралдуулж, түүнийг нээх, хаах, түүний хуралдааныг хугацаанаас өмнө зогсоох, депутатуудын танхимыг тараах эрхтэй. 7. эзэнт улсын парламент пэрүүдийн болон депутатуудын тухай гэсэн хоёр танхимаас бүрдэнэ. 8. Пэрүүдийн танхим нь эзэн хаанаас томилсон хааны бүл, тайж, жирийн иргэдээс бүрэлдэнэ. 9. Депутатуудын танхим нь сонгуулийн хуулийн дагуу ард түмнээс сонгогдсон гишүүдээс бүрэлдэнэ.

(Японы эзэнт улсын үндсэн хуулиас)

### Японы хаадын үе залгамжлал (XIV зуунаас одоо хүртэл)



Японы түүхийн үеүд	Үргэлжилсэн хугацаа	Хаадын нэр:
Муромачи	1333-1573	Го-Мураками эхэлж, Огимачи хүртэл 10 хаан
Момояма	1573-1603	Огимачи, Го-Ёэй
Эдо	1603-1868	Го-Ёэйгээс эхэлж, Мэйжи хүртэл 16 хаан
Японы эзэнт улсын үе	1868-1945	Мэйжи, Тайшо, Шова
Дайны дараах Япон улс	1945- 2019.4.30	Шова, Акихито
Рэйвагийн эрин	2019.5.1	Нарухито



### Асуулт, даалгавар гүйцэтгэх

1. 1889 оны 2 дугаар сарын 11-нд батлагдсан Японы эзэнт улсын үндсэн хуулийн 76 зүйлээс 46-г нь 1850 оны Пруссийн үндсэн хуулиас хуулбарлан авсан ажээ. Үүний учир юунд байна вэ? Боловсролтой холбоотой юу?
2. Японы улс төрийн нэгдмэл байдал нь эдийн засгийн өөрчлөлтөд хэрхэн нөлөөлсөн бэ?
3. Шинэчлэл амжилттай хэрэгжсэний үр дүн юу байв?
4. Хошуудыг халж мужийг байгуулсны учир шалтгаан юу байсан бэ?
5. Японы эзэнт улсын үндсэн хуульд эзэн хааны эрх мэдлийг хэрхэн тогтоосныг баримтад тулгуурлан харилцан ярилцаарай.



### Унших, ойлгох, эрж хайх

**Моголын эзэнт улсын уналт.** 1719-1748 онд төр барьсан Мухаммед – шахын үед Энэтхэг дэх Моголын эзэнт улс задрахад хүрэв. Эзэнт улсын янз бүрийн мужуудад орон нутгийн эрх баригчид ба сурвалжтан – заминдарууд (Моголын хожуу үед газар тариалангийн дээд давхаргын төлөөлөгчдийг заримдаа ийнхүү нэрлэж байжээ), тусгай төрөл, омог, кастын тэргүүн нарын байр суурь хүчирхэгжив. XVIII зууны эхэн үед заминдарууд удирдаж буй газар нутгаас олох орлогоо дээд зэргээр өсгөх, улс төрийн бие даасан байдалд тэмүүлж, Моголтой илт дайсагналцах болов. Иймд Моголын эсрэг олон тооны бослого тэмцэл гарсан.

Персийн Надир шах (1736-1747) 1739 онд Делиг эзлэн дээрэмдээд олз баялгаа аван, Моголын эзэнт улсыг сүйрлийн ирмэгт орхин оджээ. Сангаа дээрэмдүүлсэн Моголын хаан олон тооны цэргүүдээ тэжээх аргагүй болж, салан тусгаарлах хөдөлгөөнийг зогсоох чадваргүй болжээ.

Афганы морин цэргийн командлагч Ахмад шах (1747-1773) 1748 онд Энэтхэг рүү дээрмийн дайн эхлүүлэв. 1752 онд гуравдахь удаагаа довтлон, Кашмир, Сирхинд хүртэлх Дорнод Пенджабыг эзэлж, Моголын шах хүлээн зөвшөөрсөн байна. Моголын эзэнт улс задарч, түүний хэлтэрхий дээр бие даасан, сул дорой улсууд байгуулагдсан нь Европын худалдааны компаниудад байр сууриа бэхжүүлэх боломж олгожээ.



Европчуудын Энэтхэгт нэвтрэх гол суваг нь XVII зууны үеэс үйл ажиллагаагаа эхлүүлсэн Ост-Индийн худалдааны компани байв. Экспортын гол бүтээгдэхүүн даавуунаас гадна Энэтхэгээс элсэн чихэр, хар тамхи, индиго зэрэг газар тариалангийн бүтээгдэхүүн, мөн догшин шүү авчирч байсан.

Томоохон гар урлалын сууринд хэдэн мянган ээрмэлчид, нэхмэлчид компанийн захиалгыг гүйцэтгэж байжээ. Тус компани өргөн уудам газар нутгийг хамарсан, Энэтхэг дэх цэрэг-улс төрийн хамгийн хүчирхэг хүчин болон хувирчээ. Тэдний цөлмөн хуримтлуулсан хөрөнгө анхны хуримтлалын нэг эх булаг болж, эцэстээ Английн аж үйлдвэрийн хувьсгалыг түргэтгэхэд нөлөөлжээ. Гэвч Моголын эзэнт улс 1858 он хүртэл нэр төдий оршин тогтножээ.



### Унших, ойлгох, эрж хайх

**Османы (Оттоманы) эзэнт улсын уналт.** XVIII зуунд Османы эзэнт улс уналтад оров. Османы цэргийн болон төрийн удирдлагын хүч буурч, мужуудад салан тусгаарлах хандлага хүчтэй болов. Хотын гар урлал тодорхой дэвшилд хүрсэн хэдий ч тоо, чанарын үзүүлэлтээр (технологийн түвшин, хөдөлмөр зохион байгуулалтын хэлбэрийн хувьд) Европын аж үйлдвэрээс хол хоцорсон байв.

Турк-османчууд торго, халуун ногоо борлуулах монополио алдаж, тэдний эзэмшлийг Европын орнуудад нийлүүлэх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний (торгоны түүхий эд, ноос, үр тариа) гол эх булаг болгов.

II Махмуд султаны шинэчлэл Османы эзэнт улсыг европжуулах, түүний эдийн засаг, соёлын дэвшлийг хангах чухал үе шат болсон юм.

XIX зууны 30-40-оны үед эхэлсэн шинэчлэлийг түүхэнд “Танзимат” хэмээн нэрлэдэг. Уг шинэчлэл эдийн засгийн амьдралыг өөрчилж, өмчийн эрхийг хамгаалах талаар амжилтад хүрсэн. Шинэчлэл боловсрол гэгээрлийн салбарт ч нэвтрэв. Гэвч тэдгээр нь асар том, олон үндэстний улсын хөгжлийн шаардлагад тэр бүр нийцэж чадаагүй юм.

**Эдийн засгийн байдал:** Крымын дайн (1853-1856 он)-аар Османы эзэнт улс бараг бүх армиа алдан, эдийн засгийн асар их хохирол амсаж, хямралд автжээ. Эрх баригчид эдийн засгийн, түүний дотор татвар хураах үед албан тушаалаа урвуулан ашиглахыг устгахад чиглэсэн шинэтгэл хэрэгжүүлэхээ зарлав. Урьдын хүчирхэг эзэнт гүрэн XIX зууны дунд үе гэхэд эдийн засгийн хувьд хоцрогдмол, хөдөө аж ахуйн орон болжээ. XIX зууны 60-70-аад оны үед Османы эзэнт улсын эдийн засагт гадаадын капитал ихээхэн нэвтрэх болсон байна.

**Улс төрийн байдал:** 1876 оны үндсэн хуулинд бие хүний болон өмчийн халдашгүй байдал, хэвлэн нийтлэх эрх чөлөөг тунхаглан, парламентын тогтолцоог нэвтрүүлсэн. Мөн улсын бүх албатуудын эрх чөлөө, шашин шүтлэгээс үл хамааран хуулийн өмнө бүгд тэгш эрхтэйг баталгаажуулсан. Гэвч 1878-1908 онд бурангуй үе үргэлжилж, Абдул Хамидийн засаглалын эхний 10 жилд сөрөг хүчний үзэл бодлыг бүрэн нухчин дарав. Гэлээ ч боловсролтой сэхээтнүүд хөрөнгөтний либерал-үндсэн хуульт үзэл санааг хадгалсаар, Османы эрин үеийн төгсгөл ойртсоор байлаа.



### Асуулт, даалгавар гүйцэтгэх

1. Моголын эзэнт улс задрахад нөлөөлсөн гол хүчин зүйл юу байсан бэ?
2. Османы эзэнт улс яагаад Европт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нийлүүлэх болсон бэ?
3. Османы эзэнт улсын эдийн засгийн хямрал нь улс төрийн шинэчлэлд хэрхэн нөлөөлөв?
4. Хүснэгтийн дагуу даалгаврыг гүйцэтгээрэй.

Ай	Манж Чин	Япон	Энэтхэг	Османы эзэнт улс
Он тоолол				
Газар зүйн байршил				
Түүхэн зүтгэлтэн				
Гол үйл явдал				
Түүхэн сургамж				

**Үр дүнг ярилцъя. Бид ямар асуудлыг шийдвэрлэсэн бэ?**

Дорно дахины улсуудын хоцрогдлын шалтгаан юунд байсан бэ?	Дорно дахины улсуудтай хүчирхэг улс орнууд хэрхэн харилцсан бэ?	Дорно дахины улсуудад шинэчлэл хэрхэн хэрэгжсэн бэ?	Шинэчлэлийн үр дүн юу вэ?
Дорно дахины улсуудын улс төр, эдийн засгийн байдал хийгээд бутралын дотоод, гадаад шалтгааныг харьцуулаарай.	..... ..... ..... .....	..... ..... ..... .....	Дүгнэн ярилцаарай.



**Өөрийгөө үнэлээрэй**

1. Өгүүлбэрийг ач холбогдлоор нь зөв дараалуулж, ярилцана уу.
  - илт давуу байснаас болжээ. цэргийн зохион байгуулалт, Энэтхэгийн улсуудын зэвсэгт хүчнээс Английн байлдан дагуулал нь
  - Английн эсрэг бат бэх холбоо байгуулагдах боломжийг хаасан. Энэтхэгийн улсуудын зөрчлийг чадварлаг ашиглан,



**Чин улсын хаадын үе залгамжлал**

№	Оны цол		Он	№	Оны цол		Он
	монголоор	хятадаар			монголоор	хятадаар	
1.	Тэнгэрийн бошогт	Тянь Мин	1616-1626	8.	Сайшаалт ерөөлт	Ця Цин	1796-1820
2.	Тэнгэрийн сэцэн	Тянь Цүн	1627-1636-	9.	Төр гэрэлт	Дао Гүан	1821-1850
3.	Дээд эрдэмт	Чун Дэ	-1636-1643	10.	Түгээмэл элбэгт	Сянь Фэн	1851-1861
4.	Эеэр засагч	Шунь Жи	1644-1661	11.	Бүрэнт засагч	Тун Жи	1862-1874
5.	Энх-Амгалан	Кан Си	1662-1722	12.	Бадаргуулт төр	Гуан Сюй	1875-1908
6.	Найралт төв	Юнь Жэн	1723-1735	13.	Хэвт ёс	Сюань Түн	1909-1911
7.	Тэнгэр тэтгэсэн	Цянь Лүн	1736-1795				



### 7. ЭЗЭНТ ГҮРНҮҮДИЙН ДОРНО ДАХИНЫГ КОЛОНИЧЛОХ БОДЛОГО

ГОЛ САНАА ЮУ ЮУ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
<ul style="list-style-type: none"> <li>Колоничлох бодлогын түүхэн нөхцөл</li> <li>Колоничлох бодлогын учир шалтгаан, үр дагавар</li> </ul>	<p>Дорно дахиныг колоничлох бодлогын хэрэгжилтээр шинэ үеийн дэлхийн газрын зурагт өөрчлөлт орсон.</p>	<ul style="list-style-type: none"> <li>Эзэнт гүрнүүд</li> <li>Колони</li> <li>Хагас колони</li> <li>Хараат орон</li> </ul>



**Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх**

*Зургийг ажиглаад ямар утга агуулга илэрхийлж буй талаар таамаглал дэвшүүлж ярилцаарай.*



Улс төрийн зурагт хуудас 1890 он. Франц. [www.qioga.com](http://www.qioga.com)  
Британи, Герман, Орос, Франц, Япон улсууд Манж Чин гүрнийг хэрчин хувааж буй нь.



### XVI-XVIII зууны үеийн колоничлолын тэсрэлт.

Испани, Португали, Англи, Франц, Нидерландууд колоничлолыг Африк, Ази, Америкт хамгийн идэвхтэй хэрэгжүүлсэн билээ. Эхэн үедээ худалдааг монополичлон худалдааны хэлцлээс дээд зэргийн ашиг олоход чиглэж байв. Дараа нь түүхий эдийг зөөж ашигладаг болов.

Харин XIX зууны дунд, сүүл үеэс “Империализмын эрин үе” эхэлж, бодлого өөрчлөгдөв. Энэ үеэс өрнөдийн их гүрнүүд дэлхийг дахин хуваахын төлөө ширүүн өрсөлдөх болжээ. Тэд дорно зүг илүү анхаарал хандуулж, хүч буурай орнуудыг хоорондоо хуваан авсан юм. Колони орондоо үйлдвэр байгуулж, хямд ажиллах хүчийг ашигладаг болжээ. XIX-XX зууны зааг дээр колонийн булаан эзлэх дайн төдийгүй, их гүрнүүдийн хооронд колонийн томоохон дайн өрнөсөн юм.

**Тайлбар:** - Колони (суурьшихаар буух гэсэн утгатай латин үг) орон гэж улс төр, эдийн засгийн бүх эрх мэдлээ бусдад бүрэн алдсан орныг хэлдэг.

- Хагас колони нь улс төр, эдийн засгийн хувьд хэлбэрийн төдий тусгаар тогтносон боловч эдийн засгийн эрх мэдэлгүй болсон орон.

- Хараат орон бол улс төр, эдийн засгийн хувьд бусдын хараат байдалд, хяналтад орсон орон юм.



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

**Мэдээлэл-1:** Португалийн колоний эзэнт улс XVI зууны туршид Малайн бүлэг арал (хамгийн чухал нь Халуун ногооны арлуудын Тернат арал дээр), Тайланд, Хятад, Япон, Бирмд бэхлэлт, түшиц газруудаа байгуулсан. Португали нь Англи, Нидерланд хэмээх колонийн шинэ гүрнүүдийн довтолгоог эсэргүүцэх чадваргүй болжээ.

**Колони орны жишээ:** Энэтхэгийг эзэмшихийн төлөө тэмцэл Их Британи, Францын хооронд XVIII зууны 40-өөд оноос эхлэн өрнөжээ. 1763 оны Парисын найрамдлын гэрээгээр Франц Энэтхэг дэх өөрийн эзэмшлээсээ татгалзан, Британи Энэтхэгийг байлдан дагуулах замд шилжжээ. Тэд 1757-1764 онд Бенгалийг эзлэн авч, 1799 онд Өмнөд Энэтхэгийн хамгийн хүчирхэг улс болох Майсурыг номхруулан, 1818 онд англичууд маратхуудыг бут цохисон. 1849 онд Пенджабыг эзэлснээр Энэтхэгийг байлдан дагуулах ажиллагаа эцэслэв. Энэтхэгт 1857-1859 онд Сипайн бослого гэх Британий колоничлолыг эсэргүүцсэн хөдөлгөөн гарсан боловч дарагдсан байна. 1858 онд Английн парламент Энэтхэгийг Британий хааны эзэмшил хэмээн зарлав.

**Баримт-1:** Британийн колоничлогчид Энэтхэгийг тонон дээрэмдсэн нь:

“Тэд райотууд (тариачдад), худалдаачдад бараа таваарын өөрийн өртгийг 4 дахин нэмж хүчээр шахаж байна. Тухайлбал, тэд тариачдад болон бусад хүмүүст 1 рупийн өртөгтэй барааг 5 рупийгээр хүчээр тулган өгч байгаа болно”.

(1762 оны 5 дугаар сард *Ост - Энэтхэгийн компаний төлөөлөгчид*

*Бенгалийн захирагчаас гаргасан гомдол*)

*Жишээ: Энэтхэгээс хөвөн зөөвөрлөж, Британид даавуу нэхсэнийгээ Энэтхэгт буцааж зарна. Харин Энэтхэгийн даавууны үйлдвэрлэл уналтад орсны дараа өөрсдийн үйлдвэрээ байгуулж эдийн засгийн талаар бүхэлд нь эрх мэдлээ тогтоодог байв.*



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

**Мэдээлэл-2:** Дэлхий ертөнцийг хэрсэн колонийн систем улс орнуудыг метрополь ба колони хэмээх хоёр хэсэг болгон хуваасан юм. Колонийн түрэмгийлэл өргөжин, дорно дахинтай хийх худалдаа, тонон дээрэмдэх, мөлжих явдал улам бүр өсөж байв. Дэлхийн зах зээлийн системд бүх улс орон татагдан орсон явдал капитализмын өсөлт хөгжилтөд бүх талаар нөлөөлжээ. Европчууд худалдааны замаар Азид нэвтрэн ирж, таатай боломж олдвол эргийн түшиц газруудад бэхжих оролдлого хийж байлаа. Мөн католик сүм хийдийн үйл ажиллагаа өргөжсөн нь орон нутгийн зүй ёсны эсэргүүцэлтэй тулгарчээ.

**Хагас колони орны жишээ.** Мин улсын үеэс эхэлсэн Гуанжоугаас (Кантон) бусад боомтод Европын онгоцнууд ирэхийг хориглосон бодлогыг үргэлжлүүлсэн юм. Британичууд Энэтхэгээс Чин улсад хар тамхи нууцаар оруулж худалдахыг хориглов. Гэвч 1800-аад оноос Их Британи Манж Чин гүрэнд хар тамхи нэвтрүүлэх бодлогоо идэвхжүүлэв. Тэд бараа таваараа борлуулах, хар тамхийг чөлөөтэй худалдах зорилгоор “Хар тамхины I дайн”-ыг 1839-1842 онд, “Хар тамхины II дайн”-ыг 1856-1860 онд хийв. Эдгээр дайнд монгол жанжин Сэнгэринчин оролцсон юм.

1842 оны 8 дугаар сарын 29-нд Нанжин хотод анхны тэгш бус гэрээ буюу “Боолчлолын гэрээ”-нд гарын үсэг зурав. Уг гэрээгээр Шанхай, Гуанжоу зэрэг 5 боомтод чөлөөтэй худалдаа хийх эрхтэй болов. Мөн Хонконг арлыг 99 жилийн хугацаатайгаар Англид шилжүүлж, 20000 хайрцаг хар тамхины өр, 21 сая фунт стерлингийн дайны төлбөр төлөх болов. Их Британи Чин улсад оруулах таваартаа 5%- аас дээшгүй татвар төлөх үүрэг хүлээв. 1860 онд байгуулсан гэрээгээр Манж Чин улс дайны төлбөрт 8 сая лан мөнгө төлөх болж, гадаад улсуудын бараа бүтээгдэхүүнд зах зээлээ бүрэн нээлттэй болгожээ. Тийнхүү Европын улсууд нэн давуу эрхтэй болсноор Чин гүрэн тэдний хагас колони болоход хүрчээ.

*Их Британи, Ирландын нэгдсэн вант улсын эрхэм дээд хатан хаан, Хятадын эрхэм дээд эзэн хаан хоёр орны хооронд үүссэн удаа дараагийн дайсагналцал, маргааныг төгсгөл болгож, дараах гэрээг байгуулжээ. Хятадын эрхэм дээд эзэн хаан Британий харъяатууд, тэдний гэр бүлийнхэн болон үйлдвэрийн газруудад Кантон, Аомынь, Фучжоу, Нинбо, Шанхайд худалдааны зорилгоор ямар нэгэн хяналт, дарамтгүйгээр зөвшөөрсөн болно.*

*Зайлшгүй, хүсэлтэй үедээ Британий харъяатууд ямар нэгэн боомтод элдэв хязгаарлалтгүйгээр орох, хэрэв хэрэгтэй бол өөрийн хөлөг онгоц, зэвсэг хэрэгслээ авчирах, Гонконг арлыг британий эрхэм дээд хатан хаанд мөнхийн өвлөн эзэмшихийг Хятадын эрхэм дээд эзэн хаан найрсагаар тавьж өгсөн юм. Хятадын эрхэм дээд эзэн хаан энэхүү гэрээний 2 дахь зүйлд зөвшөөрснөөр бүх боомтуудад Британий худалдаачдад бараа таваараа оруулах, гаргахад гаалийн татварын шударга, байнгын тариф хэрэглэх, бүх нийтэд мэдээг албан ёсоор зарлаж, тогтоохыг зөвшөөрсөн болно.*

*(1842 оны Нанжиний гэрээнээс)*

**Тайлбар:** Хар тамхи - Хүний уураг тархи, мэдрэл сэтгэхүүд хүчтэй нөлөөлдөг ургамлын гаралтай мансууруулах бодис юм. Уг бодис хүнцү бие махбодод төдийгүй сэтгэцэд аймшигтай муугаар нөлөөлдөг маш хортой. **ЗҮЙЛ**



«Хятад улс нь хар тамхичдын үндэстэн хэвээрээ байсан цагт энэ улсыг цэрэг дайны ноцтой гүрэн болно хэмээн айх зүйл бидэнд байхгүй. Яагаад гэвэл энэхүү хорт дадал зуршил нь тэдний амьдрах эрч хүчийг сорон туйлдуулсаар байх болно».

*(1895 онд Эзэн хааны хар тамхины комиссын хурал дээр Хятад дахь Их Британийн консул Жефф Херстийн хэлсэн үг).*



### Асуулт, даалгавар гүйцэтгэх

1. Британичууд Манж Чин гүрэнтэй “Хар тамхины дайн” хийх болсон шалтгаан юу вэ?
2. Манжийн цэрэг ялагдсан нь шинжлэх ухааны хөгжилтэй холбогдох уу?
3. Нанжиний гэрээний мөн чанар юу байв?



### Үр дүнг нэгтгэх, танилцуулах

Эх сурвалж/ үйл ажиллагаа	Цаг, хугацаа	Нийтлэг тал	Онцлог тал
Мэдээлэл 1,2			
Баримт 1			
Нэмэлт мэдээлэл			

2. Ж.Херстийн хэлсэн үгийг задлан шинжилж, хар тамхины бодлогын мөн чанар, хор уршиг, сургамжийг тодорхойлж, өөрийн дүгнэлтээ бусадтайгаа хуваалцаарай.

3. Зураг-3.23-ын мэдээллийг задлан шинжилж, хэн, хэний тухай, ямар утга агуулга илэрхийлж буйг бусад мэдээлэлтэйгээ холбон тайлбарлаарай.

### Африкийг колоничилсон нь.



### Унших, ойлгох, эрж хайх

Сахараас өмнө зүгт орших Африкийн эргийн бүс нутагт Европчууд XV зууны сүүлч хагаст анх нэвтэрчээ.

Колоничлогчид Америкийн индианчуудыг олноор нь хядсан тул тэнд газар тариаланд ажиллах хүч шаардагджээ. Тиймээс Африкаас боолчууд аваачиж ажиллуулах болов.

Боолын худалдаа XV зууны дунд үеэс XIX зууны 70-аад он хүртэл хэрэгжсэн. Европоос галт болон хүйтэн зэвсэг, согтууруулах ундаа, даавуу, металл эдлэл, сав суулгыг Африкт авчирч боолоор арилжина. Улмаар шинэ тивд хүргэн, сахар, тамхи, хөвөн зэрэг бүтээгдэхүүнээр тэднийг арилжин, Европт хүргэдэг байлаа.


1876 он гэхэд Европчууд Африкийн газар нутгийн 10%-ийг булаан эзэлсэн бөгөөд түшиц газрууд нь Африкийн бүх л эргээр тархан байрлаж байв.

XVIII зууны сүүлч үеэс Африкийг системтэйгээр судлах болжээ. Африк дахь шашин номлогчид Европын колонийн түрэмгийллийг зөвтгөх, түүнийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. 1900 он гэхэд бүх газрын 9/10-ийг нь колоний булаан эзлэгчид хуваан авчээ. Франц Африкийн 50,5 сая хүн амтай (нийт африкчуудын 32,3%), 42,1% газар нутгийг, Англи нь 76,9 (хүн амын 49,4 %) сая хүн бүхий 37,7% газар нутгийг эзэмших болжээ.

**Тайлбар:** Колоничлол- Хүчирхэг улс гүрнүүдийн хөгжил буурай, эзэнгүй, хүн ам цөөтэй нутаг дэвсгэрт ноёрхлоо тогтоон уугуул нутгийнхныг засаглан захирах, соёлоо дэлгэрүүлэх, шилжин суурьших үйл явц



XIX зууны сүүлч бол Европын тэргүүлэх орнуудын Африк, Ази, Далайн чанад дахь хараахан эзлэгдээгүй газар нутаг, улс орныг байлдан дагуулахын төлөө хурц тэмцлийн үе юм. XX зууны эхэн үед асар том колонийн эзэнт гүрнүүд байгуулагдсанаас хамгийн том нь Британий эзэнт гүрэн байв. Колонийн системд өөрийн эрх мэдлийг бүрэн алдсан колони орон, газар нутаг, ямар нэг хэлбэрээр уламжлалт тогтолцоогоо хадгалсан хагас колони орнууд багтаж байв. Цөөн тооны хагас колони орнууд бие даасан байдлаа нэр төдий л хадгалж үлдсэн.



Африк дахь Европын улсуудын колони эзэмшил (XIX зууны сүүлч XX зууны эхэн)

**Британийн эзэнт гүрний колониуд:**

Энэтхэг (1849),  
Бирм (1890),  
Египет (1882),  
Судан (1898)  
Өмнөд Африк (1889),

**Францын колониуд:**

Төв Вьетнам (1881)  
Энэтхэг, хятад (Вьетнам, Лаос,  
Камбож)  
Сахар,  
Баруун ба экваторын Африк

Мадагаскар (1894)

Марокко (1911)

**Германы колониуд:**

Дорнод Африк  
Баруун өмнөд Африк, Того, Камерун,  
Шинэ Гвиней болон зэргэлдээ арлууд

**Бельгийн колони:**

Конго

**Нидерландийн колони:**

Индонези

**Италийн колони:**

Ливи

Тэгш бус гэрээ, мөлжлөгийн зээллэг, цэргийн холбоотон болох зэргээр дамжиж, аж үйлдвэржсэн орнуудаас хараат болж байв. Нийгэм-эдийн засгийн бүтцийн хувьд хагас колониуд колониос бараг ялгарч байсангүй. Колони орнууд бараа бүтээгдэхүүний зах зээл, хямд ажиллах хүч, түүхий эдийн эх сурвалж болж байв.



**Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх**

1. Колончлолын бодлого, түүний мөн чанарыг үнэлэн тодорхойлж, хор уршиг, үр дагаврыг шүүн хэлэлцээрэй.
2. Их гүрнүүдийн колончлох бодлогын түүх бидэнд ямар сургамж, ухаарал үлдээснийг нэгтгэн дүгнэнэ үү.
3. Энэ үеийн түүхийг өнөөгийн цаг үе, улс орныхоо нөхцөл байдалтай холбон үзэж өөрийн үзэл бодлыг илэрхийлээрэй.




XX зууны эхэн гэхэд колониуд метрополийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулах зах зээл байх үүрэг нь улам өссөн. Энэ үед тэгш бус шинэ гэрээ байгуулж, гаалийн бодлогыг метрополийн сонирхолд нийцүүлэх нь ихэссэн.

Империалист орнуудын монополиуд колони, хагас колониудад хямд үнээр газар худалдан авч, эсвэл булаан авч, тэдэнд шаардлагатай хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд тариалах аж ахуй байгуулж байв. Колони, хараат орнуудад хөрөнгө оруулах чухал объект нь цэргийн стратегийн чухал ач холбогдол бүхий төмөр зам, боомт, телеграф шугам байв. Колони ба хараат орнуудад мөн гадаадын аж үйлдвэрийн газрууд, юуны өмнө олборлох үйлдвэрүүд байгуулагдаж байв. Дорно дахины орнуудын аж ахуйн үндэс нь хөдөө аж ахуй байсан. Хүн амын 2/3 нь хөдөө аж ахуйд хөдөлмөрлөж, үйлдвэрлэлийг зохион байгуулах уламжлалт арга, хэлбэрээ удаан хугацаанд хадгалж иржээ.




**Үр дүнг нэгтгэх, танилцуулах**



1. Британий эзэнт улс (XIX зууны сүүлч XX зууны эхэн)-ын колоничлолыг газарзүйн зурагт тулгуурлан тодорхойлоорой.
2. XIX зууны сүүлч, XX зууны эхэн үеийн колони эзэмшлийн өргөжилтийг өнөөгийн газарзүйн зурагтай харьцуулан хүснэгтэд нөхөж бичээрэй.

Улсууд	Колонийн түрэмгийлэл
Британий эзэнт улс	

3. Капитализмын хөгжил, түүний дотор анхны хөрөнгө хуримтлалын үндэс тавигдахад колонийн тогтолцоо ямар үүрэг гүйцэтгэснийг баримт, мэдээлэлд тулгуурлан тодорхойлоорой.
4. Колони орны уугуул иргэдийг улс төрийн ямар ч эрх мэдэлгүй болгосны шалтгаан юу вэ ?



**8. XVIII-XX зууны эхэн үеийн өрнө дахины улс орнуудын амьдрал, соёл**

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
<ul style="list-style-type: none"> <li>XVIII-XX зууны эхэн үед Өрнөдийн улс орнуудын хүн амын аж амьдрал, соёлд олон шинэ өөрчлөлт, дэвшил хөгжил бий болсон.</li> <li>Энэ үеийн өрнөдийн нийгэм, хүмүүсийн амьдрал, соёл орчин үеийн амьдралын хэв маягийн үндэс болсон.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>XVIII-XX зууны эхэн үеийн өрнөдийн хүн амын аж байдал, амьдралын хэв маяг, дүр төрх олон талаар шинэчлэгдэн өөрчлөгдсөн.</li> <li>Энэ үеийн өрнөдийн улс орнууд соёлын хөгжил шинэ шатанд гарч, орчин үеийн соёлын үндэс суурь тавигдсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Амьдралын хэв маяг</li> <li>Эрхлэх аж ахуй</li> <li>Соёл</li> <li>Урлаг</li> </ul>



**Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх**

*Та бүхэн XVIII-XX зууны эхэн үед дэлхийн түүхэнд ямар онцлог өөрчлөлт гарсныг өмнө үзсэн сэдвүүдтэйгээ холбон сэргээн санаарай. Тэр үеийн ололт амжилт бүхэн энэ үеийн хүмүүсийн амьдралын дүр төрх, соёлын хөгжилд зүй ёсоор тусгалаа олсон юм.*

*Өрнөдийн улсуудын амьдрал, соёлд холбогдох доорх зураг, жишээ, баримтад тулгуурлан түүхийн асуулт гаргаж, таамаглал дэвшүүлээрэй.*



Зураг-3.26



*Г а р г а с а н а с у у л т у у д д а а х а р и у л т о л о х, д э в ш ү л с э н таамаглалаа нотлох баталгаа олох эрэл хайгуул хийгээрэй.*



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах



**Баримт-1:** XVIII зууны дунд үеэс эхэлсэн хөдөө аж ахуйн хувьсгалын үр дүнд хүнсний үйлдвэрлэл үлэмж хэмжээгээр нэмэгдлээ. Үр ашиг нь ихээхэн дээшилснээр хүн ам цаашдаа улам олшров. Тариаланчид хотод очиж үйлдвэрт ажилд орсноор аж үйлдвэрийн хувьсгалын хөдөлгөх хүч болов.

(Адам Харт Девис. Дэлхийн түүх. Бүрэн хэмжээний зурагт лавлах. ДК, MON sudar. УБ., 2010. т.290)

**Баримт-2:** Хот руу өөрийн эрхгүй нүүх болсон хүмүүсийн амьдрал ядуу тарчиг, бохир заваан байв. XIX зууны эхний хагаст хотод шилжин суурьшигчдын тоо нийтийн үйлчилгээний боломжоос хэтрэв. Тиймээс хотын зарим ядуу хэсэгт хүнсний хангамж, ариун цэвэр тааруу байснаас нас баралт маш өндөр хувьд хүрч (хүнс тэжээлийн дутагдал, хэт төвлөрлөөс тахал гэдэсний хижиг өвчин гарч), хүн амын өсөлт харьцангуй удаашрав. (Адам Харт Девис. Дэлхийн түүх. Бүрэн хэмжээний зурагт лавлах. ДК, MON sudar. УБ., 2010. т.323)

**Баримт-3:** 1863 оны 1-р сарын 10-нд уурын хүчээр ажилладаг Лондон хотын Метрополитен төмөр зам дэлхийд анх удаа нээгдсэнээс хойш дэлхийн олон хотод газар доор төмөр зам байгуулж, “метро” хэмээн нэрлэх болов. Газар доор урт хонгил ухаж, төмөр зам тавьснаар олон хүнтэй хотууд түргэн, хямд тээврийн хэрэгсэлтэй болов.

(Адам Харт Девис. Дэлхийн түүх. Бүрэн хэмжээний зурагт лавлах. ДК, MON sudar. УБ., т.323)



### Унших, ойлгох, эрж хайх

Европ дахь аж үйлдвэрийн хувьсгалаар техник, технологийн дэвшил эрчимтэй явагдаж тухайн үеийн хүмүүсийн амьдралын хэв маяг, оюун санаанд нөлөөлөв. Хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь, боловсрол, ертөнцийг үзэх үзэлд чухал нөлөө үзүүлжээ. Хотууд хөгжихийн хэрээр дэд бүтцийг сайжруулах шаардлага улам нэмэгдэх болсон. Нөгөө талаар хотын оршин суугчид эрүүл ахуй, орчин нөхцлөө сайжруулах талаар тэмцэл гаргах болсон байна. Нийтийн тээвэр, дэд бүтэц сайжирснаар хүмүүс хотын захаар амьдрах болжээ. Ийнхүү хотод аж төрөх шинэ хэв маяг, амьдрал бий болов.

Өгүүлэн буй үед шинжлэх ухааны нээлтүүд бий болж, Францын философич Ренэ Декарт, Жан Жак Руссо, Шотландын эдийн засагч Адам Смит, Английн яруу найрагч Лорд Байрон, В.Гёте, зохиолч А.Дюма, хөгжмийн зохиолч Л.Бетховен нарын соён гэгээрүүлэгчдийн бүтээл нийгмийн хөгжилд түлхэц өгчээ. Уран бүтээлчид романтизм, реалист чиглэлээр зохиол бүтээлээ туурвих болов.

**Соёл.** XVIII зуунаас өрнөдийн орнуудад дуурийн урлаг өргөн тархах болжээ. Хөгжмийн зохиолчид дуурийн зохиолыг бичихдээ гоцлол дуучдын хоолойд зориулсан бүтээлийг бичих болсон нь дуурийн урлагийг улам хөгжүүлжээ.



XIX зууныг дуурийн “Алтан үе” гэж нэрлэдэг. Мөн гоёмсог дуурийн театрийн барилгууд баригдах болсон юм. Италийн Венец хотын “Ла Фенече” театр, Их Британийн Лондон хотын “Колизеум” театруудыг дурдаж болно.

Мөн энэ үеийг балетын “цэцэглэлтийн үе” гэж үздэг бөгөөд бүжигчдийн ур чадвар, эмэгтэй балетчдийн байр суурь өссөн үе юм. Балетийн хөгжилд Францын Ж.П.Рамеу,

Оросын П.И.Чайковский нар чухал нөлөө үзүүлжээ. П.И.Чайковский “Хунт нуур”, Нойрсож буй гоо бүсгүй”, “Щелкунчик” бүтээлүүдээрээ алдартай.

Энэ үед уран барилгад шинэ дүр төрх, хийц бүхий бүтээлүүд бий болсон юм. Францын “Эйфелийн цамхаг” Парисын Их театр, Их Британий Лондон хотын “Парламентын барилга” уран гоёмсог барилга цамхагууд баригдсан нь өнөө хүртэл гайхагдсаар байгаа билээ.

Уран зурагт мөн реалист чиглэлийн бүтээлүүд төрөн гарах болжээ.



XIX зууны үеэс хүмүүсийн амьдралын хэв маягт гарсан бас нэг өөрчлөлт нь амралт, чөлөөт цаг гэсэн хуваарь бий болов. Хүмүүсийн орлого нэмэгдэх тусам чөлөөт цагаа өнгөрүүлэх зоогийн газар, театр, үзвэр, спортын газрууд бий болжээ. Энэ нь урлаг, уран сайхны хөгжилд түлхэц өгчээ.

Энэ үед өрнө дахины орнуудад хүний эрхийн талаар тэмцэл, хөдөлгөөн гарч байсан нь тэдний амьдралыг үзэх үзэлд чухал нөлөө үзүүлжээ. Их Британид урьд нь хүн амын дөнгөж 5 хувь нь сонгуульд оролцох эрхтэй байсан бол XIX зууны эцсээр бүх эрэгтэйчүүд сонгуулийн эрхтэй болжээ. Мөн эмэгтэйчүүд сонгуулийн эрхтэй болж, парламентаас хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн эрх ашгийг хамгаалсан эдийн засаг, нийгмийн шинжтэй хуулиудыг гаргаж, хэрэгжүүлэх болжээ.

Францад иргэний эрхийн тунхаг бичиг гарав. Гэвч эмэгтэйчүүд өмчлөх эрхгүй байсан бөгөөд 1896 онд гарсан хуулиар нөхөрт гарсан эмэгтэйчүүд өөрийн өмч, орлоготой байхыг хүлээн зөвшөөрчээ. Мөн Орост II Александр хаан 1861 онд тариачдыг хамжлагаас чөлөөлөх тухай шийдвэр гаргаж, тэдэнд хувийн эрх чөлөө олгосон байна.



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

Дараах асуултын дагуу ярилцаж, баримт, мэдээллээс юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.

1. Тухайн үеийн хүмүүсийн амьдралын талаар өгүүлсэн мэдээллийг харьцуулан шинжилж, ярилцаарай.
2. Хүснэгтийн дагуу ажиллаж, мэдээлэл тус бүрд гарсан өөрчлөлтийн үр дүнг тодорхойлоорой.

Тухайн үеийн өрнө дахины ард түмний аж амьдралыг өнөө үетэй харьцуулна уу.			
Аж ахуй	Амьдралын хэв маяг	Хүмүүсийн ажил төрөл	Урлаг

3. Өрнө дахины орнуудын хүмүүсийн аж амьдрал, соёл нь нийгэм, эдийн засаг, өв уламжлалтайгаа ямар холбоотой вэ?



### Үр дүнг нэгтгэх, танилцуулах

1. Баримт мэдээллийг судлан шинжилсэн үр дүнгээ танилцуулаарай.
2. Энэ хүрээнд хийсэн суралцахуйн үйл ажиллагаа, хөгжүүлсэн чадвар, арга барилаа үнэлээрэй.
3. Энэ сэдэвтэй холбоотойгоор цаашид юу сонирхон судлахыг хүсэж байгаагаа бусадтайгаа хуваалцаж, багшдаа санал бодлоо илэрхийлээрэй. (А.Дюмагийн зохиолууд, Шадар гурван цэрэг, П.И.Чайковскийн “Хунт нуур, “Нойрсож буй гүнж) гэх мэт.



### 9. ХVIII-XX зууны эхэн үеийн дорно дахины улс орнуудын амьдрал, соёл

ГОЛ САНАА ЮУ ВЭ?	ЭНЭ СЭДЭВ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	ТҮЛХҮҮР ҮГ:
<p>Дорно дахины улсууд өөрийн гэсэн соёл иргэншлийг бий болгож, түүнийгээ үеэс үед өвлүүлэн хөгжүүлж ирсэн. Улс орны зан заншил, амьдрал ахуй харилцан адилгүй байдаг.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Дорно дахины ард түмэн өөрийн гэсэн өвөрмөц соёлыг бий болгосон.</li> <li>• Дорно дахины ард түмний амьдрал, соёл түүхийн бүхий л цаг үед баяжин хөгжсөөр ирсэн.</li> </ul> <p>Амьдрал, соёлын хөгжилд нийгэм, улс төрийн нөхцөл байдал нөлөөлдөг.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Амьдралын хэв маяг</li> <li>• Эрхлэх аж ахуй</li> <li>• Ёс заншил</li> <li>• Бичиг үсэг</li> <li>• Урлаг, соёл</li> <li>• Өв уламжлал</li> <li>• Шашин шүтлэг</li> </ul>



#### Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх

*Түүх бол хөгжил, хөдөлгөөнтэй, амьд бодитой үйл явц. Түүхийн бүх үйл явдлыг хүмүүс оролцон бүтээж, бүхий л эрин зууны цаана хүмүүсийн амьдрал, аж төрөл, соёл дагалдан явдаг. Тухайн цаг үеийн нийгмийн амьдралын бүхий л тал хэсэг нийлж нэгдэж байж түүхийг цогц, бодитой болгодог. Түүхийн үйл явдал, үзэгдэл, амьдрал, соёл бүгд хоорондоо нягт харилцан холбоотой.*

Та бүхэн өмнө үзсэн сэдвүүдээ эргэж бодоорой. ХVIII-XX зууны эхэн үед өрнийн болоод дорнын түүхэнд ямар онцлог өөрчлөлт гарсан бэ? Энэ үеийн хүмүүсийн амьдралын дүр төрх, соёлын хөгжилд зүй ёсоор тусгалаа олсон юм.

Доор өгсөн дорно дахины улс түмний амьдрал, соёлд холбогдох зарим бодит жишээ, баримтад тулгуурлан түүхийн асуулт гаргаж, таамаглал дэвшүүлээрэй.



Зураг-3.27



### Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах

**Мэдээлэл-1.** Тухайн үед хятадууд Манж Чин улсын эрхшээлд байсан бөгөөд Манж нар хятадуудыг язгуур угсаагаар нь ангилж, давхарга бүрд үйлчлэх хуулиудыг гаргав. Уг хуулиар тариачид, гар урчууд, хотын ядуучууд, олзлогсад, боолчуудын эрх мэдлийг бүрэн хязгаарлаж, их хэмжээний, олон төрлийн алба гувчуур ноогдуулжээ. Зодож, жанчих, хөрөнгийг нь хураах, албадан ажиллуулах, цөлөх, цаазаар авах зэрэг ял шийтгэлийг хэрэглэж байв. Хүм амын нийгэмд эзлэх байр сууриас хамаарч тэдний ёс заншил, амьдралын нөхцөл байдал зэрэг нь ялгаатай байжээ. Хятадууд Манжийн захиргаанд үг дуугүй захирагдахын бэлгэ тэмдэг болгож үсээ хусуулдаг байв.

(Э.Тамир. Дорнын түүх. УБ., 2007, т.51)

Монголчууд ч Манжийн эрхшээлийн үед үсээ хусуулж тав гэзэг тавьдаг байсныг санаарай.

**Мэдээлэл-2.** Мэйжи-ийн үед Япон боловсролын системийг Европ маягаар зохион байгуулж, тэдний соёлыг нэвтрүүлэхийн тулд шилж сонгосон хүмүүсийг барууны орнуудад суралцуулсан байна.

Японы нийгэмд дээд тайж нарын, тайж нарын, энгийн ардын гэсэн гурван давхарга бий болсон байна. Мөн бүх нийтээр цэргийн алба хаах болжээ. Түүнчлэн шуудан холбоо, төмөр зам тавих, үйлдвэр барих зэрэг нийгмийн шинжтэй ажлуудыг авч хэрэгжүүлсэн нь хүмүүсийн аж амьдралд чухал нөлөө үзүүлжээ.




Хотууд хөгжсөнөөр түүнийг дагасан хотын амьдрал хөгжил бий болж, хүмүүсийн амьжиргааны төвшин дээшилснээр хүүхдээ сүмд явуулж, бичиг үсэг заалгах болов. Бичиг үсэгтэй хүмүүсийн тоо нэмэгдсэнээр олон тооны ном хэвлэгдэн гарах болжээ.

Японы гар урчууд нь ажилдаа чин сэтгэлээсээ хандах бөгөөд ашиг орлого, нэр алдраас илүү чанар сайтай эд хийхийг эрмэлзэнэ.

**Мэдээлэл-3.** XVIII зууны үеэс Энэтхэгийн эдийн засаг, улс төр, нийгмийн амьдралд ихээхэн өөрчлөлтүүд гарах болсон байна.

Газар тариалангийн хөгжилд ахиц гарч, тариачид усалгаатай талбайгаас жилдээ 2-3 ургац авч байлаа. Тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үүднээс төрөл бүрийн бордоо хэрэглэж, ээлжлэн тариалах, шинэ техник нэвтрүүлэх зэрэг арга хэмжээг авах болжээ. Мөн гадны улсуудын нөлөөгөөр эдийн засаг, нийгмийн амьдралд өөрчлөлт гарав. Ялангуяа Их Британичууд төмөр зам тавих, сургууль, христийн сүм барих зэрэг ажлуудыг хийв.

XIX зууны дунд үеэс цайны аж ахуй эрчимтэй хөгжих болжээ. Хөвөн, улаан буудай, цай зэрэг бүтээгдэхүүнүүдийг экспортод гаргах болсон бөгөөд энэ нь Их Британичуудын ашиг орлогыг нэмэгдүүлэхээс биш энэтхэгийн ард түмний амьдралд тус болдоггүй байв. Ихэнх энэтхэгчүүдийн амьдрал туйлын хүнд, ядуучууд ихтэй байлаа.



**Мэдээлэл-4.** Австрали тивийг анхлан Нидерландчууд нээсэн түүхтэй. 1770 онд Их Британийн далайчин Жеймс Кук Австралийн дорнод эргээр аялан, шинэ газрууд нээж, тэдгээр газруудаа шинэ Уэльс гэж нэрлэн, Их Британийн хааны өмч хэмээн зарлажээ. Энэ үед Австралид 500 орчим овог аймгууд амьдарч байсан бөгөөд өөр өөрийн гэсэн нутаг дэвсгэртэй, хил хязгаараа хатуу тогтооно. Тивийн уугуул иргэд-аборигенчүүд ан агнуур, загас барих, олзворлох, түүвэрлэх уламжлалт аж ахуй эрхэлж байлаа. Аборигенчүүд аман зохиолын баялаг өв уламжлалтай ард түмэн байв. Тэд дуулж, бүжиглэн баярлаж цэнгэх бөгөөд түүнийгээ “корробор” гэнэ.

XVIII зууны II хагасаас европчууд суурьших болсноор тус нутгийнхны амьдрал, ахуйд өөрчлөлт орох болжээ. Анхлан Их Британичууд энэ нутаг руу хоригдлуудыг нутаг заан цөлсөн юм. Эдгээр хүмүүс нь Австралийн дорнод эргээр суурьшин амьдрах болжээ. Шинээр суурьшигчдын нөлөөгөөр Австралийн уугуул иргэдийн аж ахуйд өөрчлөлт гарч шинээр газар тариалан хөгжиж, улаан буудай, чихрийн нишингэ, хөвөн тариалах болсон байна. Хонины аж ахуй хөгжиж, хонины ноосыг боловсруулах үйлдвэр эрчимтэй хөгжих болжээ. Далайн эргийн дагуу суурин газар, үйлдвэрийн төв, хотууд олноор байгуулагдах болсон байна.

Далайн арлын орнууд нь газар зүйн болон угсаа, соёлын шинжээрээ хоорондоо ялгаатай Меланези, Полинези, Микронези гэсэн мужид хуваагдана. Меланезийн оршин суугчид нь негроид хэв маягийн хар арьстай, буржгар үстэй хүмүүс байв.

Номхон далайн арлуудаар орших далайн орнуудад ч европчууд хөл тавьжээ. Тэд XVIII зууны II хагас хүртэл уламжлалт аж ахуй болох загас барих, сувд түүх, газар тариалан зэрэг ажил эрхлэн аж төрж байлаа.

Газар тариалангийн үйлдвэрлэл өөрийн гэсэн онцлогтой бөгөөд батата (амтат төмс), таро, гадил жимс, ямса зэрэг олон төрлийн таримал тариална. Харин Европын орнууд энд колоничлох болсноор чихрийн нишингэ, кофе, тамхи тариалах болсон байна. Мөн олзворлох үйлдвэрүүд бий болж, никель, фосфорын уурхайнууд нээгджээ. Судлаач С.И.Брук Австрали, далайн орнуудын хүн амын тоог 1750 онд 2.0 сая, 1800 онд 2.3 сая, 1850 онд 2.5 сая, 1900 онд 6.8 сая хэмээн тооцоолжээ.



### Асуулт, даалгавар гүйцэтгэх

1. Зурган болон бичвэр мэдээллийн агуулгыг бие даан шинжлэн судалж, тунгаан бодоорой.
2. Дээрх баримтын мэдээллүүдийг ашиглан XVIII-XX зууны эхэн үеийн дорно дахины ард түмний амьдралын талаар хэлэлцүүлэг хийгээрэй.



### Мэдээлэл боловсруулах, задлан шинжлэх

**Дараах асуултын дагуу ярилцаж, баримт, мэдээллээс юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.**

1. Тухайн үеийн хүмүүсийн амьдралын талаар өгүүлсэн мэдээллийг харьцуулан шинжилж, ярилцаарай.
2. Хүн амын өсөлтийн тоогоор график байгуулаарай.
3. Хүснэгтийн дагуу ажиллаж, мэдээлэл тус бүрд гарсан өөрчлөлтийн үр дүнг тодорхойлоорой.

### Тухайн үеийн дорно дахины ард түмний аж амьдралыг өнөө үетэй харьцуулна уу.

Аж ахуй	Амьдралын хэв маяг	Хүмүүсийн ажил төрөл	Соёлын иргэншлийн хэлбэр

4. Дорно дахины орнуудын хүмүүсийн аж амьдрал, соёл нь нийгэм, эдийн засаг, өв уламжлалтайгаа ямар холбоотой вэ?



### Үр дүнг нэгтгэх, танилцуулах

1. Баримт мэдээллийг судлан шинжилсэн үр дүнгээ танилцуулаарай.
2. Энэ хүрээнд хийсэн суралцахуйн үйл ажиллагаа, хөгжүүлсэн чадвар, арга барилаа үнэлээрэй.
3. Энэ сэдэвтэй холбоотойгоор цаашид юу сонирхон судлахыг хүсэж байгаагаа бусадтайгаа хуваалцаж, холбогдох баримтат кино, мэдээ, мэдээлэл, эх сурвалжийг цуглуулж, зургийн цомог бэлтгээрэй.

## ХVIII-XX зууны эхэн үеийн монгол ба дэлхий дахин

### Түүхэн он цаг, үйл явдлын товчоон

1755 – Амарсанаа Манжийн түрэмгийллийг эсэргүүцсэн тэмцэл бослого гаргажээ.  
 1755-1758- Манж нар Зүүнгарын хаант улсыг байлдан эзэлжээ.  
 1756 – Ар Монголд Чингунжавын удирдсан тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл эхлэв.  
 1761 – Их хүрээ, Ховдод манж-монгол сайдыг суулгах болжээ.  
 1761 – Баруун монголчуудыг олон хошуу, сумын зохион байгуулалтанд оруулан захирчээ.  
 1762 – Ховд хотыг Буянт голын хөвөөнд шилжүүлжээ.  
 1789 – Чин улс “Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны хууль зүйлийн бичиг” гарган мөрдөж эхлэв.

1837 – Ванчинбалын Инжинаш төржээ.  
 1861 – Их хүрээнд Оросын консулын газар анх байгуулагдав.  
 1880 – Онолтын удирдлагаар Улиастайд Чингийн эсрэг монгол цэргийн бослого гарсан.  
 1899 – Их хүрээнд цахилгаан мэдээний газар байгуулагдав.  
 1900 – Монголд алтны уурхайг ашиглах “Монголор” гэдэг гадаадын хувь нийлүүлсэн нийгэмлэг байгуулагджээ.

1900 – Улиастайд монгол цэргүүдийн, Өвөр монголд “Тохом”-ын бослого гарав.  
 1903 – Ховдод ард Аюушийн толгойлсон заргын тэмцэл эхлэв.  
 1905 – 1907 – Өвөр Монголд Тогтох, Цогдалай, Дампил нарын удирдсан бослого гарав.



1756 – Британи, Франц хоёрын хооронд гарсан долоон жилийн дайн эхлэв.  
 1770 – Английн далайчин ахмад Күүк Австралийг Британий өмч гэж тунхаглав.  
 1787 – АНУ-ын үндсэн хууль батлагдаж, боолчлолыг хуулиар хориглов. “Доллар” гэх мөнгөн тэмдэгт гаргав.  
 1789 – Францын хувьсгал эхлэв. Иргэдийн эрхийн тунхаглалыг батлан гаргав.  
 1789 – Жорж Вашингтон АНУ-ын анхны ерөнхийлөгчөөр сонгогдов.  
 1795 – Францын засгийн газрыг Директор удирдах болов.  
 1796 – Английн Эдвард Женнер салхин цэцгийн эсрэг вакцина гаргав.  
 1799 – Наполеон Францын засгийн эрхийг гартаа оруулав.

1806 – Ариун Ромын эзэнт гүрэн мөхөв.  
 1810 – Мигэл Идалго Мексикийн тусгаар тогтнолын төлөө тэмцэв.  
 1812 – Наполеон Бонапарт Орос руу дайрч ялагдал хүлээн нутаг буцав.  
 1814 – Наполеон эзэн хааны суудлаас огцров.  
 1814 – Австрид Венийн бага хурал болов.  
 1815 – Ватерлоогийн тулалдаанд холбоотнууд Наполеоныг бут цохив.  
 1825 – Британид зорчигч тээвэрлэх анхны төмөр зам байгуулагдав.  
 1840 – Британид анхны шуудангийн марк гарав.  
 1840 – Маоригийн Вайтангид болсон гэрээгээр Шинэ Зеланд Британийн колони болов.  
 1840-1842, 1856-1860 – Хар тамхины 1 ба 2-р дайн  
 1852 – АНУ-д Алиша Отис цахилгаан шат зохион бүтээв.  
 1857 – Энэтхэгт Британий эсрэг бослого дэгдэв.  
 1859 – Чарльз Дарвин Эволюцийн онолын бүтээлээ хэвлүүлэв.  
 1861-1865 – Америкт иргэний дайн гарав. Боолууд эрх чөлөөтэй болов.  
 1867 – Канад тусгаар улс болов.  
 1869 – Америкийн нэг эргээс нөгөө эрэг хүртэл төмөр зам тавив.  
 1870 – Их Британид эмэгтэйчүүд өмчтэй байх эрхтэй болов.  
 1876 – Шотландын багш Александр Белл телефон утас бүтээв.  
 1877 – АНУ-д Томас Эдисон фонограф зохион бүтээв.  
 1885 – Энэтхэгийн үндэсний конгресс байгуулагдав.  
 1888 – Бразилд боолчлолыг халав.  
 1894 – Чин улс болон Японы Солонгосыг эзлэх дайн эхлэв.  
 1895 – Италийн Гуггелмо Маркони радио зохион бүтээв.  
 1900 – Хятадад боксерийн бослого дэгдэв.

1901 – Австрали Британиас тусгаар тогтнов.  
 1902 – Польшийн эрдэмтэн Мари Кюри, түүний франц нөхөр Пьер хоёр радийг нээв.  
 1907 – Шинэ Зеланд Британиас тусгаар тогтнов.  
 1910 – Мексикийн хувьсгал эхлэв.

**Ном зүйн жагсаалт****Нэг. Монголын түүхийн ном бүтээл:**

1. Амгалан М. Баруун монголчуудын эдийн соёлын дурсгалт зүйлс. УБ., 2000
2. Болдбаатар Ж. Монгол улсын түүх бичлэг: шинэчлэл, чиг хандлага. УБ., 2008
3. Гонгор Д. Халх товчоон. Боть I, II. УБ., 1970, 1978
4. Далай Ч. Ойрад Монголын түүх. Тэргүүн боть. УБ., 2002
5. Монгол улсын түүх. III, IV боть. УБ., 2003
6. Монголчууд (XVII-XX зууны эхэн үе). Зурагт ном. Ерөнхий редактор С.Чулуун. УБ., 2014
7. Монголчууд XX зууны эхэнд. Зурагт түүх. Ерөнхий редактор О.Батсайхан. УБ., 2011
8. Нацагдорж Ш. Манжийн эрхшээлийн үеийн Халхын хураангуй түүх (1691-1911). УБ., 1963
9. Нацагдорж Ш. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978
10. Оюунжаргал О. Манж Чин улсаас Монголчуудыг захирсан бодлого (Ойрадуудын жишээн дээр). УБ., 2009
11. Пүрэвжав С. Монгол дахь шарын шашны хураангуй түүх. УБ., 1978
12. Санждорж М. Монгол төрийн түүхээс (XIII-XIX зуун). УБ., 1998
13. Сономдагва Ц. Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт (1691-1997). УБ., 1998
14. Урангуа Ж. XX зууны эхэн үеийн Монгол улс (1911-1919). УБ., 2006
15. Цолмон С. Галдан бошгот хаан (1644-1697). УБ., 2003

**Хоёр. Дэлхийн түүхийн ном бүтээл:**

1. Адам Харт-Дэвис. Дэлхийн түүх. Бүрэн хэмжээний зурагт лавлах. DK, MON sudar. УБ., 2010
2. "Дэлхийн түүх" I, II боть. (Хянан тохиолдуулсан Ж.Болдбаатар, З.Баасанжав). УБ., 2002, 2003
3. Европын түүх (XVI-XIX зуун). (Хянан тохиолдуулсан З.Баасанжав, Д.Наранцэцэг). УБ., 2000
4. Гонгоржав У. Дундат зууны түүхийн дээж бичиг. УБ., 2006
5. Наранцэцэг Д. Дэлхийн түүхийн нэр томъёоны толь. УБ., 2012
6. The Nystrom. Atlas of World History. Second edition. Herff Jones Nystrom. Printed in the USA. 2012, 2004
7. McDougal Littell. World History Patterns of interaction. Roger B.Beck, Linda Black..., Printed in the USA, 2007
8. McGraw-Hill. World History & Geography Modern Times. Jackson J. Spielvogel. Printed in the USA, 2014

**Гурав. Сурах бичиг, нэмэлт хэрэглэгдэхүүн**

1. Britanica. Ширээний нэвтэрхий толь. 8 боть. УБ., 2011
2. Гантулга Ц., бусад. Түүх II. Сурах бичиг. УБ., 2005
3. Гантулга Ц., бусад. Түүх III. Сурах бичиг. УБ., 2011
4. Наранцэцэг Д., бусад. Түүх I. Сурах бичиг. УБ., 2014
5. Сүхбаатар Г, Жамсран Л. Монголын түүхийн дээж бичиг. III боть. УБ., 1995

**Дөрөв. Цахим мэдээллийн сан:**

<http://mongol.undesten.mn/>  
<https://mn.wikipedia.org/>  
<http://www.history.com/>  
<http://www.emersonkent.com>  
<http://www.edmaps.com>  
<http://www.mapsofworld.com/>  
<http://www.euratlas.net>